



НЭГДСЭН
ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ УЛС



Монгол Улсын ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ 2021





НЭГДСЭН
ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ УЛС



Монгол Улсын
**ХӨГЖЛИЙН
ТӨЛӨВ БАЙДЛЫН
ШИНЖИЛГЭЭ
2021**



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН
ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ
2021

 unmongolia

 unmongolia

 <https://mongolia.un.org>

©Монгол дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага
2022

БҮЛЭГ 1 ХУРААНГУЙ ТОЙМ	1
БҮЛЭГ 2 УДИРТГАЛ	5
БҮЛЭГ 3 2030 ОН ХҮРТЭЛХ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР БОЛОН МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТ	7
3.1 Орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд, эрсдэлт хүчин зүйлс	7
3.1.1 Хүүхэд, өсвөр насныхан	8
3.1.2 Эмэгтэйчүүд, охид	11
3.1.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс	14
3.1.4 Ажилгүйчүүд, ур чадваргүй залуучууд	16
3.1.5 Хотын ядуус, дотоодын шилжин суурьшигчид	18
3.1.6 Хөдөөгийн ядуус, малчид	20
3.1.7 Үндэстний цөөнх	22
3.1.8 Ахмад настан	23
3.1.9 Бэлгийн цөөнх	25
3.2 Нийгмийн хөгжил, ялгаварлан гадуурхалтын талаарх шинжилгээ	26
3.3 Эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтийн шинжилгээ	36
3.4 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн шинжилгээ	46
3.5 Засаглал, улс төрийн шинжилгээ	56
3.6 Олон хэмжээст ТХЗ-ын эрсдэлийн шинжилгээ	62
3.7 Хүмүүнлэгийн, Хөгжлийн болон Энхийг сахиулах хөтөлбөрүүдийн уялдаа холбоо	64
3.8 Монгол Улсын хөгжлийн Алсын хараа, Төлөвлөлтийг 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Бүс нутаг, Олон улсын хөгжлийн хөтөлбөр/зорилготой уялдуулах нь	68
3.9 Санхүүгийн төлөв байдлын шинжилгээ	75
3.10 Оролцогч талууд/ Түншлэлийн шинжилгээ	82
БҮЛЭГ 4 ДҮГНЭЛТ	89
ХАВСРАЛТУУД	96
Хавсралт 1: Монгол Улсын Хөгжлийн төлөв байдлын шинжилгээ хийх байгууллага дундын Ажлын хэсгийг байгуулах тухай	96
Хавсралт 2: Орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдтэй хийсэн (LNOB) Фокус бүлгийн ярилцлагын тайлан	98
Хавсралт 3: Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR), НҮБ-ын Гэрээний хороодоос Монгол Улсад өгсөн зөвлөмжүүд: ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмэр	160
Хавсралт 4: Олон хэмжээст эрсдэлийн матриц	173
Хавсралт 5: Монгол Улсын 2030 хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, ТХЗ-ын хэрэгжилтийн явц, таван үндсэн категориор (5Х)	180
Товчилсон үгсийн жагсаалт	186



ХУРААНГУЙ ТОЙМ



Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Удирдлагын баг нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол саад, бэрхшээлийг тодорхойлох, Монгол Улсын хөгжлийн ахиц дэвшлийг хурдасгах стратегийн эн тэргүүний зорилтуудыг тодорхойлох зорилгоор Монгол Улсын Ерөнхий Хөгжлийн төлөв байдлын шинжилгээ (ХТБШ) хийсэн болно. Энэхүү ХТБШ нь НҮБ-ын Удирдлагын багийн арга зүйн хэрэгсэл болохын зэрэгцээ 2023-2027 онд НҮБ болон Монгол Улсын Засгийн газар хооронд Тогтвортой хөгжлийн төлөөх хамтын ажиллагааны шинэ хүрээг (ТХХАХ) тодорхойлох суурь үндэс болох юм. ХТБШ-г хийж байх явцад Монгол Улсын хөгжлийн замнал, бүтцэд хамаарах сорилт бэрхшээлийн талаар нухацтай ойлголт авах зорилгоор тус улсын хөгжлийн түүхэн чиг хандлагад дүн шинжилгээ хийсний зэрэгцээ Монгол Улсын хөгжилд үзүүлж буй КОВИД-19 цар тахлын хямралын нөлөөллийг тусгах үүднээс хамгийн сүүлийн үеийн тоо мэдээллийг ч мөн ашигласан. Иймээс ХТБШ нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн төлөөх хамтын ажиллагааны хүрээ (ТХХАХ)-ний удирдах зарчмуудыг тусгасан, хэнийг ч орхигдуулахгүй байх, хүний эрхийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг чадавхжуулах зэрэгт чиглэсэн ирээдүйг харсан баримт бичиг болсон юм.

Монгол Улсын Засгийн газар нь Тогтвортой хөгжилд чиглэсэн тодорхой арга хэмжээг авч ирсэн. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын хэрэгжилтийг удирдан чиглүүлэх үүрэг бүхий институцийн бүтцийг бий болгож, хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хамгаалах талаар олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэхийн зэрэгцээ улс орондоо тогтвортой хөгжлийг хангах замын зураглал болох урт хугацааны

хөгжлийн бодлогоо тодорхойлж баталсан. Монгол Улсын Их Хурлын сонгууль 2020 оны зургадугаар сард болж, шинэ Засгийн газар байгуулагдсан. Гэвч 2021 оны нэгдүгээр сард болсон тайван жагсаалын улмаас Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч дахин шинэ засгийн газар байгуулагдсан. Монгол Ардын Намын залуу үеийн удирдагчдаас бүрдсэн шинэ засгийн газар КОВИД-19 цар тахлын хямралыг сөрж даван туулахын тулд илүү өргөн цар хүрээг хамарсан цар тахалтай тэмцэх бодлогыг хэрэгжүүлэх, үүний зэрэгцээ нийгмийн халамж, хамгааллын бодлогоо хэвээр үргэлжлүүлэн эдийн засгаа сэргээх гэсэн хавсарсан нийлмэл бодлогыг хэрэгжүүлэхээр шийдэмгий арга хэмжээ авч ажилласан. Гэсэн хэдий ч бүтэц зохион байгуулалт сул хэвээр, засаглалын асуудлууд ужгирсан хэвээр байгаа нь ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хэдийнээ гарч эхэлсэн ахиц дэвшилд сөргөөр нөлөөлж байна.

2016-2017 онд тохиосон эдийн засгийн хүндрэлийн дараа макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах талаар Засгийн газраас ихээхэн хүчин чармайлт гаргасан хэдий ч Монгол Улсын эдийн засгийн өсөлт тогтворгүй хэвээр, шалтгаалах бусад олон хүчин зүйлс хадгалагдсаар байна. Тэр бүр төдийлэн тогтвортой байж чаддаггүй уул уурхайн салбар, ашигт малтмалын эх үүсвэрээс хэт их хамааралтай байгаа нь уул уурхайн бус салбарт ажлын байр хомс, нэмүү өртөг шингээж чадахгүйд хүргэж тус улсыг зэс, нүүрсний үнийн уналт, БНХАУ-ын түүхий эдийн эрэлт тогтворгүй болох зэрэгт улам бүр эмзэг болгож байна. Ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр, ажлын байрны чанар муу байгаа нь хөдөөгийн олон мянган өрх хот суурин руу шилжин суурьших, боловсролтой олон мянган залуус гадаад орнуудыг зорих зэрэгт хүргэж байна. Өрийн эмзэг байдлын түвшингээр Монгол Улс Ази, Номхон далайн бүс нутагтаа хамгийн өндөрт тооцогдож

байгаа бөгөөд энэ нь тус улсын санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл дагуулж байна. Үүн дээр нь цар тахлын хямрал нэмэлт дарамт учруулж макро эдийн засгийн орчныг улам бүр доройтуулж, хүмүүсийн амьжиргаа, нийгмийн байдалд сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсад 1990-ээд оны эхэн үеэс иргэний нийгмийнхэн идэвхжиж, харьцангуй чөлөөтэй хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бий болж ардчиллын төлөө тууштай хөдөлгөөн өрнөсөн байдаг. Гэсэн хэдий ч эдгээр хөдөлгөөн улс төрийн тогтворгүй байдал, системийн болоод бүтцийн томоохон сорилт бэрхшээлүүдтэй тулгарч байсан. Төр засгийн байгууллагуудад хариуцлагын механизм сул, шударга ёсыг үр дүнтэй хэрэгжүүлэх институцийн чадавх хязгаарлагдмал, эрх зүйт ёсыг баримтлах талаар сул дорой байсан аж. Авлига хээл хахуул, улсын төсвийн хөрөнгийг зүй бусаар зарцуулсан гэх мэдээлэл газар авсаар байна. Сонгууль тайван болж өнгөрлөө хэмээн сайшаан хүлээн авсан хэдий ч улс төрийн байдал хурцадмал хэвээр, нийгмийн эв нэгдэл сулрах шинж орсоор байна. Засгийн газраас цар тахлаас сэргийлэх зорилгоор тогтоож буй хатуу хязгаарлалтууд нь Монголын нийгэм даяар бухимдал төрүүлж, хүний үндсэн эрх, эрх чөлөөндөө санаа зовниход хүргэж байна.

Уур амьсгалын өөрчлөлт нь Монгол Улсын тогтвортой хөгжилд саад тотгор болж буй гол хүчин зүйлүүдийн нэг юм. Ган, зуд, үер, салхи шуурга, элсэн болоод шороон шуурга зэрэг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшгийн давтамж, хүндрэл улам бүр нэмэгдэж байгаа нь хөдөө аж ахуй, мал аж ахуй, ус болон газрын нөөц, дэд бүтцийн хөгжил, хүний эрүүл мэнд, аж амьдрал, эсэн мэнд аж төрөх зэрэгт сөргөөр нөлөөлж байгаа төдийгүй олон мянган хүн эдгээр сөрөг нөлөөллийг даван туулахын тулд нутаг усаа орхин нүүж шилжихэд хүрч байна. Монгол Улсын Засгийн газраас нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах зорилтоо ахиулан шинэчилж дэвшүүлсэн

хэдий ч өнөөгийн хэрэгжүүлж байгаа түүхий нүүрсний татаасын хөтөлбөр нь харин ч эсрэгээр түүхий нүүрсний илүү хэрэглээг дэмжсээр, сэргээгдэх эрчим хүч, ногоон хөгжилд оруулах хөрөнгө оруулалт маш бага түвшинд хэвээр байна. Монгол Улс агаарын болон усны бохирдолд маш ихээр өртөж, ялангуяа хот суурин газрын оршин суугчид, тэр дундаа хүүхэд, эхчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, үүний уршгаар амьсгалын замын болон зүрх судасны өвчлөл нэмэгдэж байна. Түүнчлэн Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990-ээд оноос хойш мал сүргийн тоо толгой нь гурав дахин өсчээ. Ингэснээр бэлчээрийн даац хэтэрч, газрын доройтолд орсон нь мал аж ахуйн менежментийг сайжруулах зайлшгүй шаардлага тулгарч байгааг харуулж байна.

Нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгох талаар ахиц дэвшил гарч байгаа хэдий ч өнөөгийн байдлаар монголчуудын дөрөвний нэгээс илүү хувь нь орлогын ядууралд өртсөн, хүнсний аюулгүй байдал нь алдагдсан хэвээр байна. Түүнчлэн эмзэг бүлгийн хүмүүст боловсрол, эрүүл мэнд, хоол хүнс, ариун цэврийн үйлчилгээ, хүчирхийлэл болон аюулт үйлдлээс хамгаалах үйлчилгээ, төлөөллийн байгууллага, нийтийн дэд бүтцийн үйлчилгээ авах боломж тун хязгаарлагдмал байна. Ядуурал, эмзэг байдал үе дамжин үргэлжлэх хандлагатай болсон нь сэтгэл зовоосон асуудал болж байгаа бөгөөд ялангуяа хүүхдүүд орлогын ядууралд өртөөд зогсохгүй бусад төрлийн гачигдал хомсдлын хүчин зүйлсэд өртсөөр байна. Хяналт төлөвлөлт орхигдсон хотжилт эрс хурдацтай өсч байгаа нь гэр хорооллууд^[1] тэлэх гол шалтгаан болж байгаа төдийгүй ядуурал, эмзэг байдал бүтэц хэлбэрээр үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна. 2015 оноос хойш эдийн засгийн өсөлт эерэг байсан хэдий ч хүн амын дунд хүнс тэжээлийн дутагдал түгээмэл болж, хүнсний аюулгүй байдал алдагдах түвшинд хүрчээ. Монгол Улс нь жендэрийн хөгжлийн үзүүлэлтээрээ бүс нутгийнхнаасаа илүү сайн байгаа ч эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн

1 Нийслэл Улаанбаатар хот болон бусад хот суурин газрын захын хорооллуудад шилжин суурьшигчид илүү олноор ирж суурьших болсон.

түвшин, улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо зэрэг үзүүлэлтээр харьцангуй сул байна. КОВИД-19 цар тахлын уршгаар орлогын болоод эд хөрөнгө, боловсролын үйлчилгээний тэгш бус байдал улам бүр нэмэгдэж, хямралын сөрөг үр дагавар ч цааш удаан үргэлжлэх төлөвтэй байна. Цар тахлын хямралын уршгаар хүүхдүүд, эмэгтэйчүүд, охид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, залуучууд, үндэстний цөөнх, гэр хорооллын оршин суугчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, гадаад орнуудад гацсан албан ёсны бүртгэлгүй цагаач иргэд зэрэг хүн амын бүлгүүд улс орныхоо тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах боломжоор хязгаарлагдаж байгаагийн зэрэгцээ тэд хөгжлийн гадна орхигдох эрсдэл хамгийн өндөр байна.

Улс төр, эдийн засаг, нийгэм, байгаль орчны сорилт бэрхшээлүүд өөр хоорондоо харилцан уялдаатай байгаа нь тогтвортой хөгжилд хүрэх ахиц дэвшлийг түргэсгэхийн тулд олон талт, сайн зохицуулалт хэрэгтэйг харуулж байна. ТХЗ-ыг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны Арван жилийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад тулгарч буй бүтцийн сорилтууд, ядуурал, тэгш бус байдлыг үүсгэж буй язгуур шалтгааныг илүү зоримог, зохистойгоор илрүүлж шийдвэрлэхийн зэрэгцээ нэн эмзэг байгаа хүн амын бүлгүүдийн оролцоог сайтар хангах шаардлагатай байна.

КОВИД-19 цар тахлын дэгдэлтээс улбаалж Монгол Улсын тогтвортой хөгжилд нөлөөлөх сорилт бэрхшээл улам бүр даамжирч, Засгийн газраас эрүүл мэнд, нийгэм-эдийн засгийн яаралтай хариу арга хэмжээг авахын тулд санхүүгийн нөөц боломжоо илүү эрэмбэлэх шаардлага тавигдсан^[2] нь хөгжлийн хөрөнгө оруулалтад зориулсан төсвийн орон зайг эрс хумихад хүргэсэн. Гэсэн хэдий ч энэ нь эдийн засгийг төрөлжүүлэх, цахимжуулах,

бүс нутгийн хамтын ажиллагаа, боловсрол, эрүүл мэндийн салбарын онцгой нөхцөлд бэлэн байх чадавхыг сайжруулах боломжийг бүрдүүлсэн. Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн стратегийн баримт бичгийг баталснаар Монгол Улсын Засгийн газар болон түүний түншлэгч талуудад стратегийн болоод бүх нийтийн оролцоог хангасан хөтөлбөрүүдийг ТХЗ-той уялдуулан, илүү нэгдмэл, зохицуулалттайгаар санхүүгийн хангалттай нөөц, хяналтын механизм бүрдүүлэн хэрэгжүүлэх хүрээг тогтоож өгсөн. ТХЗ-ыг хэрхэн амжилттай хэрэгжүүлэх нь засаглалыг сайжруулах, батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх институтийн чадавхыг бэхжүүлэх, хэнийг ч орхигдуулахгүй байх, Засгийн газрын бүх шатны байгууллага, УИХ-ын гишүүд, хувийн хэвшил, иргэний нийгэм, ажилтан, ажил олгогчдын байгууллага, хөгжлийн түншүүд, бусад талууд зэрэг холбогдох бүх талуудын оролцоог хангах, улмаар Монгол Улсын хөгжлийн чиг шугам тогтвортой бөгөөд хэнийг ч орхигдуулахгүй байх үндсэн амлалтаа хэрхэн биелүүлэхээс ихээхэн хамаарна.

2 Ерөнхийдөө, хямралын үед хүний эрхийг хангах, нийгмийн хамгааллын чиглэлд оруулсан хөрөнгө оруулалт нь эдийн засаг буцаж сэргэх бат бөх суурийг бүрдүүлж, тогтвортой хөгжилд тулгарах сорилтуудыг даван туулахад тусална. Тухайлбал, нийгмийн хамгааллын бодлогод зориулсан ДНБ-ний 1%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтын ДНБ-д үзүүлэх үржүүлэгч нөлөө 0.7-1.9 байж болохыг найман орны судалгаа харуулж байна. Хөгжлийн гарц 2021, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТҮҮНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ.



УДИРТГАЛ



Монгол Улсад Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2017-2021 онд үзүүлэх Хөгжлийн тусламжийн хүрээний хэрэгжих хугацааг КОВИД-19 цар тахлын улмаас Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Монгол Улс дахь Удирдлагын багаас гаргасан хүсэлтийн дагуу 2022 оныг дуустал сунгасан билээ. 2023-2027 оныг хамарсан НҮБ-ын Тогтвортой хөгжлийн төлөөх хамтын ажиллагааны шинэ хүрээг (ТХХАХ) 2021 оны эцэс, 2022 оны эхээр боловсруулж дуусгахаар ажиллаж байна. НҮБ-ын Удирдлагын багаас Монгол Улс дахь НҮБ-ын хөгжлийн системийн байгууллагуудад зориулан нэгдмэл дүн шинжилгээний арга зүйн үндэс болох шинэ үеийн Хөгжлийн төлөв байдлын шинжилгээг (ХТБШ) санаачилж хийлээ. Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын багийн зүгээс энэхүү ХТБШ-г боловсруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Монгол Улсад суурин байгаа болон суурин бус НҮБ-ын системийн төрөлжсөн байгууллагуудын ахлах мэргэжилтнүүдийн төлөөллөөс бүрдсэн Байгууллага дундын Ажлын хэсэг (Хавсралт 1)-ийг байгуулж ажилласан. Тус ажлын хэсэг нь суурин байгаа болон суурин бус НҮБ-ын системийн байгууллагуудаас холбогдох суурь судалгаа, баримт бичиг, тоо мэдээллийг цуглуулж баримтын судалгаа хийх, ХТБШ-ний холбогдох бүлгүүдэд тус тусын хариуцсан асуудлаар хувь нэмрээ оруулах, бодитой нотолгоо бүхий санал, дүгнэлт гаргах, дүн шинжилгээ хийхэд хамтранажиллах, зөвлөмжийн төсөлбэлтгэх, НҮБ-ын систем дэх мэргэжилтнүүдийн үр дүнтэй бөгөөд идэвхтэй оролцоог хангах зэргээр ажилласан. Энэхүү ХТБШ-ний эцсийн хувилбарыг НҮБ-ын системийн байгууллагууд дундын Ажлын хэсэг, НҮБ-ын Удирдлагын баг, суурин болон суурин бус НҮБ-ын системийн байгууллагуудын дунд зохион байгуулсан хэд хэдэн удаагийн өргөн хүрээтэй зөвлөлдөх уулзалт,

хэлэлцүүлгүүд дээр хэлэлцэж гарсан санал зөвлөмжүүдийг тусгасан болно. Хүний эрхэд суурилсан хандлага, жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, эрсдлийг даван туулах чадавхыг бэхжүүлэх, хариуцлагатай байх, тогтвортой байдал, хэнийг ч орхигдуулахгүй байх зэрэг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн төлөөх Хамтын ажиллагааны хүрээний удирдах зарчмуудыг мөрдлөгө болгон энэхүү ХТБШ-г боловсруулсан.

Ингэхдээ НҮБ-ын байгууллагуудын стратегийн баримт бичгүүд, тус улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтын талаарх тайлан мэдээлэл, үндэсний хөгжлийн стратегийн баримт бичгүүд, олон улсын байгууллагуудын хэвлэл нийтлэлүүд гэх зэрэг олон төрлийн эх сурвалжийн үнэлэлт дүгнэлтэд суурилсан болно. НҮБ-ын Удирдлагын баг түүнчлэн Дэлхийн банк (ДБ) болон Азийн хөгжлийн банк (АХБ)-ны зүгээс ирэх жилүүдэд тус улсыг дэмжихээр дэвшүүлж буй стратеги төлөвлөгөөтэй танилцан зөвлөлдөж энэхүү баримт бичгийн холбогдох хэсгүүдэд, ялангуяа, оролцогч талууд, түншлэлийн талаарх дүн шинжилгээнд тусгасан болно. Түүнчлэн Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэд, судлаачид, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, малчид, орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулж 2020 оны 7-9 дүгээр сард НҮБ-ын 75 жилийн ойн хүрээнд үндэсний хэмжээнд зохион байгуулсан цуврал хэлэлцүүлгийн үр дүнг мөн ХТБШ-нд тусгасан. Үүний зэрэгцээ ТХЗ-ыг үндэсний хэмжээнд нутагшуулан хэрэгжүүлэх үйлсийг ерөнхийд нь зохицуулж хяналт тавих үүрэг бүхий төрийн байгууллага Үндэсний хөгжлийн газар (ҮХГ) болон Монгол Улсад ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд шаардагдах тоо мэдээллийн санг бүрдүүлэх үүрэг бүхий

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) зэрэг төр, засгийн гол түнш байгууллагуудтай виртуал зөвлөгөөн хийж хамтран ажилласан. ХТБШ-г хийх явцад олон улсын санхүүгийн байгууллагууд (ОУСБ) болон бусад хөгжлийн түнш байгууллагуудаас гаргасан тайлан, судалгааны материалуудыг өргөн хэмжээнд судалсан. НҮБ-ын Удирдлагын багийн Мэдээлэл, судалгаа шинжилгээний сан (Data and Analysis Repository) байгуулах нь ХТБШ-г хийх нэг гол зорилго байсан. Ийм санг байгуулснаар тогтмол бөгөөд илүү олон давтамжтайгаар шинжилгээ судалгааны ажил, нийтлэл гаргах мэдээллийн эх сурвалжтай болохын зэрэгцээ улс орны шинэ хэрэгцээ үүсэх, нөхцөл байдал өөрчлөгдөх үед нэн даруй хариу арга хэмжээ авахад шаардагдах мэдээлэл нотолгоо бэлэн байх боломж бүрдэж байгаа юм.

Шинэ үеийн энэхүү ХТБШ-г хийхдээ ТХЗ-ын өөр хоорондоо харилцан уялдсан нэгдмэл шинж, тэдгээрийн чиг хандлага, эрсдэл, боломж, хэрэгжүүлэхэд тулгарах сорилт, бэрхшээл зэрэг гол асуудлыг нарийвчлан шинжилсэн. Эдгээр асуудалд дүн шинжилгээ хийхдээ эдийн засаг, нийгэм, байгаль орчин, засаглал зэрэг тогтвортой хөгжлийн шийдвэрлэх дөрвөн чиглэлийн хүрээнд ажилласан. Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын багийн зүгээс ХТБШ-г бэлтгэх явцад эн тэргүүнд анхаарал хандуулах шаардлагатай есөн эмзэг бүлгийг тодорхойлж, улмаар тэдэнд тулгарч буй сорилт бэрхшээлүүд, тэднийг эмзэг болгож буй үндсэн шалтгааныг тодорхойлох зорилгоор эмзэг бүлгийн долоон бүлэг хүмүүсийг сонгож фокус бүлгийн ярилцлага зохион байгуулсан. Эмзэг бүлгийн хүмүүстэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагын дэлгэрэнгүй тайланг Хавсралт 2-т оруулсан. Бодлогын зорилт, түүний хэрэгжилтийн уялдаа холбоогүй байгаа байдал, ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого төлөвлөлт, төсвийн төлөвлөгөө өөр хоорондоо уялдахгүй байгаа зэрэгт хүргэж буй бүтцийн болоод тулгарч буй саад бэрхшээлийн нарийн учир шалтгааныг тодорхойлох зорилгыг НҮБ-ын Удирдлагын Баг тавьсан. ХТБШ-ний хүрээнд тус улсын санхүүжилтийн тогтолцоог шинжилж үзэхэд Монгол Улс ТХЗ-ыг амжилттай хэрэгжүүлэх

үүрэг амлалтаа биелүүлэхийн тулд хөрөнгө нөөцийг тогтвортой хөгжилд чиглүүлэх хамгийн том боломж байгааг олж тогтоосон. Үүний зэрэгцээ хөгжлийн бүхий л хүрээ, хүмүүнлэгийн болон хүний эрхийн асуудлыг бүхэлд нь хамарсан олон төрлийн эрсдэл тус улсын хөгжлийн замналд тулгарч байгаа нь ХТБШ-гээр илэрч байна. Мөн, ХТБШ-нд оролцогч талуудын өөрсдийн чиг үүргийн хүрээнд хийсэн КОВИД-19 цар тахлын хямрал хүмүүсийн амьдрал, амьжиргаанд хэрхэн нөлөөлсөн талаарх олон тооны судалгаа, үнэлгээ, түүнчлэн НҮБ-ын КОВИД-19 цар тахлын эсрэг Нийгэм, эдийн засгийн хариу арга хэмжээний төлөвлөгөө зэргийг судалж ашигласан.

ХТБШ нь зөвхөн нэг удаагийн ажил биш бөгөөд харин улс орны хөгжлийн үйл явц дахь хувьсал өөрчлөлтийг ажиглан Монгол Улс дахь НҮБ-ын системд мэдээлж байх тасралтгүй үйл явц байх болно. Энэхүү анх удаагийн шинэ үеийн ХТБШ нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн төлөөх Хамтын ажиллагааны шинэ хүрээ (шинэ ТХХАХ)-г бэлтгэх суурь мэдээлэл болох бөгөөд ТХХАХ-ний тэргүүлэх чиглэлүүдийг тогтоох үйл ажиллагааны хүрээнд ХТБШ-ний үр дүнг илүү олон оролцогч талуудыг хамруулан дэлгэрэнгүй танилцуулахаар төлөвлөж байна.


2030 ОН ХҮРТЭЛХ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР БОЛОН МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТ



3.1 ОРХИГДОХ ЭРСДЭЛТЭЙ ХҮН АМЫН БҮЛГҮҮД, ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС

2020 оны байдлаар Монгол Улсын нийт хүн ам 3,357,542^[3]-д хүрсэн бөгөөд тэд 1,566,500 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт амьдарч байна. Тус улс нь дэлхийн хамгийн бага хүн амын нягтралтай орны нэг юм.^[4] Хүн ам нь жигд бусаар тархан суурьшсан. Анх 300,000 гаруй хүн оршин суухаар төлөвлөж байгуулсан нийслэл Улаанбаатар хотноо эдүгээ тус улсын нийт хүн амын бараг тал хувь нь амьдарч байна.^[5] Нийт хүн амын үлдсэн хагас нь хөдөө орон нутагт аж төрж байна. Хүн амын бүтцийг ажиглавал насны бүлэг бүрийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцаа 1:1 байна (Зураг 3.1.1). 1990-ээд оны эдийн засгийн шилжилтийн үед хүн амын төрөлтийн түвшин огцом буурснаас Монгол Улсын хүн ам зүйн бүтцэд ихээхэн өөрчлөлт гарсан бөгөөд төрөөс хүн амын өсөлтийг дэмжих бодлого баримталж эхэлснээр зөвхөн 2005 онд өссөн үзүүлэлттэй байна. Үүний үр дүнд 2020 онд 14 хүртэлх насны хүн ам хамгийн олон буюу нийт хүн амын бараг 32 хувийг бүрдүүлж байгаа бол өнөөгийн 15-24 насныхан ойролцоогоор 15 хувийг бүрдүүлж байна. Монгол Улсын хүн ам гэнэтийн хямралд маш өртөмтгий байна. 2018 он хүртэлх таван жилийн хугацаанд нийт хүн амын 36 хувь нь ямар нэг буюу хэд хэдэн

Зураг 3.1.1: Монгол Улсын Хүн амын бүтэц, насны бүлгээр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2020

төрлийн хямралд давхар өртөж байжээ.^[6] Хүн ам зүйн тэнцвэргүй байдал, газарзүйн байршил, үндэс угсаа, үйлчилгээний хүртээмж, амьжиргааны эх үүсвэр зэрэг нь өөр хоорондоо харилцан нөлөөлж байгаагаас хүн амын тодорхой бүлгүүдэд олон тооны бэрхшээл давхцан тулгарч, Монгол Улсын хувьд хөгжлийн гадна хэнийг ч орхихгүй гэсэн амлалтаа биелүүлэхэд нь хүндрэл учирч байна.


3 Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо. Хүн ам. Үзэх <https://www.1212.mn>
 4 Монгол Улсын Хүн амын нягтрал. Үзэх <https://www.populationpyramid.net/population-density/mongolia/2020/>
 5 АХБ. (2020 оны 6-р дугаар сар). Монгол Улсын Эдийн засгийн хэтийн төлөв. Үзэх <https://www.adb.org/publications/mongolia-economic-prospects>.
 6 Дэлхийн банк. (2020). Бодлогын зөвлөмж: Монгол Улс Хүн капиталд оруулах хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх нь.

Хүн амын хамгийн бага орлоготой 40 хувьд хамрагдаж байгаа, ихэвчлэн хөдөө орон нутагт амьдардаг, боловсрол муутай хүмүүс хөгжлийн үр шимээс орхигдох магадлалтай байна хэмээн НҮБ-ын Ази, номхон далайн бүс нутгийн Эдийн засаг, Нийгмийн Комисс (НҮБАНДЭЗНК)-ын судалгаанд^[7] дүгнэжээ. Түүнчлэн КОВИД-19 цар тахлын эсрэг Нийгэм, эдийн засгийн хариу арга хэмжээний төлөвлөгөө болон 2019 оны Үндэсний сайн дурын илтгэл (ҮСДИ)^[8]-д тодорхойлсон орхигдох эрсдэлтэй хүн амын төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн хэлэлцүүлгийн тайлан зэрэг НҮБ-ын байгууллагуудын хийсэн судалгааны тайлан, баримт бичгүүд, төрийн болон төрийн бус оролцогч талууд, олон улсын хүний эрхийн тайланд хийсэн дүн шинжилгээ, холбогдох зөвлөмжүүд, Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын хяналтын албад (Хавсралт 3)-ын баримт бичиг зэрэг олон төрлийн эх сурвалжийг судалж үзэхэд хүн амын дараах бүлгүүд хөгжлөөс орхигдох эрсдэлтэй байгааг харуулж байна. Тухайлбал,

3.1.1 ХҮҮХЭД, ӨСВӨР НАСНЫХАН

Монгол Улсын ядуу таван хүн тутмын хоёр нь 15-аас доош насны хүүхдүүд байгаа нь ядуурал нь айл өрхийн хүүхдийн тоо, хүн ам зүйн ачаалалтай ихээхэн холбоотой байгаа төдийгүй айл өрхөд хүүхдээ өсгөж тэжээхийн тулд орлого олдог хүмүүс цөөн, улмаар хүний нөөц бүрдэх хэтийн төлөв алдагдаж байгааг харуулж байна. Орлогын ядуурлаас гадна өөр олон хэлбэрээр хүүхдүүд гачигдалд (child deprivation) орох тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, тэд мэдээллийн хүртээмж, орон сууц, ариун цэврийн байгууламж, бага насны хүүхдийн боловсрол зэрэг үйлчилгээг авч чадахгүй гачигдаж байна. Хүүхдийн гачигдлын түвшин ялангуяа хөдөөгийн хүүхдүүдийн дунд хамгийн өндөр байна (Зураг 3.1.2). Барагцаалбал, гурван хүүхэд тутмын хоёр нь хамгийн багадаа гурван үзүүлэлтээр

Зураг 3.1.2: 0-17 насны хүүхдүүдийн гачигдлын түвшин, үзүүлэлтийн төрөл, байршлаар, %



Эх сурвалж: ХНХЯ, НҮБ-ын Хүүхдийн сан. Монгол Улс дахь Хүүхдийн олон хэмжээст, хавсарсан гачигдлын шинжилгээ, 2021

гачигдалд орж байгаа нь амьжиргааны түвшин, оршин суугаа байршлаар ихээхэн ялгаатай байна. Хамгийн ядуу бүлгийн өрхүүдэд амьдарч байгаа хүүхдүүд 4.3 үзүүлэлтээр гачигдалд орж байгаа бол хөдөө орон нутагт амьдарч байгаа хүүхдүүд 3.8 үзүүлэлтээр гачигдалд орж байна.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2013 оноос хойш өөрлөгдөөгүй 17 хувь хэвээр байна. Хүүхдүүд хөдөө аж ахуй, уул уурхай, барилга, хурдан морины уралдаан зэрэг аюул, осолтой хөдөлмөр хийсээр байгаа нь улам ноцтой асуудал болж байна. Ялангуяа хурдан морь унаач хүүхдүүд морьдын эздийн зүгээс үзүүлэх бие махбодийн болоод сэтгэл санааны дарамтад өртөх, сургууль завсардах, бэртэж гэмтэх, амь насаа алдах зэрэг эрсдэлд өртөж байна. Хүүхдийг хурдан морь унаач болгох асуудал үндэсний өв соёлоо

7 НҮБАНДЭЗНК. (2021). Монгол Улс: Орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд. *Нийгмийн хөгжлийн бодлогын товчоон*. Үзэх <https://www.unescap.org/resources/leaving-no-one-behind-in-ob-country>

8 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газар. (2019). *Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл*. Үзэх <https://sustainabledevelopment.un.org/memberstates/mongolia>

уламжлан хадгалах гэхээс илүүтэйгээр эцэг, эх, уяачдын мөнгө санхүүгийн ашиг сонирхлын асуудал болж байгаа нь орон нутгийн эрх баригчидтай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас ажиглагдаж байна. Цаашид энэ асуудлаар эцэг, эх, уяачдын зүгээс хүлээх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавих шаардлагатай байна. Үндэсний хууль тогтоомжоос 2017 онд хасагдсан 16 хүртэлх насны хүүхдийг хурдан морины уралдаанд морь унуулахыг хориглосон тухай заалтыг дахин баталж мөрдөхийг НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос зөвлөмж болгосон.^{9]} Өсвөр насны хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас үзэхэд КОВИД-19 цар тахлын улмаас сургуулиуд хаагдаж цахим сургалтад шилжих үеэр хөдөө орон нутагт амьдардаг олон мянган өсвөр насныхан мал маллах ажилд туслахаас гадна барилгын талбарт ажиллаж, худалдаа үйлчилгээний ажил хийж байхдаа хичээлийн даалгавраа цаг тухайд нь хийж амжихгүй байх, хичээлээ таслах, ялангуяа барилгын талбарт туслах ажил хийж байсан хөвгүүд хөдөлмөрийн аюултай нөхцөлд хүнд ажил хийж байхдаа бэртэж гэмтэх зэрэг олон тохиолдлууд гарч байжээ.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл 2020 онд эрс нэмэгджээ. Хүүхдийн тусламжийн утсанд гутаан доромжлох, хуурч мэхлэх, хүчирхийлэх, үл тоомсорлох зэрэг хүүхэд хамгааллын эрх зөрчигдсөн тухай мэдээлэл ирэх нь эрс нэмэгджээ. Тухайлбал, тохиолдлын (кейс) удирдлагын үйлчилгээ шаардлагатай болсон тохиолдлын тоо 2017 онд 3407 байсан бол 2020 онд 9192 болж нэмэгдсэн байна. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон болон тусламж эрэлхийлж Нэг цэгийн үйлчилгээний төв болон хамгаалах байруудад ирсэн нийт хүний тоо 2019 онд 1875 байсан бол 2020 онд нийт 3472 хүн болж нэмэгдсэн бөгөөд тэдгээрийн 2019 нь хүүхэд байжээ. Эцэг эхийн хараа хяналтгүй 1000 орчим хүүхэд одоогоор асрамжийн газруудад амьдарч

байна. Түүнчлэн, бусад олон тохиолдлуудыг хүүхэд хамгааллын хамтарсан багууд, хүүхэд, аймаг, дүүргийн гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагууд, эрүүл мэндийн байгууллага, сургуулиуд түүгээрээ мэдээлж, илрүүлж, шийдвэрлэж байна. Засгийн газраас хүүхэд хамгааллын орчныг бэхжүүлэх талаар хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч хүүхэд хамгааллыг илүү сайжруулахын тулд нийгмийн хамгаалал, хууль эрх зүй, эрүүл мэнд, боловсролын хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээг тасралтгүй явуулахад шаардагдах хууль тогтоомж, практик үйл ажиллагааг зохих түвшинд хүргэх, хүүхэд хамгааллын нийгмийн үйлчилгээний боловсон хүчнийг бэхжүүлэх, улмаар нийгмийн ажлын хяналт, тусгай зөвшөөрөл олгох журмыг албажуулах, тохиолдлын удирдлага, лавлагааны тогтолцоог нэвтрүүлэх нэн шаардлагатай болж байна. Энэ нь КОВИД-19 цар тахлын үед сургуулиуд хаагдсаны улмаас хүүхдүүд гэртээ удаан хугацаагаар байсантай холбоотой төдийгүй эцэг эх, хүүхдийн хоорондын харилцаанд илүү их асуудал үүсч байгаа нь ажиглагдаж байна. Архи согтууруулах ундааны хор хөнөөлтэй хэрэглээ нь хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл зэрэг бүх төрлийн хүн хоорондын хүчирхийллийн эрсдэлт хүчин зүйл болж байгаа тул архи согтууруулах ундааны хүртээмжийг хязгаарлаж, үнийг нь нэмэгдүүлэх замаар хүн амын архины хэрэглээг бууруулах, хүүхэд хамгааллын үйлчилгээ болон архины эмчилгээний үйлчилгээ хоорондын уялдааг сайжруулах замаар хүчирхийллийг бууруулах үр дүнтэй стратеги, арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Түүнчлэн, хүүхэд залуучуудын цахим орчин дахь ихэнх цагаа өнгөрүүлдэг, мөн бэлгийн зүй бус агуулгатай контент үзэх, бэлгийн өдөөн хатгалга зэрэгт өртөх өндөр эрсдэлтэй гэгдэх нийгмийн сүлжээнд хүүхэд хамгааллын зөрчил хамгийн түгээмэл байна. Өнөөгийн байдлаар Монгол Улс фэйсбүүк нээсэн хаягийн тоогоор Ази тивд нэгдүгээрт,

9 НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо. (75-р хуралдаан, 2017, Женев). *Монгол Улсын 5-р тайланд өгсөн дүгнэлт зөвлөмж CRC/C/MNG/CO/5 (CRC 2017).*

Зураг 3.1.3: Хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас



дэлхийд 49 дүгээр байрт бичигдэж байна. Энэ нь цөөн хүн амтай Монгол Улсын хувьд маш түгшүүртэй тоо юм.^[10] Өсөн нэмэгдэж буй эрсдэлтэй тохиолдлуудын хохирлыг ихэнхдээ хүүхдүүд өөрсдөө үүрч байна. Тэд эцэг эх, мэргэжлийн хүмүүсээс ч дутуугүй эрсдэлийн талаар ойлгож байгаа хэдий ч айж ичих, өөрсдийнх нь үзэл бодлыг үл тоомсорлохоос болгоомжлон ам нээх дургүй байдаг аж. Эцэг эхчүүд цахим болон цахим бус харилцаа, тэдгээртэй холбоотой эрсдэл, тухайлбал, ангуучлал, хууран мэхлэлтийн бусад хэлбэрийн талаар хангалттай сайн мэдлэггүй байна. Хүүхдийн дижитал технологийн хэрэглээ болон дижитал технологийг зүй бусаар ашиглаж хүүхдийн эрхэнд халдах зэрэгтэй холбоотой эрсдэл, хор уршгийг арилгахын тулд засгийн газар, салбарууд, эцэг эх, бусад асран хамгаалагчид, сурган хүмүүжүүлэгчид, хүүхэд, залуучуудын дунд Хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, гутаан доромжлох (CSEA)-той тэмцэх талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулах шаардлагатай.

Хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, гутаан доромжлох (CSEA)-той холбоотой шинээр гарч байгаа гэмт хэргүүдийг мөрдөн байцаах, яллах асуудал зарим тохиолдолд хууль сахиулах байгууллага, прокурорт танил тал байхгүйгээс болж сарнин удааширч байна. Дижитал криминалистикийн чадавх сул, мэдээлэл хадгалах, хамгаалах эрх зүйн үндэслэл дутмаг байгаа нь хууль сахиулах ажилд тулгарч буй томоохон сорилт болж байна.^[11]

Боловсролын чанар анхан шатнаасаа эхлээд салбарын хэмжээнд сүүлийн хэдэн арван жилийн турш хамгийн тулгамдсан асуудал болж байна. 2018 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар 2, 3 дугаар ангид суралцаж буй охид, хөвгүүдийн дөнгөж 33 хувь нь тоо бодох суурь мэдлэгтэй байсан бол 44 хувь нь унших суурь чадвартай болсон байжээ. Харин үндэстний цөөнхийн хүүхдүүдийн дунд энэ нөхцөл байдал улам дор түвшинд байсан бөгөөд энэ бүлгийн хүүхдүүд ихэвчлэн анхаарлын гадна орхигдох

10 Монгол Улс дахь НҮБХС. (2019). Нөхцөл байдлын шинжилгээ: Монголын Өсвөр үеийнхний цогц хөгжлийг ойлгох нь. х. 109

11 Монгол Улс дахь НҮБХС. (2019). Хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, гутаан доромжлолын эрсдэл, хариу арга хэмжээний талаарх нөхцөл байдлын шинжилгээ.

хандлагатай байна.^[12] Зайны сургалтын явцад алслагдсан нутгийн малчин өрхийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, эцэг эхийн хараа хяналт сул хүүхдүүд хоцрох эрсдэл хамгийн өндөр байна.^[13]

Хүүхдийн хөгжилд маш чухал болох сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд чинээлэг болон ядуу өрхийн хүүхдүүдийн хамрагдалт ихээхэн ялгаатай байгаа бөгөөд хамгийн ядуу бүлгийн өрхийн хүүхдүүдийн 48 хувь, хамгийн чинээлэг бүлгийн өрхийн хүүхдүүдийн 69 хувь нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. Мөн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүрэлцээ бодит эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байна. Тухайлбал, 2018 онд 2-6 насны 405 мянга орчим хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын нийт 1435 байгууллага 7843 багштайгаар үйлчилгээ үзүүлж байсан бөгөөд нэг багшид 52 орчим хүүхэд ногдож байв.^[14] Нүүдлийн буюу бэлчээрийн мал аж ахуй эрхэлж буй айл өрхийн хүүхдүүд нийгэм, соёл, эдийн засгийн олон хүчин зүйлээс шалтгаалж чанартай боловсрол эзэмших боломжгүй байна.^[15]

3.1.2 ЭМЭГТЭЙЧҮҮД, ОХИД

Хоёр эмэгтэй тутмын нэг нь амьдралдаа хамгийн багадаа нэг удаа жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөж байсан бол гурван эмэгтэй тутмын нэг нь судалгаа авахын өмнөх жилд хүчирхийлэлд өртөж байжээ.^[16] КОВИД-19 цар тахлаас сэргийлж тогтоосон хөл хорионы үед жендэрт суурилсан хүчирхийлэл мэдэгдэхүйц нэмэгдэж ноцтой байдалд хүрсэн байна. 2020 оны эхний хагаст гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол 2019 оны мөн үетэй харьцуулахад 30 хувиар өсчээ.^[17] Энэ нь ялангуяа гэр бүлийн

хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн ноцтой гэмт хэргийн тоо 2019 онтой харьцуулахад 2020 онд 15.5 хувиар өссөнтэй холбоотой. Бүртгэгдсэн хөнгөвтөр гэмт хэргийн тоо буурсан мэт байгаа нь хатуу хөл хорионы үеэр хүчирхийлэгчтэй хамт байхаас өөр аргагүйд хүрч байсан учир гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол бүрийг тухай бүрт нь цагдаагийн байгууллагад мэдээлэх боломж хохирогчдод хязгаарлагдмал байсантай холбоотой. Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээс үзэхэд гэр бүлийн хүчирхийллийн шинж байдал улам хүндэрч, эмэгтэйчүүд өөрийгөө болон хамтрагчаа хохироох шинэ хэлбэр бий болж байна. Монгол Улс 2017 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг баталсан хэдий ч Засгийн газраас тус хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийг хангалттай төсөвлөөгүй байна.^[18] НҮБ-ын Хүн амын сан (НҮБХАС)-гийн судалгаагаар дотны хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн улмаас Монгол Улс жилд 601.2 тэрбум төгрөгтэй дүйцэх хэмжээний хохирол амсдаг аж. Дотны хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртсөн хүмүүс ажлаа таслах, бие махбодийн болон сэтгэл зүйн зовлон дарамтад ордог нь тэдний ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлдөг учир тэд хүчирхийлэлд өртөөгүй хүмүүсээс даруй 35 хувиар бага цалин авч байгаа тооцоо байна. Энэ нь хүчирхийллийн улмаас эдийн засагт гарч буй бүтээмжийн мэдэгдэхүйц алдагдал буюу 540.65 тэрбум төгрөгтэй дүйцэхээр, мөн 2020 оны ДНБ-ний 1.68 хувьтай тэнцэхээр тооцоо гарчээ.^[19] Түүнчлэн ажлын байран дахь дарамт, хүчирхийллийн тохиолдол цөөнгүй гарч байгаа нь хөдөлмөрийн хууль сахиулах үйл ажиллагааг дорвитой сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.

12 Монгол Улс дахь НҮБХС. *Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018 – Инфографик.*

13 Монгол Улс дахь НҮБХС. (2020.) *Теле хичээлийн үр нөлөөний үнэлгээ.*

14 Дэлхийн банк. (2020.) *Бодлогын зөвлөмж: Монгол Улс дахь Хүн капиталд оруулах хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх нь.*

15 НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан соёлын байгууллага (НҮББШУСБ). (2019). *Дэлхийн боловсролын хяналт шинжилгээний тайлан - Монгол Улсын Кейс судалгаа - Үүсч буй боловсролын хэрэгцээ, малчид, бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн бодит байдал.* Үзэх <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000266056>; НҮББШУСБ. (2019). *Дэлхийн боловсролын хяналт шинжилгээний тайлан.* Үзэх <https://en.unesco.org/gem-report/report/2019/migration>

16 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, НҮБХАС. (2017 оны 6 дугаар сар). *Жендэрт суурилсан хүчирхийллийн анхны судалгаа – 2017.*

17 НҮБХС. (2020). *Өрх гэр, ажлын байр, олон нийтийн газарт жендэрт суурилсан хүчирхийллийг цэглэе: Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян.* Үзэх <https://www.unicef.org/mongolia/press-releases/gender-based-violence>

18 ТХЗ-ын хэрэгжилтийн талаарх Иргэний нийгмийн байгууллагуудын нэгдсэн тайлан, үзүүлэлт 16.2.2. Үзэх <https://action4sd.org/>

19 НҮБХАС. (2020). *Дотны хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн эдийн засгийн өртөг, зардлын судалгаа.*

Зураг 3.1.4: Эмэгтэйчүүдийн фокус бүлгийн ярилцлагаас



Залуу эмэгтэйчүүд, охид нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалтай тулгарч байна. Өсвөр насны охидын төрөлтийн түвшин (15-19 насны 1000 эмэгтэйд ногдох төрөлт) 2019 онд^[20] 31-д хүрсэн нь Европын орнуудынхаас бараг 3 дахин өндөр байна. Төв болон зүүн бүсийн аймгуудад энэ үзүүлэлт өндөр байгаа буюу өсвөр насны 1000 охид тутмын 51 (Төвийн бүс) болон 89 (Зүүн бүс) нь хүүхэд төрүүлжээ. Үүнийг улсын дундаж болох 23 хувьтай харьцуулахад энэ насныхны дунд гэр бүл төлөвлөлтийн талаарх хэрэгцээ шаардлага маш өндөр (32 хувь) байгаа болон бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг сул байгаатай холбоотой гэж үзэж болох юм. Аймгууд дахь орон нутгийн

хүний эрхийн байгууллагууд эсэргүүцэл илэрхийлж байгаа хэдий ч сургууль, дотуур байранд охидыг бэлгийн эрүүл мэндийн үзлэгт заавал хамруулах ажил зохион байгуулагдсан хэвээр байна. Гэрлэсэн, бэлгийн харилцаанд орсон байдлыг авч үзэхэд 20-24 насны эмэгтэйчүүд болон 18 хүртэлх насны охидын аль алины хувийн жин нэмэгдэж байгаа бөгөөд эрт гэрлэлтийн түвшин 2013 онд 5.2 хувь байсан бол 2018 онд 12 хувь болж өссөн байна. Залуучуудын бараг 80 хувь нь Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ)-ийн халдварын талаарх ойлголт муутай байна.^[21]

Монгол Улс жендэрийн хөгжлийн индексийн үзүүлэлтээр Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудынхаас илүү сайн буюу насанд

20 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. (2020). Орлого, зарлагын тэгш бус байдлаас үүсэх эрсдэл, Үндэсний статистикийн хороо.

21 Мөн тэнд.

хүрсэн эмэгтэйчүүдийн 91.5 хувь нь бүрэн дундаас дээш боловсрол эзэмшсэн байгаа аж. Эрэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт 86.1 хувь байна. Харин эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс (68.3 хувь) бага буюу 53.4 хувь байна.^[22] Ялангуяа хөдөөгийн малчин өрхийн хөвгүүд гэр бүлийнхээ санхүүд дэмжлэг үзүүлэх үүднээс сургуулиас эрт гарч мал аж ахуйн ажилд оролцож эхэлж байгаа бол охид үргэлжлүүлэн суралцаж арай илүү боловсрол эзэмшиж байна. Гэсэн хэдий ч хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн (15 болон түүнээс дээш насны) 46.7 хувь нь эдийн засгийн идэвхгүй хэвээр байгаа бөгөөд сүүлийн 10 жилд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин бараг сайжирч өөрчлөгдөөгүй байна.^[23] Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцооны түвшин төдийлэн сайжрахгүй байгаад нэг талаас өрхийн болон зах зээлийн ажил үүргийн хуваарилалт нөлөөлж байж болох юм. Тухайлбал, Монгол эмэгтэйчүүд хүүхдүүдээ асран хүмүүжүүлэх үндсэн үүрэг хүлээхээс гадна гэр орныхоо бусад ажлыг ч хариуцан гүйцэтгэх өрхийн гол гишүүн юм. Гэр орны ажил үүрэгтэй холбоотой жендэрийн энэхүү тогтсон хэм хэмжээ нь хөдөлмөрийн зах зээлийн харилцаанд эмэгтэйчүүдийн зарцуулах цаг хугацааг багасгаж, тэдний оролцож болох хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагааны төрөлд ч нөлөөлдөг аж. Чинээлэг өрхийн эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлд оролцох магадлал өндөр байгаа нь зарим талаараа тэд хүүхэд асрах үйлчилгээний зардлыг төлөх чадвартайгаас гадна илүү өндөр боловсрол, ур чадвар эзэмшиж тэр хирээрээ илүү өндөр цалинтай ажилд орж хөдөлмөрийн зах зээлийн шаардлагыг хангаж чадаж байгаатай холбоотой юм. Үүний нэгэн адил хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд хөдөө аж ахуйн ажил хийхийн зэрэгцээ гэр орныхоо үүрэг хариуцлагыг хавсран гүйцэтгэх

боломжтой байгаа учир тэдний хөдөлмөр оролцооны түвшин өндөр байна. Эсрэгээрээ, үйлдвэр, үйлчилгээний салбар давамгайлсан, ажлын байр нь ихэвчлэн гэрээс нь зайтай байдаг хот суурин газрын эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны түвшин бага байгаа нь зарим талаар тэд үндсэн ажлынхаа хажуугаар гэр орныхоо үүрэг хариуцлагыг давхар гүйцэтгэхэд амаргүй байдагтай холбоотой.^[24]

КОВИД-19 цар тахлын уршгаар олон салбарт ажлын байрны хомсдол үүсч ажиллах хүчний оролцооны түвшин сүүлийн арван жилийн хамгийн доод түвшинд хүрч буурсан (Зураг 3.1.5) нь ялангуяа эмэгтэйчүүдэд маш хүндээр туссан байна. Эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс илүү хурдацтай өсчээ (Зураг 3.1.6). Цэцэрлэг, сургуулиуд хаагдсанаар гэр бүл, үр хүүхдүүдээ асран халамжлах үүрэг нэмэгдсэнээр илүү олон эмэгтэйчүүд ажиллах хүчний эгнээг орхисны улмаас ажил идэвхтэй хайж буй эмэгтэйчүүдийн тоо ч эрс буурсан аж.^[25] КОВИД-19 цар тахлаас сэргийлж 2020 оны 11-р сараас хойш дараалан тогтоосон хөл хорионууд албан бус хөдөлмөр эрхлэгчид, жижиг бизнес эрхлэгчдэд маш хүн цохилт болжээ. Ялангуяа цэцэрлэг, сургууль хаагдсаны улмаас бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд цалин хөлсгүй гэрийн ажил, халамж асаргааны дарамт нэмэгдсэний зэрэгцээ хүүхдүүд нь бие даан гэртээ үлдэх, том нь дүү нараа асран халамжлах, зарим нь эцэг эхдээ бараа бүтээгдэхүүн савалж бооход туслах зэргээр ажиллаж байсныг судалгаанд тэмдэглэсэн байна.^[26] Мөн Монгол Улсын эрүүл мэндийн салбарын нийт ажиллагсдын 82 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа бөгөөд тэд болон тэдний гэр бүлийн гишүүд КОВИД-19 цар тахлын халдварт өртөх эрсдэл хамгийн өндөр байна.^[27]

22 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. (2019). *Мэдээлэл*. Үзэх 1212.mn

23 Дэлхийн банк, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. (2018). *Ядуурлын дүр төрх*.

24 *Мөн тэнд*.

25 Дэлхийн банк. (2021 оны 2-р дугаар сар). *Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал*.


26 Азийн сан. (2021). *Монголын бичил болон жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд КОВИД-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ*.

27 НҮБХХ / АХБ. (2021 оны 3 дугаар сар). *Монгол Улсад КОВИД-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа*. Үзэх <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/-covid-19-impact-onwomenand-girls-in-mongolia--study.html>

Зураг 3.1.5: Хөдөлмөр эрхлэлтэд гарсан өөрчлөлт (IIIY 2020/IIIY 2019, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, %)



Зураг 3.1.6: Ажилгүйдлийн түвшин, хүйсээр



Эх сурвалж: Дэлхийн банк, Монгол Улсын Эдийн засгийн төлөв байдал, 2021 оны 2-сар

Үндсэндээ Монгол Улс нь жендэрийн хувьсал өөрчлөлтийн өвөрмөц түүхтэй бөгөөд өнөөгийн жендэрийн хэм хэмжээг нүүдэлчдийн соёл иргэншил, орчин үеийн төлөв хандлагын цогц харилцан үйлчлэлийн үр дүн хэмээн ойлгох боломжтой. Эцгийн эрхт ёс ноёлсон нүүдэлчдийн соёл иргэншлийн үед эрэгтэйчүүд гол баялаг болох мал сүргээ эзэмших, захиран зарцуулах эрх үүрэгтэй байсан бол эмэгтэйчүүд нь гэр бүл, үр удмаа асран хүмүүжүүлэх үндсэн үүрэг хүлээж байсан аж. Ийм хэм хэмжээ нь одоо ч гэсэн хүмүүсийн дунд тодорхой орон зай эзэлсэн хэвээр байна. Гэхдээ социализмын үеийн болон түүний дараах үеийн төрийн бодлогоор жендэрийн тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн шинэ тунхаглалыг бий болгосон байна. Боловсрол эзэмшсэнээр эмэгтэйчүүдийн өмнө албан ёсоор хөдөлмөр эрхлэх зам нээгдэж улмаар олон нийтийн дунд тэд нийгэм, эдийн засгийн тодорхой байр суурь эзлэх болсон байна. Гэтэл уламжлагдаж ирсэн жендэрийн хэм хэмжээ нь хэзээ ч ийм сорилтод хүргэж байгаагүй. Энэ нь охид, эмэгтэйчүүдэд давхар ачаалал бий болоход хүргэж, мөн гэр бүлийн хүрээнд эрчүүдийг

ч эмзэг байдалд ороход хүргэх болжээ.^[28] Үндэсний статистикийн мэдээллээр ганц бие эцэг, эхийн тэргүүлсэн нийт 86,525 өрхийн 70,304 (82 хувь) нь эмэгтэй өрхийн тэргүүнтэй байгаа бол үлдсэн 16,221 (18 хувь) нь эрэгтэй өрхийн тэргүүнтэй байна.^[29]

3.1.3 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮС

Монгол Улсад нийт 106,400 гаруй (2020) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байгаагийн 55.4 хувь нь эрэгтэй, 44.6 хувь нь эмэгтэйчүүд^[30] бөгөөд тэд хүн амын хамгийн ихээр ялгаварлагдсан эмзэг бүлэг болсон хэвээр байна. 2000 оны Хүн амын тооллогоор төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний тоо 13.9 мянгаар буюу 37.7 хувиар өссөн байна. Энэ нь нэг талаас хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт сайжирсантай холбоотой гэж үзэж болох ч сүүлийн 10 жилийн хугацаанд агаар, орчны бохирдол болон бусад хүчин зүйлээс шалтгаалж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд олноор төрж байгааг илэрхийлж байж болох талтай.


Монголын нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс алагчлагдан гадуурхагдсан хэвээр

28 Монгол Улс дахь НҮБХС. (2020). Гэр бүл, эцгүүд: Жендэрийн шинэ хандлага.

29 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. Үзэх <https://www.1212.mn>

30 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. (2020). Хүн амын тоо. Үзэх <https://www.1212.mn>

Зураг 3.1.7: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн фокус бүлгийн ярилцлагаас



байгаад дараах нөхцөл нөлөөлж байж болзошгүй юм. Тухайлбал, а). Азийн олон оронд нийтлэг тохиолддог хөгжлийн бэрхшээлийн талаарх соёлын сөрөг ойлголт болоод шашин шүтлэгийн итгэл үнэмшил, б). хөгжлийн бэрхшээлийн бүх хэлбэрийг эргэлзээтэй болгоход хүргэдэг гэмтэл согогийн талаарх анагаах ухааны яриа таниулга нь эмчлэгдэхгүй л бол хөдөлмөрийн чадвар, аж байдал нь бүрмөсөн доройтно хэмээх үзэл бодлыг төрүүлж байж болзошгүй юм. Нийгмийн гадуурхлын ийм хэм хэмжээнээс болж хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн бусдаас ичиж бэрэгшээх мэдрэмж улам бүр

хурцдаж, ялангуяа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ, "хамгаалах", "нуух" зорилгоор гэрээс гаргахгүй байлгахыг илүүд үзэхэд хүргэж байна. Цаашилбал, хөгжлийн бэрхшээл нь жендэрийн эрсдэл, эмзэг байдлыг ч өдөөх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртөх, үндсэн эрх чөлөө нь үгүйсгэгдэх, нийгмийн үйлчилгээ авах боломж нь хязгаарлагдах зэрэг эрсдэлд өртөж байна.^[31]

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр насныхан ихэнх тохиолдолд орчны саад

31 Монгол Улс дахь НҮБХС. (2019). Нөхцөл байдлын шинжилгээ: Монголын Өсвөр үеийнхний цогц хөгжлийг ойлгох нь.

бэрхшээлээс болж сургуульд сурч чадахгүй байна.^[32] Судалгаанаас харахад гэр, сургууль хоорондын зай нь холдох тусам хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуульд явахгүй байх магадлал нэмэгдэж байна. Жишээ нь, сургууль дотор нь тэдэнд тохиромжтой бие засах газар байхгүй тохиолдолд алхаж явах бэрхшээлтэй буюу тэргэнцэр хэрэглэдэг өсвөр насныханд хамгийн их бэрхшээлтэй байдаг аж. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцах "боломжтой" эсэхээ тодорхойлуулахын тулд ихэвчлэн өндөр өртөгтэй эмнэлгийн үзлэгт хамрагдах шаардлагатай болж байна. Сургуульд элсэн суралцах боломжтой байсан ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хөгжлийн бэрхшээлгүй үе тэнгийнхнийхээ зүгээс ялгаварлан гадуурхагдах, сэтгэл санааны болон бие махбодийн доромжлолд өртөх тохиолдол цөөнгүй байдаг бөгөөд үүнийг нь багш, нийгмийн ажилтнууд үл тоодог тухай фокус бүлгийн ярилцлагад оролцогсод ярьж байсан.

Хорин таваас дээш тооны ажилтантай төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нийт ажиллагсадынхаа дөрвөн хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээр бүрдүүлсэн байх тухай хууль тогтоомжийн заалт байдаг хэдий ч дагаж мөрдөх нь ховор бөгөөд харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулах гэхээсээ илүүтэй хууль тогтоомж дагаж мөрдөөгүйн шийтгэл болох багахан хэмжээний торгууль төлсөн нь дээр үзэж байна.

Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийг 2009 онд соёрхон баталсан. Түүнээс хойш бодлогын түвшинд томоохон эерэг өөрчлөлтүүд гарч, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг боловсруулан баталж, улмаар дагаж мөрдөх журмуудыг батлан гаргасан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгмийн үйлчилгээ авах, хөдөлмөр эрхлэх тэгш боломжоор хангах Засгийн газрын үүрэг амлалтаа

баталгаажуулсан. Гэсэн хэдий ч тус улс нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд үндэсний хууль тогтоомж, бодлогоо конвенцтэй уялдуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн загварыг боловсруулан баталж цаашид нийгмийн халамжийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт зэрэг нийгмийн хөгжлийн салбарт ягштал дагаж мөрдөн хэрэгжүүлэх шаардлагатай байна.^[33]

3.1.4 АЖИЛГҮЙЧҮҮД, УР ЧАДВАРГҮЙ ЗАЛУУЧУУД

Дээр өгүүлсэнчлэн Монгол Улс нь бүс нутагтаа хамгийн залуу хүн амтай орны нэг бөгөөд нийт хүн амынх нь гуравны нэг нь хүүхэд юм. Залуучууд олноороо ажиллах хүчний эгнээнд нэгдэхийн хэрээр тэдгээрийг зөвхөн техник технологийн хүч ихээр шаарддаг уул уурхайн салбарт төдийгүй бусад салбарт ч үр бүтээлтэй, зохистой хөдөлмөр эрхлэх хангалттай хэмжээний ажлын байр бий болгож эдгээр шинэ ажиллах хүчний чадавхыг бүрэн дүүрэн ашиглах хэрэгтэй. КОВИД-19 цар тахлын хямралын өмнөх үеийн насанд хүрэгчидтэй харьцуулахад өнөөгийн залуучууд нь маш эмзэг болсон хөдөлмөрийн зах зээлтэй учирч байна. 2020 онд Монгол Улсад залуучуудын ажилгүйдлийн түвшин (15-24 насны) 18.2 хувь байсан бол насанд хүрэгчдийн (25-аас дээш насныхны) ажилгүйдлийн түвшин 4.7 хувь байна.^[34] Хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй залуучуудын хувийн жин 2019 онд 19.7 хувь (залуу эмэгтэйчүүд 21 хувь; залуу эрэгтэйчүүд 18.4 хувь) байна.^[35]

Цалин сайтай ажил олдохгүйгээс боловсролтой, чадварлаг монголчуудын цөөнгүй хувь нь гадаад улс орон руу хөдөлмөр эрхлэхээр цагаачилж байна. Энэ нь ялангуяа Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын орнуудад


32 Хүний эрхийн хороо. (2017 оны 8 дугаар сарын 22-ны өдөр). *Монгол Улсын Зургаадугаар илтгэлийн талаарх дүгнэлт*. CCPR/C/MNG/CO/6. Үзэх https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolNo=CCPR/C/MNG/CO/6&Lang=En

33 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хороо. (2015 оны 5 дугаар сар). *Монгол Улсын анхны тайланд хийсэн дүгнэлт*. Үзэх <https://un-docs.org/CRPD/C/MNG/CO/1>

34 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. Үзэх <https://www.1212.mn>

35 ОУХБ-ын Статистикийн хэлтэс. Үзэх <https://www.ilo.org/shinyapps/bulkeplorer57/>

Зураг 3.1.8: Залуучуудын фокус бүлгийн ярилцлагаас



суралцахаар явсан залуус тэндээ үлдэж хөдөлмөр эрхлэхийг илүүд үзэж байгаагаас ажиглагдаж байна.

Хөдөө орон нутагт хөдөлмөр эрхлэх боломж хомс, зөвхөн бага цалинтай ажил олдохоос гадна дийлэнх ажлын байр мал аж ахуйн салбарт л төвлөрч байгаа тухай фокус бүлгийн ярилцлагад оролцогсад ярьж байлаа. Түүнчлэн залуу ажилчдын ажлын туршлага дутмаг, өөрсдийгөө хамгаалах хөдөлмөрлөх эрхийн талаарх мэдлэг сулыг далимдуулан ажлын байран дээр нь ахимаг насны болон туршлагатай ажилтнууд насных нь байдлаар нь алагчлан дарамталж байсан талаар олон залуус гомдоллож байв. Үүний уршгаар залуучууд илүү цагаар ажилладаг бөгөөд заримдаа ажлынхаа хөлсийг ч авдаггүй

байна. СИКА компанийн судалгаанд оролцсон залуучуудын 38.2 хувь нь зарим тохиолдолд тэдний хөдөлмөрийг дутуу үнэлдэг хэмээн хариулжээ.^[36] Эцэг эх, танил талынхаа ажлын газар болон ажиллаж байсан газарт ажилд орсон залуусын хувьд цалингаа цаг тухайд нь өгөхгүй байх, ажлын байран дахь дарамт шахалт зэрэг асуудал гарах нь бага аж. Ер нь ажил олоход танил тал, арын хаалга маш чухал байна. Боломж нөхцөл хязгаарлагдмал учир олон залуус хот суурин газар, нийслэл Улаанбаатар руу шилжих, заримдаа амьжиргаагаа дээшлүүлэхийн тулд гадаад улс орон руу явах нь сүүлийн жилүүдэд улам нэмэгджээ.

Монголчуудын согтууруулах ундааны хэрэглээ, түүний дотор архины хэрэглээ

нь хуучин Зөвлөлтийн нөлөөн дор олж авсан нийгэм, соёлын салшгүй дадал зуршил юм. Одоо ч гэсэн ялангуяа өвлийн улиралд архины хэрэглээ их хэвээр байна. Согтууруулах ундааны хэрэглээ, хөвгүүдийн дунд 16-17 наснаас эхэлж байгаа бөгөөд хотын хөвгүүд хөдөө орон нутгийн хөвгүүдээс хоёр дахин илүү хэрэглээтэй байна.^[37] 15-24 насныхны дунд цусны даралт ихсэх зэрэг халдварт бус өвчний тархалт нэмэгдэж буй төдийгүй тэдний 15 хувь нь эм хэрэглэх шаардлагатай болж байна.^[38] Түүнчлэн халдварт бус өвчлөлийн тархалт тамхины хэрэглээ, эрүүл бус хооллолт, хөдөлгөөний хомсдол, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх зэрэг амьдралын хэв маяг, зан үйлтэй холбоотой байдаг талаарх суурь ойлголт залуучуудын дунд дутмаг байна.

Өсвөрийн парламент, жил бүр Залуучуудын чуулга уулзалт зохион байгуулах зэргээр шийдвэр гаргах үйл явцад залуучуудыг татан оролцуулахыг хүлээн зөвшөөрч, зарим ахиц дэвшил гарч байгаа хэдий ч залуучуудад олон нийтийн амьдралд оролцох, өөрсдийнх нь амьдралд нөлөөлөх шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж хязгаарлагдмал байгааг фокус бүлгийн ярилцлагад оролцогчид тэмдэглэсэн байна. Тухайлбал, фокус бүлгийн ярилцлагад оролцогчдоос цөөн хэд нь л Засгийн газраас явуулж буй санаачилга болох Залуучуудын оролцоо төслийн талаар мэдэж байсан бөгөөд тэд голчлон хувийн харилцаагаараа дамжуулан тус төслийн үйл ажиллагаанд оролцсон байна.

3.1.5 ХОТЫН ЯДУУС, ДОТООДЫН ШИЛЖИН СУУРЬШИГЧИД

2020 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 48 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, аймаг тус бүрт дөрөв хүрэхгүй хувь нь тус тус оршин сууж байна.^[39] Улаанбаатар хот ДНБ-ий үйлдвэрлэлийн 65 хувь, эрчим хүчний үйлдвэрлэлийн 85 хувь, хөрөнгө оруулалтын 50 хувийг үйлдвэрлэж байна. Энэ байдлаас шалтгаалан өндөр ур чадвартай, чадваргүй ажилтнуудын аль аль нь ажил хийхээр нийслэл хот руу шилжин суурьшиж байна. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ)-ын судалгаагаар шилжин суурьшигчдын дийлэнх нь 20-34 насны эдийн засгийн идэвхтэй, ганц бие, бүрэн дунд боловсролтой хүмүүс байна. Нийслэлд шилжин суурьшсаны дараа тэдний хөдөлмөр эрхлэлтийн байдал сайжирч байгаа нь судалгаанаас харагдаж байна.^[40] Гэсэн хэдий ч нийслэл хотын хүн амын 42 орчим хувь нь гэр хороололд амьдарч байгаа бөгөөд тэдний дийлэнх нь хөдөлмөр эрхлэх боломж, орон сууц, эрүүл мэнд, ундны ус, ариун цэврийн байгууламж зэрэг нийгмийн суурь үйлчилгээг авах боломжоор хомс байна.^[41] Гэр хорооллыг орон сууцны байршил, холбоо харилцаа, чанар зэргийг нь үндэслэн төвийн, дундын, захын гэсэн гурван бүст хувааж хотын ядуусыг байршлаар нь зааглаж болох бөгөөд тэдгээрийн 60 орчим хувь нь гэр сууцад амьдарч байна.^[42]

Нийслэл Улаанбаатар хотын захиргаа нь цөөн тооны өндөр ур чадвартай ажиллах хүчийг хот руу шилжиж ирэхийг дэмжсэн шилжилт хөдөлгөөний хаалттай бодлого баримталж Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг зөрчиж байна.^[43] Энэ нь нийслэл хотод шилжиж

37 Монгол Улс дахь НҮБХС. (2019). *Нөхцөл байдлын шинжилгээ: Монголын Өсвөр үеийнхний цогц хөгжлийг ойлгох нь.*

38 *Мөн тэнд.*

39 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. Үзэх <https://www.1212.mn>


40 Нийслэлд шилжиж ирсэний дараа сарын дундаж орлого нь дунджаар 127 ам. доллараар өссөн бол тэдний хөдөлмөр оролцооны коэффициент 24 пунктээр, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 27.4 пунктээр тус тус өссөн.

41 ОУШХБ. (2020). *Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа.*

42 Монгол Улс дахь НҮБХС. (2019). *Нөхцөл байдлын шинжилгээ: Монголын Өсвөр үеийнхний цогц хөгжлийг ойлгох нь.*

43 Монгол Улс дахь НҮБХС. (2019). *Нөхцөл байдлын шинжилгээ: Монголын Өсвөр үеийнхний цогц хөгжлийг ойлгох нь. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 12 дугаар зүйл: Тухайн улсын иргэн бүр өөрийн улсын нутаг дэвсгэрийн харьяаллын хүрээнд чөлөөтэй зорчих, оршин суух газраа өөрөө сонгох эрхтэй.*

Зураг 3.1.9: Хотын ядуус, шилжин сууршигчдын фокус бүлгийн ярилцлагаас



ирсэн албан ёсны бүртгэлтэй хүмүүсийн тоо 2017 онд 25,000 байсан бол 2019 онд 6,800 болж буурахад хүргэсэн хэдий ч хүн амын бодит шилжилт хөдөлгөөнийг хорьж чадаагүй учир нүүж ирсээр байгаа ядуу өрхүүд иргэний бүртгэлд бүртгүүлэх боломж хязгаарлагдаж улмаар тэдний боловсрол, эрүүл мэндийн суурь үйлчилгээ авах, газар өмчлөх эрх зөрчигдөхөд хүргэсэн. Энэ нь бага насны хүүхэд болон өсвөр насныханд ноцтой эрсдэл учруулж байна. Албан ёсны бүртгэлгүй дотоодын шилжин ирэгсдийн дотор гол тэжээгч нь эмэгтэй, ахимаг настай, боловсрол багатай (бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой) өрхүүд, тэтгэврийн насны олон ам бүлтэй өрхүүд, 14 болон түүнээс доош насны хүүхдүүдтэй айл өрхүүд хамгийн эмзэг байна. Албан ёсны бүртгэлгүй шилжин суурьшигчдын

шинээр төрсөн нярай хүүхдээ бүртгүүлэх, эрүүл мэндийн хяналтад оруулахад маш хүндрэлтэй болохыг фокус бүлгийн ярилцлагад оролцогсад дурджээ. Нөгөөтэйгүүр, сургуульд сурч байгаа өсвөр насны хүүхдүүддээ боловсрол эзэмшүүлэхийн тулд хотын оршин суугч хамаатнуудынхаа тусламжтайгаар түр оршин суугчаар бүртгүүлэхээс өөр аргагүйд хүрч байна. Замын түгжрэл, агаарын бохирдол, байгаль орчны доройтол, төрийн үйлчилгээ хангалтгүй байгаа зэрэгт шилжин суурьшигчдыг буруутгаж, хотын иргэдийн зүгээс тэднийг ялгаварлан гадуурхах байдал улам бүр газар авч байна.

Үнэхээр ч энэ нь Монгол Улсын хот суурин газрын ядуурал орлогын хомсдолоос гадна үйлчилгээний хүртээмж хязгаарлагдаж

байгаагаар илэрч байна. Улсын хэмжээнд хот суурин газар бүрийн төвд гэр хороолол байгаа бөгөөд ихэвчлэн түгжрэл, төвлөрөл ихтэй байгаа нь цэцэрлэг сургууль, эрүүл мэндийн төв зэрэг нийгмийн дэд бүтцэд ихээхэн дарамт учруулж байна.^[44] Хил дамнасан бизнес, уул уурхайн хөгжлийг дагаад хотжиж буй бусад аймгийн төвүүд, Замын Үүд, Уянга зэрэг томоохон сумдад бий болж буй эдийн засгийн боломжууд нь хөдөлмөрийн насны хүмүүсийн сонирхлыг ихээхэн татах болж байгааг нэг талаас, хөдөө орон нутгийн дэд бүтцийн хөгжил сул, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрүүдэд оруулах төсвийн хөрөнгө оруулалт дутмаг, нөгөө талаас боловсрол, эдийн засгийн боломжууд хот суурин газруудад хэт төвлөрсөн зэргээс шалтгаалж ийм нөхцөлд хүрснийг гайхах зүйл үгүй юм.

Сүүлийн хэдэн жилд шилжих хөдөлгөөний урвуу (хотоос хөдөө рүү) урсгал шинээр ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь 2020 онд КОВИД-19 цар тахлын хямралыг даван туулах арга стратеги хэлбэрээр илэрч байна. ҮСХ-ны мэдээлснээр 2020 онд Улаанбаатар хотоос Төв, Орхон, Сэлэнгэ, Дархан, Хэнтий, Өвөрхангай, Дорноговь зэрэг аймаг руу нийт 43,478 хүн шилжин суурьшсан байна. Урвуу шилжилт хөдөлгөөнд оролцож буй шилжин суурьшигчдын дийлэнх нь эдийн засгийн идэвхтэй хүмүүс байгаа бөгөөд тэдгээрийн 35 орчим хувь нь бакалаврын зэрэгтэй, 57 гаруй хувь нь гэр бүлтэй, ихэвчлэн хөдөлмөр эрхэлдэг хүмүүс байна. ОУШХБ-ын судалгаагаар шилжин суурьшигчид нь ихэвчлэн илүү сайн амьдрах нөхцөл, ажлын байр, найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ эргэн нэгдэх зорилгоор хөдөө орон нутаг руу шилжсэн бөгөөд гаргасан шийдвэртээ ч тэд сэтгэл хангалуун байна.

Сулхан зохицуулалт, удирдлагатай шилжилт хөдөлгөөн нь хүн худалдаалах, орчин үеийн боолчлол зэрэг гэмт хэрэгт өртөх гол шалтгаан болж байна. Шилжин суурьшиж

байгаа ядуу өрхийн охид, залуу эмэгтэйчүүд биеэ үнэлж байгаа тухай судалгаа ч байна. Ийм тохиолдлуудын дийлэнх нь уул уурхайн бүс нутаг, худалдаа, бизнес идэвхтэй өрнөж буй хил орчмын бүс нутаг, нийслэл хотод гарч байгаа аж. Тухайлбал, улсын өмнөд хил орчмын бүс нутагт "шатахууны охид"-ын үйлчилгээ нэмэгдэх болжээ. Эдгээр охидын дийлэнх нь Улаанбаатар хот болон бусад аймгаас ирсэн охид байдаг тул нутгийн иргэд үүнийг "орон нутгийн" асуудал гэж үзэхгүй байна. Хот суурин газарт, ялангуяа Улаанбаатар хотод 8-27 хүртэлх насны охид, эмэгтэйчүүд биеэ үнэлж байна. Тэдгээрийн дийлэнх нь шилжин сууршигч эмэгтэйчүүд, охид байгаа бөгөөд тэд голдуугэр хорооллын оршин суугчид байна.^[45] Өнөөгийн байдлаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, тэдэнд туслах үйлчилгээг үндсэндээ гадаад, дотоодын төрийн бус байгууллагууд үзүүлж байна. Энэ төрлийн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх туршлага Монгол Улсын Засгийн газарт дутмаг байгаа бөгөөд төсөв мөнгө ч хуваарилахгүй байна. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг ч мөн гадаад, дотоодын төрийн бус байгууллагууд өөрсдийн санаачлагаар явуулж байна.

3.1.6 ХӨДӨӨГИЙН ЯДУУС, МАЛЧИД

Цаг агаарын хүнд нөхцөлөөс шалтгаалж Монгол Улсын нийт өрхийн 30 орчим хувь буюу нүүдлийн болон хагас нүүдлийн^[46] 169,706 малчин айл өрх амьжиргааных нь цорын ганц эх үүсвэр болох мал сүргийнхээ хамт маш эмзэг, эрсдэлтэй аж төрж байна. Өөрөөр хөдөлмөр эрхлэх боломж хөдөө орон нутагт тун хомс юм. Тэдгээр айл өрхүүд уур амьсгалын өөрчлөлт, ган, зуд, бэлчээрийн доройтол зэрэг байгалийн аливаа гамшигт үзэгдлээс үүдэлтэй гадны нөлөөлөлд ихээхэн автаж байна. 200-гаас доош тооны малтай ядуу малчин өрхүүд (нийт малчин өрхийн 42.3 хувь) болон 201-500 толгой малтай дундаж орлоготой өрхүүд (34.4 хувь)

44 Мөн тэнд.

45 Мөн тэнд.

46 НҮБХХ . (2020 оны 5-р дугаар сар). "Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо: Монгол Улсын Хөдөөгийн иргэдийн дасан зохицох чадавх, эрсдэлийн удирдлагыг сайжруулах нь" төсөл; НҮБ-ын ХХААБ. (2020 оны 7-р дугаар сар). "Монгол Улсын мал аж ахуйн салбарын эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж, турших нь" Эцсийн тайлан.

Зураг 3.1.10: Хөдөөгийн ядуус, малчдын фокус бүлгийн ярилцлагаас



^[47] зудтай өвлийн хүнд үед ядуурах эрсдэл өндөр байна.

Түүхэндээ ойролцоогоор 10 орчим жилд нэг удаа зуд тохиолдож байсан бол сүүлийн үед зудын давтамж нэмэгдэж 4-5 жилд багадаа л нэг удаа зуд тохиолдох болсон. Зуд ихээхэн хор хөнөөл учруулж ирсэн. Тухайлбал, 2009-2010 онд болсон зудын улмаас улсын нийт малын 22 хувь буюу 9.7 сая орчим толгой мал хорогдсон байна. Хорь гаруй сургууль хүүхдүүдийн хичээлийн ирц буурсан, зарим сурагчид эмнэлэгт хэвтэж, 10 гаруй хоног хичээлдээ явж чадаагүй тухай мэдээлсэн байна. Ийнхүү зуд нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй малчдын хүүхдэд сургуульдаа очих нөхцөлийг хязгаарлаж байгаа зэргээс

хүүхдийн сургуулийн ирц буурахад нөлөөлж байна.^[48] Малчдын дунд тэгш бус байдал илэрхий нэмэгдэж байгаа талаар фокус бүлгийн ярилцлагад оролцсон малчид дурьдсан байна. Өвөлжилтийн бэлтгэл дорвитой хангаагүйгээс, малдаа зориулсан өвөлжөөгүйгээс болж ядуу малчид ихэвчлэн хүндрэлд орж байгаа бөгөөд эрсдэлтэй тохиолдол нэг удаа болоход л бүх малаа алдах нөхцөл байдал үүсэх тул тэдгээр айл өрхүүдэд хүнсний хомсдол үүсч болзошгүй байна.

Бэлчээр нутгаа алдах нь малчдын уламжлалт амьжиргаанд хамгийн гол аюул болж байна. Нийт нутаг дэвсгэрийн долоогоос илүү хувийг эзлэх болсон уул уурхайн салбарын үйл ажиллагаа, малын

47 НҮБ-ын ХХААБ. (2020 оны 9-р дугаар сар). "Монгол Улсад хөдөө аж ахуйн салбарын байгалийн гамшгийн хохирол, алдагдлын талаарх мэдээллийн удирдлагын системийг байгуулах, салбарын эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ хийх, сэндайн үйл ажиллагааны хүрээний хэрэгжилтийн тайлан" эцсийн тайлан.

48 Мөн тэнд.

тоо толгой олширч бэлчээрийн даац хэтрэх болсон зэргээс шалтгаалж малчид бэлчээр нутгаа алдаж байна. Уул уурхайн үйл ажиллагаа нь ялангуяа цаа бугын аж ахуй эрхэлдэг цаатан малчдын бүлгүүдэд онцгой аюул учруулж байна. Хөдөө орон нутагт ган гачиг тохиож байгаагаас усны хомсдолд орж малчид бэлчээр нутгаа алдахын зэрэгцээ хөрс бохирдон усаар дамжих халдварт өвчин болох сальмонеллээс, цусан суулга өвчний өвчлөл нэмэгдэж хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Улс орон зах зээлийн нийгэмд шилжиж хөдөө аж ахуйн нэгдэл татан буугдсанаар онцгой байдлын үед өвс тэжээл олох, мал эмнэлгийн үйлчилгээ авах болон бусад хэрэгцээ шаардлага гарах үед малчид нийгмийн ямар ч хамгаалалтгүй үлдсэн. Эрсдэлийг төр биш хувь хүн өөрөө үүрэх болсон. Иймээс малчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийг илүүнэмэгдүүлэх шаардлагатай байгаа тухай фокус бүлгийн ярилцлагад оролцсон хэд хэдэн малчид ярьж байсан.

Хот суурин төвтэй боловсролын үйлчилгээг дагаад малчин айл өрх арга буюу хуваагдан амьдрах болсон нь Монголын нийгмийн бүтцийн салшгүй нэг үзэгдэл болж байна. Энэ нь нилээд өвөрмөц үзэгдэл бөгөөд хүүхдүүдээ сургуульд сургаж суурь боловсрол эзэмшүүлэхийн тулд ээжүүд хүүхдүүдээ дагуулан хот суурин бараадаж, харин аавууд алс хол нутагтаа ганцаар үлдэж өвлийн хүнд хүчир нөхцөлд өөр ямар ч дэмжлэггүйгээр малаа хариулан үлдэнэ. Хот суурин газарт ээж хүүхдүүд нийлж ээжээрээ тэргүүлүүлсэн өрхийг бүрдүүлж, бүхий л ачааллыг дангаар үүрч, орлогын болоод хүнсний аюулгүй байдал нь улам бүр эмзэг болж, хүчирхийллийн эрсдэлийг ч сөрөх жишээтэй.^[49] Ийнхүү айл өрхүүд хуваагдах үйл явц нь малчин эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд нь эдийн засгийн болоод сэтгэл зүй-нийгмийн асар их дарамт учруулж байна.

3.1.7 ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХ

Монгол Улс орон зайн болон геополитикийн хувьд алслагдсан үндэстний цөөнх хүн амтайгаа нэгдмэл байх талаар бас нэгэн сорилттой тулгарч байна. Монгол Улсын нийт хүн амын дийлэнх нь буюу 82 хувь нь халх монголчууд, бусад монгол угсаатнууд 13 хувийг, тухайлбал, хойд хэсэгт буриад зон голдуу амьдарч байгаа бол үлдсэн таван хувийг түрэг гэх зэрэг бусад угсаатны цөөнх бүрдүүлж байна.

Монголчуудын өвөрмөц онцлог нь нүүдэлчин амьдралын хэв шинж, нийтлэг нэг хэл, оюун санааны болон амьдралын төлөв байдлаар илэрдэг боловч “бусад үндэстнүүд”-тэйгээ, ялангуяа, казах, цаатан үндэстэнүүдтэйгээ хэл, соёлын ялгаатай, алслагдсан газар нутагт оршин суудаг зэргээс шалтгаалан үндэстнүүдийн нэгдмэл байдалд зарим бэрхшээл тулгарсаар ирсэн. Баруун аймгуудын нэг болох Баян-Өлгий аймгийн хүн амын дийлэнх нь казах үндэстнүүд юм. Нэгдмэл байхад тулгарч буй гол сорилт нь нийгэм эдийн засгийн төлөв байдлаар илэрч байгаа бөгөөд баруун бүс нь тус улсын хамгийн буурай хөгжилтэй бүс нутаг болж байна. Энэ бүс нутгийн хүүхдүүд хүнс тэжээл, сургуулийн өмнөх насны боловсрол, суурь боловсрол эзэмшиж буй байдал зэргээрээ бусад бүс нутгийн хүүхдүүдтэй харьцуулахад ихээхэн сул байна.

Монгол Улсын Үндсэн хуульд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон байдаг ч үндэс угсаагаар алагчлан үзэх гэх зэрэг ялгаварлан гадуурхах бусад хэлбэрийн талаар тусгайлсан зүйл заалт байдаггүй. Арьс үндсээр алагчлахыг устгах хороо (АҮАУХ) нь Монгол Улсад Арьс үндсээр алагчлахын эсрэг цогц хууль тогтоомж байхгүй байгааг дурдаад тус улсын илгээсэн 19-22 дугаар ээлжит тайланд Монгол Улсад арьс үндсээр ялгаварлан гадуурхсан тухай ямар нэгэн гомдол гарч байгаагүй хэмээн дурдсан нь хэр үндэслэлтэй болох нь эргэлзээтэй

49 Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах хороо. (2016). Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын ээлжит 8, 9 дүгээр ээлжит тайланд өгсөн нэгдсэн дүгнэлт. W/C/MNG/CO/8-9.

байгааг тэмдэглэсэн байна. Монгол Улс арьс үндсээр алагчлахаас хамгаалах хүрээг өргөтгөх заалтыг Эрүүгийн шинэ хуульд тусгах талаарх олон улсын зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд 1994 оны Нийгмийн даатгалын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөд цаатан малчдыг бусад малчдын нэгэн адил нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулахаар хуульчилж, казах хүүхдүүдэд зориулсан хос хэлээр сургалт явуулах сургуулиудад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн.^[50]

Гэсэн хэдий ч Монгол Улс дахь үндэстний цөөнх, нутгийн уугуул иргэдийн нөхцөл байдал түгшүүртэй асуудал хэвээр байна. Ялангуяа, эх хэлээрээ боловсрол эзэмшихэд нь саад бэрхшээл тулгарч байгаагаас үүдэж бага, дунд, дээд боловсрол эзэмшсэн казах, тува, цаатан (Духа) хүмүүсийн тоо улсын дундажтай харьцуулахад тун цөөн байгаа нь АҮАУХ-ны анхаарлыг татсан хэвээр байна. Казах, цаатан (духа), тувачуудын ажилгүйдлийн түвшин улсын дунджаас өндөр байна. Төрийн албаны тухай хуулинд үндэс угсаагаар алагчлахыг хориглосон заалтууд тусгагдсан хэдий ч Баян-Өлгий аймагт үндэстний цөөнхүүд ажилд орох, тэр дундаа төрийн албанд ороход алагчлах үзэлтэй тулгарсаар байна. Мөн үндэстний цөөнх, ялангуяа цаа бугын аж ахуй эрхэлдэг хүмүүстэй зөвшилцөлгүйгээр амьжиргаагаа залгуулдаг нутаг дэвсгэрт нь уул уурхайн ашиглалтын лиценз, хайгуулын зөвшөөрлийг олгосоор байгаа нь тэдний уламжилж ирсэн амьжиргаа, соёлын зан үйлд сөргөөр нөлөөлж байна гэсэн мэдээлэл гарсаар байна.

Тэнгис Шишгэдийн тусгай хамгаалалттай газар нутагт загас агнуур, ан агнуур хийхийг хориглосон заалт нь цаатангуудын уламжлалт аж ахуй, соёлын эрхэнд сөргөөр нөлөөлж аюулд оруулж болохыг, мөн цаатан хүмүүс, ялангуяа өндөр настан, өвчтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эмнэлгийн

үйлчилгээ авахад тулгарч буй саад бэрхшээл их байгаа талаар цаатан (духа) хүмүүсийн нөхцөл байдлын талаарх 2019 оны АҮАУХ-ны дүгнэлтэд онцгойлон тэмдэглэсэн байна.^[51]

Эцэст нь дурьдахад үндэстний хэмжээний статистикийн мэдээлэлд үндэстний цөөнхийн талаарх тоо мэдээлэл хомс байгаагийн зэрэгцээ нийт үндэстний цөөнхийн бүлгүүдийг хамруулсан нийгэм, эдийн засгийн үнэн зөв, цогц мэдээлэл байхгүй байна. Түүврийн хэмжээ нь ихэвчлэн бага байдаг учир үндэстний цөөнхийн бүлгүүдийн талаарх мэдээллийг статистикийн хувьд төлөөлөх чадвар нь сул хэмээн үзэж нэгдсэн дүгнэлт хийлгүй орхигдуулах магадлал өндөр байна. Мөн "үндэстний хэмжээнд төлөөлөх чадвартай" дийлэнх судалгааг зөвхөн монгол хэлээр явуулж байгаа учир үндэстний цөөнх ихэнхдээ хамрагдахгүй байна. Ийм байдал нь эрх тэгш байдлыг хангах шийдвэр гаргахад шаардагдах бодит нотолгоо болж чадахгүй байна.^[52]

3.1.8 АХМАД НАСТАН

Монгол Улсын хүн амын нас хүйсийн суврага нь өндөр хөгжилтэй орнуудын хүн амын бүтцийн суврага шиг "хавчиг хэлбэр"-т хараахан хүрээгүй ч энэ үйл явц үргэлжлэх төлөвтэй байна. Монгол Улсын хүн ам 2040 он гэхэд 2010 оныхоос хамгийн багадаа 1.4 сая хүнээр нэмэгдэх төлөвтэй байна. Нийт хүн амд өндөр настай хүмүүсийн эзлэх хувийн жин 2000 онд 5.2 хувь байсан бол 2040 он гэхэд 16.7 хувь болж эрчимтэй өсөх хандлагатай байна. Дундаж наслалт нэмэгдэхийн хэрээр ахмад настнуудад бие бялдарын болоод эрүүл мэндийн асуудал тулгарч бусдын тусламж авах зайлшгүй шаардлага гарах болно. Эрүүл мэндийн статистикийн 2016 оны мэдээгээр, 60 болон түүнээс дээш насны хүмүүсийн 25 хувь нь өдөр тутмынхаа амьдралын үйл хэрэгт бусдын тусламжийг дунд зэрэг буюу нилээд

50 Монгол Улс дахь НҮБХС. (2019). *Нөхцөл байдлын шинжилгээ: Монголын Өсвөр үеийнхний цогц хөгжлийг ойлгох нь.*

51 Арьс үндсээр алагчлахыг устгах хороо. (2019 оны 9 дугаар сарын 17-ны өдөр). *Монгол Улсын илгээсэн 23, 24 дүгээр ээлжит тайланд өгсөн дүгнэлт.* ERD/C/MNG/CO/23-24 Үзэх https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CERD/C/MNG/CO/23-24&Lang=En

52 Монгол Улс дахь НҮБХС. (2020). *Бодлогын товчоон: Тэгш шударга бодлого боловсруулах хяналт шинжилгээ, үнэлгээ: Монгол Улсад хүүхэд, өсвөр насныхны эрхийг хамгаалах нь.*

Зураг 3.1.11: Ахмад настай хүмүүсийн фокус бүлгийн ярилцлагаас



хэмжээгээр авч байсан бол долоон хувь нь бусдын тусламжаас ихээхэн хамааралтай амьдарч байна. Настай эрэгтэйчүүдтэй харьцуулахад настай эмэгтэйчүүд өдөр тутмын амьдралынхаа үйл хэрэгт тусламж авах илүү шаардлагатай байна. Ахимаг насны таван хүн тутмын нэг нь илүүдэл жинтэй буюу таргалалттай байгаагаас харахад тэд даралт ихсэх өвчин зэрэг халдварт бус өвчнөөр өвдөх эрсдэл өндөр байна. Ахимаг насны эмэгтэйчүүдийн дунд таргалалт буюу илүүдэл жинтэй байх магадлал ахимаг настай эрэгтэйчүүдээс бараг хоёр дахин их байна.^[53] Халдварт бус өвчний тархалт их байгаа нь ялангуяа 65 болон түүнээс дээш насны хүмүүсийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй болох өвчлөх эрсдлийг улам бүр нэмэгдүүлж байна.

Фокус бүлгийн ярилцлагаас ажиглахад ахмад настнуудын эрхээ бүрэн эдлэх, боломж чадавхаа ашиглах зэрэгт нь олон

саад бэрхшээл тулгарч байна. Ахмад настнууд ерөнхийдөө өөрсдийн олсон орлого, гэр бүлийнхнийхээ дэмжлэг, төр засгаас олгож буй өндөр насны тэтгэвэр, нийгмийн хамгааллын тэтгэмж зэргээр амьдарч ирсэн уламжлалтай. Насанд хүрсэн үр хүүхдүүд, бусад төрөл төрөгсөд нь ахмад настнууддаа дэмжлэг үзүүлж ирсэн уламжлал хүчтэй хэвээр байгаа хэдий ч ам бүлийн тоо цөөрч, дотоод, гадаад шилжих хөдөлгөөн нэмэгдэхийн хэрээр ийм дэмжлэг нь хурдацтай буурах болжээ. Тус улсад ажилгүйдэл, бүрэн бус хөдөлмөр эрхлэлт газар авч байгаа энэ үед ахмад настнуудад үр бүтээлтэй ажил хийх боломж нь улам бүр хумигдаж өндөр насны тэтгэвэр нь тэдний орлогын гол эх үүсвэр болж байгаа нь тэднийг ядуурлаас хамгаалахад хүрэлцэхгүй улам бүр төвөгтэй болгож байна. Өндөр насны тэтгэврийн хэмжээ бага, амьжиргааны түвшин хангалтгүй байгаагаас тэтгэвэрт гарсан хэдий ч

53 АХБ. (2020 оны 11 дүгээр сар). Монгол Улс: Урт хугацааны тусламж үйлчилгээний талаарх диагностик судалгаа.

ахмад настнууд ажил хийх сонирхолтой байна. Ялангуяа дээд боловсролтой хуульч, нягтлан бодогч, багшийн мэргэжилтэй ахмадуудын дунд ажил хийх сонирхол их байна. Харин боловсролгүй, бага боловсролтой ахмадуудад ажил хийх боломж маш хязгаарлагдмал байна. Ерөнхийдөө ахмад насны эмэгтэйчүүд нь хөгжлийн бэрхшээлтэй ач зээ, өөрийн өндөр настай эцэг эх, хадам эцэг эх, ах эгч нараа асрах үүрэг хүлээж байна.

Гэр хороололд амьдардаг ахмадууд цэвэр усны болон төвлөрсөн халаалтын сүлжээнд холбогдоогүй амьдарч байгаа төдийгүй хүнс тэжээлийн дутагдалд ч орж байна. Эрүүл мэндийн салбарын мэдээгээр 2018 оны байдлаар ахмад настнуудын 16 хувь нь хүнс тэжээлийн дутагдалд орох эрсдэлтэй байна.^[54] Зарим судалгаанаас харахад ахмад настнууд архидалт, гэмт хэрэг, хүчирхийлэлд өртөх нь нэмэгдсээр байгаа бөгөөд ахмад настай гурван хүн тутмын нэг нь гэр бүлийн хүчирхийлэлд ямар нэг хэлбэрээр өртөж байна.^[55] Ахмад настнууд ганцаардахаас айж орон байраа зарж борлуулснаас орон гэргүй болох, тэтгэврийн мөнгөө өөрийн мэдлээр зарцуулж чадахгүй байх зэргээр эдийн засгийн болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртөж байгаа тухай фокус бүлгийн ярилцлагад оролцсон хүмүүс өгүүлжээ.

Ахмад настны тухай хууль 2017 онд батлагдсан хэдий ч түүний хэрэгжилт тун хангалтгүй байна. Монгол Улсад урт хугацааны тусламж үйлчилгээний талаарх тусгайлсан бодлого, стратеги одоогоор байхгүй байгаа бөгөөд насжиж доройтсон өндөр настнуудын тоо өсч байгаа, тэр дундаа ахмад настай эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэх болсон энэ нөхцөлд ийм бодлого тун шаардлагатай байна. Урт хугацааны тусламж үйлчилгээний талаарх ойлголт, үйл ажиллагаа нь нийгмийн болоод эрүүл мэндийн салбаруудыг дамжин үндсэн утга нь өөрчлөгдөн сарниж, зайлшгүй шаардлагатай дэд бүтэц, орон сууц гэх зэрэг

нэн чухал тогтолцоог орхигдуулж байгаа нь ажиглагдаж байна.

3.1.9 БЭЛГИЙН ЦӨӨНХ

Монгол Улсад бэлгийн цөөнхийн нөхцөл байдлын талаарх тоо мэдээлэл хомс байна. НҮБ-ын хүний эрхийн талаарх баримт бичгүүдэд лесбиан, гей, бисексуал, трансжендер болон интерсекс (ЛГБТИ) хүмүүс нь хөдөлмөр эрхлэлт, орон сууц, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авах зэрэгт байнга ялгаварлан гадуурхах асуудалтай тулгарч байгааг тэмдэглэсэн байдаг. Ижил хүйстэн хосуудыг нийгмээрээ хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэдий ч СИКА-гийн судалгаа ижил хүйстний гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх хандлага цаг хугацаа өнгөрөх тусам өөрчлөгдөж байгааг харуулж байна.^[56]

Монгол Улсын 2015 оны шинэ Эрүүгийн хуулийн “ялгаварлан гадуурхах” гэмт хэрэг, “үзэн ядах гэмт хэрэг” гэсэн зүйл, заалтуудын хүрээнд хүмүүсийг бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, интерсекс байдал, хүйсийн илэрхийллээр нь ялгаварлан гадуурхах, дарамтлахаас хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн. Гэсэн хэдий ч ЛГБТИ-ийн талаарх хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагыг өөрчлөх, бэлгийн цөөнхөд чиглэсэн ялгаварлан гадуурхах болон хүчирхийллийн үйлдлүүдийг мөрдөн шалгах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах, гэм буруутай нь тогтоогдвол зохих шийтгэл оногдуулах зэрэг чиглэлээр мөрдөн байцаагч, прокуроруудад зориулсан сургалт, нөлөөлөл сурталчилгааны ажлыг цаашид зохион байгуулах шаардлагатай байна.

Түүнчлэн гэр орон болон сургууль дээр хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах үзэгдэл гарах явдал газар авч байгаа нь ЛГБТИ хүүхэд, залуучуудын эрхийг хамгаалахад томоохон саад тотгор болж байна. ЛГБТИ хүмүүс нь өөрсдийн хэрэгцээнд

54 Мөн тэнд.

55 Хүний эрхийн дээд комиссарын газар. Үзэх <https://www.ohchr.org/Documents/Issues/OlderPersons/Submissions/Mongolia.pdf>

56 ЭС АЙ СИ ЭЙ (СИКА). (2020). *Монгол Улсын Нийгмийн үеийг тодорхойлох судалгаа*.

Зураг 3.1.12: ЛГБТИ хүмүүсийн фокус бүлгийн ярилцлагаас



нийцсэн нийгмийн болоод эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байна. Цөөнгүй тооны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид нь бэлгийн цөөнхтэй

холбоотой бие махбодийн болоод сэтгэл зүйн асуудлаар мэдлэггүй, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхдээ ёс зүйн хэм хэмжээг баримтлахгүй байна.

3.2 НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫН ТАЛААРХ ШИНЖИЛГЭЭ

Дээрх хэсэгт өгүүлсэн хүн амын зарим бүлгийг хөгжлийн үйл явцад оролцохыг хязгаарлаж буй хэд хэдэн хүчин зүйлс байна. Нэгдүгээрт, нийгэмд тогтсон хэм хэмжээ, хэвшмэл ойлголт, ёс заншил, зан үйлийн ёс жаяг зэрэг нь ялгаварлан гадуурхах хандлага, дадал зуршлыг өдөөж даврахын зэрэгцээ эмзэг бүлгийнхний, ялангуяа эмэгтэйчүүд, охидын эрхээ шаардах, үйлчилгээ авах, зан үйлд дасан зохицох итгэлийг нь сулруулж байна. Хоёрдугаарт, хууль эрх зүйн орчин, салбарын хөтөлбөрүүд, төсвийн санхүүжилт, төсвийн хуваарилалтыг төлөвлөх, хянах механизм зэрэг нь өөр хоорондоо уялдаагүйгээс шалтгаалж, хүн бүрийн оролцоог хангахад чиглэсэн бодлого шийдвэр гаргах үүрэг

хүлээгчдийн чадавх хязгаарлагдмал байна. Бодлогоор тунхагласан амлалтаа эцсийн хэрэглэгчдэд зориулсан бодит үйлчилгээ болгон хувиргах төрийн байгууллагуудын институцийн чадавх олон талаараа сул хэвээр байна. Энэ нь орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийг тодорхойлох, тэдгээрийн оролцоог нухацтайгаар дэмжих бодлогын үр нөлөөг хянаж байх хангалттай нарийвчлалтай тоо мэдээллийг бий болгох, ашиглах асуудал дутагдалтай байгааг илэрхийлж байна. Гуравдугаарт, өөрсдийнх нь эрх ашгийг хөндөх аливаа шийдвэр гаргах үйл явцад эрх эдлэгч талууд системтэйгээр оролцож чадахгүй байгаа нь тэдний оролцоог хангах зохион байгуулалт, механизм дутмаг байгаагаас

шалтгаалж байна. Энэ нь эрх эдлэгч талуудын үзэл бодлыг үл тоомсорлож байгаа төдийгүй тэднийг дэмжих, улмаар хэрэгцээ шаардлагыг нь хангах асуудал орхигдож үндэсний бодлого үр дүн муутай болно гэсэн үг юм. Дөрөвдүгээрт, ялангуяа хөдөө орон нутаг болон алслагдсан бүс нутагт төрийн үйлчилгээ хүргэгчдийн чадавхтай холбоотой бэрхшээл байна. Нийгмийн үйлчилгээний шинэчлэл жигд хэрэгжихгүй байна. Тухайлбал, нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээ тэлж байгаа хэдий ч чанар нь сайжрахгүй байна. Эцэст нь, бодлого боловсруулагчид болон эмзэг бүлгийнхний төлөө үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын өөр хоорондын хамтын ажиллагааны зохицуулалт дутмаг байгаа нь эмзэг бүлгийнхний оролцоог хангах үйл явцыг идэвхжүүлэх, зохицуулах амин чухал дэмжлэгийг хязгаарлаж байна гэсэн үг юм.

Монгол Улс боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа боловч төсвийн тооцоо хийх аргачлал, төсвийн хуваарилалтын үр ашиг, нийгмийн үйлчилгээний чанарын үл алагчлах зарчмын мөрдөлт зэргийг сайжруулах шаардлагатай байна. Монгол Улсын тэтгэврийн сангаас өндөр насны тэтгэвэр болон нийгмийн даатгалын бусад тэтгэмжид зарцуулж буй хөрөнгө ДНБ-ий долоон хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн нь бүс нутгийн бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Үүний хоёр хувийг нь улсын татаасаар^[57] нөхөж байна. Энэ нь олгож байгаа тэтгэврийн хэмжээтэй харьцуулахад даатгуулагчийн төлж байгаа шимтгэлийн хэмжээ хангалтгүй, тэтгэвэр тогтоолгох нас харьцангуй залуу (эмэгтэй 55, эрэгтэй

60 нас), эрт тэтгэвэр тогтоох хөнгөлөлттэй нөхцөлүүд хуульчлагдсан зэрэгтэй холбоотой алдагдал юм. Иймээс нийгмийн даатгалын системийг бэхжүүлэх нь нэн чухал болж байна. ДНБ-ий дөрвөөс илүү хувийг нийгмийн эрүүл мэндийн салбарт зарцуулж байна. Боловсролын салбар мөн адил хэмжээний төсвийн зарцуулалттай байна. Нийгмийн хамгаалалд ДНБ-ий хоёроос илүү хувийг зарцуулж байна. Нийгмийн салбарт зарцуулж буй улсын төсвийн нийт зардлын харьцаа нь адил төстэй улс орнуудтай харьцуулахад дундаж түвшинд^[58], хөгжиж буй орнуудад зөвлөмж болгож буй хамгийн доод түвшинтэй⁵ тэнцэхүйц^[59] хэмжээнд байгаа боловч үр ашгийг дээшлүүлэх нь тус улсын ядуурлыг арилгах, хүртээмжтэй боловсролын үйлчилгээг дэмжих, бүх нийтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулах, нийгмийн хамгааллын зохистой үйлчилгээг хүргэх гэсэн тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд нийгмийн салбарын төсвийн зарцуулалтын гол тэргүүлэх чиглэл байх ёстой.

Үүнээс ажиглахад Монгол Улс нь нийгмийн хамгаалалд хамрагдаж байгаа хүн амын хувийн жингээр Ази, Номхон далайн бүс нутагт хамгийн өндөрт орж байна.^[60] Тус улсын нийгмийн хамгааллын тогтолцоо нь хүний амьдралын мөчлөгийн олон үе шатанд тодорхой дэмжлэг үзүүлж байгаа бол бусад улс орнууд хүн амын тодорхой бүлгүүд, категориудад чиглүүлж нийгмийн хамгааллын үйл ажиллагаа явуулж байна. Нийгмийн халамжийн бодлогод эдийн засгийн мөчлөг, улс төрийн амлалтууд ч ихээхэн нөлөөлж байна. Улуурхай эрчимтэй хөгжихийн хэрээр айл өрхүүд рүү чиглэсэн мөнгөн тусламжууд ч нэмэгдсэн. Засгийн

57 Дэлхийн банк. (2020 оны 6 дугаар сар). *Бодлогын зөвлөмж: Монгол Улс, Хүн капиталд оруулах хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх нь.*

58 Дэлхийн банк. (2018). *Өрийн дарамтгүй, тогтвортой бөгөөд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох нь. Төсвийн орлого, зардлын үр ашгийг нэмэгдүүлэх нь. Монгол Улсын Төсвийн зардлын тойм судалгаа.*

59 Боловсрол 2030 он хүртэлх Боловсролын салбарын Үйл ажиллагааны хүрээ баримт бичигт ДНБ-ий 4-6%-иас доошгүй хувийг боловсролд хуваарилах болон/буюу төсвийн зардлын 15-20%-ийг боловсролын салбарт хуваарилах гэсэн хоёр шалгуур үзүүлэлтийг "зорилт" болгохоор санал оруулсан. Холбоос: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000245656>. Эрүүл мэндийн салбарын төсвийн зарцуулалтын хувьд, 2018 онд Монгол Улс ДНБ-ийхээ 3.79%-ийг зарцуулсан бол, дэлхийн дундаж ДНБ-ий 9.8 хувь байсан (Дэлхийн банкны мэдээгээр). ДЭМБ-ын зөвлөмж болгосон жишиг - 5% хувь байсан нь – нилээд маргаан дагуулсан. ЭЗХАХБ-ын орнуудынх 10+ % байна.

60 НҮБАНДЭЗНК. (2020 оны 10 дугаар сар). *Бидний хүсч буй хамгаалалт: Ази, Номхон далайн бүсийн нийгмийн хамгааллын төлөв байдал.* Үзэх <https://www.unescap.org/publications/protectionwe-want-social-outlook-asia-and-pacific>

газраас 2010 оноос 2012 оны долдугаар сар хүртэлх хугацаанд уул уурхайн салбарын орлогоос бүрдүүлсэн “Хүний хөгжил сан”-гаас Монгол Улсын иргэн бүрт, хүүхдүүдийг оролцуулан мөнгөн тэтгэмж (сард 21 мянган төгрөг) олгох хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэхүү мөнгөн тэтгэмж нь нийгмийн халамж гэхээсээ эх орныхоо байгалийн баялгаас хүртэж буй хөгжлийн үр шим юм хэмээх ойлголтыг илүүтэй агуулж байжээ. 2012 оны аравдугаар сараас тус улс байгалийн баялгаас олсон орлогыг дахин хуваарилах зорилгоор өнөөгийн хэрэгжиж буй Хүүхдийн мөнгө хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг тэтгэмжийг 20,000 төгрөг (14.40 ам.доллар орчим)-өөр тогтоож 18-аас доош насны бүх хүүхдэд олгож байна.

Эдийн засаг тогтвортой өсч байсан хэдий ч хүн амын ядуурал дорвитой буураагүй байна. Дэлхийн банк, ҮСХ-ны хамтарсан судалгаагаар 2016-2018 онд нэг хүнд ногдох ДНБ-ий нэг хувийн өсөлт тутамд ногдох ядуурлын түвшний бууралт 0.5 нэгж хувь байгаа буюу ядуурал харьцангуй өндөр хэвээр, 2018 оны байдлаар хүн амын дөрөвний нэгээс илүү хувь нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байна. Мөн ядуурлын хамрагдалтын түвшин 28.4 хувь байгаа нь Монгол Улсын 905 мянга орчим хүн зайлшгүй шаардлагатай бараа бүтээгдэхүүн худалдан авах боломжгүй байгааг илэрхийлж байна. Ядууралд хэдийнээ өртсөн хүмүүсээс гадна хүн амын 14.9 хувь буюу 474.8 мянган хүн ядуурлын шугам болон ядуурлын шугамыг 25 хувиар дээш өсгөсөн түвшин хоёрын хооронд дахь хэрэглээтэй амьдарч байна.^[61] Хэрэв ямар нэгэн гэнэтийн хямрал тохиовол эдгээр эмзэг бүлгийн өрхүүд бүгд ядуу өрхүүдийн эгнээнд гулсан ороход бэлэн

байна. Түүнчлэн Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хороо (ЭАБХУХ) нь хөдөөгийн эмэгтэйчүүдийн ядуурал болон тэдний эд хөрөнгө өмчлөх эрхийн талаар ч мөн санаа зовж байна.^[62]

“КОВИД-19” цар тахлын үед айл өрхүүдийг хамгаалах зорилгоор төрөөс 18 хүртэлх насны бүх хүүхдэд олгох хүүхдийн мөнгийг эрс нэмэгдүүлж 2020 онд 1.1 их наяд төгрөг буюу ДНБ-ий гурван хувь, төсвийн зарлагын найм орчим хувьтай тэнцэх хэмжээнд хүргэсэн.^[63] Хүүхдийн мөнгө хөтөлбөр (ХМХ), хүнсний талон, нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай хөтөлбөрүүд зэрэгт хийсэн АХБ-ны судалгаагаар хэрэв засгийн газраас эдгээр арга хэмжээг аваагүй байсан бол 2018 онд 28,4 хувь байсан Монгол Улсын ядуурлын түвшин 2020 онд 36,7 хувь болж өсөх байсан хэмээн дүгнэжээ. Мөн эдгээр нийгмийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлснээр 2020 онд ядуурлын түвшинг 17.6 хувь хүртэл бууруулах боломжтой байсан хэмээн дүгнэсэн байна. АХБ-ны судалгаагаар цар тахлаас үүдсэн ядуурлын үр дагаврыг бууруулахад ХМХ-ийн нэмэгдэл ихээхэн хувь нэмэр оруулах төдийгүй тус хөтөлбөр дангаар ядуурлыг 24.9 хувь хүртэл бууруулахад нөлөөлнө хэмээн үзсэн байна. Түүгээр ч зогсохгүй зөвхөн ХМХ-ийг нэмэгдүүлснээр Жини коэффициент 0.307 болж буурахаар тооцжээ. ХНХЯ, НҮБХС-гийн хийсэн судалгаа ХМХ-ийн нэмэгдэл нь цар тахлын үед хүүхэдтэй өрхүүдэд үндсэн хэрэгцээгээ хангахад нь ихээхэн тус болсныг харуулж байна.^[64] Үүний зэрэгцээ, НҮБ-ын хийсэн судалгаа шинжилгээний үр дүн^[65] нь КОВИД-19 цар тахлын үед эдийн засгийн идэвхжил буурсантай

61 Дэлхийн банк, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. (2018). *Ядуурлын дүр төрх*.

62 ЭАБХУХ.

63 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. *Тайлбар: ДНБ-ий хувийг 2019 оны ДНБ-ээр тооцсон*.

64 НҮБХС болон ХНХЯ-ны судалгаагаар өрхийн 60 гаруй хувь нь хүүхдийн мөнгөний нэмэгдлийг гэр бүлдээ хоол хүнс худалдаж авахад зарцуулсан байна. Судалгаанаас харахад нийт өрхийн 80 орчим хувь нь цар тахлын улмаас учирсан санхүүгийн алдагдлаа нөхөхөд хүүхдийн мөнгийг ашиглажээ. Мөн хүүхэдтэй өрхүүдийн 98 хувьд ХМХ хүрсэн нь тэд КОВИД-19 цар тахлын эсрэг Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бусад арга хэмжээнүүдээс илүүтэйгээр ХМХ-ийн үр шимийг хүртэж байгааг харуулж байна. Тухайлбал, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай зэрэг хэмжээний ижил зардалтай арга хэмжээ нь хүүхэдтэй өрхийн 30 хүрэхгүй хувьд л хүрсэн байна.

65 Энэ шинжилгээ нь Монгол Улсын Эдийн засгийн тооцооллын ерөнхий тэнцвэрийн загвар (CGE), НҮБАНДЭЗНХ-ын Excel-д суурилсан загвар, Дэлхийн эдийн засгийн хэтийн тооцооны загвар (WEFM-e) зэрэг гурван загварыг ашиглан хийсэн тооцоо юм. CGE загвар нь 2020 оны нэг суурь хувилбар, 2021 оны хоёр (U хэлбэрийн болон V хэлбэрийн сэргэлт) хувилбаруудыг авч үзсэн.


холбоотойгоор 2020 онд ядуурал, тэгш бус байдал нэмэгдэх хандлагатай байгааг анхааруулсан. Монгол Улсын хүн амын өсөлт өндөр (жилд хоёр хувь орчим) байгаа бөгөөд нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлтийн эрч ядуурлын түвшинг дорвитойгоор бууруулах хэмжээнд хүрэхгүй байна. Нэг хүнд ногдох бодит ДНБ 2019 онд 4440 ам.доллар байсан бол 2020 онд 4194 ам.доллар болж буурсан нь 2018 оны ядуурлын түвшинтэй харьцуулахад үндэсний хэмжээний ядуурлын шугамнаас доогуур орлоготой амьдарч байгаа хүмүүсийг 2020 онд 90,000 хүнээр буюу гурван нэгж хувиар нэмэгдүүлэх тооцоо суурь хувилбараар гарч байна (Зураг 3.2.1).

Сүүлийн жилүүдэд тэгш бус байдал ихээхэн нэмэгдсэн хэмээх ойлголт олон нийтийн дунд түгээмэл байгаа хэдий ч Жини коэффициентийн тооцоо тийм мэдрэмжийг илэрхийлэхгүй байна. 2020 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-ны тооцоогоор Жини коэффициент 32 байна. Цаг хугацаа өнгөрөх тусам тэгш бус байдлыг арилгахад дорвитой ахиц дэвшил гарахгүй байгааг тоо баримт харуулж байна. Монгол Улсын 2019 оны Хүний хөгжлийн индекс (ХХИ)-д тэгш бус байдлын нөлөөллийг тооцсон тохиолдолд 0.737-оос

0.634 болж 14.0 хувиар буурсан нь Зүүн Ази, Номхон далайн бүсийн орнуудын дунджаас доогуур байна. Энэхүү алдагдалд ХХИ-ийн орлогын тэгш бус байдлын үзүүлэлт голлон нөлөөлж байна.^[66]


ҮСХ-ны судалгаагаар 2018 оны байдлаар нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдагсдын буюу нийгмийн халамж (шимтгэлгүй) болон нийгмийн даатгал (шимтгэл төлдөг)-ын хөтөлбөрт хамрагдагсдын 30 хувь нь ядуу байсан бөгөөд үлдсэн 70 хувь нь ядуу бус гэсэн ангилалд багтаж байна. Гэтэл нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн нийт зарцуулалтын 19 хувь нь ядууст, 81 хувь нь ядуу бус хүмүүст зориулагдсан байна (Зураг 3.2.2). АХБ-ны дүн шинжилгээнээс харахад хүүхдийн мөнгө хөтөлбөрийн нийт төсвийн 26.4 хувь нь хүн амын хамгийн бага орлоготой 20 хувьд хүрч байгаа бол 13.2 орчим хувь нь хүн амын хамгийн өндөр орлоготой 20 хувьд хүрч байна. Дэлхийн банк, ҮСХ-ны судалгаагаар мөн ядуу өрхийн 84 орчим хувь, ядуу бус өрхийн 60 орчим хувь нь хүүхдийн мөнгөний хөтөлбөрт хамрагдаж байгаа бөгөөд хүнсний аюулгүй байдал нь эрсдэлд орсон нийт айл өрхийн дөнгөж 11 хувь нь орлогыг орлуулан тооцох аргачлалыг үндэслэн тогтоосон хүнсний

Зураг 3.2.1: Ядуурлын түвшин, Тэгш бус байдал



Тайлбар:


CGE-V Эдийн засгийн тооцооллын ерөнхий тэнцвэрийн V загвар
CGE-U Эдийн засгийн тооцооллын ерөнхий тэнцвэрийн U загвар
Excel НҮБАНДЭЗК-ийн Эксэлд суурилсан загвар



Эх сурвалж: Монгол Улсын CGE загвар, WEFM-е, ESCAP Excel-д суурилсан загвар.

Загварт ашигласан бүх утгууд нь 2017 оны үнэ (өөрөөр хэлбэл инфляцийн тохируулгатай) болно. Хувилбаруудыг загварчлахын өмнө бодит ДНБ, эцсийн хэрэглээ, хөрөнгө оруулалт, цэвэр экспорт, төсвийн алдагдал, засгийн газрын өр зэргийг хуулбарлан тооцох зорилгоор 2019 оны SAM-ыг шинэчилсэн. 2020 оны суурь хувилбарт Засгийн газрын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нөлөөллийг тооцсон болно.

Зураг 3.2.2: Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд, тэдгээрийн санхүүжилт, хамрагдагсдын тоо (зүүн талд), санхүүжилт (баруун талд)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2020

Зураг 3.2.3: Ядуурлын түвшин, өрхийн тэргүүлэгчийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар

	Ядуурлын хамрах хүрээ, хувиар				
	2010	2012	2014	2016	2018
Улсын дундаж	38.8	37.4	21.6	29.6	28.4
Нийт	37.5	25.9	20.2	27.6	27.0
Хөдөлмөр эрхэлдэг					
Хөдөө аж ахуй	56.1	39.3	27.9	39.1	35.9
Үйлдвэр	38.	27.4	24.0	31.7	30.0
Үйлчилгээ	25.8	16.7	12.8	19.8	20.9
Бусад		42.4			
Ажилгүй	51.2	44.0	42.2	48.7	44.9
Ажиллах хүчнээс гадуурх	34.6	25.4	20.0	30.6	29.3
Тодорхойгүй			34.3		

Эх сурвалж: Ажиллах хүчний судалгаа, Үндэсний статистикийн хороо

талон авч байгаа бол ядуу өрхүүдийн 21 хувь нь хүнсний талон авч байна.^[67]

2018 оны ӨНЭЗС-ны дүнгээр хөдөлмөрийн насны нийт хүн амын дунд ажилгүй, эдийн засгийн идэвхгүй хүмүүс хамгийн ядуу байна. Хөдөлмөрийн насны (15 болон түүнээс дээш насны) ажилгүйчүүдийн ядуурлын түвшин 44.9 хувь байна. Хөдөлмөр эрхэлж байгаа таван хүн тутмын нэг нь ядуу гэсэн ангилалд орж байгаагийн зэрэгцээ хөдөлмөр эрхэлж буй эрэгтэйчүүдийн 23.2 хувь, эмэгтэйчүүдийн 21 хувь нь ядуу байна.^[68] Хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн ядуурлын түвшин хамгийн өндөр буюу 35.9 хувь байна (Зураг 3.2.3). КОВИД-19 цар тахлын үед ноос, ноолуур, арьс шир зэрэг мал аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт буурч ханган нийлүүлэлтийн сүлжээ тасалдаж, орлого, хэрэглээнд нь ихээхэн нөлөөлсний улмаас хөдөөгийн малчид багагүй хэмжээний орлогоо алджээ.^[69] Сүүлийн үеийн ядуурлын бууралтад нөлөөлж байсан хамгийн том хүчин зүйл бол малчдын орлогын өсөлт байжээ.^[70]

Энэ нь Монгол Улсад эдийн засгийн салбаруудын цалингийн ялгаа их байгааг, мөн нарийн ур чадвар шаарддаггүй, бага зэрэглэлийн үйлчилгээний ажлын байр зонхилж байгааг харуулж байна.



Дэлхийн банкны судалгаанаас харахад цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг ядуу ажилтнуудын 30 гаруй хувь нь тодорхой ур чадвар шаардахгүй ажил, 40 гаруй хувь нь гар урлал, худалдаа, үйлчилгээний ажил хийж байна. Эсрэгээрээ, цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг ядуу бус арван ажилтан тутмын нэг нь тодорхой ур чадвар шаардахгүй ажил хийдэг бол ядуу бус арван ажилтан тутмын дөрөв нь удирдах албан тушаал, мэргэжлийн болон техникийн албан тушаалд ажиллаж байгаа нь ядуу болон ядуу бус хүмүүсийн цалингийн ялгааг бий болгож байна (Зураг 3.2.4).

67 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк. (2020). Өрхөд суурилсан КОВИД-19 цар тахлын нөлөөлийг тодорхойлох судалгаа.

68 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. (2020). Орлого, зарлагын тэгш бус байдал.

69 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, НҮБХХ-ийн тайлан. (2020 оны 7 дугаар сар). Монгол Улс: КОВИД-19 цар тахлын үеийн ядуурал, тэг бус байдлыг их өгөгдлийг ашиглан судлах нь.

70 Дэлхийн банк. (2021 оын 2 дугаар сар). Монгол Улсын Эдийн засгийн тойм: Тусламж дэмжлэгээс сэргэлт өөд.

Зураг 3.2.4: Цалин хөлстэй ажилтнуудын ажлын төрөл, дундаж цалингийн орлого, 2018**(а) Цалин хөлстэй ажиллагчдын ажил мэргэжлийн төрөл, хэрэглээний тэнцүү таван бүлгээр****(б) Нэг ажиллагчид ногдох жилийн дундаж цалин хөлсний орлого, хэрэглээний тэнцүү таван бүлгээр**

Эх сурвалж: Монгол Улсын Ядуурлыг дүр төрх, Дэлхийн банк/УСХ, 2018

Дэлхий нийтийн чиг хандлагын нэгэн адил Монгол Улсын хүн амын ядуурал нь хүн амын боловсролын түвшинтэй ихээхэн хамааралтай. Тус улсын бүрэн дунд боловсролын хамран сургалтын түвшин бараг 100 хувь хүрэх дөхдөг хэдий ч залуучуудын 70 гаруй хувь нь бүрэн дунд боловсрол эзэмшиж төгсөж байгаа бөгөөд энэ нь хүмүүсийн нийгэм, эдийн засгийн байдлаас нь хамаарч харилцан адилгүй байна. Ядуу айл өрхийн хүүхдүүдийн дөнгөж 10 орчим хувь нь их дээд сургуулийн боловсрол эзэмшсэн байна. Харин чинээлэг айл өрхийн хүүхдүүд эртнээс сургуульд явж эхлэн улмаар удаан хугацаагаар үргэлжлүүлэн суралцаж, мэдээлэл технологитой илүү түргэн танилцаж байгаа нь ядуу болон ядуу бус өрхийн хүүхдүүдийн хооронд хүний нөөцийн чадавхын ялгааг улам бүр нэмэгдүүлж байж болзошгүй юм. КОВИД-19 цар тахлын үед хүн бүрт чанартай боловсрол олгох асуудал улам бүр хурцадсан байна. Түүвэр судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 21 хувь нь теле хичээлийг үздэггүй хэмээн хариулжээ. Боловсрол эзэмших явцад гарч буй эдгээр ялгаа нь залуус сургуулийн орчноос ажил, хөдөлмөрийн талбарт шилжихэд мөн сөрөг нөлөө үзүүлж байна.^[71]

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийн төгсөгчдийн дунд явуулсан хамгийн сүүлийн үеийн судалгаагаар төгсөгчдийн дөнгөж гуравны нэг хүрэхгүй хувь нь МСҮТ-д суралцсан мэргэжилдээ тохирох ажилд орсон байна. МСҮТ-өөс олж авсан мэргэжлээрээ ажиллаагүй дараах гол шалтгаануудыг дурджээ. Үүнд: i) МСҮТ-ийн төгсөгчдийн орсон ажил нь ихэвчлэн цалин бага, хөдөлмөрийн нөхцөл нь муу байсан; ii) төгсөгчид ажлын хангалттай туршлагагүй, мөн МСҮТ-ийн багшлах чадварлаг нөөц дутмаг байснаас эзэмшсэн ур чадвар нь зах зээлийн шаардлагад нийцээгүй; iii) ажилгүйчүүд болон бага орлоготой айл өрхүүдэд үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээ харьцангуй сайжирсан учир залуучуудад хөдөлмөр эрхлэх сонирхол бага болсон; iv) ажил олгогчид МСҮТ төгсөгчдийг бус дээд боловсрол эзэмшсэн хүмүүсийг ажилд авахыг илүүд үздэг зэрэг байна.^[72] Дээд боловсролын салбарт мөн л олон сорилт тулгарч байгаа бөгөөд төгсөгчдийнх нь боловсролын чанар сул, эзэмшсэн ур чадвар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байна. Үүнд чанаргүй олон хувийн их, дээд сургуулиуд ихээхэн нөлөөлж байна.^[73] Амьдрах ухааны

71 Монгол Улс дахь НҮБХС. (2020). *Теле хичээлийн үр дүнгийн үнэлгээ*.72 НҮББШУСБ. (2019). *Монгол Улсын Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын тойм шинжилгээ (Англи хувилбар)*. Үзэх <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374199?posInSet=2&queryId=44cedc2c-c698-42bb-b5fd-cba0f2aa9dad>73 НҮББШУСБ. (2020). *Боловсролын салбар*. Монгол Улсын Боловсролын бодлогын тойм шинжилгээ. Үзэх <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687>

боловсрол нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд “нийцэхгүй” байгаа өсвөр үеийнхний ур чадвар (эрсдэл, эмзэг байдлыг удирдах)-ыг дээшлүүлэх, Монгол Улсын шинэ тутам эдийн засагт тулгарч буй сорилт, гарч буй боломжийг шийдвэрлэх нийтлэг стратеги болж байна.^[74] Бүх шатны боловсролын байгууллагуудын суурь болон дамжуулан хөгжүүлж болох ур чадварын сургалтын аль алинд нь хөрөнгө оруулалт хийснээр илүү өндөр түвшний сэтгэлгээг шаардах сургуульд хүүхдүүд цааш үргэлжлүүлэн суралцах болон ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлнэ. Гэхдээ ийм ур чадварыг эзэмшээгүй өсвөр насны охид, хөвгүүд анхаарлын гадна орхигдож ирээдүйд илүү сайн ажил хөдөлмөр хийх боломжийг эдэлж чадахгүй байх эрсдэл байна.^[75]

Монгол Улсад хоол тэжээлийн дутагдал, хүнсний аюулгүй байдал анхаарал татсан асуудал хэвээр байна. НҮБ-ын ХХААБ-ын мэдээлснээр, бараг 700,000 хүн (хүн амын 22 хувь) идэвхтэй, эрүүл амьдрахын тулд хэрэгцээ, сонголтод нь нийцсэн хүрэлцэхүйц хэмжээний хоол хүнсээр хангагдаагүй байгаа бөгөөд бараг дөрвөн монгол хүн тутмын нэгнийх нь хүнсний аюулгүй байдал дунд буюу ноцтой түвшинд хүрсэн байна.^[76] Хөдөө орон нутгийнхтай харьцуулахад жижиг хот суурин газруудын хүнсний хангамж нь зах зээлээс шууд хамааралтай, зах зээлийн эрс өөрчлөлтөд ихээхэн эмзэг^[77], хэрэгцээт хүнснийхээ 38 хувийг импортоор авдаг бөгөөд нийслэл хотод хүнсний аюулгүй байдал ихээхэн хурцадмал асуудал болж байна.^[78] КОВИД-19 цар тахлын үеэр хүнсний хэрэглээний

үнийн индекст үнлэслэсэн инфляц өмнөх жилийн мөн үеийнхээс өсч найман хувь болсон байна.^[79] Энэ нь ялангуяа орлого багатай ядуу иргэдийн хүнсний аюулгүй байдлыг улам хүндрүүлсэн. НҮБ-ын ХХААБ-аас явуулсан шуурхай судалгааны үр дүнгээс харахад олон айл өрх хүнсний хэрэглээгээ хязгаарлаж (72 хувь), хоол хүнс хүрэлцэхгүй байгаад санаа нь зовж байгаа (47 хувь), хэрэглээний хэмжээг багасгах шаардлагатай болсон (34 хувь) хэмээн хариулжээ.^[80] Хүнсний хэрэглээ ийнхүү тасалдах болсон нь голчлон эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалсан бөгөөд хүнсний бүтээгдэхүүний олдоц, нийгмийн хүртээмжээс ч мөн тодорхой хэмжээгээр шалтгаалжээ. Үүний нэгэн адил Дэлхийн банкнаас явуулсан КОВИД-19 цар тахлын нөлөөллийн талаар утсаар холбогдож авсан өрхийн судалгаанд оролцсон ядуу хүмүүсийн бараг тал хувь нь хангалттай хэмжээний хоол хүнс авч чадаж байгаа эсэх, эрүүл хоол хүнс олж авч байгаа эсэх, хангалттай төрлийн хоол хүнс авч чадаж байгаа эсэхээ мэдэхгүй хэмээн хариулсан байна.^[81]

Монгол Улс сүүлийн 20 жилийн хугацаанд хүүхдийн хоол тэжээлийн дутагдлыг бууруулах чиглэлээр тодорхой ахиц дэвшил гаргасан. 2000-2018 оны хооронд тав хүртэлх насны жингийн дутагдалтай хүүхдийн хувийн жин 12.7 хувиас 1.8 хувь болж, өсөлт хоцролттой хүүхдийн хувийн жин (өндөр нь наснаас нь хамаарч) 24.6 хувиас 9.4 хувь болж тус тус буурчээ. Ийм ахиц дэвшил гарсан хэдий ч тус улсад хоол тэжээлийн дутагдлын давхар дарамт хэвээр байна. 2017 оны Хүн амын хоол тэжээлийн

74 ОУХБ. (2008). *Сургуулиас ажилд шилжигсдийн судалгаа*. Үзэх https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/documents/publication/wcms_105100.pdf

75 НҮБХС. (2018). *Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн Боловсрол, сургалтын тогтолцоог сайжруулах 2 дахь Арван жил*. Үзэх <https://www.unicef.org/eap/reports/improving-second-decade-education-and-learning-east-asia-and-pacific>

76 НҮБ-ын ХХААБ, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан, НҮБХС, Дэлхийн Хүнсний Хөтөлбөр, ДЭМБ. (2020). *Дэлхийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн байдал. Хүнсний тогтолцоог боломжийн үнэтэй эрүүл хооллолтоор өөрчлөх*. Үзэх <https://www.fao.org/documents/card/en/c/ca9692en>

77 Монгол Улс дахь НҮБ-ын ХХААБ. (2019). *Хоол тэжээлийн дутагдал-хямрал үүсч байна уу?* Үзэх <https://www.montsame.mn/en/read/203944>

78 Дэлхийн хүнсний хөтөлбөр. *Өлсгөлөнгийн зураглал*. Үзэх <https://hungermap.wfp.org/>

79 Дэлхийн банк. (2021 оны 1 дүгээр сар). *Монгол Улсад КОВИД-19 цар тахлын нөлөөллийг тодорхойлох утсанд суурилсан өрхийн судалгаа*.

80 Монгол Улс дахь НҮБ-ын ХХААБ. (2020). *Малчид, тариаланчдын дунд хүнс, хөдөө аж ахуйн салбарын түргэвчилсэн үнэлгээ*.

81 *Мөн тэнд*.

байдал үндэсний хэмжээний судалгаагаар хоол тэжээлийн болон хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүд бүс нутгуудаар нилээд ялгаатай байсан бөгөөд Хангай, Баруун бүс, Улаанбаатар хотын гэр хороололд нөхцөл байдал харьцангуй тааруу байгааг илрүүлжээ. Хүн амын бүх бүлгүүдийн дунд бичил тэжээл буюу аминдэм эрдэс бодисын дутагдал нилээд түгээмэл байсан бөгөөд тав хүртэлх насны хүүхдийн дунд хамгийн өндөр тархалттай буюу тэдний 27 хувь нь цус багадалттай, 21 хувь нь төмрийн, 70 хувь нь А аминдэмийн, 90 хувь нь Д аминдэмийн дутагдалтай байжээ. Монгол Улсын нийт хүн амын дунд Д аминдэмийн дутагдал өндөр байгаа бөгөөд жирэмсэн эмэгтэйчүүдийн 95 хувь, эрэгтэйчүүдийн 82 хувь, хүүхдүүдийн 90 хувь нь Д аминдэмийн дутагдалтай байна.

Хүүхэд болон насанд хүрэгчдийн дунд илүүдэл жинтэй, таргалалттай хүмүүсийн хувийн жин нэмэгдэж байна. Ялангуяа сургуулийн насны (6-11 нас) хүүхдүүдийн дунд илүүдэл жин, таргалалтын тохиолдол эрс нэмэгдсэн. Илүүдэл жингийн тархалт 2010 онд 3.7 хувь байсан бол 2017 онд 22.2 хувь болж, таргалалтын тархалт 0.6 хувиас 6.4 хувь болж тус тус өссөн байна. Насанд хүрсэн хүн амын талаас илүү хувь нь илүүдэл жинтэй (Биеийн жингийн индекс ≥ 25), 20 орчим хувь нь таргалалттай (Биеийн жингийн индекс ≥ 30) байна.

Хүүхдийн хооллолтын дадал нилэнхүйдээ сайнгүй байна. Сүүлийн жилүүдэд эхчүүд хүүхдээ хөхөөр хооллох нь цөөрч 2005 онд нийт эхчүүдийн 57 хувь нь хүүхдээ хөхөөр хооллодог байсан бол энэ үзүүлэлт 2018 онд 50 хувь болж буурчээ. Хүүхдийн нэмэлт тэжээлийн хэрэглээ, бүтэц ч хангалтгүй байна. 6-23 сартай хүүхдүүдийн дөнгөж 28 хувь нь нэмэлт тэжээлийг зөвшөөрөгдөх хамгийн бага түвшинд авсан байна. Монгол Улсад эрүүл хооллолт, энэ талын зохистой дадлын талаарх мэдлэг сул, 10 эх тутмын долоо нь бага насны хүүхэд, нярайн зохистой хооллолтын талаарх хангалттай мэдлэг байхгүй байна^[82]. Иймээс насанд хүрэгчид болон хүүхдүүдэд тэдний хоол тэжээлийн

хэрэгцээний талаарх мэдлэг олгож, илүү олон төрлийн хоол хүнс хэрэглэх нь тэдний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд маш чухал болохыг сайтар ойлгуулах хэрэгтэй.

Хүнсний аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхийн тулд технологийн шинэчлэл, эдийн засгийн урамшууллын механизмыг бодлоготойгоор хэрэглэх, нэгдмэл бөгөөд оролцоог хангасан засаглал, дадал зуршлын өөрчлөлтийг шаардах хүнсний тогтвортой тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна. Хөдөө аж ахуйг тогтвортой эрчимжүүлж, хөдөө аж ахуйн өртгийн сүлжээг бэхжүүлэх нь өсөн нэмэгдэж буй хүн амын хүнсний хэрэгцээг хангах, хөдөөгийн ажлын байрыг тогтвортой өргөжүүлэхэд тусална. Хүнсний тогтолцоо, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн удирдлагын уялдаа холбоог шийдвэрлэхэд бодлого, институцийн уялдаа холбоо зайлшгүй чухал юм. Эдгээр чиг хандлага, сорилтуудыг хүлээн зөвшөөрч, Монгол Улсын Засгийн газраас хүн амаа эрүүл, аюулгүй хүнсээр хангах зорилготой 'Эрүүл хүнс - Эрүүл монгол хүн' үндэсний хөтөлбөрийг 2019 онд баталсан.

Монгол Улс эрүүл мэндийн үзүүлэлтээрээ томоохон ахиц дэвшил гаргасан. 2000 онд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 42.4 ногдож байсан бол 2019 онд 16.1 болж буурсан. Нялхсын эндэгдэл 2000 онд 1000 амьд төрөлтөд 32.8 ногдож байсан бол 2019 онд 13.3 болж буурчээ. Сүүлийн хэдэн арван жилд нас баралтын үзүүлэлтүүд үндсэндээ буурсан хэдий ч тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, нялхсын эндэгдэл хөрш орнуудтай харьцуулахад өндөр хэвээр байна (жишээлбэл, БНХАУ-д 1000 амьд төрөлтөд 8.6 болон 7.4, Казахстанд 9.9 болон 8.8 байна). 2000 онд эхийн эндэгдэл 1000 амьд төрөлт тутамд 155 ногдож байсан нь 2017 онд 45 болж буурсан. Ингэснээр эхийн эндэгдлийг гурав дахин бууруулах дэлхийн хэмжээнд тавьсан зорилтыг амжилттай хэрэгжүүлсэн дэлхийн есөн орны нэг нь Монгол Улс болсон билээ.

2019 оны Эрүүл мэндийн үзүүлэлтээс

82 НҮБ-ын ХХААБ, НҮБХС, НҮБХХ. (2007). Хүнсний аюулгүй байдлын талаарх хамтарсан судалгаа.

харахад нийт нас баралтын 58.7 хувь нь зүрх судасны өвчин, хорт хавдраас шалтгаалж, эрүүл мэндийн салбарын төсвийн 70 гаруй хувийг архаг болон хожуу үе шатанд байгаа халдварт бус өвчний өндөр өртөгтэй оношлогоо, эмчилгээнд зарцуулсан байна. 2018 оны байдлаар эрэгтэйчүүдийн дундаж наслалт 66.1 жил, эмэгтэйчүүдийнх 75.8 жил болж нэмэгдсэн хэдий ч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 1992 онд 4.2 байсан бол 2018 онд 2.3 дахин буюу 9.7 болж нэмэгдсэн нэг гол шалтгаан нь халдварт бус өвчин байна. Тамхины хэрэглээ, согтууруулах ундааг эмх замбараагүй хэтрүүлэн хэрэглэх, эрүүл бус хооллолт, хөдөлгөөний хомсдол, илүүдэл жин, таргалалт зэрэг нь эрэгтэйчүүдийн халдварт бус өвчнөөр эндэх гол эрсдэлт хүчин зүйл болж байна. 2019 онд явуулсан Халдварт бус өвчин, осолгэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын үндэсний хэмжээний дөрөв дэх удаагийн судалгаа (STEPS)-нд хамрагдсан 15-69 насны эрэгтэйчүүдийн 39.5 хувь нь өдөр бүр тамхи татдаг, 44.9 хувь нь сүүлийн 30 хоногт согтууруулах ундаа хэрэглэсэн байна. Өсвөр насныхны эрүүл мэнд, тэр дундаа нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэнд, хоол тэжээл, гэмтэл бэртэл, мансууруулах бодисын хэрэглээ зэрэг нь эрүүл мэндийн салбарын эн тэргүүнд анхаарах асуудал болж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нийлүүлэлт тал дээр өсвөр насныхны эрүүл мэндийн чиглэлээр дагнан мэргэшсэн мэргэжилтнүүд, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд, сэтгэл зүйч зэрэг хүний нөөц дутагдалтай байгаа гэх мэт олон асуудал байна. Мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй холбоотой бэрхшээлүүд ч байна. Тухайлбал, эрүүл мэндийн салбарын алдаа дутагдлыг дутуу тайлагнах, тусламж үйлчилгээ хүсэх дадал төлөвшөөгүй, өсвөр насныхныг эрүүл мэндийн эрсдэлээс сэргийлэх, даван туулахад нь тус болох нийгэм-сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх ур чадвар хангалтгүй зэрэг асуудал ч байна. Эрүүл мэндийн салбарын мэдээгээр Монгол Улсад 2003 онд 10-

14 насныхны амиа хорлолт энэ насны хүүхдүүдийн эндэгдлийн 3.3 хувийг эзэлж байсан бол 2018 онд 13.6 хувь болж дөрөв дахин өсчээ. 2018 оны байдлаар Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн 14 орны дунд Монгол Улсын 10-19 насны хөвгүүдийн амиа хорлолтын үзүүлэлт хамгийн өндөр байна.

Дэлхийн банкны тооцоогоор 2018 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулах хүмүүсийн халаасны зардал эрүүл мэндийн урсгал зардлын 32.3 хувьтай тэнцэж байна.^[83] Энэ нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын дунджаас дээгүүр байгаа хэдий ч энэ нь эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрт хамрагдаагүй эмзэг бүлгийн хүмүүс эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад нь дарамт болохын зэрэгцээ тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг тэгш бус байдалд хүргэж болзошгүй байна. Тухайлбал, Улаанбаатар хотод албан ёсны бүртгэлгүй, эрүүл мэндийн даатгалд хамрагдах эрхгүй дотоодын шилжин суурьшигчид, малчид зэрэг алслагдсан бүс нутагт амьдарч буй хүмүүсийн хувьд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж онцгой анхаарал татаж байгаа асуудлын нэг болж байна.

Нийтийн ахуйн үйлчилгээний хувьд ялангуяа гэр хороололд амьдарч байгаа хүмүүсийн ариун цэврийн зохистой байгууламж, найдвартай халаалтын эх үүсвэр зэрэг асуудалд дээр сорилт бэрхшээл байсаар байна. 2018 онд арван ядуу хүн тутмын долоо нь дэд бүтцийн суурь үйлчилгээний аль нэгийг нь (ундны ус, ариун цэврийн сайжруулсан байгууламж, халаалтын тогтвортой эх үүсвэр) авч чадаагүй байна. Үүнд тэдний амьдарч байгаа сууцны төрөл (гэр) болон амьдарч байгаа байршил (алслагдсан хөдөө орон нутаг, хот суурингийн гэр хороолол) голчлон нөлөөлж байна. Өндөр орлоготой хэсгүүд хүртэл ороод, нийслэл хотод, хаана ч нийт хүн амын 40-60 орчим хувь нь зохистой ариун цэврийн байгууламжгүй, хуучирч муудсан халаалтын эх үүсвэр зэргээс болж таагүй орчинд амьдарч байна. Эдгээр үйлчилгээний хүртээмж аймгуудаар ихээхэн ялгаатай байгаа бөгөөд ялангуяа Хангайн

83 Дэлхийн банк. Хувь хүнээс гарсан зардал. (эрүүл мэндийн урсгал зардлын хувь). Үзэх <https://data.worldbank.org/indicator/SH.XPD.OOPC.CH.ZS?locations>

болон Баруун бүс нутагт хамгийн хүнд байна.^[84] Нийт хүн амын 15 орчим хувь нь гадаргын болон баталгаагүй эх үүсвэрээс ундны усаа авч хэрэглэж байгаа бөгөөд 10 орчим хувь нь ил задгай бие засдаг хэвээр байна. Ялангуяа хөдөө орон нутагт ариун цэврийн зохистой байгууламжийн хүртээмж хязгаарлагдмал бөгөөд нийт хүн амын ердөө 50 орчим хувь нь нийтийн эзэмшлийн бус ариун цэврийн байгууламж ашиглах боломжтой байна. Хүний эрх, ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгч мөн л Монгол Улсад ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн тэгш бус байдалд нөлөөлж буй хавсарсан олон асуудал байгааг онцлон тэмдэглээд энэхүү ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн тэгш бус байдлыг шийдвэрлэхийн тулд хүний эрхийг ханган хамгаалах байр сууринаас хууль эрх зүй, бодлого, институцийн болоод технологийн шийдэл нэн шаардлагатай болохыг дахин сануулсан. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой хүний эрхийн асуудлыг шийдвэрлэхэд саад тээг болж байгаа ус, ариун цэврийн салбарын институцийн зохицуулалтыг шийдвэрлэхэд чиглэсэн цөөнгүй арга хэмжээг Тусгай илтгэгч зөвлөмж болгосон.^[85]

Нийт ядуу хүн амын 30.8 хувь нь амьдарч байгаа хөдөө орон нутгийнхаас хот суурин газрын ядуурлын түвшин (27.2 хувь) харьцангуй бага байгаа^[86] хэдий ч тэдний амьдрах нөхцөл эмзэг бүлгийн малчин өрхүүдийнхээс ч илүү муу байна. 2018 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны дүнгээс харахад улсын хэмжээнд нийт хүн амын дөнгөж 31 хувь нь хоол унд хийх, халаалт, гэрэлтүүлэг зэрэгтээ цэвэр түлш,

технологи ашиглаж байна. Нийт ядуу хүн амын 45.8 орчим хувь нь Улаанбаатар хотод амьдарч байгаа бөгөөд маш олон тооны гачигдал дутагдлын асуудалтай тулгарч байна. Улаанбаатар хотын нийт оршин суугчдын тавны гурав (гол төлөв дотоодын шилжин суурьшигчид) орчим хувь нь амьдарч байгаа хот тойрсон захын хорооллуудад буюу гэр хороололд дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ байхгүй байна. Эдгээр оршин суугчид өвлийн саруудад нүүрс түлж гэр орноо дулаацуулахаас өөр аргагүйд хүрдэг учир түүнээс үүдсэн утаа униар хотыг нэлэнхийд нь бүрхэж ялангуяа өвлийн улиралд нийслэл хотоо дэлхийн хамгийн их бохирдолтой хот болгож байна. Гэр хорооллын олон хэсгээр тээврийн хэрэгсэл зорчих боломж муутай, ус зайлуулах шугам шуудуугүй, замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдаагүй, их хэмжээний тоосжилт үүсдэг гэх зэргээр гэр хорооллын дундуурх ямар ч төлөвлөлтгүй, засвар хийцгүй олон шороон замууд оршин суугчдын тулгамдсан асуудлын нэг болж байна. Гэр хорооллоос үүсч буй хатуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах асуудал ч мөн эмх замбараа муутай, сард нэг удаа, заримдаа бүр гурван сард нэг удаа ачиж зайлуулж байгаа нь маш таагүй төдийгүй хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулахаар байна.

КОВИД-19 цар тахлын дэгдэлт нь нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь хэр чухал болохыг анхааруулсан бөгөөд эдгээр салбарын онцгой байдлын үеийн бэлэн байдлыг сайжруулах, хүн амын бүх бүлэгт, ялангуяа өнөөгийн тогтолцоонд орхигдох хамгийн өндөр эрсдэлтэй хүмүүст үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх боломжоор хангахын тулд шинэчлэл хийх шаардлагатай байгааг харуулж байна.

84 Мөн тэнд.

85 Монгол Улсад айлчилсан Хүний эрх, ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан. (2018 оны 7-р дугаар сарын 18-ны өдөр). Үзэх A/HRC/39/55/Add.2 (accessible from <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G18/222/08/PDF/G1822208.pdf?OpenElement>)

86 Дэлхийн банк, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. (2018). *Ядуурлын дүр төрх*. Үзэх <https://www.worldbank.org/en/country/mongolia/publication/mongolia-poverty-update>

3.3 ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТИЙН ШИНЖИЛГЭЭ


Монгол Улсад 1990-ээд оны эхэн үеэс төвлөрсөн төлөвлөгөөт, Зөвлөлт Холбоот Улсаас хараат байсан эдийн засгийг бие даасан, зах зээлд суурилсан эдийн засагт шилжүүлэх үйл явц эхэлснээр Монгол Улсын эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтийн эхний давалгаа эхэлсэн. Энэ үед Монгол Улс эдийн засгийн бүтцийг сууриар нь өөрчлөх 'огцом' либералчлах буюу 'шок эмчилгээ' шинэчлэлийн стратегиа баталсан^[87] нь улсын эдийн засагт болон хүн амын амьжиргаанд ноцтой цохилт өгсөн. Боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр гэх мэт төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээ ихээхэн хэмжээгээр хумигдсан. Өргөн цар хүрээг хамарсан хувьчлал явагдсанаар төрийн өмчийн олон жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн газрууд хаагдсан нь ажилгүйдлийн түвшин нэмэгдэхэд ихээхэн нөлөөлсөн (Зураг 3.3.1). 1990-ээд оны эхэн үед гаргасан бодлогын шийдвэрүүдийн үр нөлөө одоо ч мэдрэгдсэн хэвээр байгаа бөгөөд ядуурал,

тэгш бус байдал нь улс орны нийгэм, эдийн засгийн дүр төрхийг илэрхийлэх гол шинж тэмдэг болсон. Тус улсын шилжилтийн үйл явц нь зах зээлийн эдийн засгийг удирдах чадварлаг институцгүйгээр, урьдчилсан бэлтгэл багатай, маш түргэн хугацаанд явагдсанаас эмх замбараагүй байдал үүсч байсан хэмээн АХБ-ны судалгаа дүгнэжээ.^[88]

Зах зээлд суурилсан тогтвортой эдийн засагт шилжих бүтцийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд Монгол Улс Төв Азийн бусад олон орноос илүү сайн ажиллаж байгааг Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны 2020-2021 оны Шилжилтийн тайланд дурдсан байна.^[89] Ийнхүү зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцад мэдэгдэхүйц ахиц гарсан хэдий ч тус улсын эдийн засгийн өсөлтөд байгалийн баялгийн олборлолт давамгайл нөлөөлөл үзүүлсэн хэвээр байгаа нь Монгол Улсын эдийн засаг бие даан тогтвортой өсч хөгжихөд шаардагдах бүтцийн өөрчлөлтийг хараахан хийж чадаагүй байна гэсэн болгоомжлолыг улам бүр нэмэгдүүлж байна.^[90] Энэ нь ялангуяа гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын урсгал тогтмол буурч байгаа болон авлига, улс төрийн тогтворгүй байдал зэрэг засаглал, институцийн хөрөнгийн асуудлууд 2016-2020^[91] онд суларсантай холбоотой юм. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих явц гучин жилийн өмнө эхэлсэн хэдий ч Монгол Улсын эдийн засагт шилжилтийн үеийн олон шинж төрх хадгалагдсан хэвээр байна.

Монголын эдийн засгийн бас нэг онцлог бол байгалийн баялгийн арвин их нөөцтэй бөгөөд энэхүү нөөцийн хэмжээ нь нэг их наядаас гурван их наяд ам.долларт

Зураг 3.3.1: Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, 1991-2020



Эх сурвалж: АХБ, Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгаа, 2020 оны 6-р сар

87 'Шок эмчилгээ' стратегийн мөн чанар нь 1991 оноос эхэлсэн төр засгийн хяналтыг татан буулгах (үнийн чөлөөлөлт) үйл явц нь төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг хувьчлах замаар өмчлөлийн хэлбэрийг өөрчлөн шинэчлэхэд оршиж байсан.

88 АХБ. (2020 оны 6 дугаар сар). *Монгол Улсын хэтийн төлөв*. Үзэх <https://www.adb.org/publications/mongolia-economic-prospects>

89 Шилжилтийн чанарын үнэлгээнүүд (ATQs) нь маш олон тооны үзүүлэлт, тогтмол хийсэн үнэлгээнүүдийг нэгтгэсэн нийлмэл индексүүд юм. Энэ нь ЕСБХБ-ны 2018 онд баталсан зах зээлийн тогтвортой эдийн засгийн шинэ аргачлал бөгөөд өрсөлдөх чадвартай, сайн засаглалтай, ногоон, хүртээмжтэй, эрсдлийг даах чадвартай, нэгдмэл гэсэн зургаан шинжээр тодорхойлогдоно.

90 Мөн тэнд.


91 ЕСБХБ. *Шилжилтийн тайлан 2020-2021*.

хүрэхээр тооцоотой байна (ОУВС 2015). АХБ-ны тооцоогоор тус улс нүүрсний нөөцөөрөө дэлхийд 11-т, зэсийн нөөцөөр 14-т орж байна.^[92] 2000-аад оны эхээр нүүрсний томоохон ордууд, алт зэсийн хүдрийн ордууд шинээр илрүүлснээр уул уурхайн салбарын эдийн засгийн ач холбогдол улам бүр нэмэгдсэн. Ялангуяа тус улсын уул уурхайн хамгийн том төсөл болох Оюутолгойн зэсийн уурхайн үйл ажиллагаа 2009 онд эхэлснээр үндсэндээ хөдөө аж ахуйд суурилж байсан эдийн засгаас байгалийн нөөцөөс хамааралтай эдийн засагт шилжих шилжилтийн чухал үе үүдээ нээсэн. 2000 онд тус улсын ДНБ-ий аравны нэг хувийг бүрдүүлж байсан уул уурхайн салбар бол өнөөдөр дөрөвний нэг хувийг бүрдүүлэх болсон. ГШХО уул уурхайн салбарт төвлөрч байна. Уул уурхайн салбарт 2000 онд ГШХО-ын 44 хувь орж байсан бол энэ нь 2019 онд 73 хувь болж нэмэгдсэн байна. Ашигт малтмалын экспорт нь нийт

экспортын 90 орчим хувийг, төсвийн орлогын 26 хувийг тус тус бүрдүүлж байна. Монголын байгалийн баялгийн түрээсийн орлого 2004 оноос хойш мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдэж, эдийн засгийн бүтэц, орлогоороо адил төстэй болон жишиг бусад орнуудаас хэдийнээ давсан байна.^[93] (Зураг 3.3.2, 3.3.3)^[94].

Монголын эдийн засаг байгалийн баялгаас ихээхэн хамааралтай байгаа нь түүхий эдийн үнийн хэлбэлзэл, худалдааны гол түншүүдийн бизнесийн мөчлөг зэрэг гадны нөлөөнд нэн эмзэг болгож байна. 2009 оноос хойш ДНБ-ий жилийн дундаж өсөлт 1.3 хувиас 17.3 хувийн хооронд хэлбэлзэж байсан нь дэлхийн хэмжээнд гарч байсан хамгийн өргөн далайцтай хэлбэлзэл байсан. Засгийн газраас түүхий эдийн үнийн уналт, сэргэлтийн мөчлөгт тохирсон төсвийн зохистой бодлого хэрэгжүүлж чадаагүй бөгөөд, ялангуяа түүхий эдийн

Зураг 3.3.2: Монгол Улсын эдийн засагт оруулж буй уул уурхайн салбарын хувь нэмэр



Зураг 3.3.3: Монгол Улсын уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин, адил төстэй орнуудтай харьцуулахад



Эх сурвалж: Дэлхийн банк, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тойм судалгаа, 2020 оны 9-р сар


92 АХБ. (2020 оны 6 дугаар сар). *Монгол Улсын хэтийн төлөв*. Үзэх <https://www.adb.org/publications/mongolia-economic-prospects>

93 Дэлхийн банк. (2020 оны 9 дүгээр сар). *Дэлхийн банкны тайланд эдийн засгийн бүтэц, орлогоор адил төстэй орнуудаар: Армени, Казахстан, Колумб, Оросын Холбооны Улс (ОХУ), Перу, Гайана, Эквадор улсуудыг, эдийн засгийн бүтэц нь адил боловч өндөр орлоготой жишиг орнуудаар: Австрали, АНЭУ, Канад, Малайз, Чили улсуудыг сонгосон. Адил төстэй болон жишиг орнуудыг сонгохдоо эдийн засгийн бүтэц, хүн амын тоо, эдийн засгийн хөгжил, нэг хүнд ногдох орлого зэрэг үзүүлэлтийг харгалзан сонгосон аж. Эх сурвалж: Дэлхийн банк. Уул уурхай ба оюун ухаан: Байгалийн баялгийн өгөөжийг инситүц болон хүний хөгжилд чиглүүлэх нь*. Үзэх <https://openknowledge.worldbank.org/handle/10986/34551>

94 Дэлхийн банк. (2020 оны 9 дүгээр сар). *Уул уурхай ба оюун ухаан: Байгалийн баялгийн өгөөжийг инситүц болон хүний хөгжилд чиглүүлэх нь*. Үзэх <https://openknowledge.worldbank.org/handle/10986/34551>

үнийн уналтын^[95] үед нь байгалийн баялгаа хуримтлуулж, түүхий эдийн үнийн сэргэлтийн үед нь зээлийг нэмэгдүүлэх замаар төсвийн алдагдлаа дорвитой зохицуулах боломжийг ашиглаагүй байна. (Зураг 3.3.4). Монгол Улс ОУВС-гийн зургаан удаагийн зээлийн хөтөлбөрт хамрагдсан^[96] нь тус улс зөвхөн 1990-ээд оны эхэн үеийн шилжилтийн үед тулгарч байсан сорилт бэрхшээлүүд төдийгүй байгалийн баялгаа макро-эдийн засгийн бодлогын хүрээнд үр дүнтэй удирдан шийдвэрлэж чадахгүй байсныг харуулж байна.^[97]

Зураг 3.3.4: Монгол Улс: Түүхий эдийн үнийн Уналт, Сэргэлтийн мөчлөг





Эх сурвалж: Дэлхийн банк, Төсвийн зардлын тойм судалгаа 2018

2017-2019 онуудад төсвийн шинэчлэл хийсний дараахан КОВИД-19 цар тахлын нөлөөг сааруулах зорилготой төсвийн томоохон дэмжлэгийн улмаас 2020-2021 онд төсвийн алдагдал, улсын өр их хэмжээгээр нэмэгдсэн. Төсвийн зардал 2019 онд ДНБ-ий 32 хувьтай тэнцэж байсан бол 2020 онд ДНБ-ий 38 хувь болж өссөн нь үндсэндээ хүн бүрт олгосон нийгмийн халамжийн зардал 2019 онд ДНБ-ий найман хувь байсан бол 2020 онд 13 хувь болж

өссөнөөс шалтгаалсан. Энэ үзүүлэлтээрээ Монгол Улс адил төстэй эдийн засгийн бүтэц, орлоготой улс орнуудынхаас хол давсан (Зураг 3.3.5). Хүн бүрт олгосон нөхцөлт бус мөнгөн тэтгэмж, тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрүүдийн хувийн жин бусад улс орнуудтай харьцуулахад өндөр хэвээр байгаа бөгөөд нийт нийгмийн халамжийн зардлын 69 хувь, 24 хувийг тус тус эзэлж байна (Зураг 3.3.6).^[98] Монгол Улсын КОВИД-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн яаралтай тусламжийн арга хэмжээ нь ядуурлыг нэмэгдүүлэхээс сэргийлж байсан хэдий ч эдгээр арга хэмжээ нь маш өндөр өртөгтэй байсан төдийгүй тус улсын ирээдүйн төсвийн тогтвортой байдалд сэргөөр нөлөөлнө хэмээн ОУВС болон Дэлхийн банк үзэж байна.^[99]

Монгол Улсын төсвийн орлого нь уул уурхайн орлогоос ихээхэн хамааралтай төдийгүй татварын суурь багатай зэргээс шалтгаалан хэдийнээ тогтворгүй болсон байна. Тус улсын төсвийн орлого 2019 онд ДНБ-ий 30 хувьтай тэнцэж байсан бол КОВИД-19 цар тахлын үед буюу 2020 онд 26 орчим хувь болж буурчээ. Хөрөнгө оруулалт болон нүүрсний экспорт буурсан нь үйлдвэрлэл, хэрэглээний татварын орлогод ч сэргөөр нөлөөлжээ. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) болон холбогдох ногдол ашиг, үл хөдлөх хөрөнгийн ашгийн татвар зэрэг шууд татварууд ч огцом буурчээ. Орлогын алдагдал нь ялангуяа уул уурхайн салбарын орлого (роялти, ААНОАТ, газрын тосны орлого)-оос хамгийн их хамааралтай байна. Үүний уршгаар, 2019 онд ДНБ-ий хоёр хувьтай тэнцэж байсан Монгол Улсын нэгдсэн төсвийн алдагдал 2020 онд ДНБ-ий 12 хувьд хүрч^[100], улмаар 2020 онд ДНБ-ий 77.4 хувьтай тэнцэх хэмжээний улсын өр хуримтлагдсан

95 Дэлхийн банк. (2018). Өрийн дарамтгүй, тогтвортой бөгөөд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох нь: Төсвийн орлого, зардлын үр ашгийг нэмэгдүүлэх нь. Монгол Улсын төсвийн зардлын тойм судалгаа.
 96 Монгол Улс 1991 онд ОУВС-д элссэн цагаасаа хойш нийт зургаан удаагийн ОУВС-гийн Зээлийн хөтөлбөрт хамрагдсан. Тухайлбал, 1991 онд Стэнд бай буюу богино хугацааны хөтөлбөр; 1993, 1997 онуудад бүтцийн өөрчлөлтийг сайжруулах хөтөлбөр; 2001 онд ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөр; 2009 онд Стэнд бай буюу богино хугацааны хөтөлбөр; болон 2017 онд Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр зэрэг болно. ОУВС 2009, 2019b.
 97 АХБ. (2020 оын 6 дугаар сар). Монгол Улсын Эдийн засгийн төлөв байдал. Үзэх <https://www.adb.org/publications/mongolia-economic-prospects>
 98 Монгол Улс: ОУВС-гийн Дүрмийн IV Заалтын 2021 оны Зөвлөлдөх уулзалтын тайлан. (2021 оны 11-р дүгээр сарын 3-ны өдөр).
 99 Дэлхийн банк. (2020). Бодлогын зөвлөмж: Монгол Улс Хүн капиталд оруулах хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх нь.
 100 Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо. Үзэх <https://www.1212.mn>

Зураг 3.3.5: КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний төсвийн дэмжлэг (ДНБ-д эзлэх хувиар)**Зураг 3.3.6: Нийгмийн халамжийн нийт зардал (ДНБ-д эзлэх хувиар)**

Эх сурвалж: ОУВС-ийн Дүрмийн IV Заалтын 2021 оны Зөвлөлдөх уулзалтын тайлан, 2021 оны 11-р сарын 3

бөгөөд энэ нь 2021 онд үргэлжлэн нэмэгдсээр байна. ОУВС-гийн тооцоогоор 2022 онд төсвийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх хэдий ч дунд хугацаанд төсвийн тэнцэл муудах төлөвтэй байна. Төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх гол хүчин зүйлс нь төсвийн зардал тал юм. Тухайлбал, 2022 оны төсөвт нийгмийн халамжийн томоохон зардлууд төлөвлөгдсөн; төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг байнга хүндрэлд оруулж байгаа том хэмжээний хөрөнгийн зардлууд, мөн тэтгэвэр, боловсрол, эрүүл мэндийн зардлын байнгын өсөлт зэргээс шалтгаалж төсвийн зардал ихээхэн нэмэгдэхээр байна.^[101]

Монгол Улсын хувьд байгалийн баялгаа эдийн засгийн амжилт болгон хувиргаж чадахгүй нөөц баялаг ихтэй олон орнуудын нэгэн адил баялгийн хараалын нөлөөнд өртөж байна. Монгол Улсад ДНБ-ий өсөлт өндөр байхад ч Монгол Улсын нэг хүнд ногдох орлого бага байсан бөгөөд КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засгийн нөлөөллийн улмаас 2020 онд нэг хүнд ногдох орлого 11.6 сая төгрөг буюу 4,128 тэрбум ам.доллар^[102] болсон нь 2019

оны түвшнээс 7.8 нэгж хувиар доогуур байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшний өсөлт эдийн засгийн өсөлтөөс удаан байгаа буюу 2000-2017 оны хооронд эдийн засгийн өсөлтийн нэг хувь тутамд хөдөлмөр эрхлэлтийн түвшний 0.5 нэгж хувийн өсөлт ногдож байна^[103]. Эдийн засгийн өсөлт нь бүтээмжийн тогтвортой өсөлтөөс илүүтэй бараг бүхэлдээ хөрөнгийн хуримтлал, байгалийн нөөцийг эрчимтэй ашиглах замаар бий болжээ. 2016 онд 29.6 хувь байсан ядуурлын түвшин 2018 онд 28.4 хувь болж буурсан нь хангалттай цалинтай ажлын байрыг олноор бий болгосны үр дүн биш харин хэт өгөөмөр нийгмийн халамжийн тогтолцоог бий болгосонтой холбоотой юм.^[104]

Салбаруудын бүтцийн өөрчлөлтийн хандлагыг даган (Зураг 3.3.7) бүтээмж багатай хөдөө аж ахуйн салбараас ажиллах хүч олноор гарч эхэлснээр 2000 онд^[105] 48.6 хувь байсан хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөр эрхлэгчдийн хувийн жин 2019 онд 25 хувь болж буурчээ. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйлүүдийн нэг бол 2000-2002 оны

101 Монгол Улс: ОУВС-гийн Дүрмийн IV Заалтын 2021 оны Зөвлөлдөх уулзалтын тайлан. (2021 оны 11-р дүгээр сарын 3-ны өдөр).

102 Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо. Үзэх <https://www.1212.mn>

103 Мөн тэнд.

104 Дэлхийн банк. (2020 оны 9 дүгээр сар). Уул уурхай ба оюун ухаан: Байгалийн баялгийн өгөөжийг инситүц болон хүний хөгжилд чиглүүлэх нь. Үзэх <https://openknowledge.worldbank.org/handle/10986/34551>


105 АХБ. (2020 оын 6 дугаар сар). Монгол Улсын Эдийн засгийн төлөв байдал. Үзэх <https://www.adb.org/publications/mongolia-economic-prospects>

зудын^[106] гамшиг байсан бөгөөд энэ үеэр мал сүргээ олноор алдаж малгүй болсон малчид хөдөө орон нутаг дотроо болон хот суурин газрууд руу арай дээр амьжиргаа хайж шилжин суурьших болсон байна. Гэхдээ эдгээр ажиллах хүчний дийлэнх нь харьцангуй бүтээмж багатай үйлчилгээний салбарт орсоноор үйлчилгээний салбарын ажиллах хүчний хувийн жин 2000 онд 37.2 хувь байсан бол 2019 онд 62 хувь болж өсчээ.^[107] Бодитоор харвал сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд Монгол Улсад “бэлчээрийн мал аж ахуйгаа орхих” үзэгдэл газар авах болсны зэрэгцээ бэлчээрийн мал аж ахуйн үйл ажиллагаа хумигдаж эхэлсэн нь эдийн засаг, экологийн хүчин зүйлээс шалтгаалсан байж болохоос гадна хүмүүс ч өөрсдийн хүслээр зах зээлийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохоор шилжин суурьших болсон нь нөлөөлж байна. Хөдөөнөөс хот суурин руу хүмүүс олноор шилжин суурьших болсонд нөлөөлөх олон хүчин зүйлс байсны хажуугаар хүмүүс өөрсдөө ч аж амьдралаа өөрчлөхийг хүссэн нь тодорхой юм. Нөгөө талаас, экспортын чанар хангасан ноолуур, арьс ширний үйлдвэрлэл, сүү, махны чиглэлийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бэлчээрийн мал аж ахуйг эдийн засгийн

эргэлтэд оруулах үйл хэргийг нэмэгдүүлснээр нийт малын тоо толгой богино хугацаанд гурав дахин өсөхөд хүргэсэн.^[108]


Үүний зэрэгцээ, тус улс нь түүхий эдийн мөчлөгөөс хараат, макро эдийн засгийн бодлого зохицуулалт сул байгаа нь нөөцийн хуваарилалтад нөлөөлж Монгол Улсад оруулсан нийт хөрөнгө оруулалтын уул уурхайн салбарт эзлэх хувь ихэнх хувийг шингээж^[109] байхад аж үйлдвэрийн салбарын хөдөлмөр эрхлэлтийн түвшин бараг өөрчлөгдөөгүй хэвээр байна. Үүнээс үүдэж уул уурхайн салбарыг багтаасан аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж харьцангуй өндөр буюу нэг ажилтанд ногдох нэмүү өртөг нь үйлчилгээний салбарынхаас хоёр дахин, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн салбарынхаас дөрөв дахин илүү байна (Зураг 3.3.8). 2019 онд нийт ажиллах хүчний тавны нэгээс бага хувь нь аж үйлдвэрийн салбарт хөдөлмөр эрхэлж байгаагийн таван хувь нь уул уурхайн салбарт, найман хувь нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт хөдөлмөр эрхэлж байгаа^[110] нь өндөр үр бүтээлтэй ажлын байр хэмээн тооцогдож ирсэнээс шалтгаалжээ. НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагын тооцоогоор, КОВИД-19 цар

Зураг 3.3.7: ДНБ-ний бүтцийн өөрчлөлт, салбараар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Статистикийн мэдээллийн сан, www.1212.mn

Зураг 3.3.8: Хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, салбараар



Эх сурвалж: Дэлхийн банк, Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгаа, 2020 оны 9-р сар

106 Зуд гэдэг нь гамшигт үзэгдлийг илэрхийлсэн Монгол өвөрмөц хэллэг юм. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 286 тоот тогтоолоор баталсан ус цаг уур, орчны аюултай, гамшигт үзэгдлийг үнэлэх журмаар зудыг тодорхойлсон байдаг. Зуд гэж өвөл, хаврын цаг агаарын хүндрэлээс мал сүрэг, бэлчээр, усаар нэн гачигдан, турж зутран хорогдох нөхцөл бүрэлдэхийг ойлгоно.

107 Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо. Үзэх <https://www.1212.mn>

108 Монгол Улс дахь НҮБХС. (2019). *Нөхцөл байдлын шинжилгээ: Монголын Өсвөр үеийнхний цогц хөгжлийг ойлгох нь*.

109 Дэлхийн банк. (2020 оны 9 дүгээр сар). *Уул уурхай ба оюун ухаан: Байгалийн баялгийн өгөөжийг инситүц болон хүний хөгжилд чиглүүлэх нь*. Үзэх <https://openknowledge.worldbank.org/handle/10986/34551>

110 Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо. *Статистикийн мэдээллийн сан*. Үзэх <https://www.1212.mn>

тахлын хямрал Монгол Улсын боловсруулах үйлдвэрүүдэд томоохон цохилт өгсөн бөгөөд нийт 110 аж ахуйн нэгжийн 92 хувь нь орлогоо алдаж, тэдгээрийн тал хувь нь ажлын байраа цомхотгох төлөвтэй байна. Жижиг болон томоохон экспортлогч компаниуд ажлын байраа хамгийн ихээр цомхотгох төлөвтэй байна.^[111]

Аж үйлдвэр, үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхлэгчдийн хүйсийн ялгаа өндөр байна. Бөөний болон жижиглэнгийн худалдаа, зочид буудал, зоогийн газар, боловсрол, эрүүл мэндийн салбарт эмэгтэйчүүд түлхүү ажиллаж байгаа бол уул уурхай, барилга, тээвэр зэрэг биеийн хүч шаардсан үйлдвэрүүдэд эрэгтэйчүүд илүү олноор ажиллаж байна. Боловсролын салбарт ажиллагчдын 75 хувь, эрүүл мэндийн салбарт ажиллагчдын 81 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа бол уул уурхай, барилга, тээврийн салбарт ажиллагчдын 80 гаруй хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна.^[112] Эмэгтэй ажилтнуудын сарын дундаж цалин (1,021 мянган төгрөг) эрэгтэй ажилтнуудынхаас (1,223 мянган төгрөг) 20 орчим хувиар бага байна.^[113]

ХАА-н салбарыг оролцуулаад нийт хөдөлмөр эрхлэгчдийн бараг тал хувь нь албан болон албан бус салбарт албан бусаар хөдөлмөр эрхэлж байна. Өвчний улмаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж гэх зэрэг нийгмийн хамгааллын үйлчилгээг хягаарлагдмал хэмжээнд авах болон огт авахгүйгээр олон цагаар ажиллаж байгаагаар хөдөлмөрийн нөхцөл тодорхойлогдож байна. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК)-оос 2016-2017 онд зохион байгуулсан Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдийн хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн эрхийн талаарх судалгаагаар хөдөлмөрийн гэрээгүй, уртасгасан цагаар ажиллуулах, цалин хөлсгүйгээр дагалдуулан

ажиллуулах, ажилтнуудыг дарамтлах, ажлаас үндэслэлгүйгээр халах зэрэг зөвшөөрч үл болох ажлын хэлбэрүүд байгааг илрүүлжээ. Түүнчлэн зам барилга, эрчим хүч, уул уурхайн салбарт эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны стандарт хангалтгүй, хүний амь нас хохирсон осол гарч байгаад анхаарал хандуулах нэн шаардлагатай байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд хууль тогтоомжийн зарим арга хэмжээ авсан хэдий ч хөдөлмөрийн аюулгүй байдал, хяналтын чадавх сул хэвээр байна.^[114]

Азийн бүтээмжийн байгууллагын мэдээлснээр, үндсэн хүчин зүйлсийн бүтээмжийн өсөлт 2010-2015 онд 2.4 хувь байсан бол 2015-2017 онд 1.2 хувь болж мэдэгдэхүйц хэмжээгээр буурч хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн (Зураг 3.3.9) нь шинэ технологи нэвтрээгүй дотоодын зах зээл рүү түлхүү анхаардаг Монголын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн шинэлэг бус дадал хэвшил хэвээр байгаатай холбоотой байна.

Түүнчлэн, Монгол Улсын үндсэн хүчин зүйлсийн бүтээмж 2017 оны байдлаар АНУ-ын үндсэн хүчин зүйлсийн бүтээмжийн дөнгөж 35 орчим хувьтай дүйцэхүйц хэмжээнд байгаа нь эдийн засгийн бүтэц, орлогоороо адил төстэй орнуудаас ихээхэн доогуур байна.^[115] Зураг 3.3.10-аас харахад Монгол Улсын эдийн засгийн өсөлт нь дэвшилтэт эдийн засагтай орнуудын өнөөгийн технологиудыг өөртөө шингээх гэхээс илүүтэйгээр хөрөнгийн хуримтлалд тулгуурлаж байна. Ийм хөгжлийн загвар нь тус улсыг цааш хөгжүүлэхэд хэтэрхий өртөг өндөртэй болгож магадгүй юм. Өнөөгийн байдлаар нийт хөрөнгө оруулалтын ердөө хоёрхон хувийг бүрдүүлж байгаа мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх өндөр боломж байна. Үйлдвэрлэлийн салбарт технологийн дэвшлийг нэвтрүүлэхэд түлхүү

111 НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага (АҮХБ). КОВИД-19 цар тахлын хямралын Монгол Улсын үйлдвэрүүдэд үзүүлэх нөлөөллийн судалгааны тайлан. (2020 оны 4-6 дугаар сар).


112 Дэлхийн банк, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. (2018). *Ядуурлын дүр төрх*. Үзэх <https://www.worldbank.org/en/country/mongolia/publication/mongolia-poverty-update>

113 Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо. Үзэх <https://www.1212.mn>

114 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо.


115 Дэлхийн банк. (2020 оны 9 дүгээр сар). *Уул уурхай ба оюун ухаан: Байгалийн баялгийн өгөөжийг инситүц болон хүний хөгжилд чиглүүлэх нь*. Үзэх <https://openknowledge.worldbank.org/handle/10986/34551>

Зураг 3.3.9: Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийн бүтэц



Эх сурвалж: Азийн бүтээмжийн байгууллагын мэдээллийн сан, 2019

Зураг 3.3.10: Эдийн засгийн өсөлтийн бүтэц, 2010-2017



Эх сурвалж: Азийн бүтээмжийн байгууллагын мэдээллийн сан, 2019


анхаарч байсан өнгөрсөн үетэй харьцуулахад өнөө цаг үеийн бүтээмж муу байгаа Монгол Улсын үйлчилгээний болон хөдөө аж ахуйн салбарт мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлснээр үйлдвэрлэлд ихээхэн ашиг авчрах болно. Монгол Улсын эдийн засагт үйлчилгээний салбар хамгийн өндөр хувь (2019 онд ДНБ-ий 55 хувь) эзэлж байгаа өнөөгийн нөхцөлд үйлчилгээний салбарт мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлж үр нөлөөг дээшлүүлснээр эдийн засгийн хөгжил, бүтээмжийн өсөлтөд асар их нөлөө үзүүлж чадна. Шинэ технологи нэвтрүүлэх, үйлдвэржилт^[116], инновацийг дэмжсэнээр уламжлалт хөдөө аж ахуйгаас гадна агро-бизнесийн салбарт зохистой ажлын байр бий болгоход туслахын зэрэгцээ хөдөө аж ахуйн салбарын тогтвортой эрчимжүүлэлтийг хурдасгаж, бүтээмжийг нэмэгдүүлэх болно.

Монгол Улс нь Төв Азийн шилжилтийн эдийн засагтай орнуудтай харьцуулахад хамгийн нээлттэй худалдааны дэглэмтэй. Ад-валоремын (Ad-valorem) бус тариф^[117], тарифын квот гэх зэрэг тарифын бус хэрэгслүүдийг төдийлэн хэрэглэдэггүй, худалдааны тусгай хамгаалалт үгүй улс


юм. Бизнес, харилцаа холбоо, санхүүгийн үйлчилгээ зэрэг 11 салбарын 6 нь маш нээлттэй салбарууд байна. Мөн Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрт заасан аялал жуулчлал, энэ чиглэлийн үйлчилгээний талаар хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлж байна.

Үүний үр дүнд Монгол Улсын эдийн засгийн худалдааны чиг баримжааг илэрхийлэх үзүүлэлт болох стандарт худалдаа болон ДНБ-ий харьцаа 1980-аад онд дунджаар 40 хувь байсан бол 2010-2019 онд 110 орчим хувь болж өссөн. Үүнд импорт голчлон нөлөөлсөн бөгөөд импортын хэлбэлзэлд мөн ашигт малтмалын экспорт ч нөлөөлсөн байна^[118] (Зураг 3.3.11). 1980-аад оны сүүлчээр Монгол Улс экспортынхоо 90 гаруй хувийг Зөвлөлт Холбоот Улстай, дөрөв хүрэхгүй хувийг БНХАУ-тай хийж байжээ. Экспортын энэ загвар удаах хорин жилд эрс өөрчлөгдсөн байна (Зураг 3.3.12). 2019 оны байдлаар тус улс нийт экспортынхоо бараг 90 хувийг БНХАУ-руу, дөнгөж нэг хувийг ОХУ-руу гаргажээ. Түүнчлэн БНХАУ руу экспортолсон нийт бүтээгдэхүүний 90

Зург 3.3.11: Худалдааны нээлттэй байдал, 1980-2017



Зураг 3.3.12: БНХАУ болон ОХУ-руу хийсэн экспорт, 1987-2017



Эх сурвалж: АХБ, Монгол Улсын Эдийн засгийн төлөв байдал, 2020 оны 6-р сар

116 НУБАҮХБ. (2020). Аж үйлдвэржилтийн хөгжлийн тайлан. Үзэх https://www.unido.org/sites/default/files/files/2019-11/UNIDO_IDR2020-MainReport_overview.pdf

117 ДХБ. Үнэ болон өртөгийн хувиар илэрхийлэгдээгүй тарифыг ад-валоремын бус тариф гэнэ. ДХБ-ын журмаар Монгол Улсад орж ирж буй импортын татварыг 5%-иар (1997 онд 15%-ийн нэгдсэн татвартай харьцуулахад) ногдуулдаг. 2004 онд энгийн дундажийг хэрэглэсэн (хамгийн таатай нөхцөлтэй орон) тариф 5.0% байсан. Үзэх. https://www.wto.org/english/tratop_e/tariffs_e/tariff_profiles_e/mng_e.pdf

118 АХБ. (2020 оын 6 дугаар сар). Монгол Улсын Эдийн засгийн төлөв байдал. Үзэх <https://www.adb.org/publications/mongolia-economic-prospects>

хувийг зэсийн хүдэр, нүүрс, түүхий нефть эзэлж байна^[119].

Монгол Улс нутаг дэвсгэрийнхээ хэмжээгээр далайд гарцгүй орнуудын дунд Казахстаны дараа хоёрдугаарт орж байна. Эдийн засгаараа өөрөөсөө 600, 100 дахин том^[120] БНХАУ, ОХУ-ын дунд далайд гарцгүй байршиж байгаа нь Монгол улсын эдийн засагт болоод хил дамнасан хамтын ажиллагаанд боломж, сорилтын аль алиныг бий болгож байна. Эдгээр хоёр том гүрний хооронд ачаа бараа тээвэрлэх өндөр боломж байгаа хэдий ч төмөр зам, авто замын дэд бүтцийн хөгжил сул учраас Монгол Улсыг дамжин өнгөрөх ачаа тээврийн хэмжээ харьцангуй бага байна. 2014 онд хөрш гурван улс хамтран Монгол Улс-ОХУ-БНХАУ-ын эдийн засгийн коридор (МОХЭЗК)-оор дамжуулан эдийн засгийн харилцаа холбоогоо ойртуулж, дэд бүтэц, аж үйлдвэрийн төслүүдийг хөгжүүлэх зорилгоо албан ёсоор тохиролцсон. Зөвхөн Монгол Улсын талаас авч үзвэл үр өгөөж, зардлын харьцаа харьцангуй өндөр биш бөгөөд БНХАУ, ОХУ-ын талаас шаардлагатай хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг санхүүжүүлэх шаардлагатай байгаа учраас МОХЭЗК-ийн боломжит үр өгөөжийг Монгол Улс хараахан хүртээгүй байна.^[121] Түүнчлэн Монгол Улсын худалдааны тэнцэл, дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн хөгжилд МОХЭЗК-ын нөлөө ямар байх нь одоогоор бүрхэг байна.

Хил дамнасан хамтын ажиллагаа ялангуяа, КОВИД-19 цар тахлын үед онцгой ач холбогдолтой болж байгаа бөгөөд хөдөлгөөний хориг, саадаас болж ноолуур, махны өртөгийн сүлжээ тасалдахад хүрсэн. 2020 оны туршид хилийн нийт 52 боомтын зөвхөн 13 нь үйл ажиллагаа явуулсан. Гадаад нислэгүүд 64.4 хувиар цөөрсөн байна. Алтанбулаг (Монгол

Улс-ОХУ-ын хил) боомтоор зорчих ачаа тээврийн машины тоо 72.7 хувиар, Замын-Үүд (Монгол Улс-БНХАУ-ын хил) боомтоор зорчих ачаа тээврийн машины тоо 63 хувиар тус тус буурчээ.^[122] Энэ нь 2020 оны эхний хагаст БНХАУ-д хийх нүүрсний экспортод сөргөөр нөлөөлж, Монгол Улсын эдийн засаг 2020 оны эхний зургаан сарын байдлаар 9.7 хувиар агшихад нөлөөлсөн байна. Цар тахлын онцгой нөхцөлд хоёр улсын гадаад худалдааг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор Монгол Улс, БНХАУ-ын хооронд “Ногоон гарц” түр журмыг 2020 оны наймдугаар сарын 1-нд хоёр тал тохиролцжээ. Энэхүү арга хэмжээний үр дүнд тус улсын нүүрсний экспорт сэргэж, 2020 оны сүүлийн хоёр улиралд эдийн засгийн эерэг өсөлтийг бий болгож, эдийн засгийн жилийн дундаж агшилтыг 5.3 орчим хувьд хүргэсэн.

Дэлхийн банкнаас нийтэлсэн 2018 оны Ложистикийн гүйцэтгэлийн индексээр (ЛГИ) Монгол Улс 2.37 оноогоор 160 орноос 130-д жагссан байна.^[123] Худалдаа, тээвэртэй холбоотой дэд бүтцийн чанар, ачаа тээшийн бүртгэл, мөшгин хянах чадавхтай холбоотой үзүүлэлтүүдээрээ Монгол Улс нилээд сул гүйцэтгэлтэй байна (Зураг 3.3.13).

Тээвэрлэлтийн дундаж зай 600 км-ээс дээш ачаа тээвэрлэлтийн нийт ложистикийн зардал ДНБ-ий 30 орчим хувьтай тэнцэж байна^[124]. Монгол Улсад агуулахын аж ахуй хөгжөөгүй, түгээлтийн механизм үр ашиггүй байгаа зэрэг нь мал аж ахуйн салбарт болон дотооддоо үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг түгээх, тээвэрлэх, хадгалахад ихээхэн хүндрэл учруулж байна. Энэхүү үр ашиггүй ложистикийн тогтолцооноос болж бараа бүтээгдэхүүний үнэ өсөхийн зэрэгцээ хот суурин газруудад, ялангуяа Улаанбаатар хотод түгжрэл, бохирдлыг улам хөөрөгдөж

119 Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо. *Статистикийн мэдээллийн сан*. Үзэх <https://www.1212.mn>

120 ДНБ нь ердөө 13 тэрбум ам. доллартай (2019) тэнцэж байгаа Монгол Улс бол чинээлэг орны жижигхэн хоттой дүйцэхүйц хэмжээний жижиг эдийн засагтай орон юм.


121 Дэлхийн банк. (2020 оны 11 дүгээр сар). *ИНФРАсап: Харилцан хамааралтай, эдийн засгийг төрөлжүүлэх дэд бүтэц*.

122 Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 13 дугаар тушаалаар КОВИД-19 халдвараас сэргийлэх зорилгоор Хилийн боомтуудад эрсдэлийн үнэлгээ хийх үүрэг бүхий Эрсдэлийн үнэлгээний багийг байгуулсан.

123 Дэлхийн банк. *ЛГИ-ийн ерөнхий оноо нь гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг, худалдаа, тээвэртэй холбоотой дэд бүтцийн чанар, өрсөлдөхүйц үнээр тээвэрлэлтийг зохион байгуулахыг хялбаршуулсан байдал, ложистикийн үйлчилгээний чанар, ачаа тээшийг хянах, мөшгих чадвар, ачаа тээш хүлээн авагчдад товлосон хугацаандаа хүрч байсан тоо давтамж зэрэгт үндэслэсэн ложистикийн талаарх үнэлгээг тусгасан байдаг. Индекс 1-5 хооронд хэлбэлзэх бөгөөд өндөр оноо нь илүү сайн гүйцэтгэлийг илэрхийлнэ*. Үзэх <https://lpi.worldbank.org/international/scorecard/radar/254/C/MNG/2018/C/JPN/2018#chartarea>

124 Узбекистан Улс бол далайд гарцгүй орнуудын нэг бөгөөд ложистикийн зардал нь ДНБ-ий 17 хувь байдаг.

Зураг 3.3.13: Монгол Улсын Ложистикийн гүйцэтгэлийн индекс, бүс нутаг болон шилдэг үзүүлэлттэй орныхтой харьцуулбал (Япон Улс)



Эх сурвалж: Дэлхийн банк

байна. Хэдийгээр дэд бүтцийг хөгжүүлснээр эдийн засгийн алслагдмал байдлыг ойртуулж, хөдөө орон нутагт эдийн засгийн үйл ажиллагаа явуулах боломжийг нээх боловч Монгол Улс өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн амын нягтрал багатай^[125] учраас эдийн засгийн өгөөж тун бага учир улс орныг бүхэлд нь дэд бүтцээр холбох боломж муутай. Иймээс дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргахдаа эдийн засгийн боломжийг нь сайтар судлах шаардлагатай.^[126]

Гадаад улс орнуудад 190 мянга гаруй монголчууд амьдарч байгаа гэсэн мэдээлэл байгаа ч гадаад улсад цагаачилсан хүмүүсийн бодит тоо энэхүү албан ёсны мэдээллээс хамаагүй олон байх магадлалтай. Тэдгээрийн хамгийн олон нь Өмнөд Солонгос, АНУ, Чех,

БНХАУ-д оршин суудаг бөгөөд эдгээр улсууд хөдөө аж ахуйн салбарын шууд хөрөнгө оруулалтын хамгийн их хувийг бүрдүүлж байна.^[127] Хамгийн гол нь гадаадад байгаа 10 монгол хүн тутмын ес нь эдийн засгийн идэвхтэй насны хүмүүс байгаа юм.^[128] Нийгэм, санхүү, соёл урлаг, мэдлэг, холбоо сүлжээ тогтоох зэрэг чадавхаараа гадаадад байгаа Монголчууд буюу Монголын цагаач иргэд нь Монгол Улсын хөгжилд эдийн засаг, нийгмийн ач холбогдлоороо тун чухал юм.

Уур амьсгалын өөрчлөлт, БНХАУ-ын нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах амлалт зэргээс ажиглахад эдийн засгаа төрөлжүүлэхэд чиглэсэн дорвитой арга хэмжээ авахгүй бол Монгол Улсын эдийн засгийн цаашдын төлөв байдал хүндрэлд орж болзошгүй юм. Дэлхийн банкны Ерөнхий тэнцвэрийн тооцооллын загвар (CGE)-ын симуляцийн шинжилгээнээс харахад Монгол Улс уул уурхайн салбараас хамааралтай хэвээр байх аваас БНХАУ-ын нүүрсний эрэлт тогтвортой буурснаар Монгол Улсын экспорт жил бүр дунджаар 1.1 нэгж хувиар, эдийн засгийн өсөлт 0.7 нэгж хувиар тус тус саарахаар байна.^[129] Мөн КОВИД-19 цар тахлын хямрал нэг бүтээгдэхүүн, нэг зах зээлд суурилсан өнөөгийн хөгжлийн зам нь тогтвортой бус^[130] төдийгүй хүртээмжгүй гэдгийг харуулсан бөгөөд макроэдийн засгийн орчны хэт тогтворгүй байдлаас зайлсхийхийн тулд Монгол Улсын эдийн засгийг уул уурхайн салбараас хараат бус болгож төрөлжүүлэх нэн шаардлагатайг бататгаж өгсөн. Монгол Улс макро эдийн засгийн оновчтой бодлого, хүчирхэг институц, дэд бүтэцтэй байснаар олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвараа дээшлүүлж, эдийн засгийн өсөлт, бүтцийн өөрчлөлтөд үзүүлэх чөлөөт худалдааны эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх болно.

125 125.3.2 сая хүн амын 1.4 сая нь нийслэл Улаанбаатар хот болон түүнийг тойрон амьдардаг. Дараагийн томоохон суурин газрууд нь Баян-Өндөр (98 мянган хүн амтай), Дархан (83 мянган хүн амтай) юм. Үлдсэн хэсэг нь хөдөө орон нутагт мал маллан амьдардаг. 100 квадрат км нутаг дэвсгэрт 120 хүн ногдож байна.

126 Дэлхийн банк. (2020 оны 11 дүгээр сар). *ИНФРАсап: Харилцан хамааралтай, эдийн засгийг төрөлжүүлэх дэд бүтэц*.

127 Үндэсний хөгжлийн газар. *Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт татах, сурталчлах төлөвлөгөө*.

128 Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо. *Хүн ам, орон сууцны тооллого*. хуудас153.

129 Дэлхийн банк. (2020 оны 9 дүгээр сар). *Уул уурхай ба оюун ухаан: Байгалийн баялгийн өгөөжийг инситүц болон хүний хөгжилд чиглүүлэх нь*. Үзэх <https://openknowledge.worldbank.org/>

130 "КОВИД-19" цар тахлын халдвар дэгдсэнээс хойш БНХАУ-руу нийлүүлэх нүүрсний экспорт түр зогссоноос шалтгаалж Монгол Улсын эдийн засаг 2020 оны 9 сарын байдлаар 7.3 хувиар агшсан.

3.4 БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчныг хамгаалах асуудал чухал байр суурь эзлэх болсон. Монгол Улс 2014 онд Ногоон хөгжлийн бодлогоо баталсан төдийгүй хэрэгжилтийг нь хянах ногоон хөгжлийн 38 шалгуур үзүүлэлтийг 2017 онд баталж гаргасан. Түүнчлэн 2016 онд Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан бөгөөд түүнийгээ улам өргөжүүлж Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг 2020 онд баталсан билээ. Ийм ахиц дэвшил гарч байгаа хэдий ч хангалттай хэмжээний тоо мэдээлэлгүйгээр “Эх дэлхий”-тэйгээ холбоотой ТХЗ-ын хэрэгжилтийн явцад хяналт тавих боломжгүй юм.

Тус улсын экосистем, амьдралын хэв маяг нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртөх өндөр эрсдэлтэй байна. 1940-2015 оны хооронд агаарын дундаж температур 2.24°C-ээр нэмэгдсэнээр шороон шуургын тохиолдол олширсон, хур тунадасны хэмжээ, давтамж өөрчлөгдсөн, ган гачиг болох нөхцөл бүрэлдсэн зэрэг олон өөрчлөлт хэдийнээ илэрч эхэлсэн. 1961-2010 оны хооронд бүртгэгдэж байсан хүйтэн жавартай өдрүүдийн үргэлжлэх хугацаа 15 хоногоор цөөрч, мөн хугацаанд тохиож байсан зуны халууны үргэлжлэх хугацаа 24 хоногоор нэмэгдсэн байна.^[131] Жилийн арваннэгдүгээр сараас гуравдугаар сарыг дуустал хугацаанд агаарын дундаж температур хасах хэмтэй байдаг бөгөөд агаарын температур хамгийн доод тал нь -50°C хэм хүртэл хүйтэрдэг, зуны улиралд агаарын температур хамгийн дээд тал нь 36°C хэм хүрч халдаг Монгол орны цаг агаарын эрс тэс нөхцөл байдал улам бүр хурцдах төлөвтэй байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, зуд зэрэг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшиг нь байгаль орчны өмнө тулгарч байгаа сорилт бэрхшээлийг улам бүр хурцатгаж байна. Энэ нь ялангуяа бүс нутгийн хэмжээнд хил дамнасан орчны эрүүл ахуйн тулгамдсан асуудлын нэг болох шороон болон элсэн шуургаар илэрч байна.^[132] Агаарын температур нэмэгдэх, хур тунадас багасах зэрэг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн бусад хүчин зүйлс, тэр дундаа хүчтэй салхи шуургын давтамж нэмэгдэх зэрэг нь зарим газар нутгийн хуурайшилтыг улам бүр гүнзгийрүүлж, давтамж олонтой удаан үргэлжилсэн ган гачигт хүргэж байна. Эдгээр бүх хүчин зүйлүүд хавсран сүүлийн гучин жилийн хугацаанд Монголоос гаралтай элсэн болон шороон хүчтэй шуурганы идэвхжил нэмэгдсэн нь бүр цааш хүрээгээ тэлж Солонгосын хойгт хүрэх болсон байна.^[133] Байгалийн гамшигт үзэгдэл хэдийнээ олон давтагдах болсон Монгол Улсад зуд, элсэн болон шороон шуурга зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гамшигт үзэгдлүүд улам бүр олшрох төлөвтэй байна.^[134] Хил дамнасан шороон болон элсэн шуурга нь байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд ноцтой нөлөөлөл үзүүлэхээс гадна зам тээвэр, хүний эрүүл мэнд, хүмүүсийн амьжиргаанд нөлөөлж, хүний амь нас, мал сүргийн ихээхэн хэмжээний хохирол учруулж байгаа бөгөөд хамгийн сүүлд 2021 оны гуравдугаар сард болсон шороон шуурганаар 10 хүний амь нас хохирчээ.^[135]

Уур амьсгалын өөрчлөлт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст харилцан адилгүй нөлөө үзүүлдэг. Өөрөөр хэлбэл нийгэм соёлын давамгайлсан хэм хэмжээ, жендэрийн хэвшмэл ойлголт, ядуурлын түвшин, хөрөнгө, нөөцийг захиран зарцуулах эрх

131 НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц. (2018). *Үндэсний Гуравдугаар тайлан*.

132 НҮБАНДЭЗНК. (2018). *Ази, Номхон далайн бүс нутгийн элсэн болон шороон шуурга: Бүс нутгийн хамтын ажиллагааны боломж, үйл ажиллагаа*.

133 Мидлтон, 2018

134 НҮБ-ын Гамшигийн эрсдлийг бууруулах газар. (2019). *Монгол Улсад Гамшигийн эрсдэлийг бууруулах нь: Төлөв байдлын тайлан*.

135 Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэг. (2021). *Монгол: Элсэн шуурга - Онцгой байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө*. Үзэх <https://reliefweb.int/report/mongolia/mongolia-sandstorm-emergency-plan-action-epoa-dref-operation-n-mdrmn014>

мэдэл зэргээс шалтгаалан эрсдлийг даван туулах боломж, чадавх нь харилцан адилгүй байдаг. НҮБХХ-ийн судалгаанаас харахад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн гамшигт залуу эрэгтэйчүүд шууд өртөх эрсдэлтэй байгаа бол уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн гамшгийн урт хугацааны сөрөг үр дагаварт эмэгтэйчүүд илүү өртөх эрсдэлтэй байна. Гамшгийн дараах нөхцөлд хөдөлмөрийн хуваарь, ажлын ачаалалд эрэгтэйчүүд өртөх нь бага байна. Гэр бүлийн гишүүд нь аливаа төрлийн гамшигт нэрвэгдсэн үед эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, гэрийн ажлын ачаалал ихээхэн нэмэгдэж байна. Үндэсний болон орон нутгийн аль ч түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого, стратеги, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээнд жендэрийн асуудлыг тэр бүр анхаарч үзэхгүй байна.^[136]

Үүний зэрэгцээ засгийн газарт хөдөө аж ахуй, гамшгийн эрсдлийг бууруулах, статистик, байгаль орчин зэрэг асуудал хариуцсан байгууллагуудын хамтын ажиллагааг үр дүнтэй зохицуулах механизм, санхүүжилт дутмаг байна. Энэ нь гамшгийн хорхөнөөл, хохирлын мэдээллийн удирдлага болон эрсдэлийн ерөнхий удирдлагад давхардал, орхигдолыг бий болгоход хүргэж эрсдэлийн удирдлагын гүйцэтгэлийг доголдуулж байна. Тухайлбал, зудын үеийн тусламжийн хөтөлбөрүүд нь малын эрүүл мэнд, малчдын амьжиргааг сайжруулах богино хугацааны арга хэмжээнд голчлон чиглэгдэж байгаа боловч урт хугацаанд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг малчдад бий болгох, мал аж ахуйн үйл ажиллагааг урт хугацаанд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох буюу тогтвортой байдлыг нь хангах зэрэгт чиглэгдэхгүй байна. Түүнчлэн, одоогийн тооцоолол, тоон өгөгдлийн хэрэглээ, түүнийг

хадгалах чадавх нь хангалттай байгаа хэдий ч сар, улирлаар урьдчилсан тооцоолол хийх, уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэлд суурилсан урт хугацааны төлөвлөлт хийхэд шаардагдах загваруудыг бий болгоход хүчин чадал, чадавх нь хангалтгүй бөгөөд үүнд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх шаардлагатай.

Монгол Улсын хот суурин газрууд агаар, хөрс, усны ноцтой бохирдолд өртөж байна. Өвлийн урт улиралд Улаанбаатар хотын агаарын бохирдлын хэмжээ дэлхийд дээгүүрт орох болсон. Тухайлбал, 2020 оны арванхоёрдугаар сард Улаанбаатар хотын агаар дахь РМ 2.5 тоосонцорын агууламж 113 мг/м³, 2021 оны нэгдүгээр сард 104 мг/м³ ^[137] байв. Гэтэл ДЭМБ-ын зөвлөмжөөр хамгийн ихдээ 25 мг/м³ (хоногийн дундаж) байвал хүлцэх буюу зөвшөөрөгдөх хэмжээ гэж тодорхойлсон байдаг. Гэр хорооллынхны галлагаа^[138], дулааны болон цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх нүүрсний технологид суурилсан станцуудаас гарах утаа нь Улаанбаатар хот болон бусад хот суурин газрын оршин суугчид, хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж буй агаарын бохирдлын гол шалтгаан болж байна.^[139]

Агаарын бохирдлоос үүдэлтэй нас баралт 100,000 хүн тутамд 155.9 ногдож байгаа үзүүлэлтээр Монгол Улс агаарын бохирдолд хамгийн ихээр нэрвэгдсэн орны тоонд орж байна. 2018 оны байдлаар хүн амын амьсгалын тогтолцооны өвчлөлийн 20.2 хувийг уушгины хатгалгаа өвчин эзэлж байна. Энэ үзүүлэлт тав хүртэлх насны хүүхдийн дунд өндөр буюу 70.9 хувь байна.^[140] Агаарын бохирдол нь жирэмсэн эхийн хэвлийд бүрэлдэж буй ургийн танин мэдэхүйн хөгжилд сөргөөр нөлөөлж байгааг олон улсын судалгаа шинжилгээ нотолж

136 Уур амьсгалын ногоон сан. (2020 оны 11 дүгээр сар). Жендэрийн үнэлгээ: Монгол Улс.

137 Цаг уур, орчны шинжилгээний газар. (2020 оны 12 дугаар сар, 2021 оны 1 дүгээр сар). Хүйтний улиралд Улаанбаатар хотын агаарын чанарын байдал. Үзэх <http://tsag-agaar.mn/> сайтаас

138 2019 оны Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэлд 'нэн ядуу өрхүүд машины хуучин дугуй, ашигласан тос масло, хаягдал гутал хувцас болон элдэв хог хаягдлыг түлж агаар орчныг бохирдуулж байна'.

139 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газар. (2019). Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл. Үзэх <https://sustainabledevelopment.un.org/memberstates/mongolia>

140 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. (2019). Улаанбаатар хотын гадаад орчны агаарын бохирдол ба эрүүл мэнд. Үзэх http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=air_pollution_health_concerns_UB.pdf&ln=En

байгаа бөгөөд энэ нь Монгол Улсын хүний нөөц, бүтээмжид ч нөлөөлнө. Эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс гадна агаарын бохирдол нь эдийн засагт хүнд дарамт учруулж олон улсын түвшинд ДНБ-ий 6.9 хувьтай тэнцэхээр зардал гарч байна^[141]. 2018 оны байдлаар нийт хүн амын 50 хувь нь хоол ундаа боловсруулахдаа цэвэр эрчим хүчний эх үүсвэр ашиглаж байгаа бөгөөд 2 сая хүн хоол ундаа боловсруулахдаа аргал хөрзөн, түүхий нүүрс ашигласан хэвээр байна.^[142]

Түүхий нүүрс хэрэглэснээс ялгарах нүүрстөрөгчийн давхар ислийн нийт хэмжээ 2010 оныхоос хоёр дахин нэмэгдэж, 2019 онд 35.9 сая метр тонн болжээ.^[143] Монгол Улс дэлхийн нийт нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлын багахан хувийг (0.1 хувь) бүрдүүлж байна. Гэсэн хэдий ч Монгол Улсын нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгаруулалт 11.51 тонн CO₂-экв буюу 2019 онд нэг хүнд ногдох дэлхийн дундаж болох 4.8 тонн CO₂-экв -оос давсан нь анхаарал татаж байна.^[144] Монгол Улсын үүсгэж байгаа нүүрстөрөгчийн давхар ислийн нийт ялгаруулалтын 50 хувийг нүүрсэнд суурилсан эрчим хүчний салбар бүрдүүлж байгаа бол хөдөө аж ахуйн салбар бараг 49 хувийг нь үүсгэж байна. Эрчим хүчний үйлдвэрлэл (сэргээгдэх эрчим хүч болон үйлдвэрлэлийн үр ашиг), эрчим хүчний хэрэглээ (тээвэр, аж үйлдвэрийн эрчим хүчний хэмнэлт, хот байгуулалт) зэрэгт онцгой анхаарал хандуулснаар 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтыг 11.2 Мт CO₂-экв –аар бууруулах боломж байна.

2020 онд болсон Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилтыг ахиулан тодорхойлох

дээд хэмжээний чуулга уулзалтын үеэр Монгол Улс нүүрсхүчлийн хий ялгаруулах, хадгалах, хог хаягдлаас эрчим хүч гаргах зэрэг технологийг нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 27.2 хувиар бууруулах шинэчилсэн зорилт бүхий Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн амлалт авч байгаагаа зарласан.^[145] Эдгээр арга хэмжээг бүрэн хэрэгжүүлснээр бизнесийн ердийн загвартай харьцуулахад 2030 он гэхэд нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалтыг 12 хувиар, агаар дахь нарийн ширхэгтэй тоосонцор (PM_{2.5})-ын ялгаруулалтыг есөн хувиар, азотын давхар исэл (NO_x)-ийн ялгаралтыг 10 хувиар тус тус бууруулна.^[146]

Хөдөө аж ахуйн салбар нь малын тоо толгой өссөнтэй холбоотойгоор хүлэмжийн хийг хамгийн ихээр ялгаруулдаг хоёр дахь том салбар болж байна. Хөдөө аж ахуйн салбар 1990 онд 10.5 сая тонн CO₂-экв хүлэмжийн хий ялгаруулж байсан бол 2017 оны байдлаар 27.3 сая тонн CO₂-экв-д хүрсэн нь 1990 онд 25.9 сая байсан мал сүргийн тоо толгой 2020 онд 67.1 сая болж огцом өссөнтэй холбоотой. Хивэгч мал өсөхийн хэрээр тэдний гүзээн дэх микро организмын исэлдэлээс гарах хий болон өтөг бууцаас ялгарах хүлэмжийн хий нь салбарын нийт хүлэмжийн хийн ялгарлын 57.3 орчим хувийг буй болгож байгаа бөгөөд бусад эх үүсвэрүүд, газрын CO₂ ялгаруулдаггүй бусад эх үүсвэрүүд нийлээд хүлэмжийн хийн ялгарлын 41.2 хувийг бүрдүүлж байна. Малыг өсөлтийг хязгаарлах, журамлах, малын өтгө бууцны менежментийг сайжруулах арга

141 Эрүүл мэндийн яам, АХБ, НҮБХС. (2020). *Эх, хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх агаарын бохирдлын нөлөөг бууруулах нь: Шинжлэх ухааны нотолгоо, олон нийтэд зориулсан зөвлөмжүүд.*

142 Олон улсын эрчим хүчний байгууллага, Олон улсын Сэргээгдэх эрчим хүчний агентлаг, НҮБСХ, Дэлхийн банк, ДЭМБ. (2020). *ТХЗ 7-ын хэрэгжилт: Эрчим хүчний тайлан.* Дэлхийн банк. Вашингтон хот.

143 НҮБАНДЭЗНХ. *ТХЗ-ын мэдээллийн сан.* Үзэх [https://dataexplorer.unescap.org/vis?dq=MNG..FOSSIL_CO2_EMISSIONS.A&p-d=2010%2C2020&frequency=A&lc=en&fc=datasource_id&fs\[0\]=datasource_id%2CFossil%20CO2%20emissions%20%28EDGAR%29%-23FOSSIL_CO2_EMISSIONS%23&pg=0&df\[ds\]=ESCAP_KEYS&df\[id\]=DF_ESCAP_THEME_Dataflow&df\[ag\]=ESCAP&df\[vs\]=1.0&vw=tb](https://dataexplorer.unescap.org/vis?dq=MNG..FOSSIL_CO2_EMISSIONS.A&p-d=2010%2C2020&frequency=A&lc=en&fc=datasource_id&fs[0]=datasource_id%2CFossil%20CO2%20emissions%20%28EDGAR%29%-23FOSSIL_CO2_EMISSIONS%23&pg=0&df[ds]=ESCAP_KEYS&df[id]=DF_ESCAP_THEME_Dataflow&df[ag]=ESCAP&df[vs]=1.0&vw=tb)

144 Дэлхийн нөөцийн хүрээлэн. Үзэх <https://www.wri.org/blog/2019/12/co2-emissions-climb-all-time-high-again-2019-6-takeaways-latest-climatedata>

145 Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2020). *НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцэд хүргүүлсэн Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмэр.*

146 Уур амьсгал, цэвэр агаарын эвсэл. (2020 оны 3-р дугаар сар). *Монгол хүн агаарын чанар, хүний эрүүл мэндийг сайжруулах үйлсээрээ уур амьсгалын өөрчлөлтийн хүсэл эрмэлзэлээ нэмэгдүүлж байна.* Үзэх <https://www.ccacoalition.org/en/news/mongolia-increases-climate-change-ambition-action-improve-air-quality-and-human-health->



Улаанбаатар хотын агаарын бохирдол өвлийн улиралд.
Гэрэл зургийг НҮБ-н Хүүхдийн сан / Баярсайхан

хэмжээ авснаар тус салбарын хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 5283.4 мянган тонн CO₂-экв-ээр буюу 23.4 хувиар бууруулах боломжтой.

Монгол Улсын Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.^[147] Тухайлбал, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрс ашиглахыг хориглох; гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр хангах, цахилгаан халаалтыг дэмжих зорилгоор гэр хорооллын цахилгаан эрчим хүчний татаас олгох, сургуулиудын зөвхөн нүүрсээр ажилладаг дулааны уурын зуухыг хийн болон цахилгаан халаагуураар солих, агаарын бохирдлын эсрэг санг сэргээн байгуулах, агаарын бохирдлын төлбөр хураамж тогтоох, гэр хорооллын нутаг дэвсгэрт агаарын бохирдлын хяналтыг

өргөжүүлэх, гэр хорооллын агаарын бохирдолд хяналт шинжилгээ хийх зэрэг болно.

Агаарын бохирдлын эсрэг арга хэмжээнд улсын төсвөөс 147.3 тэрбум төгрөг, 60.7 сая ам.доллартай тэнцэх хэмжээний гадаадын зээл тусламжийн хөрөнгийг 2008-2018 онуудад жил бүр зарцуулж байжээ.^[148] Эдгээр бодлогын үр дүнд 2019-2020 оны хүйтний улиралд Улаанбаатар хотын хэмжээнд нарийн ширхэгт PM_{2.5} тоосонцорын дундаж агууламж өмнөх жилийн агаарын чанарын стандартаас хоёр дахин өндөр байсан оргил үетэй харьцуулахад 40 хувиар буурсан байна.^[149]

Үүний зэрэгцээ бохирдуулагчдын амьдралын хэв маягийг өөрчлөхөд чиглэсэн үр дүнтэй санаачлагуудыг бий болгож чадах эдийн засгийн хөшүүрэг тааруухан байна. Монгол

147 2017-2025 онд хэрэгжүүлэх Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр.

148 AARC/НҮБХХ. (2019). *Монгол Улсын агаарын бохирдол: Цаашдын арга зам, боломжууд*. Үзэх <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/air-pollution-in-mongolia--opportunities-for-further-actions.html>

149 НҮБАНДЭЗНХ. (2021 оны 4 дүгээр сар). Бодлого, технологийн хамтын ажиллагааны суурь баримт бичиг. Үзэх https://www.nea-spec.org/sites/default/files//Background%20Paper%20on%20PTC_%20SPC-3_Apr9_format.pdf

Улсын эрчим хүчний татаасын хувь хэмжээ хараахан тодорхойгүй байгаа ч нүүрсний дотоодын үнийг эрчим хүчний бодит өртгийг нөхөх түвшнээс хамаагүй доогуур тогтоосон буюу дотоодын нүүрсний үнэ нь нүүрсний хилийн дундаж үнээс нилээд доогуур байгаа нь ихээхэн хэмжээний татаас олгож байгааг харуулж байна.^[150] Ус бохирдуулагчдад ногдуулах татварын хувь хэмжээний хязгаарыг тодорхойлсон хууль тогтоомжтой хэдий ч, тэдгээрийг хэрэгжүүлэх журмыг хараахан батлаагүй байна. Агаарын бохирдлын татварын хувь хэмжээ хэт бага байгаа бөгөөд автомашины шатахуун түлшинд ногдуулах онцгой албан татварыг бензин болон дизель түлшний оновчтой хэрэглээг нэвтрүүлэх хэрэгсэл болгож чадахгүй байна. Одоогийн байдлаар Монгол Улс хэрэгцээт шатахууныхаа 95 хувийг импортоор хангаж байгаа бөгөөд шатахуун дахь хүхрийн агууламжаар бүс нутагтаа хамгийн өндөр үзүүлэлттэй байна.^[151]

Жилдээ 230-260 нарлаг өдрүүд тохиодог, салхи исгэрсэн тал хээр нутагтай, цөл хээрийн уудам бүс нутагтай Монгол орон нар, салхины эрчим хүчний арвин их нөөцтэй.^[152] Монгол Улс нь дэлхийн томоохон эдийн засагтай хоёр их гүрний дунд оршихын зэрэгцээ Төв Ази болон түүнээс цааших олон бүс нутагтай холбогдох нөхцөл бүхий эдийн засгийн томоохон коридорын дагуу орших стратегийн чухал байршилтай нь сэргээгдэх эрчим хүчийг ашиглах болон тус улсын ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх зах зээлийн өргөн боломжийг олгож байна. АНДБЭЗК-ийн хийсэн судалгаанаас харахад бүс нутгийн хамтын ажиллагааг тогтвортой эрчим хүчний хөгжилд чиглүүлж өргөжүүлэх нь дараах олон боломжийг нээж үр өгөөж авчрах ирээдүйтэй байна. Тухайлбал, эдийн засгийн хөгжлийг

эрчимжүүлэх, агаарын ноцтой бохирдлыг сааруулах, импортын эрчим хүчнээс хараат байдлыг сулруулах, сэргээгдэх эрчим хүчний нөөцөд тулгуурлан эрчим хүч экспортлох боломжийг нэмэгдүүлэх зэрэг болно.^[153] Монгол Улс нь мал маллагааны өнө удаан жилийн түүхтэй бөгөөд сайн чанарын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Стратегийн ийм өргөн боломжууд байгаа хэдий ч Монгол Улсын эдийн засгийн хөгжил уул уурхайгаас дэндүү их хамааралтай, ус, ой, биологийн нөөц баялаг, ашигт малтмал, бэлчээр нутаг зэрэг байгалийн нөөц баялгаа зүй зохисгүй ашиглаж байгаа, мал аж ахуйгаа зохистой удирдаж чадахгүй байгаа, хот суурин газруудын төлөвлөлт сул, үр ашиг муутай байгаа, дэд бүтцийн хөгжил тааруугаас улбаалсан хот суурингийн бөөгнөрөл, түгжрэл, дэд бүтцийн үйлчилгээ өндөр зардалтай зэрэг олон асуудал байна.^[154]

Монгол Улс нь химийн бодис, аюултай хог хаягдал, удаан задардаг органик бохирдуулагчийн талаарх томоохон конвенцуудыг (Базель, Минамата, Стокгольмын конвенцүүд) соёрхон баталсан боловч хүний нөөц, мэргэжлийн чадавх хязгаарлагдмал учир хэрэгжилтийг нь тайлагнах үүргээ бүрэн биелүүлэхгүй байна. Монгол Улс жилд 27,000-54,000 тонн аюултай хог хаягдал ялгаруулдаг гэсэн тооцоо байдаг ч энэ талаарх найдвартай мэдээллийн эх үүсвэр хомс байна.^[155] Уул уурхайн салбар нь эдийн засгийн чухал ач холбогдолтой салбар боловч 2017 оны байдлаар тус улсын нийт нутаг дэвсгэрийн 6.2 хувьд нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Гэсэн хэдий ч тэдгээрийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бүрэн хэмжээгээр нь тооцсон мэдээлэл хязгаарлагдмал^[156], байгаль орчны асуудлыг шийдвэрлэх хууль эрх зүйн болон

150 Монгол Улсын хилийн нэг тонн нүүрсний дундаж үнэ 2015 онд 38.5 ам.доллар байгаа нь дотоодын үнээс 25 ам.доллараар өндөр байна. Эх сурвалж: НҮБ-ын Европын эдийн засгийн комисс (НҮБЕЭЗК). (2018). *Монгол Улсын Байгаль орчны гүйцэтгэлийн тойм*.

151 НҮБЕЭЗК. (2018). *Монгол Улсын Байгаль орчны гүйцэтгэлийн тайлан*.

152 НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц. (2018). *Үндэсний Гуравдугаар тайлан*.

153 НҮБАНДЭЗНК. *Тогтвортой хөгжлийн бус нутгийн эрчим хүчний сүлжээний холболт Зүүн хойд Азийн бодлого, стратеги*. Үзэх <https://www.unescap.org/sites/default/d8files/knowledge-products/Regional%20Power%20Grid%20Connectivity%20for%20Sustainable%20Development%20in%20North-East%20Asia.pdf>

154 Дэлхийн банк. (2020). *Бодлогын зөвлөмж: Ногоон, уян хатан солонгорсон эдийн засгийн төлөөх байгалийн баялаг болон үндсэн хөрөнгийн тогтвортой удирдлага*.

155 Мөн тэнд.

156 Мөн тэнд.

бодлогын хэрэгжилтийн талаар тайлангуудад дурдаагүй^[157], бүс нутгуудад хууль бус алт олборлолтын үйл ажиллагаа үргэлжилсэн хэвээр гадаргын болон гүний ус, хөрсийг мөнгөн усаар бохирдуулсаар байгаа зэрэг олон асуудал байна.^[158]

Гол усны сав газар, ойр орчимд мал аж ахуйн гаралтай хог хаягдлыг замбараагүй хаяж урсгаж байгаагаас жижиг нуур цөөрөмд замаг ургамал ихээрүүсч тэлэн загас жараахай, хоёр нутагтан, хэвлийгээр явагч зэрэг сүргийн амьдрах орчинд аюул учруулж байна.^[159]

Монгол Улсад жилд нийт хичнээн хэмжээний хог хаягдал ялгаруулж байгаа талаар тодорхой тоо мэдээлэл байхгүй ч 2018 оны байдлаар 3,353,548.73 тонн хог хаягдал тээвэрлэснээс үзэхэд 2008 онд хогийн цэг рүү тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээнээс дөрөв дахин нэмэгдсэн байна.^[160] Монгол Улсад хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ харьцангуй сул байгаа бөгөөд хот суурингийн хог хаягдлын 70 орчим хувийг, хөдөө орон нутгийн хог хаягдлын 40 хувийг л дөнгөж цуглуулж чадаж байна.^[161]

Хэдийгээр ил жорлон ашиглаж байгаа айл өрхүүдийн талаарх үнэн зөв тоо мэдээлэл байхгүй ч гэр хороололд амьдарч буй хүмүүсийн дийлэнх нь төвлөрсөн бохирын шугамд холбогдоогүй ил жорлон ашиглаж байгаа нь тодорхой. Улаанбаатар хотод үерийн гамшиг тохиолдоход ил задгай жорлон үерт автаж, агаар дуслуар дамжих олон төрлийн өвчин эмгэг, хөрсний бохирдол, усны бохирдол үүсэх эрсдэл өндөр байна. Эргээд энэ нь Монгол Улсын хүн амын тал хувьд сөрөг нөлөө үзүүлнэ. Иймээс энэ асуудлаар нарийвчилсан судалгаа хийж нотолгоонд

суурилсан шийдвэр гаргах шаардлагатай. Түүнчлэн гэр хорооллын хэрэглэсэн нүүрсний үнсийг зайлуулах тодорхой зохицуулалт байхгүйгээс хүмүүс гэр хорооллын ойролцоох нийтийн хог хаягдлын цэгүүд, гуу жалга, хаа нэгтээ шатаасан нүүрсний үнсийг замбараагүй хаяж байна. Үүний уршгаар шатаасан нүүрсний үнс Улаанбаатар хотын гэр хорооллын хөрсний бохирдлын нэг гол эх үүсвэр болж байна. Дутуу шатсан нүүрсний үнсэн дэх хүнд металлын агууламж 4-10 дахин ихэсдэг учир бусад геологийн материалтай харьцуулахад энэ нь хүний эрүүл мэндэд маш хор хөнөөлтэй.^[162]

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь тодорхой хэмжээгээр цөлжилт, доройтолд орсон бөгөөд эдгээр газар нутгийн 22.9 хувь нь маш ихээр эвдэрч доройтсон байна (Зураг 3.4.1). Малын тоо толгой нэмэгдэж байгаа нь бэлчээрийн даацад сөргөөр нөлөөлж байна. Мал аж ахуй, бэлчээрийн удирдлагыг боловсронгуй болгох зорилгоор УИХ-аас 2020 оны арваннэгдүгээр сард Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг баталсан боловч КОВИД-19 цар тахлаас үүдсэн эдийн засгийн хямрал үргэлжилж байгаа тул хэрэгжих хугацаа 2021 оны долдугаар сарын 1 хүртэл хойшлуулсан.^[163] Чухамдаа малын тоо толгойн албан татварын орлогыг бэлчээрийн тогтвортой менежмент, ган зудын эрсдэлийг бууруулахад зарцуулах шаардлагатай тул татвар хураах механизмыг малчдын бэлчээрийн менежментийн үйл ажиллагаатай нягт уялдуулах хэрэгтэй. Иймд мал аж ахуйн ашиг шимийг дээшлүүлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлж газрын талхлалт дарамтыг бууруулах, улмаар

157 Аюулгүй, цэвэр, эрүүл, тогтвортой орчныг бүрдүүлэхтэй холбоотой хүний эрхийн асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгчийн Монгол Улсад ажилласан тухай тайлан. (2018). A/ HRC/39/55/Add.2. Үзэх <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G18/222/08/PDF/G1822208.pdf?OpenElement>

158 Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцийн Ажлын албанд 2020 онд өргөн мэдүүлсэн Монгол Улсад Алтны гараар олборлолт болон бичил уурхайгаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах чиглэлээр 2019-2023 онд хэрэгжүүлэх Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр. Одоогоор 332 уурхайн талбарт 11962 гар аргаар алт олборлогчид буюу бичил уурхай эрхлэгчид үйл ажиллагаа явуулж байна.

159 НҮБЕЭЗК. (2018). *Байгаль орчны гүйцэтгэлийн тайлан*.


160 Азийн сан. (2019). *Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлын бүтцийн судалгаа (Монгол Улс)*.

161 НҮБЕЭЗК. (2018). *Байгаль орчны гүйцэтгэлийн тайлан*.

162 Э.Батцэцэг, Т.Мураяма, К.Фукуши, С.Нишикизава, С.Чонохүү, А.Очир, С.Цэцэгэ, Д.Даваасүрэн. (2020). Монгол Улс, Улаанбаатар хотын гэр хорооллын хөрсөн дэх хүнд металлын бохирдлын экологи болон хүний эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ. *Олон улсын хүрээлэн буй орчны судалгаа, нийгмийн эрүүл мэндийн сэтгүүл*. Үзэх <https://doi.org/10.3390/ijerph1713466>.

163 НҮБ-ын ХХААБ. (2021 оны 1 дүгээр сар). *Монгол Улсын Хөдөө аж ахуйн салбар: Тогтвортой өсөлтийн хэтийн төлөв, боломжууд*.

Зураг 3.4.1: Монгол орны цөлжилт, газрын доройтол, 2020-2021



Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан 2020 оны 8-р сарын 26-ны мэдээ

малчдын амьжиргааг дээшлүүлэх зэргээр хөдөө аж ахуйн салбарын дасан зохицох үйл ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагатай. Хөрс, усны нөхцөлийг сайжруулах шилдэг туршлагыг нутгийн хүмүүсийн амьжиргааг дэмжих, төрөл бүрийн экологийн бүс нутгийн биологийн олон янз байдлыг хамгаалах зэрэг үйл ажиллагаатай уялдуулан нэвтрүүлэхээр төлөвлөх нь чухал юм. Мал аж ахуйн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэхэд зөвхөн татвар, албадлагын арга хэмжээ нөлөөлөөд зогсохгүй хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэхэд чиглүүлж нийгмийн асуудлыг нь ч бас давхар анхаарах хэрэгтэй. Малчдын бүлгүүд ч мөн Ойн нөхөрлөлийнхний нэгэн адил чухал үүрэг гүйцэтгэх боломжтой учир тэдэнд дорвитой дэмжлэг үзүүлэх нь чухал байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт тал хээрийн бүс зонхилдог боловч умард хэсгээрээ тайгын шилмүүлст ойн сан бүхий 14.2 сая га нутаг дэвсгэр, өмнөд хэсгээрээ заган ойн сан бүхий хоёр сая га нутаг дэвсгэртэй томоохон ойн сантай бөгөөд эдгээр нь хөдөөгийн хүн амын амьжиргаа, орон нутгийн эдийн засгийн хөгжил, хуурай газрын усны эх үүсвэрийг хамгаалахад экосистемийн чухал үйлчилгээ үзүүлж байна.^[164] Ойн хомсдол, доройтлын түвшин нэмэгдсээр байна. Уур амьсгалын дулаарал, мод бэлтгэлийн зохисгүй үйл ажиллагаа, ой хээрийн түймэр, хортон шавжид өртөх зэргээс шалтгаалж жил бүр 140,000 орчим га ойн сан доройтон сүйдэж байна. Уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилт ихэссэний улмаас олон тооны гол мөрөн, булаг шанд, нуур цөөрөм татарч, мөнх

164 ССРЦУ, БОАЖЯ. (2019). Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө. Үзэх https://redd.unfccc.int/files/national_strategy_and_action_plan_redd_mongolia_eng.pdf

цэвдэг, мөсөн голууд хайлан урсаж байна. Ойн хомсдолын талаарх тоо баримтаас харахад ой модтой холбоотойгоор жилд дунджаар 3.5 сая тонн CO₂-экв хүлэмжийн хий ялгаруулж байна.^[165] Түүнчлэн ойн салбар нь Монгол Улсын ДНБ-ий дөнгөж 0.5 хувийг бүрдүүлж байгаа хэдий ч ой үржүүлэг, ойг нөхөн сэргээх, ой цэвэрлэх, мод боловсруулах зэрэг үйл ажиллагаа нь хөдөө орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт, орлогын чухал эх үүсвэр болж байна.^[166] Ой нь хуурай газрын зэрлэг ан амьтдын үндсэн амьдрах орчин учраас ойн (тайгын шилмүүлст болон заган ой) тогтвортой удирдлага, бэлчээр нутгийн зохистой удирдлага нь биологийн олон янз байдлыг хамгаалах үйлсэд ихээхэн хувь нэмэр оруулна. Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас гарах үр ашгийг шударга, эрх тэгш хуваалцах тухай Нагоягийн протоколыг Монгол Улсын Их хурал 2013 онд соёрхон баталсан учир Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаралтай генетик нөөц болон тэдгээртэй холбоотой уламжлалт мэдлэгийн ашиглалтад хяналт тавих үндэсний хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

Монголын нийт нутаг дэвсгэрийн нэг орчим хувийг эзэлдэг хүлэрт намаг нь усны экосистемийн үйлчилгээг хангаж хомсдуулахгүй байх, бэлчээр нутгийг дэмжих, мөнх цэвдэгийг хамгаалах зэрэгт чухал үүрэг гүйцэтгэдэг намгархаг газрын төрөл юм.^[167] Хүлэрт намаг нь маш их хэмжээний нүүрстөрөгчийг хуримтлуулж байдаг тул хүлэрт намаг доройтох аваас тэр хэмжээгээр хүлэмжийн хий ялгаруулна

гэсэн үг.^[168] Гэтэл Монгол орны хүлэрт намаг нь өөрчлөгдөн хувирах, бэлчээрийн даац хэтрэх, гал түймэр, уур амьсгалын өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж ихээхэн аюулд өртөж байна. Үүний зэрэгцээ Монгол орны мөнх цэвдэгт гэсэлт явагдаж нутгийн дорнод хэсгээс умард хэсэг рүү тархан хумигдаж байгаагийн зэрэгцээ мөнх цэвдгийн тархалт 1971 онд нийт газар нутгийн 63 хувьд бүртгэгдэж байсан бол 2015 онд 29 хувь болж буурчээ.^[169] Мөнх цэвдэг хайлсны улмаас байшин барилга суух, дэд бүтэц эвдэрч гэмтэх зэргээр ойрын жилүүдэд ихээхэн хэмжээний зардал гарч болзошгүй юм. Тухайлбал, Ховд аймгийн Алтай сумын хуучин төвийн ихэнх инженерийн барилга байгууламжид цэвдгийн нөлөөнөөс суулт, хагарал, гажилт ихээр илэрч тэдгээрийг ашиглах боломжгүй болсны улмаас 2009 онд тус сумын төвийг цэвдэггүй газар нүүлгэн шилжүүлжээ. Мөн өөр хэд хэдэн сумдад цэцэрлэг, эмнэлэг болон бусад барилга байгууламжид ч цэвдэгийн нөлөөнөөс цууралт, гажилт үүссэний улмаас ашиглах боломжгүй болж байна.^[170] Бэлчээрийн талхлагдал улам эрчимжиж, бүтээмж нь доройтон нөхөн сэргээх боломж улам бүр хумигдахаас урьтан бэлчээрийн менежментэд зохих өөрчлөлтийг цаг алдалгүй хийж бэлчээрийн сэргэх чадавхид суурилсан ашиглалтыг нэвтрүүлбээс төлөв байдлыг нь ойрын арван жилд мэдэгдэхүйц хэмжээнд сайжруулж чадна.^[171]

Монгол Улсад хил дамнан орж ирэх усны урсгал байхгүй тул дотоод нөхөн сэргээгдэх

165 Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зорилготой НҮБ-ын REDD+ хөтөлбөр, БОАЖЯ. (2018). *Монгол улсын Ойн суурь түвшинг НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцэд хүргүүлсэн тухай тайлан*. Үзэх https://redd.unfccc.int/files/mongolia_2018_frl_submission_modified.pdf

166 Таван зуугаад ойн нөхөрлөлүүд хуш модны самар, жимс жимсгэнэ, эмийн ургамал зэрэг мод бэлтгэлийн бус ойн дагалт баялгийг түүж хэрэглэх эрх эдэлж байна. Жилдээ 12.18 сая.ам долларын ойн дагалт баялгийг ашиглаж, үр шимийг нь хүртэх боломжтой. Эх сурвалж: З. Нарангэрэл, Г. Нандин-Эрдэнэ, Хавир Де Ламо, В.Симонсон, М.Гут болон Шарлот Хикс (2017) *Монгол Улсад Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зорилготой (UN-REDD+) үндэсний хөтөлбөрөөс хүртэх олон талт үр ашгийг судлахад орон зайн дүн шинжилгээг ашиглах нь*. Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн (УЦУОСМХ), НҮБ-ын Байгаль орчны газрын Дэлхийн Байгаль хамгаалах мониторингийн төв ба НҮБ-ын REDD+ хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн хамтарсан тайлан, Улаанбаатар хот.

167 АХБ, БОАЖЯ. (2017). *Үнэлгээний тайлан: Монгол орны хүлэрт намагийг хамгаалах, зохистой ашиглах стратегийн төлөвлөгөө*. Үзэх <https://www.mne.mn/wp-content/uploads/2017/11/Peatlands-Mongolia-Assessment-Report-ilovepdf-compressed.pdf>

168 Дэлхийн хэмжээнд хүлэрт намаг нь нийт газрын гадаргууны 3 орчим хувийг эзэлдэг ч дэлхийн хөрсний органик нүүрстөрөгчийн 20-25 хувийг агуулж байдаг. (IPCC, 2014).

169 Монголын гүний ойн ач холбогдол. Үзэх <https://www.unep.org/ru/node/23973>

170 БОАЖЯ. (2016). *Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2015-2016*. Үзэх <https://www.mne.mn>

171 ГЗБГЗЗГ, ШХА, УЦУОСМХ. (2015). *Монгол орны бэлчээрийн төлөв байдлын тайлан*.

усны нөөц нь нийт нөхөн сэргээгдэх усны нөөцтэй (34.6 км³/жил гэсэн тооцоо бий) ижил гэсэн үг бөгөөд усны нийт хэрэглээ 2014 онд 534 сая м³ байсан бол 2018 онд 560 сая м³ болж нэмэгдсэн.^[172] Монгол Улсын нөхөн сэргээгдэх усны нөөцийн 60 хувь нь ОХУ, БНХАУ руу урсдаг бөгөөд ердөө 1200 сая шоо метр нь далан, усан санд хадгалагдан үлддэг гэсэн тооцоо бий.^[173] Усны хамгийн том хэрэглэгч нь хөдөө аж ахуйн салбар (40 хувь) бөгөөд дараа нь аж үйлдвэрийн салбар (25 хувь), ахуйн хэрэглээний салбарууд (16 хувь) юм. Хөдөө аж ахуйн салбарт ашиглагдаж байгаа усны дийлэнх нь ургамлаар дамжин ууршдаг. Ерөнхийдөө Монгол Улсад ахуйн хэрэглээний болон үйлдвэрийн ашигласан усыг цэвэршүүлэх тогтолцоо сайнгүй. Улаанбаатар хотын бохир ус цэвэрлэх байгууламжууд нь усыг шаардагдах стандартын түвшинд хүргэж цэвэршүүлэх боломжгүй.^[174] Уул уурхайн салбарт ихэвчлэн хаягдал, бохирдол, бохир усны асуудлаа зохисгүй удирдаж, ус цэвэршүүлэх технологийг зохих ёсоор нэвтрүүлэхгүй байгаа нь усны бохирдлын ноцтой асуудалд хүргэж байна. Хүний эрхийн комиссоос саяхны гаргасан тайланд уул уурхай нь эдийн засагт асар их хувь нэмэр оруулж байгаа хэдий ч “агаар, усыг бохирдуулах, гүний усны нөөцийг хэтрүүлэн ашиглах, бэлчээр нутгийг сүйтгэх зэрэг байгаль орчны ноцтой асуудал үүсгэж байна” хэмээн тэмдэглэжээ.^[175] Эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор усны нөөц ихээр шаардагдах уул уурхай, усан цахилгаан станцын далангууд, экспортод чиглэсэн дулааны цахилгаан станцууд, нүүрсийг хий болгон хувиргах үйлдвэрүүд зэрэг томоохон бүтээн байгуулалтуудыг

төлөвлөж байгаа нь Монгол Улсын усны нөөцөд хүчтэй дарамт учруулах болно. Дэлхийн банкны 2030 оны Усны нөөцийн бүлгийн тооцоогоор ойрын хорин жилд усны хэрэгцээ гурав дахин нэмэгдэж, усны хангамж буурч, ирэх арван жилийн эцэс гэхэд Монгол Улс усны хомсдолд орохоор байна.^[176] Цаашид эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уул уурхайн салбарыг хөгжүүлэх зэрэгт шаардагдах усан хангамжийг нэмэгдүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газар хэд хэдэн томоохон усан цахилгаан станц барихаар төлөвлөж байгаа нь гол нуурын ай савын экосистем, тэдгээрийн ойр орчмын хүн амын амьжиргаа, ялангуяа Сэлэнгэ мөрний бэлчир, ОХУ дахь Байгаль нуур^[177], БНХАУ дахь Далай нуурын экосистемд ноцтой нөлөө үзүүлж болзошгүй юм. Усны бохирдол, ус хангамжийн асуудлыг шийдвэрлэхийн тулд саарал усыг усалгааны зориулалтаар эргүүлэн ашиглах, лагийг дахин боловсруулж био бордоо боловсруулах зэрэг олон хувилбартай бохир ус цэвэршүүлэх байгууламж, тогтолцоог бий болгоход анхаарч, хот суурин, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөд эн тэргүүний чиглэл болгон тусгах хэрэгтэй.

Биологийн олон янз байдлаар баялаг Монгол оронд 5682 зүйл ургамал бүртгэгдсэнээс 2950 зүйлийн гуурст ургамал, 445 зүйлийн хөвд, 999 зүйлийн хаг, 1288 зүйлийн замаг бүртгэгдсэн нь генетикийн өвөрмөц нөөцтэйг илэрхийлж байна. Тус улсад мөн бүртгэгдсэн 472 зүйлийн шувуудын өлгий нутаг бөгөөд үүнээс 391 нь нүүдлийн шувууд байгаагийн 10 орчим хувь нь 2011 онд ховордсон шувууны ангилалд багтсан

172 АХБ. (2020). Монгол Улсын Усны нөөцийн тогтолцоо, менежментийн тойм.

173 АХБ. (2017).

174 АХБ. (2020). Монгол Улсын Усны нөөцийн тогтолцоо, менежментийн тойм.

175 Аюулгүй, цэвэр, эрүүл, тогтвортой орчныг бүрдүүлэхтэй холбоотой хүний эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн Монгол Улсад ажилласан тухай тайлан. (2018). Үзэх <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G18/222/08/PDF/G1822208.pdf?OpenElement>

176 Мөн тэнд.

177 НҮББШУСБ нь 1996 онд Байгаль нуурыг Дэлхийн өвийн санд бүртгэж, 1997 онд Сэлэнгэ мөрний бэлчирийн намгархаг газрыг Рамсарын бүртгэлд авсан. Байгаль нуур нь дэлхийн хөлддөггүй цэнгэг усны нөөцийн 20%-ийг агуулдаг төдийгүй дэлхийн өөр хаана ч байдаггүй нэн ховор ургамал, амьтны аймгууд, тухайлбал, үндэсний болон олон улсын Улаан номонд орсон Тайман хулд загас, Байгаль нуурын хилэм болон бусад олон нутагшмал ховор төрөл зүйлүүд бий (McKinney, 2019).

байна.^[178] Мөн Монгол оронд 138 зүйлийн хөхтөн амьтан, зургаан зүйлийн хоёр нутагтан, 21 зүйлийн хэвлийгээр явагч, цэнгэг усны 76 зүйлийн загас бүртгэгдсэн байна. Тус улсын хэмжээнд 128 зүйлийн ургамал ховордсон буюу устаж үгүй болох аюулд өртөж байгаа хэмээн бүртгэгджээ. Тус улсын хөхтөн амьтдын 16 хувь нь бүс нутгийн хэмжээнд аюулд өртөж байгаагийн 2 хувь нь нэн ховордсон, 11 хувь нь устах аюулд орсон байна.^[179] 2019 оны байдлаар Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 20.1 хувь нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан байна. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрт (2015) 2025 он гэхэд тус улсын үндсэн экосистемийн "төлөөлөл бүрийн 30-аас доошгүй хувийг" Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах зорилтыг тусгасан бөгөөд энэ зорилт тал хээрийн экосистемээс бусад бүх томоохон экосистемийн хувьд хэдийнээ биелэгдсэн бөгөөд одоогоор тал хээрийн экосистемийн ердөө 8.5 хувийг хамгаалалтад авсан байна.^[180]

Улс орны биологийн олон янз байдалд ихээхэн нөлөө үзүүлж байгаа хил дамнасан байгаль орчны нэг гол асуудал бол зэрлэг амьтдын хууль бус худалдаа юм.^[181] Амьтдын амьдрах орчны доройтол, дэд бүтэц (амьтдын хөдөлгөөнийг хязгаарласан замын хашаа хайс, цахилгаан эрчим хүчний шугам сүлжээнээс болж шувууд эрсдэх гэх мэт)-ийн шугам сүлжээ, газар нутгийн хуваагдал зэрэг олон хүчин зүйлүүд хавсран Монголын тал хээрийн экосистемд нэн чухал болох олон зүйлийн амьтдын тоо толгой хорогдоход ноцтой нөлөө үзүүлж байна. Монгол Улсын хүн амын тодорхой хэсэг нь зэрлэг амьтны чамин

бүтээгдэхүүнийг хэрэглэх дуртай бөгөөд тус орон 2015 оны байдлаар зэрлэг амьтны хууль бус худалдаа дамжин өнгөрдөг орон байсан бол одоо хэрэглэгч орон гэгдэх болсон.^[182]

Өргөн уудам хилийн зурвастай хил гааль, хяналт шалгалтын чадавх сул зэрэг нь Монгол Улсыг зэрлэг амьтны хууль бус худалдааны бай болгож байна. Хөдөөгийн ядуурал, үр ашиг муутай агнуурын зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул зэрэг нь хөдөөгийн малчдыг гэмт хэргийн сүлжээний нөлөөнд автаж, ангаа нийлүүлэх замаар ашигтай наймаанд оролцох нөхцөлийг бүрдүүлж ихээхэн уруу татаж байна.^[183] Малын тоо толгой нэмэгдсэнээр малчид цагаан зээр, аргаль янгир зэрэг зэрлэг амьтадтай бэлчээрийн төлөө тэмцэлдэж, улмаар чоно, цоохор ирвэс зэрэг махчин амьтдыг устгах ёстой дайснаа хэмээн үзэх болсон нь тэдний мөнгөний төлөөх сэдлийг улам бүр нэмэгдүүлж байна. Үүний уршгаар зэрлэг амьтны хууль бус худалдаа нэмэгдэж байгаа нь биологийн олон янз байдал алдагдах, улмаар экосистем доройтох, ялангуяа ховордож буй зүйлүүдийн сүргийн тоо эрс буурах зэргээр Монгол Улсад маш өргөн хүрээтэйгээр урт хугацааны нөлөө үзүүлэх төлөвтэй байна.^[184]

178 С.Гомбобаатар, Э.М. Монкс (эмхэтгэсэн), Сэйдлер, Р., Д.Сумъяа, Н. Цэвээнмядаг, С.Баярхүү, Ж.Э.М. Байли, Ш. Болдбаатар, Ч.Ууганбаяр (редактор) (2011) *Бүс нутгийн улаан дансны цуврал*. Боть 7. Шувууд. Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, МУИС, Монголын шувуу судлалын нийгэмлэг.

179 БОАЖЯ. (2018). *Биологийн олон янз байдлын конвенцын тухай Монгол Улсын Үндэсний VI тайлан*.

180 *Мөн тэнд*.

181 Санхүүгийн Таймс. (2019).

182 Ж. Вингард, М. Паскуал, А. Руд, А. Хоул, С. Гомбобаатар, Г. Бхаттачарья, М. Мөнхжаргал, Н. Конабой, С. Мягмарсүрэн, Т. Халиун, Т. Батсугар, Т. Болд (2018). *Зэлүүд тал II: Нэгэн аравны дараах зэрлэг амьтны худалдааны хямрал*. Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, Их Британийн Лондон, Хууль зүйн атлас, ИРИМ. Үзэх <https://juliahanjanicki.com/portfolio/SilentSteppell.pdf>

183 Pratt et al., 2004

184 НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (НҮБОХ)-ДБХХТ. (2018).

3.5 ЗАСАГЛАЛ, УЛС ТӨРИЙН ШИНЖИЛГЭЭ

Ардчиллын төлөв байдлыг сонгосон үзүүлэлтийн дагуу хэмждэг Эдийн засагчдын судалгааны төвийн 2020 оны Ардчиллын индекс^[185] -ээр Монгол Улс дэлхийд 61 дүгээр байранд жагсаж байна. Ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжээд гучин жил болж байгаа ч Монгол Улс ардчиллыг бүрэн дүүрэн төлөвшүүлэхэд сорилт бэрхшээлтэй тулгарсан хэвээр байна.

Монгол Улс нь хууль тогтоох эрх мэдлийг Улсын Их Хурал (УИХ), гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхий сайд хэрэгжүүлдэг парламентын засаглалтай ардчилсан улс юм. Ерөнхийлөгч нь Монгол Улсын иргэдээс шууд сонгогддог төрийн тэргүүн. Монгол Улсад 35 улс төрийн нам бүртгэлтэй байна. Одоогоор гурван улс төрийн нам УИХ-д суудалтай байна. 2020 оны сонгуулийн дүнд байгуулагдсан УИХ-ын 76 суудлын 78 хувь буюу 60 суудлыг Монгол Ардын Нам (МАН) бүрдүүлж байна. 2021 оны зургадугаар сард МАН-ын нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдсоноор 2009 оноос хойш Ардчилсан Намд хамаарч байсан ерөнхийлөгчийн суудал шилжсэн болно.

1992 оны Үндсэн хуульд өөрчлөлт хийхээр удаан хугацаанд хэлэлцсэн Үндсэн хуулийн хоёр дахь нэмэлт өөрчлөлт 2019 оны арваннэгдүгээр сард батлагдаж, 2020 оны тавдугаар сараас хүчин төгөлдөр болжээ...^[186] Энэхүү өөрчлөлт нь Ерөнхий сайд, Ерөнхийлөгчийн эрх мэдлийн тэнцвэрийг тодорхой болгоход чиглэсэн бөгөөд Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх бүрэн эрхийг Ерөнхий сайдад олгож, эрх мэдэл, бие даасан байдлыг нь бэхжүүлэх зорилго агуулжээ.

Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш зохион байгуулсан УИХ-ын найман удаагийн сонгуулийнн долоо нь мажоритар, 2012 оны сонгууль холимог тогтолцоогоор (мажоритар системээр 48,

намын жагсаалтаар 28 суудал) явагдсан байна. Сонгуулийн тогтолцоо нь улс төрийн намуудын институцийг бэхжүүлэх, улс төрийн намын санхүүжилт, хууль тогтоох байгууллагад эмэгтэйчүүд, залуучуудын төлөөллийг бүрдүүлэхэд нөлөөлдөг. Иймээс сонгуулийн тогтолцооны шинэчлэл нь улс төрийн хүрээнд олон жил яригдаж байна. Сонгуулийн тогтолцоог мажоритараас холимог тогтолцоонд шилжүүлэх асуудал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлын хүрээнд яригдаж байсан ч батлагдаагүй юм.

Анхны ардчилсан сонгуулиас хойш сонгогчдын сонгуульд оролцох ирц Монгол Улсад байнга буурч байна. Гэсэн хэдий ч сүүлийн хоёр удаагийн буюу 2016, 2020 оны парламентын сонгуулийн ирц 75.3 хувь болон 74 хувь айсан.^[187] Харин саяхны буюу 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр болсон УИХ-ын хоёр суудлын төлөөх нөхөн сонгуульд сонгогчдын ирц 37 орчим хувь байсан нь тус улсын түүхэнд хамгийн бага ирцтэй сонгууль болсон. Сонгогчдын ирц бага байсан нь улс төрийн намуудын нэр дэвшигчид сонгогчдын хүлээлтэд нийцээгүй, итгэл төрүүлэхүйц биш байсан тул сонгогчид залхсан, оролцох идэвх нь суларч, улмаар засаглалын болоод сонгуулийн тогтолцоог шинэчлэхийг уриалахад хүргэжээ. Залуучуудын сонгуулийн оролцоо бусад насны бүлгүүдээс байнга доогуур байна.

УИХ-ын нийт суудалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (13 суудал буюу 17.3%) дэлхийн дундаж болох 25.5 хувиас доогуур байгаа бөгөөд энэ үзүүлэлтээр Монгол Улс 184 улс орноос 127-д жагсаж байна.^[188] Одоо мөрдөгдөж буй жендэрийн 20 хувийн квотыг нэмэгдүүлэх уриалга биелээгүй байна. Нийт 14 сайдын дөрөв нь эмэгтэй байна. ХЭҮК-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан жендэрийн квотын дагуу 2020 онд ХЭҮК-ын гишүүний таван албан тушаалд гурван

185 The Economist Intelligence Unit. (2021). *Ардчилалын Индекс 2020*.

186 2028 оноос хэрэгжиж эхлэх улс төрийн намын тухай заалтыг эс тооцвол.

187 Сонгуулийн үр дүн. Үзэх <https://www.montsame.mn/mn/read/27285> ; <https://ikon.mn/elections/2020>

188 Үндэсний парламент дахь эмэгтэйчүүдийн дэлхийн болон бүс нутгийн дундаж үзүүлэлт. Үзэх <https://data.ipu.org/women-averages>



Монгол дахь НҮБ нь жендэрийн тэгш байдлыг хангах, засаглалын бүхий л түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Гэрэл зургийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

эмэгтэй гишүүн томилсон.^[189] Энэ нь УИХ-д үйл ажиллагаагаа хариуцан тайлагнадаг хамтын удирдлагын байгууллагуудын удирдах түвшинд жендэрийн квотыг хангах жишиг болж байна.

2020 оны арванхоёрдугаар сард батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд хоорондын чиг үүргийн хуваарилалт, төсвийн төвлөрлийг сааруулах, нутгийн өөрөө удирдах ёсны тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр өргөн хүрээний шинэчлэл хийсэн. Хөдөө орон нутагт эдийн засгийн боломж хязгаарлагдмал, хот, хөдөөг тэнцвэртэй хөгжүүлэх бодлого сул, орон нутгийн эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр,

төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадавх дутмаг зэргээс шалтгаалж орон нутгийн засаг захиргаадад орлого бүрдүүлэх суурь үгүй байна. Засгийн газрын зүгээс орон нутгийн захиргаанд чиг үүрэг, санхүүгийн эрх мэдлийг шилжүүлэх талаар дорвитой алхам хийхгүй байна. Орон нутгийн удирдлагад сонгогдсон албан тушаалтнуудын авлига, ёс зүйн асуудал нь тулгарч буй гол сорилт бэрхшээлийн нэг болж байна. КОВИД-19 цар тахлын үед нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчид цар тахлыг даван туулах талаар ихээхэн туршлага хуримтлуулж байгаа ч илүү үр дүнтэй хариу арга хэмжээ авахад шаардагдах хөрөнгө нөөц, техник хэрэгсэл хангалтгүй байна.


Сүүлийн хорин жилийн хугацаанд нэг засгийн газрын эрх барих дундаж хугацаа

189 Монгол Улсын Хүний эрхийн Комиссын тухай хууль. (2021 оны 1 дүгээр сар). Үзэх <https://www.legalinfo.mn/law/details/15152?law-id=15152>

ойролцоогоор 1.5 жил^[190] байсан учир засгийн газрын бодлого нь удирдлагын болоод хүний нөөцийн өөрчлөлтөөс шалтгаалж ихэвчлэн тасалдаж байжээ. Урт хугацааны тогтвортой хөгжлийн ашиг сонирхлоос илүүтэйгээр богино хугацааны үр ашигт хэт их анхаарал хандуулах явдал төрийн бүх шатны байгууллагуудад давамгайлж байсан аж. Нотолгоонд суурилсан, үр дүнд чиглэсэн тогтвортой хөгжлийн бодлого шийдвэр гаргах талаар Засгийн газар, УИХ-ын чадавх бэхжээгүй, үр дүн гаргахыг шаардах хариуцлагын механизм сул хэвээр байна. Мөн төрийн захиргааны чадавх сул байгаа нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг хүргэхэд саад болж байна. Монгол Улсад төрийн захиргааны удирдлагын гүйцэтгэлийг илүү өндөр түвшинд гаргахын тулд төрийн албыг илүү мэргэшүүлэх шаардлагатай. 2020 онд Монгол Улсын Эрх зүйт ёсны индекс 6.3 болж, 128 орноос 57-р байрт жагссан байна.^[191] НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн 2018 оны Хүний хөгжлийн илтгэлээс харахад судалгаанд оролцогчдын дөнгөж 28 хувь нь Засгийн газартаа итгэж байгаа ажээ.^[192]

Дэлхийн банкны судалгаанаас харахад Монгол Улсын засаглалын үр нөлөө, зохицуулалтын чанар, эрх зүйт ёс, авлигын эсрэг тэмцэл зэрэг үзүүлэлтүүд 50 хувиас доогуур байна (Зураг 3.5.1). Монгол Улсад өрнөж буй улс төрийн үйл явц нь үзэл баримтлал, бодлогын ялгаатай байдалд уялддаггүй, харин нэг танхим бүхий парламентын фракцууд хоорондын зөрчил ихээхэн нөлөөлж байна. Улс төрийн элитүүд хоорондын болон дотоод хагарал бий болсон, авлига газар авсан зэрэг нь улс төр, эдийн засгийн урт хугацааны шинэчлэлийг хэрэгжүүлэхэд саад тотгор болж байна. Үүний уршгаар тус улсын хууль тогтоомжид байнга өөрчлөлт орох, засаглал, сонгуультай холбоотойгоор хариуцлага сулрах^[193], улмаар ийм байдал нь сонгуулийн хугацааны

Зураг 3.5.1: Монгол Улс: Засаглалын индекс, эрэмбэ (0-100%)



Эх сурвалж: Дэлхийн банк, Олон улсын Засаглалын индекс

туршид үргэлжлэхэд хүргэж байна. Энэ нь цаашлаад урт хугацааны хөгжлийн үр дүн, Тогтвортой хөгжлийн зорилгуудыг (ТХЗ) хэрэгжүүлэхэд шаардагдах хууль дээдлэх ёс, сайн засаглал, ардчилалд сөргөөр нөлөөлж байна.

УИХ нь Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хороог (ЁСХБХ) шинээр байгууллаа. УИХ-ын гишүүдийн ирц, хөрөнгө, орлогын мэдүүлгийн асуудлыг голчлон хэлэлцдэг байсан өмнөх УИХ-ын Ёс зүйн дэд хорооноос ялгаатай нь шинэ ЁСХБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагын бодлого, төрийн албаны бүх шатны Ёс зүйн хорооны асуудал багтжээ.

Төрийн албан хаагчдын орон тоо өсөх хандлага өөрчлөгдөөгүй байна. 2021 оны нэгдүгээр сарын байдлаар төрийн 4,147 байгууллагад 205,011 (бүх шатны) албан хаагч ажиллаж байна.^[194] Монгол Улсын нийт ажиллах хүчний 15.4 хувийг төрийн албан хаагчид бүрдүүлж байна. Сүүлийн арван жилд төрийн албаны орон тоо 27.5 орчим хувиар өсчээ. Төрийн албанд хууль дээдлэх

190 УХГ. (2018). Хөгжлийн бодлогын тогтвортой байдал, түүний уялдаа холбоонд хийсэн дүн шинжилгээ.

191 Бертелсман Сан. (2020). Монгол Улсын тайлан. Үзэх <https://www.bti-project.org/en/reports/country-report-MNG-2020.html>

192 НҮБХХ. Дэлхийн дахины Хүний хөгжлийн илтгэл 2018. Үзэх http://hdr.undp.org/sites/default/files/2018_human_development_statistical_update.pdf

193 Дэлхийн банк. Дэлхий дахины засаглалын үзүүлэлтүүд. Үзэх <https://databank.worldbank.org/source/worldwide-governance-indicators>

194 Төрийн албаны зөвлөл. Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлангийн хэлэлцүүлэг. Үзэх <https://csc.gov.mn/s/44/980>

ёсыг төлөвшүүлэн хэвшүүлэх, үүрэг, сахилга, хариуцлагын тогтолцоог тодорхой болгож, уялдаатай, тууштай хэрэгжүүлэх зөв зохицуулалтыг бүрдүүлэхийн тулд цаашид шинэчлэл хийх шаардлагатай гэдэгтэй улс төрийн хүрээнд санал нэг байна. Төрийн албаны шинэчлэлийн зорилтуудыг Засгийн газрын хөтөлбөрүүдэд, тухайлбал Дижитал стратегид тусгаж өгсөн бөгөөд төрийн үйлчилгээг олон нийтэд үр дүнтэй хүргэх, цахим засаглалд шилжихэд голлон анхаарч байна.

Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 онд баталсан нь шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр хийсэн дорвитой алхам болсон. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тоог 5-аас 10 болгон нэмэгдүүлж, гишүүдийн тал хувийг нь Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилдог болсон. Шүүхийн сахилгын хорооны есөн гишүүний талаас илүү хувийг нь анх удаа УИХ-аар томилох гэж байна.

Монгол Улс 2016 онд Олон улсын гэрээний тухай хуулиа шинэчлэн баталж, гэрээний заалт, үүргийг дотоодын хууль тогтоомжид заавал тусгах шаардлагатай болсон. Энэ нь тус улс үндэсний хууль тогтоомжоо олон улсын холбогдох гэрээтэй нийцүүлэн харилцан уялдаатай, тууштай хэрэгжүүлэх чухал алхам болсон юм.

УИХ-аас хүний эрхийн үндэсний байгууллагыг бэхжүүлэх, хараат бус гишүүд болон хүний эрхийг хамгаалагч, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий нэгжийн бүрэн эрхийг тодорхойлох зорилгоор ХЭҮК-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, улмаар эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулав. Монгол Улсын ХЭҮК-ыг Парисын зарчимд бүрнээ нийцүүлэн, бүрэн эрхээ үр дүнтэй, хараат бусаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхийн тулд хүний болон санхүүгийн нөөцийн чадавхыг цаашид бэхжүүлэх

шаардлагатай байна.

Монгол Улс Хүний эрхийн төлөв байдлын үндэсний илтгэлээ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт 2010, 2015, 2020 оны 11 дүгээр сард тус тус гурван удаа хүргүүлж үнэлүүлсэн. Гурав дахь удаагийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгээс ирүүлсэн 190 зөвлөмжөөс Монгол Улс 170 зөвлөмжийг хүлээн авч, үлдэх 20 зөвлөмжийг тэмдэглэсэн байна. Зөвлөмжид боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, хүн худалдаалах гэмт хэрэг зэрэгтэй тэмцэх, хохирогчдыг хамгаалах, байгаль орчны маргаан зөрчлөөс үүдэлтэй хүний эрхийн зөрчлийг бууруулах, хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдлыг баталгаажуулах зэрэг асуудлыг тусгасан байна.

“Хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай” хууль 2021 оны дөрөвдүгээр сард батлагдсан. Ялгаварлан гадуурхах, айлган сүрдүүлэх, дарамтлах, гутаан доромжлох, бие махбодийн халдлага зэргийг хувь хүмүүс, зарим тохиолдолд хууль сахиулах болон төрийн бусад албан тушаалтнууд үйлдэж байгааг хүний эрхийг хамгаалагчид мэдээлдэг. Ялангуяа биеэ үнэлэгчид, бэлгийн цөөнх, үндэстний цөөнх болон улс төрийн элитүүдийн эсрэг ялгаварлан гадуурхсан, үзэн ядсан үг хэллэг интернет, нийгмийн сүлжээнд их байгааг онцолжээ.^[195] Тэд мөн саяхан батлагдсан КОВИД-19 цар тахалтай тэмцэх тухай хууль тогтоомж, Зөрчлийн тухай хууль зэрэг нь сэтгүүлчид, хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг хязгаарлахад нөлөөлж байгааг дурджээ. Ашгийн бус байгууллагын тухай хуулийн төсөл нь бүртгүүлэх үйл явц болон гадаадын санхүүжилтэд тавих хяналтыг чангатгах замаар иргэний нийгмийн үйл ажиллагааг улам бүр хумихаар байна. Монгол Улсад иргэний нийгмийн байгууллагууд бүрэлдэн тогтохын

195 Д. Мөнхчимэг, Ц. Чимэддондог. (2018). Цахим сайтуудад дахь үзэн ядах хэллэг. Контент анализын судалгаа.



НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсад эмзэг бүлгийн иргэд, ялангуяа хөгжийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хамгаалах чиглэлээр дорвитой ахиц гаргахыг зөвлөсөн. Гэрэл зургийг Д. Давааням

хэрээр чадавхыг нь бэхжүүлэх, төрийн үйл хэрэгт тэднийг татан оролцуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар хүчин чармайлт гаргах нь чухал байна.

Олон улсын хэм хэмжээнээс гадна^[196], Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсад Хүний эрхийг хангах тухай үндэсний хөтөлбөр (2003) зэрэг суурь эрх зүйн актуудад шилжилт хөдөлгөөнд оролцож буй хүнийг "эх орныхоо нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй" хэмээн хуульчилсан. Хүн амын шилжилт хөдөлгөөнд цаашид ямар нэгэн хязгаарлалт тавихдаа дотоодын шилжилт хөдөлгөөнөөс болж тус улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журамд аюул занал учрах эсэхийг тодорхой судалж үзсэний үндсэн дээр шийдвэртэй арга хэмжээ авах шаардлагатай. Сүүлийн жилүүдэд баг, сумаас аймгийн төв рүү, улмаар нийслэл рүү ("хөдөө - хот суурин - нийслэл") шилжин суурьших зэргээр дотоодын шилжилт хөдөлгөөн улам

бүр нэмэгдэж байна. Шилжих хөдөлгөөнийг үүсгэж буй үндсэн шалтгаан, хүчин зүйлстэй тэмцэхийн оронд өнөөгийн авч хэрэгжүүлж буй салбарын бодлого, хязгаарлалтын арга хэмжээнүүд нь зөвхөн дотоод шилжилт хөдөлгөөн болон түүний шинж тэмдэгтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдэж байна. Иймээс шилжилт хөдөлгөөний удирдлага зохицуулалтыг сайжруулах, шилжилт хөдөлгөөнийг тооцсон бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, үүнтэй холбоотойгоор хүний нөөцийг чадавхжуулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Уул уурхайн компаниудын үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, тэдгээрийн талаарх урьд өмнөөс хуримтлагдаж ирсэн гомдол маргаан нь уламжлалт мал аж ахуй эрхлэгчдэд хүндээр нөлөөлж зөрчилдөх гол шалтгаан болж байна. Арьс үндсээр алагчлах явдлыг устгах хороо нь Монгол Улсад уул уурхайн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, хайгуулын зөвшөөрөл олгохдоо үндэсний цөөнхтэй зөвшилцөхгүй байгаад харамсаж

196 Хүний эрхийн Түгээмэл тунхаглал. (1948 он). 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг: Өөрийн улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрх; Хүний эрхийн Түгээмэл тунхаглал. (1948 он). 13 дугаар зүйлийн 2 дах хэсэг: Гадаад улс руу явах, эх орондоо буцаж ирэх эрх

буйгаа илэрхийлж, аливаа уул уурхайн үйл ажиллагаа нь үндэстний цөөнхийн соёлын өвд хор хөнөөл учруулахгүй байх талаар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, төлөвлөгөөнд анхаарал хандуулахгүй байгаад шүүмжлэлтэй хандаж дүгнэлт хийхийг зөвлөсөн. Түүнчлэн, үндэстний цөөнхийн эрт дээр үеэс ашиглаж, эзэмшиж ирсэн газар нутагт ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө тэдний эрхийг хангах, баталгаажуулах үүднээс Ашигт малтмалын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль зэрэгт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулахыг Монгол Улсын Засгийн газарт зөвлөжээ.^[197]

Эдийн засгийн тэгш бус байдлын уршгаар эмэгтэйчүүд, охид болон уул уурхайн нөлөөлөлд өртсөн эмзэг бүлгийн хүмүүс хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэл илүүтэй нэмэгдэж байна. Монгол Улсын уул уурхай, байгаль орчны талаарх хууль тогтоомж, бодлогод газар өмчлөх, эзэмших эрх, орон сууцны хүртээмж, аюулгүй байдал, боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, дэд бүтцийн хүртээмжийг өргөжүүлэх талаарх заалтууд тодорхойгүй, ил тод бус байна.

Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит тайлангуудад НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос үнэлгээ хийж, Дүгнэлт зөвлөмждөө хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхийн тулд төрийн бүх шатны байгууллагууд ажлын уялдаа холбоогоо сайжруулах шаардлагатай байгааг удаа дараа зөвлөж байжээ. Энэ нь сайжруулах зайлшгүй шаардлагатай асуудал юм.

2021 оны Хэвлэлийн эрх чөлөөний индекс^[198]-ээр Монгол Улс 180 орноос 68-д (28.97) жагсаж, таван байраар урагшилжээ. Монгол Улсад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хүлээн зөвшөөрөх тухай өргөн

нэвтрүүлгийн ерөнхий хууль, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөлийн ил тод байдал, төвлөрлийн тухай хууль, эх сурвалжийг хамгаалах тухай хууль зэрэг хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах чухал хууль тогтоомж, бодлого дутагдаж байна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яам хэд хэдэн хуулийн төслийг боловсруулж байна. Тухайлбал, i) "Мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болох "Нийтийн мэдээллийн тухай" хууль; ii) "Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай" хуулийн төсөл; iii) "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" хуулийн шинэчилсэн найруулгыг үүнд дурдаж болно.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө засгийн газрын хөндлөнгийн оролцоо, хязгаарлалтаас хуулиар хамгаалагдсан хэдий ч зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэл улс төржсөн, улстөрчдийн болон бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автсан хэвээр байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөө тэмцэгчид хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд тавих төрийн хязгаарлалт нэмэгдэж байгаа^[199], ялангуяа цар тахал, гамшгаас хамгаалах хүрээнд сүүлийн үеийн хууль тогтоомжийн өөрчлөлтүүдтэй холбоотойгоор хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд хяналт тавих тохиолдлууд гарч байгаа, түүнчлэн "буруу мэдээлэл" нийтэлсний улмаас шийтгэл хүлээхээс эмээж өөрсдийгөө хянаж, хязгаарлахад хүрч байгаа талаар мэдээлж байна.^[200] Түүнчлэн судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 67 хувь нь ямар нэгэн байдлаар сүрдүүлэг, дарамт, заналхийлэл, доромжлолд өртөж байсан бөгөөд эмэгтэй сэтгүүлчид ийм халдлагад өртөх магадлал хоёр дахин их байна.^[201]

Авлига нь Монгол Улсын эдийн засаг, улс төрийн хөгжил дэвшлийн томоохон сорилт

197 Арьс үндсээр алагчлахыг устгах хороо. (2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр). *Монгол Улсын ээлжит 23, 24 дэх ээлжит тайланд хийсэн дүгнэлтийн зөвлөмж*. CERD/C/MNG/CO/23-24. Үзэх https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CERD/C/MNG/CO/23-24&Lang=En

198 Хил хязгааргүй сурвалжлагчдын байгууллага. (2021). Үзэх <https://rsf.org/en/ranking>

199 Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл. (2020). *Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл хэвлэл мэдээллийн салбарт төрийн хяналтыг нэмэгдүүлэхийг эсэргүүцэж байна*. Үзэх <https://www.mediacouncil.mn/a/205>

200 Глоб Интернэшнл төв. (2019). *Хэвлэлийн эрх чөлөөний тайлан*.

201 *Мөн тэнд*.

хэвээр байна. Монгол Улс 2015 онд Авлигын төсөөллийн индексээр 72 дугаар байр (180-аас)-т орж байсан бол 2020 онд 111 дүгээр байрт жагсаж ухарчээ. ^[202] Ерөнхий сайд асан, УИХ-ын гишүүд асан зэрэг өндөр түвшний шийдвэр гаргагчидтай холбоотой хэд хэдэн авлигын хэргүүд илэрч олон нийтийн дургүйцэл, эсэргүүцлийг төрүүлж, улмаар Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгалт явуулсан байна. Авлига нь засгийн газрын үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй явуулахад хүндрэл учруулж, төрийн институцэд итгэх итгэлийг бууруулахад нөлөөлсөөр байгаа хэдий ч эрх баригчид бүтцийн шалтгааныг одоог хүртэл оновчтой

шийдвэрлэж чадахгүй байна. Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 7 дугаар сард Монгол Улсын Авлигын төсөөллийн индексийг ойрын хоёр жилд ахиулах үүрэг бүхий Яамд хоорондын Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн гол зорилго нь авлигын үндсэн шалтгаан болох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, төрийн үйлчилгээг цахим системд шилжүүлэх ажлыг эрчимжүүлэхэд оршиж байна. Мөн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай, Улс төрийн намын санхүүжилтийн тухай зэрэг хуулиуд нэн чухал болохыг Засгийн газраас онцолж байна.

3.6 ОЛОН ХЭМЖЭЭСТ ТХЗ-ЫН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Эрүүл мэнд, нийгэм эдийн засаг, байгаль орчин, улс төр, бүс нутаг, дэлхийн хэмжээнд тулгамдаж буй асуудал, бэрхшээлүүдээс гадна ойрын ирээдүйд ноцтой эрсдлүүдийг үүсгэх өндөр магадлалтай дараах асуудлууд байна.

Нийгмийн үйлчилгээний дэд бүтцийн хөгжил сул учраас халамжийн үйлчилгээний чанар, хүртээмж тэгш бус байгаа, хүмүүсийн халааснаас гарах эрүүл мэндийн зардал өндөр байгаа, түүхий болон боловсруулсан нүүрсний хэрэглээ, утаа маш ихээр ялгаруулдаг хуучин тээврийн хэрэгсэл, чанар муутай түлшний хэрэглээ зэргээс агаарын бохирдол улам дордох болсон, өсвөр насныхан болон залуучуудын дунд амиа хорлох тохиолдол олон гарах болсон зэрэг нь нийгмийн эрүүл мэндийн ноцтой эрсдэлд хүргэж болзошгүй бөгөөд улмаар Тогтвортой хөгжлийн 3 дугаар зорилгын хэрэгжилтэд шууд, бусад олон ТХЗ-ын хэрэгжилтэд шууд бусаар нөлөөлөхөөр байна.

Хүнсний үнийн өсөлт, ой хээрийн түймэр, ган, зуд, гамшигт үзэгдлээс улбаалсан газар

нутгийн доройтол, газар тариалангийн хэрэглээний усны хомсдол, малын тоо толгой өссөнөөс биологийн олон янз байдал доройтож, устаж байгаа зэргээс шалтгаалж нэн эмзэг бүлгийн хүн ам хоол тэжээлийн дутагдалд орох, ядуурал гүнзгийрэх, хүнсний аюулгүй байдал алдагдах болсон зэрэг нь хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйг ноцтой эрсдэлд хүргэж болзошгүй бөгөөд улмаар Тогтвортой хөгжлийн 1, 2, 3 дугаар зорилгуудын хэрэгжилтэд шууд, бусад олон зорилгуудын хэрэгжилтэд шууд бусаар нөлөөлөхөөр байна.

Хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй ойн түймэр болон хортон шавжийн нөлөөгөөр бэлчээр нутаг, тал хээр, хүлэрт намаг, ойн санг даац хэтрүүлэн ашигласнаас газар нутаг цөлжин доройтож байгаа, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт үзэгдлүүдийн уршгаар байгаль орчин, байгалийн нөөцөөс ихээхэн хамааралтай хөдөө аж ахуйн салбар, орон нутгийн хүн ам улам бүр эмзэг байдалд орж байгаа, байгалийн нөөцийн хомсдол (ус, бэлчээр, ашигт малтмал), хот суурин газрын агаарын бохирдол (нүүрсэнд суурилсан

202 Авлигийн үзүүлэлт. Үзэх <https://www.transparency.org/en/cpi/2020/table/mng>; Монгол Улсын Авлигийн үзүүлэлт. Үзэх <https://tradingeconomics.com/mongolia/corruption-index>

эрчим хүчний станцуудаас шалтгаалсан нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хийн ялгаруулалт нэмэгдсэн); малын тоо толгой өссөнөөс шалтгаалж амьдрах орчин нь доройтсоны улмаас биологийн олон янз байдал алдагдах болсон, уул уурхай, дэд бүтцийн хөгжил, зэрлэг амьтны хууль бус худалдаа, зохисгүй хэрэглээ, дэлхийн дулаарал зэрэг нь байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн ноцтой эрсдэлд хүргэж болзошгүй бөгөөд улмаар Тогтвортой хөгжлийн 13, 15 дугаар зорилгуудын хэрэгжилтэд шууд, бусад олон ТХЗ-ын хэрэгжилтэд шууд бусаар нөлөөлөхөөр байна.

Засгийн газар солигдох бүрт Гүйцэтгэх засаглалын албан тушаалтнууд байнга солигдож байгаагаас төрийн албаны чадавх, засаглалын институц сулрах болсон, улс төрийн намууд болон бүх шатны байгууллагуудад тархсан авлигын сүлжээ, кибер аюулгүй байдлыг хангахад тулгарч байгаа бэрхшээлүүд зэрэг нь тогтвортой байдал, дотоодын аюулгүй байдлыг эрсдэлд хүргэж болзошгүй бөгөөд улмаар Тогтвортой хөгжлийн 16, 17 дугаар зорилгын хэрэгжилтэд шууд, бусад олон ТХЗ-д шууд бусаар нөлөөлөхөөр байна.

Эдийн засгийн ашиг тусаар тэр бүр тодорхойлогдохгүй харин улс төрийн үзэмжээр тодорхойлогдож байгаа байгалийн баялгийн орлогын менежмент, зудын гамшгаас үүдэлтэй мал сүргийн хорогдол зэрэг нь гарах өндөр магадлалтай эрсдэлүүд хэдий ч эдийн засаг болоод санхүүгийн эрсдэлийг дунд түвшинд хүргэж болзошгүй юм. Хот суурин газруудад хөдөө орон нутгаас шилжин ирэгсдэд үзүүлэх суурь үйлчилгээ дутмаг, хүүхэд, насанд хүрэгчдийн дунд таргалалт нэмэгдэж байгаа зэрэг нь нийгмийн эрүүл мэнд, шилжилт хөдөлгөөний зохицуулалтын асуудалд дунд зэргийн нөлөө үзүүлэх магадлал өндөртэй эрсдэлүүд юм.

Хүний эрхийг хамгаалагчид болон бусад цөөнхийн бүлгүүдийн эсрэг нийгэм дэх үзэн ядсан үг яриа, ялгаварлан гадуурхал, дарамтлал, гутаан доромжлол, бие махбодид халдах тохиолдлууд нэмэгдэж байгаа нь ардчиллын орон зайд дунд зэргийн эрсдэл, үр дагварыг бий болгохоор байна. Залуучуудын дунд ажилгүйдэл их байгаагаас тус улсын оюуны чадавх гадаад улс руу гарах эрсдэл түүнээс үүдэн гарах үр дагавар дунд түвшинд байж болзошгүй.

Ундны ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ дутмаг, төлөвлөлт муутай хотжилтын улмаас хот суурингийн албан ёсны бүртгэлгүй оршин суугчид үерт өртөх, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, бэлчээрийн доройтлоос үүдэлтэйгээр малчдын амьжиргаа доройтох зэрэг нь дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг дунд зэргийн эрсдэлд хүргэж болзошгүй байна.

Хууль зүйн үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал, хүний эрхийн зөрчлийг арилгах арга хэмжээ сул зэргээс үүдэж иргэдийн дунд төр засаг болоод төрийн байгууллагуудын хууль дээдлэх ёсонд итгэх итгэл алдагдах нь шударга ёс, эрх зүйт ёсыг дунд зэргийн эрсдэлд хүргэж болзошгүй юм.

Уул уурхайн үйл ажиллагааны үр дагварт өртсөн бүс нутгийн эмзэг бүлгийн хүмүүс эдийн засгийн тэгш бус байдлаас болж янз бүрийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй бөгөөд энэ нь нийгмийн эв нэгдлийн асуудалд аюул учруулж болзошгүй юм.

Эцэст нь, үр дагавар өндөртэй боловч гарах магадлал багатай эрсдэлүүдийг Олон хэмжээст ТХЗ-ын эрсдэлийн матриц Хавсралт 4-т оруулсан. Тус хавсралт нь Монгол Улсын хүн амыг эмзэг байдалд оруулж буй дээрх өөр хоорондоо уялдаа бүхий эрсдэлүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан болно.

3.7 ХҮМҮҮНЛЭГИЙН, ХӨГЖЛИЙН БОЛОН ЭНХИЙГ САХИУЛАХ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН УЯЛДАА ХОЛБОО

Монгол Улс геологи, биологи, уур амьсгал, хүний хүчин зүйлээс үүдэж болзошгүй төрөл бүрийн гамшигт өртөмтгий байдаг. Тухайлбал, ган, зуд (хахир хүйтэн өвөл), үер, ой хээрийн түймэр, мөндөр, элсэн шуурга зэрэг байгалийн гамшиг үе үе тохиож байна. Хот суурингаас гадагш хөдөө орон нутагт газар хөдлөлт байнга бүртгэгдэж байгаа бөгөөд саяхан 2021 оны нэгдүгээр сард Хөвсгөл аймгийн Ханх суманд болсон 6.8 магнитудын хүчтэй газар хөдлөлтөөс бусад тохиолдлуудад хохирол бараг бүртгэгдээгүй байна. Сүүлчийн газар хөдлөлтийн үеэр барилга байгууламжийн хана цуурснаас өөр хүний эндэгдэл бүртгэгдээгүй байна. Нийслэлийг тойрсон жижиг хэмжээний газар хөдлөлтүүд нэмэгдэж байгаа хэдий ч хотын суурьшлын бүсэд, ялангуяа Улаанбаатар хотод өндөр магнитудын газар хөдлөлт болох магадлал одоогоор тодорхойгүй байна. Иймээс газар хөдлөлтийн асуудлаар нарийвчилсан судалгаа хийх хэрэгтэй.

КОВИД-19 цар тахлын хямрал нь урьд өмнө тохиож байсан бүхий л хямралтай харьцуулахын аргагүй илүү олон төрлийн тусламж дэмжлэг хэрэгтэй болохыг, ялангуяа, хүмүүнлэгийн болоод хөгжлийн тусламжийг нягт уялдаатай, урьд өмнөхөөс илүү бодитойгоор, яаралтай шийдвэрлэх хэрэгтэй байгааг харуулж байна. Цар тахал нь вирусын шууд хор хөнөөлөөс үүдэлтэй нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал болон нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөө зэрэг давхар сорилтуудыг бий болгосон. Нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд засгийн газрууд зайлшгүй авахаас өөр аргагүй болсон эрс шийдэмгий арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.^[203] НҮБ-ын КОВИД-19 цар тахлын эсрэг арга хэмжээ нь цар тахлын уршгаар үүсч болзошгүй эрүүл мэнд, хүмүүнлэг, нийгэм-эдийн засаг, хүний эрхийн сорилт бэрхшээлийг даван туулахад нь Монгол

Улсад дэмжлэг үзүүлэх цогц арга хэмжээ юм. Хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрүүдийг вирусын халдвар авсан хүмүүсийг эмчлэхэд ашиглаж байгаа бөгөөд үүний зэрэгцээ өвчний дэгдэлт, түүнтэй холбоотой хязгаарлалтыг даван туулахын тулд Монгол Улсын эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сул тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн хөгжлийн тусламжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй цар тахлын эсрэг тусламжийн арга хэмжээнүүд тус болсон хэдий ч сүүлийн үед хийсэн судалгаагаар КОВИД-19 цар тахлын хямрал Монголын ядуу, эмзэг бүлгийн хүмүүст хүнд цохилт болсон нь тогтоогдсон. Жишээлбэл, КОВИД-19 цар тахлын хямрал айл өрхийн эдийн засгийн нөхцөл байдалд, түүнчлэн эдийн засгийн янз бүрийн салбаруудад, ялангуяа эмэгтэйчүүд зонхилон ажилладаг салбаруудад ноцтой нөлөөлсөн^[204] (тайлангийн 3.3-т энэ талаар тусгасан). Иймээс хүмүүнлэгийн болон хөгжлийн хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангахдаа КОВИД-19 цар тахлын хямралын хариу арга хэмжээ жендэрийн мэдрэмжтэй байхыг баталгаажуулах хэрэгтэй байна.

Агаарын температурын хэлбэлзэл, уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйлдэл зэргээс шалтгаалж зуд, ой хээрийн түймэр, шар усны үер зэрэг ноцтой хор уршиг бүхий гамшиг тохиох эрсдэл өндөр байна. Ийм эрсдэл үүссэнээр улс орон даяар хүн амын амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлэх төдийгүй ялангуяа малчдын амьжиргаанд ноцтой аюул учруулж болзошгүй юм.

Зуд гэдэг нь өвлийн улиралд хэт хүйтэрснээс мал сүрэг тэжээлийн хомсдолд орж даарч бээрснээс богино хугацаанд олноор үхэж хорогддог гамшигт үзэгдэл юм. 2009-2010 онд улс орон даяар зуд нүүрэлж нийт хорогдсон малын тоо 2010 оны байдлаар

203 НҮБ-ын Хүмүүнлэгийн хэргийг зохицуулах газар. (2020 оны 6 дугаар сар). *КОВИД-19 хариу арга хэмжээний НЕСУС хандлагад юу тохиолдсон бэ?* Үзэх <https://reliefweb.int/report/world/what-happened-nexus-approach-covid-19-response>.


204 НҮБХХ / АХБ. *Монгол Улсад Охид, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийнзасгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа*. Үзэх <https://www.mn.undp.org/content/dam/mongolia/Publications/Covid%20Impact%20Assessment%20FINAL%2025%20March%202021.pdf>



Давтамж ойр тохиох зудын гамшиг Монгол Улсын хувьд хүмүүнлэгийн хямрал учруулах эрсдэлтэй. Гэрэл зургийг Б. Рэнцэндорж

ДНБ-ий 6.3 хувьтай тэнцэж байв^[205] (Зураг 3.7.1). Түүхэнд зудын улмаас хүний амь нас хохирсон тохиолдол үе үе бүртгэгдэж байсан. Өнөөг хүртэл хүмүүнлэгийн болон хөгжлийн тусламж, дэмжлэгийн ихээхэн хувийг зудын үед зарцуулж ирсэн бөгөөд удаад нь үерийн гамшгийн хариу арга хэмжээний хөтөлбөрүүд орж байна. Иймд зудын гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үр дүнтэй, оновчтой механизмыг бий болгох нь амин чухал юм. 2020 оны байдлаар нийт нутгийн 50 гаруй хувь нь зудын эрсдэлтэй, нийт нутгийн 25 хувь нь дунд эрсдэлтэй, найман аймгийн нутгийн 20 гаруй хувь нь зудын нэн өндөр эрсдэлтэй бүсэд хамрагдсан байна (Зураг 3.7.2). Цаг агаарын эрс тэс нөхцөл байдлыг даван туулах уламжлагдан ирсэн малчдын гол стратеги нь отор нүүдэл байв. Байгалийн гамшгийн улмаас


Зураг 3.7.1: Малын хорогдол, хохирол, ДНБ-нд эзлэх хувиар, %



Эх сурвалж: ХХААХҮЯ, ҮСХ, ОБЕГ-ын мэдээлэлд үндэслэн тооцов.

205 НҮБ-ын ХХААБ. (2020 оны 9-р дугаар сар). "Хөдөө аж ахуйн салбарын гамшгийн хохирол, ослын мэдээллийн удирдлагын системийг байгуулж, Эмзэг байдал эрсдэлийн үнэлгээ хийх, VRA, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхэд ашиглах нь" эцсийн тайлан.

Зураг 3.7.2: Хүн амын тархалт, сумдаар, Зудын эрсдэлийн түвшингээр, 2020




Эх сурвалж: ОБЕГ, ОУШХБ. Хүн амын хөдөлгөөнийг хянах матриц (NEMA/DTM network)

мал сүргээ олноор хорогдуулахаас сэргийлж малчид нөхцөл байдал гайгүй бүс нутгууд руу нүүж өвөлждөг. Хэт хүйтрэх, хэт ихээр цас орох, хур тунадас эрс татрах зэрэг цаг уурын өөрчлөлттэй холбоотой гэнэтийн гамшиг тохиолдохыг урьдчилан таамаглахад бэрх тул хүн амын нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг байнга хянаж, бүртгэн гэнэтийн гамшиг тохиолдох үед шуурхай, үр дүнтэй хариу арга хэмжээ авах нь нэн чухал юм.

Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)-ын мэдээлснээр 2020 онд улсын хэмжээнд 4006 аюулт үзэгдэл, осол гарсан бөгөөд нийт аюулт үзэгдлийн 79.3 хувийг гал түймрийн осол, улмаар хүний буруутай үйл ажиллагаанаас

шалтгаалсан осол (13.6 хувь) эзэлж байна (Зураг 3.7.3). Эдгээрийн улмаас 248 хүн нас барж, 1301 хүн гэмтэж бэртэж, 80,954 толгой мал хорогджээ. Аюултай үзэгдэл, ослын улмаас нас барсан нийт хүний 48.8 хувь нь усанд осолдож, 31 хувь нь барилгын гал түймрийн улмаас нас барсан байна (Зураг 3.7.4). Аюултай үзэгдэл, ослын улмаас нийт эдийн засгийн хохирол 31.3 тэрбум төгрөг, үүнээс гал түймрийн улмаас 14.6 (46.6 хувь) тэрбум төгрөг, ус, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гамшгийн улмаас 16.5 (52.7 хувь) тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Иймээс эдгээр ослын үндсэн шалтгааныг, ялангуяа барилгын гал, усны ослын шалтгаан нөхцөлийг арилгах нь хүний амь насыг аврахад

Зураг 3.7.3: Аюулт үзэгдэл, ослын тохиолдол, 2020, %, төрлөөр



Зураг 3.7.4: Нас баралт, гамшгийн төрлөөр, 2020



Эх сурвалж: ОБЕГ. Гамшгаас хамгаалах ЦААГААН НОМ, 2020

нэн чухал юм. Түүнчлэн эмзэг байдлыг арилгахад чиглэсэн хөгжлийн асуудалд системтэйгээр хөрөнгө оруулалт хийх нь цаашид маш их хөрөнгө нөөцийг хамгаалж хэмнэн, гамшгийг тэсвэртэйгээр даван туулах чадавхыг бэхжүүлэх болно. НҮБ-ын ХХААБ-ын мэдээлснээр урьдчилан сэргийлэх буюу эртнээс арга хэмжээ авахад зарцуулсан нэг доллар^[206] нь ирээдүйд гарах долоон долларыг хэмнэх болно.

Монгол Улсын Засгийн газар нийгмийн хамгааллын тогтолцоогоо аливаа хямралыг даван туулах чадавхтай болгож бэхжүүлэхийн төлөө хөгжлийн түншүүдтэйгээ хамтран ихээхэн хүчин чармайлт гаргаж байна. Тухайлбал, ХНХЯ Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хямралын үеийн халамжийн зарим хөтөлбөрийг цааш өргөжүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Мөн эрсдэлтэй нөхцөл байдал, хүмүүнлэгийн онцгой байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах талаар тодорхой арга хэмжээ, тусламж дутмаг байгаа нь асуудал дагуулж байна.^[207] Улс орныг эрсдэлтэй, эмзэг, гамшигт өртөмтгий байдлаас урьдчилан сэргийлэх, улмаар сааруулах; төв орон

нутгийн түвшинд бэлэн байдлыг хангаж хариу арга хэмжээ авах, сэргээн босгох чадавхыг бэхжүүлэхэд эдийн засаг, нийгэм, хүн ам, эрүүл мэнд, соёл, боловсрол, байгаль орчны нэгдсэн, хүртээмжтэй бодлогууд нэн чухал юм. Малын тоо толгойн өсөлтөд хяналт тавьж, малын чанарыг сайжруулахад анхаарах нь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулахад тустай. Ингэснээр бэлчээрийн даацыг тэнцвэржүүлнэ. Улмаар өвөлжилт хүндрэх үеийн малчдын эмзэг байдлыг ч бууруулна. Гамшигтай тэмцэх өргөн цар хүрээтэй, олон сорилт хавсарсан амаргүй ажлын асуудал бүрийг хэсэг бүлэг, байгууллагууд дангаар шийдэж чадахгүй тул энэхүү ээдрээтэй сорилтуудыг шийдвэрлэхэд хөгжлийн түншүүд зэрэг бусад олон оролцогч талуудтай нягт хамтран ажиллах нь чухал юм.

Олон хүн Монгол Улсын тухай бодохдоо хамгийн түрүүнд Евразийн газар нутгийг байлдан дагуулж байсан домогт Чингис хааны тухай боддог. Гэвч өнөөдөр Монгол Улс дэлхийн энх тайвны төлөөх ажиллагаа, Азийн бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагаанд чухал хувь нэмэр оруулж байгаагаараа дэлхий дахинаа танигдаж

206 НҮБ-ын ХХААБ. (2018). *Монгол Улс: Эрт сэрэмжлүүлэг, Эрт арга хэмжээний үр нөлөө - Малчдын амьжиргааг зудын эрсдэлээс хамгаалах нь.*

207 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах хороо.

байна.^[208] Монгол Улс анх 2002 онд Баруун Сахарын Бүх нийтийн санал асуулга явагдах үед НҮБ-ын төлөөлөгчийн газарт зэвсэггүй хоёр офицер ажиглагч илгээснээр НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд нэгдсэн. Түүнээс хойш арав гаруйхан жилийн дотор Монгол Улс НҮБ-ын энхийг сахиулах үйлсэд ихээхэн хувь нэмэр оруулсан 27 дахь орон болсон бөгөөд одоогоор Өмнөд Судан Улсын Абизэй, Дарфур муж, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Баруун Сахар зэрэгт явуулж буй таван удаагийн энхийг сахиулах үйл ажиллагаанд 900 орчим цэрэг, цагдаагийн албан хаагчид оролцож байна. Монгол Улсын энхийг сахиулах ажиллагаанд оруулсан хувь нэмэр их бөгөөд цэрэг, цагдаа, зэвсэггүй цэргийн ажиглагчдаас бүрдсэн, олон тооны эмэгтэй албан хаагчид оролцсон, бэлтгэл сургуулилтын өндөр стандартыг хангасан зэргээрээ онцлог юм.^[209]

Мөн Монгол Улс Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагад нэгдсэн, Умард Атлантын гэрээний байгууллагатай түншлэлийн харилцаатай, Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг даргалж байгаа зэрэг олон улсын олон талт аюулгүй байдлын байгууллага, түншлэлд оролцох оролцоогоо өргөжүүлж байна. Цэрэг армийн өөрчлөлт, шинэчлэлийн хөтөлбөрүүд болон ОХУ, БНХАУ гэсэн хоёр их гүрний дунд геополитикийн өвөрмөц байршилтэй зэрэг асуудлынхаа тэнцлийг хангах сорилтууд байгаа хэдий ч Монгол Улс цэргийн стратегиа гадаад бодлогоо хэрэгжүүлэх хэрэгсэл болгон үр дүнтэй ашиглаж олон улсын хамтын ажиллагааг дэмжих, өөрийн орны тусгаар тогтнол, үндэсний өвөрмөц байдал, дипломат эрх чөлөөгөө хамгаалах "гуравдагч хөрш"-ийн бодлого баримталж байна.^[210]

3.8 МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ТӨЛӨВЛӨЛТИЙГ 2030 ОН ХҮРТЭЛХ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР, БҮС НУТАГ, ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР/ЗОРИЛГОТОЙ УЯЛДУУЛАХ НЬ

Монгол Улс нь Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-д тулгуурлан үндэсний урт хугацааны хөгжлийн бодлогоо баталсан анхдагч улс орнуудын нэг билээ. Монгол Улсын Их Хурал 2016 оны хоёрдугаар сард Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030" (ТХҮБ-2030)-ыг баталсан. Энэ нь агуулгын хувьд ТХЗ-д суурилсан бөгөөд тогтвортой хөгжлийн тулгуур зарчим болох эдийн засаг, нийгэм, байгаль орчин, засаглал гэсэн дөрвөн үндсэн чиглэлийн хүрээнд зорилго, зорилтуудаа тодорхойлсон урт хугацааны хөгжлийн стратегийн баримт бичиг болсон. Үндэсний хөгжлийн газар (ҮХГ)-аас

2018 онд хийсэн үнэлгээнээс үзэхэд ойролцоогоор ТХЗ-ын 60 хүрэхгүй хувь нь ТХҮБ 2030-д тусгалаа олсон байна.^[211]

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурал 2015 оны арваннэгдүгээр сарын 26-ны өдөр анх удаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг баталсан. Энэхүү хууль батлагдсан нь Монгол Улс 1990-ээд оны эхээр төвлөрсөн төлөвлөгөөт социалист тогтолцооноос ардчилсан, зах зээлд суурилсан эдийн засгийн тогтолцоонд шилжсэн цагаас хойш анх удаа бодлого боловсруулагчдад бодлого боловсруулах үйл явцыг эргэн харж, сайтар системчлэх боломж олгосон томоохон алхам болсон. Тус

208 Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яам. *Монгол Улс ба дэлхийн энх тайвны үйл ажиллагааны санаачилга*. Үзэх <https://mn.usembassy.gov/peace-khaan-quest-mongolia-global-peace-operations->

209 НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны мэдээллийн сан. *Цэргүүд ба цагдаагийн ажилтнууд*. Үзэх <https://peacekeeping.un.org/en/troop-and-police-contributors>

210 Кристиан Пульц. (2014 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр). Монгол Улсын Цэргийн стратегид энхийг сахиулах ажиллагааны гүйцэтгэх үүрэг. *Азийн судалгааны үндэсний товчоо*.

211 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газар. (2019). *Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл*. Үзэх <https://sustainabledevelopment.un.org/memberstates/mongolia>

хууль нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл явц болох бодлого боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, үр дүнд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, бодлогын хэвтээ, босоо уялдаа холбоо зэргийг зохицуулж өгсөн. УИХ-ын Төрийн бодлогын байнгын хорооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу уг хуулийн хэрэгжилтэд 2019 оны эхээр Үндэсний аудитын газраас хэрэгжилтийн аудит, дүгнэлт хийжээ.^[212] Салбаруудын бодлого, үндэсний болон орон нутгийн бодлогууд өөр хоорондоо харилцан уялдаа холбоогүй, зохицуулалтгүй, мэдлэг мэдээлэл хомс, хуулийн хэрэгжилт сул байгааг арилгах нь нэн чухал бөгөөд үүнийг сайжруулахад нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай болохыг аудитын дүгнэлт онцолсон байна. 2019 онд НҮБ-ын улс төрийн өндөр түвшний чуулга уулзалтад танилцуулсан Монгол Улсын анхны Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн Үндэсний сайн дурын илтгэлд ТХЗ-ыг үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төсөвт амжилттай тусгасанаар ТХЗ-г хэрэгжүүлэх боломжтой болох бөгөөд ингэснээр монголчуудын, тэр дундаа хөгжлөөс орхигдох эрсдэлтэй хүмүүсийн амьдралыг сайжруулахад бодитой нөлөө үзүүлэх болно хэмээн дүгнэсэн.

Түүнчэн уг тайланд салбарын болон салбар дундын 200 гаруй бодлого, хөтөлбөрүүд ТХЗ-той нийцээгүй, өөр хоорондоо уялдаа холбоогүй, агуулгын давхардал ихтэй, заримдаа зөрчилдсөн заалттай төдийгүй тогтвортой хөгжлийн асуудлыг зохистойгоор шийдэж чадахгүй байгааг онцолжээ. Эдгээр бодлогын дийлэнх нь шинжлэх ухааны үндэслэл муутай, нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлаа нарийвчлан судлаагүй, эн тэргүүнд шийдвэрлэх асуудлаа тодорхойлоогүй, хүрэх үр дүн нь бүрхэг,

санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй, бодлого боловсруулах үйл явцад олон талын оролцоо хангалтгүй байсан зэрэг дутагдал илэрсэнийг дурьджээ. ҮСДИ-д ТХЗ тус бүрийн хэрэгжилтийн явц, тулгарч буй сорилт бэрхшээлийн талаар тодорхой дүгнэлт гаргасны зэрэгцээ ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд тоо мэдээлэл хангалтгүй байгааг анхааруулсан байна.^[213] Салбарын болон салбар дундын бодлогуудад ҮХГ-аас 2019 онд^[214] хийсэн үнэлгээний үр дүн нь дээр өгүүлсэн ҮСДИ-ийн дүгнэлтүүдийг баталж байсан бөгөөд урт, дунд, богино хугацааны бодлогын хэвтээ, босоо уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байгааг онцолсон. Мөн түүнчлэн аливаа шийдвэр гаргах, төсөв боловсруулах үйл явцад хүүхдийн санал бодлыг тусгахгүй байгааг ҮСДИ-ийг танилцуулах үеэр зохион байгуулсан арга хэмжээн дээр тэмдэглэсэн бөгөөд өсвөр үеийнхний оролцоог хангах тогтвортой, цогц механизмыг салбар бүрт бий болгох, Засгийн газрын бүхий л үйл ажиллагаанд хүүхдийн санал бодлыг сонсож тусгаж байхыг уриалсан байна.^[215]

Түүнчлэн ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар бодлогын зөвлөгөө өгөх НҮБ, АХБ-ны хамтарсан баг нь Монгол Улсад ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг даван туулахад шаардагдаж буй дэмжлэгийг санал болгох зорилготойгоор 2017 онд судалгаа хийж ажилласан.^[216] Монгол Улс ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцыг зохицуулах, уялдаа холбоог нь хангах, хөгжлийн төлөвлөлт, төсвийн төлөвлөлтийг илүү сайн нийцүүлэх, бодлогын хэрэгжилтэд системтэйгээр хяналт шинжилгээ хийх зэрэг нь нэн чухал болохыг тус багын тайланд онцолсон.

212 УАЕГ. (2019). *Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан. Алсын хараа -2050 (хуулийн хэрэгжилтийн хэсэгт хамаарна)*. Үзэх https://cabinet.gov.mn/wp-content/uploads/2050_VISION_LONG-TERM-DEVELOPMENT-POLICY.pdf

213 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газар. (2019). *Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл*. Үзэх <https://sustainabledevelopment.un.org/memberstates/mongolia>

214 ҮХГ. (2019). *Салбарын болон салбар дундын бодлогын уялдаа холбоонд хийсэн үнэлгээ*. Монгол Улсын Их Хурал. (2020). *Алсын хараа-2050 (хөгжлийн бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх хэсэг)*.

215 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газар. (2019). *Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл*. Үзэх <https://sustainabledevelopment.un.org/memberstates/mongolia>

216 НҮБ, АХБ. (2017). *АХБ-ны хамтарсан ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар бодлогын зөвлөгөө өгөх ажлын хэсгийн тайлан*. Үзэх https://mongolia.un.org/sites/default/files/2019-09/un_adb_maps_mongolia_report_eng_final-2.pdf



УИХ-аас “Тогтвортой хөгжлийн зорилго” дээд түвшний форумыг анх удаа 2021 оны 10-р сард зохион байгуулав. Гэрэл зургийг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар / Д. Давааням

Нэмж дурдахад, НУБАНДЭЗНК, БОАЖЯ, ҮХГ хамтран гаргасан Монгол Улсын Тогтвортой хөгжлийн төлөв байдлын (ТХТ) тайланд Монгол Улс үндэсний хөгжлийн бодлогоо тогтвортой хөгжлийн зорилготой илүү сайн уялдуулах шаардлагатайг мөн онцолсон байна. ТХЗ-ыг үндэсний хөгжлийн бодлогод тусгахдаа ТХЗ-ын өөр хоорондын уялдаа холбоо, тэргүүлэх чиглэлийг харгалзалгүйгээр үндэсний хөгжлийн төлөвлөгөөнд ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг хуулбарлан оруулах замаар ажиллаж хэрхэвч болохгүй юм.^[217] Дээр дурьдсан шинжилгээ, тайлангуудад Монгол Улсад ТХЗ-ыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд өндөр түвшний манлайлал чухал болохыг онцлон тэмдэглэсэн байна.

Нэгдмэл, цогц, харилцан уялдаатай бодлого боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг үр дүнтэй зохицуулах, хөгжлийн үр дүнд хариуцлагатай хандах зэрэгт тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурал

2020 оны тавдугаар сард баталж хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ихээхэн хүчин чармайлт гаргасан. Энэхүү хууль нь Алсын хараа 2050 болон бусад урт, дунд, богино хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлогын уялдаа, нэгдмэл байдал болон институтийн зохицуулалтыг бүрдүүлэхэд чиглэсэн. Тогтвортой хөгжлийн бодлого боловсруулахад нотолгоонд суурилсан, үр дүнд чиглэсэн, өөр хоорондоо уялдсан, тэргүүлэх чиглэлээ тодорхойлсон цогц бөгөөд салбар дундын дүн шинжилгээ хийх шаардлага тавигдах учир тус хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх институтийн болоод хүний нөөцийн чадавх Монгол Улсын Засгийн газарт дутмаг хэвээр байна.

ТХҮБ 2030 баримт бичгийг орлох Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогыг Монгол Улсын Их Хурал 2020 оны тавдугаар сард баталж, Монгол Улсын ирэх 30 жилийн хөгжлийн стратегийн чиг хандлагыг тодорхойлсон. Алсын хараа 2050 нь үндэсний нийтлэг үнэт зүйл болох стратегийн есөн эрхэм зорилготой. Эдгээр

217 Монгол Улсын Тогтвортой хөгжлийн төлөв (ТХТ). Үзэх (https://www.unescap.org/sites/default/d8files/knowledge-products/SOM%20eng%202018_09_04%20last.pdf)

эрхэм зорилгыг хүний хөгжил; амьдралын чанар, дундаж давхарга; эдийн засаг; сайн засаглал; ногоон хөгжил; нийгмийн амар амгалан, аюулгүй байдал; бүсчилсэн хөгжил; Улаанбаатар болон дагуул хотууд гэж томъёолсон. Энэ нь 2020-2030 он хүртэл I үе шат; 2031-2040 он хүртэл II үе шат; 2041-2050 он хүртэл III үе шат гэсэн гурван үндсэн үе шаттайгаар хэрэгжинэ. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Алсын хараа 2050-ын хэрэгжилтийг 10 жилээр төлөвлөсөн хүний хөгжил, нийгмийн хөгжил, эдийн засаг, дэд бүтцийн хөгжил, байгаль орчин, засаглал, бүсчилсэн хөгжил, үндэсний өрсөлдөх чадварыг хөгжүүлэх гэсэн долоон зорилтот хөтөлбөрүүдээр дэмжих юм.

Монгол Улсын анхны дунд хугацааны хөгжлийн нэгдсэн хөтөлбөр болох Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг УИХ 2020 оны есдүгээр сард баталсан. Үүнтэй хамт 2021-2025 онд 39.6 их наяд төгрөг (буюу 13.9 тэрбум ам. доллар^[218])-ийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр батлагдсан. Тус хөтөлбөрийн 377 тэрбум төгрөг (буюу нийт дүнгийн нэг хувь)-ийг үндэсний нэгдмэл үнэт зүйлсийг хамгаалахад, 2.1 их наяд төгрөг буюу 5.4 хувийг хүний хөгжилд (эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан, инноваци, биеийн тамир, спорт); 2.3 их наяд төгрөг буюу 5.8 хувийг амьдралын чанар, дундаж давхаргыг нэмэгдүүлэхэд (орлогод нийцсэн орон сууц, зохистой хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнес, нийгмийн хамгаалал); 30.4 их наяд төгрөг буюу 76.7 хувийг эдийн засгийн салбарт (уул уурхай, хүнд үйлдвэр; хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр; аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжил); 321 тэрбум төгрөг буюу 0.8 хувийг засаглалыг бэхжүүлэхэд; 709 тэрбум төгрөг буюу 1.8 хувийг ногоон хөгжилд; 696 тэрбум төгрөг буюу 1.7 хувийг амар амгалан, аюулгүй нийгмийг бэхжүүлэхэд; 1.5 их наяд буюу 3.8 хувийг бүс, орон нутгийн хөгжилд; 1.2 их наяд төгрөг буюу 3 хувийг

Улаанбаатар болон дагуул хотын хөгжилд тус тус зарцуулахаар төлөвлөсөн байна.

Алсны хараа 2050 нь хүний хөгжлийг стратегийнхаа цөм болгож байгаа хэдий ч бодит амьдрал дээр тус улс нөөц баялагт тулгуурласан хөгжлийн замналаа үргэлжлүүлэхээр төлөвлөж буйг Хөрөнгө оруулалтын хөтөлбөр харуулж байна. Энэ нь 2021-2025 онд төлөвлөж байгаа нийт хөрөнгө оруулалтын бараг 30 хувийг эзэлж байгаа бол хүний капитал, засаглал, ногоон хөгжилд дөнгөж найман хувь буюу харьцангуй бага хөрөнгө оруулалт хийгдэхээр байна.^[219]

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (ЗГҮАХ)-ийн УИХ-аас баталсан бөгөөд уг хөтөлбөр нь улс төрийн эрх баригч нам болох Монгол Ардын Намын сонгуулийн мөрийн хөтөлбөр болон КОВИД-19 цар тахлын эсрэг авах шуурхай арга хэмжээний төлөвлөгөө зэрэгт тулгуурлан боловсруулагджээ. Дунд хугацааны таван жилийн үндсэн чиглэл болон ЗГҮАХ бодлогын баримт бичгүүдийн харилцан уялдаа холбоо сул, давхардмал агуулгатай байгаа бөгөөд бодлогын тэргүүлэх чиглэл, уялдаа холбоог нь цаашид илүү сайжруулах шаардлагатай байна.

НҮБХХ-өөс саяхан хийсэн судалгааны урьдчилсан дүнгээс харахад^[220], Алсын хараа 2050-ын зорилго зорилтууд нь ТХЗ, зорилтуудын дунджаар 82 орчим хувьтай бүрэн, 11 хувьтай хэсэгчлэн нийцсэн байгаа бол (Зураг 3.8.1); Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго зорилтууд нь ТХЗ, зорилтуудын 64 орчим хувьтай бүрэн, 24 хувьтай хэсэгчлэн нийцсэн байна (Зураг 3.8.2); Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтууд нь ТХЗ, зорилтуудын 76 орчим хувьтай бүрэн, 17 хувьтай хэсэгчлэн нийцсэн байна (Зураг 3.8.3).

Эндээс ажиглахад эдгээр гурван баримт

218 2021 оны 2-р сарын 19-ний өдрийн Монголбанкны ам.доллар/төгрөгтэй харьцах ханшаар тооцсон болно. Үзэх <https://www.mongol-bank.mn/eng/dblistofficialdailyrate.aspx?vYear=2021&vMonth=1&vDay=19>

219 Монгол Улсын Их Хурал. (2020). *Алсын хараа-2050 (хөгжлийн бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх хэсэг)*.


220 НҮБХХ. (2021). *Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогод ТХЗ, зорилтуудыг тусгасан байдал судалгаа*.

бичгийн шалгуур үзүүлэлтүүдийн ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдтэй нийцсэн байдал маш сул байна. Тухайлбал, Алсын хараа 2050 болон таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтүүд ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдтэй нийцсэн байдал дунджаар найман хувь байсан бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024)-ийнх долоон хувь байна (Зураг 3.8.4). Иймээс эдгээр бодлогын арга хэмжээнээс ТХЗ-ын хэрэгжилтэд үзүүлэх нөлөө маш бага байх тул ТХЗ,


зорилтуудыг, ялангуяа 10 жилийн зорилтот долоон хөтөлбөр, жилийн төлөвлөгөө, төсөв зэрэг удахгүй гарах бодлогын баримт бичгүүдэд тусгахын тулд дорвитой хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.

Монгол Улс нь ТХЗ-ын үндэсний зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдийг албан ёсоор баталж амжаагүй байна. Монгол Улсын Засгийн газраас 2019 онд үндэсний хэмжээний ТХЗ-ын зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдийг


Зураг 3.8.1: Алсын хараа-2050-ны зорилго, зорилтууд нь ТХЗ, зорилтуудтай нийцсэн байдал




Зураг 3.8.2: Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилтууд нь ТХЗ, зорилтуудтай нийцсэн байдал



Зураг 3.8.3: Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтууд нь ТХЗ, зорилтуудтай нийцсэн байдал



Зураг 3.8.4: ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн нийцсэн байдал




Эх сурвалж: НҮБХХ -ийн судалгаа, 2020

тодорхойлох зорилгоор ҮХГ-аар ахлуулсан салбар дундын найман ажлын хэсгийг байгуулсан. Монгол Улсын Засгийн газар болон УИХ-ын намрын чуулганаар одоогоор боловсруулаад байгаа ТХЗ-ын үндэсний зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдийн төслийг хэлэлцэн батлахаар зорьж байна. Эдгээр ТХЗ-ын зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдийг тус улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого боловсруулах, ялангуяа 10 жилийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулах явцад зөв зохистойгоор тусгах шаардлагатай байна. ТХЗ-ын зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдийн төсөлд Монгол Улсад ТХЗ-ыг нутагшуулан хэрэгжүүлэх явцад хяналт тавих, улмаар үр дүнг хэмжих нийт 255 шалгуур үзүүлэлтыг томъёолоод байгаа бөгөөд эдгээрээс 133^[221] үзүүлэлт нь үндэсний хөгжлийн бодлогын зорилтуудыг тодорхойлсон жишиг үзүүлэлтүүд байгаа болно.

ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт тавьж үнэлэлт дүгнэлт гаргах найдвартай механизмыг бэхжүүлэхийн тулд үйл явцыг хянах, бодлогын шийдвэрийг мэдээлэх, үр дүнгийн төлөөх хариуцлагыг баталгаажуулах үнэн бодитой шалгуур үзүүлэлтүүд, тоо мэдээлэл зайлшгүй шаардлагатай. Дэлхий нийтээр хэрэгжүүлэх 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн 17 зорилгын биелэлтэд хяналт тавих нийт 248 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. Тэдгээрээс 16 зорилго, 238 шалгуур үзүүлэлт нь Монгол Улсад хамаарна. Үндэсний статистикийн хорооноос (ҮСХ) ТХЗ-ын тоо мэдээллийн бэлэн байдалд хийсэн үнэлгээнээс харахад дээрх Монгол Улсад хамаарах үзүүлэлтүүдийн 132^[222] -ыг нь Монгол Улс тооцох боломжтой бөгөөд үлдсэн 45 хувийг нь тооцохын тулд нэмэлт тоо мэдээлэл цуглуулах шаардлагатай байна. 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн "Эх дэлхий"-тэй холбоотой үзүүлэлтүүдийг тооцох тоо мэдээлэл тун хомс байна (Зураг 3.8.5). НҮБ-ын Статистикийн комисс (НҮБСТАТ) 2021 оны есдүгээр сард олон

улсын ТХЗ-ын мэдээллийн платформ^[223] -ыг бэлтгэж нээсэн бөгөөд энэ платформ дээр улс орон бүрийн ТХЗ-ын хэрэгжилтийн төлөв байдлыг дэлгэрэнгүй танилцуулсан мэдээллийн сан бий болсон. Энэхүү платформ дээрх Монгол Улсын мэдээллийн санд ҮСХ-ны болон улс дотроо тооцох боломжтой тоо мэдээллээс хавьгүй их мэдээлэл орсон (28 орчим хувийг тооцох боломжгүй) байна. Түүнчлэн НҮБСТАТ болон ҮСХ-ны зарим тоо мэдээлэл зөрүүтэй байгааг цаашид судалж залруулах шаардлагатай.

Зураг 3.8.5 Монгол Улс: ТХЗ-ын тоо мэдээллийн бэлэн байдал, 2020



Эх сурвалж: ТХЗ-ын мэдээллийн сан, 1212.mn, ҮСХ

221 ҮХГ. (ТХҮЗ-ийн хурал. 2020 оны 5 дугаар сар). Үндэсний ТХЗ-ын зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдийн төсөл.

222 Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо. (2021). ТХЗ-ын мэдээллийн сан. Үзэх <https://www.1212.mn>

223 Тогтвортой Хөгжлийн зорилтуудын үзүүлэлтийн цахим хуудас. Үзэх <https://unstats.un.org/sdgs/>

НҮБ-аас ҮСХ болон НҮБСТАТ-ын гаргасан мэдээллийн уялдаа болон зөрүүг шинжилж үзэхэд ТХЗ-ын нийт 238 үзүүлэлтээс 171 үзүүлэлтийг тооцох мэдээллийг НҮБСТАТ тус тусад нь гаргасан бөгөөд 67 үзүүлэлт (буюу 28 хувь)-ийг тооцохын тулд нэмэлт тоо мэдээлэл шаардлагатай гэж үзжээ. Харин ҮСХ 131 үзүүлэлтийг тус тусад нь тооцож гаргах боломжтой бөгөөд 107 үзүүлэлт (45 хувь)-ийг тооцохын тулд нэмэлт тоо мэдээлэл шаардлагатай хэмээн үзэж байна. НҮБСТАТ болон ҮСХ-ны дээрх мэдээллийг нэгтгэж үзвэл ТХЗ-ын 238 үзүүлэлтээс 190 үзүүлэлтийг тооцох боломжтой бөгөөд 48 үзүүлэлт (20 хувь)-ийг тооцохын тулд нэмэлт тоо мэдээлэл шаардлагатай байна (Зураг 3.8.6).

Монгол Улсын Их хурлын Эдийн засгийн байнгын хорооны удирдлага дор (2015 оноос Нийгмийн бодлогын байнгын хороонд харъяалагдаж байсан) ТХЗ-ын дэд хороог 2020 онд шинэчлэн байгуулагдсан^[224] бөгөөд 2021 онд Ерөнхий сайдын захирамжаар Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийг шинэчлэн байгуулсан^[225] зэргээр Монгол Улс ТХЗ-ын хэрэгжилтэд ерөнхийд нь хяналт тавих үндэсний хэмжээний институцийн механизмыг бүрдүүлсэн. Гэсэн хэдий ч энэхүү Үндэсний зөвлөл байгуулагдсан цагаасаа хойш 2019 онд Үндэсний сайн дурын илтгэлийг батлах зорилгоор ганцхан удаа хуралдсан байна. Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар 2021 оны нэгдүгээр сард Тогтвортой хөгжлийн

Зураг 3.8.6. ТХЗ-ын 238 шалгуур үзүүлэлтээс ҮСХ болон НҮБСТАТ-ын тооцох боломжтой үзүүлэлтүүд

ТХЗ	238 үзүү- лэлт	ТХЗ-ын үзүүлэлтүүд																												Мэдээлэл байхгүй - 48		Мэдээлэл байгаа - 190	
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28				
ТХЗ 1	13	1.1	1.2	1.22	1.3	1.4	1.42	1.5	1.52	1.53	1.54	1a1	1a2	1b1																	2	11	
ТХЗ 2	14	2.1	2.2	2.21	2.22	2.23	2.3	2.32	2.4	2.5	2.52	2a1	2a2	2b1	2c1																	2	12
ТХЗ 3	28	3.1	3.2	3.21	3.22	3.3	3.32	3.33	3.34	3.35	3.4	3.42	3.5	3.52	3.6	3.7	3.72	3.8	3.82	3.9	3.92	3.93	3a1	3b1	3b2	3b3	3c1	3d1	3d2	2	26		
ТХЗ 4	12	4.1	4.2	4.21	4.22	4.3	4.4	4.5	4.6	4.7	4a1	4b1	4c1																			1	11
ТХЗ 5	14	5.1	5.2	5.22	5.3	5.32	5.4	5.5	5.52	5.6	5.62	5a1	5a2	5b1	5c1																	4	10
ТХЗ 6	11	6.1	6.2	6.3	6.32	6.4	6.42	6.5	6.52	6.6	6a1	6b1																			1	10	
ТХЗ 7	6	7.1	7.2	7.3	7a1	7b1																								0	6		
ТХЗ 8	16	8.1	8.2	8.3	8.4	8.42	8.5	8.52	8.6	8.7	8.8	8.82	8.9	8.10	8.102	8a1	8b1															1	15
ТХЗ 9	12	9.1	9.2	9.21	9.22	9.3	9.32	9.4	9.5	9.52	9a1	9b1	9c1																		3	9	
ТХЗ 10	14	10.1	10.2	10.3	10.4	10.42	10.5	10.6	10.7	10.72	10.73	10.74	10a1	10b1	10c1																	3	11
ТХЗ 11	15	11.1	11.2	11.3	11.32	11.4	11.5	11.52	11.6	11.62	11.7	11.72	11a1	11b1	11b2	11c																5	10
ТХЗ 12	13	12.1	12.2	12.22	12.3	12.4	12.42	12.5	12.6	12.7	12.8	12a1	12b1	12c1																		7	6
ТХЗ 13	8	13.1	13.2	13.3	13.32	13.4	13a1	13b1																							3	5	
ТХЗ 15	14	15.1	15.2	15.3	15.4	15.42	15.5	15.6	15.7	15.8	15.9	15a1	15b1	15c1																		2	12
ТХЗ 16	24	16.1	16.2	16.3	16.4	16.42	16.5	16.6	16.7	16.8	16.9	16.10	16.11	16.12	16.13	16.14	16.15	16.16	16.17	16.18	16.19	16.20	16.21	16.22	16.23	16.24	4	20					
ТХЗ 17	24	17.1	17.2	17.3	17.4	17.5	17.6	17.7	17.8	17.9	17.10	17.11	17.12	17.13	17.14	17.15	17.16	17.17	17.18	17.19	17.20	17.21	17.22	17.23	17.24	8	16						

Тийм Үгүй

224 ТХЗ-ын Дэд хороо байгуулах тухай УИХ-ын тогтоол, 2015 оны 11-р сар. legalinfo.mn. 2020 онд ТХЗ-ын дэд хороог шинэчлэн байгуулж Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

225 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Үзэх <http://legalinfo.mn>

үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэн шинэчилж салбар яамд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, Монгол Улс дахь НҮБ-ын хөгжлийн системийн төлөөлөл зэргийг тус тус хамруулж баталсан. Өнөөгийн Засгийн газрын хувьд нэгдмэл, зохицуулалттайгаар бодлого боловсруулах, ТХЗ-ыг урт хугацааны хөгжлийн стратегид тусгаж уялдуулах, улмаар тэдгээрийг дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогод тусгаж уялдуулах, хэрэгжилтийг нь удирдан зохицуулах үүргийг Монгол Улсын Засгийн

газрын Хэрэг эрхлэх газар болон ҮХГ хоёул давхархүлээж байна. ТХЗ-ын санхүүжилтийн асуудал Сангийн яамны чиг үүрэгт хамаарч байна. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүд болон тоо мэдээллийн бэлэн байдлыг хангах асуудлыг Үндэсний статистикийн хороо хариуцаж байна.^[226] Үндэсний хэмжээний үнэлгээний системүүдийн босоо, хэвтээ харилцан уялдаа холбоо, зохицуулалтын тогтолцоо тун сул байгаа бөгөөд үнэлгээ хийхэд шаардагдах хөрөнгө нөөц хомс, чанартай, бүрэн, бодитой, нарийвчилсан тоо мэдээллийн олдоц ч хязгаарлагдмал байна.

3.9 САНХҮҮГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын санхүүгийн төлөв байдлыг уул уурхайд тулгуурласан эдийн засаг, гадаад орчны нөлөөнд нэн өртөмтгий байгалийн баялаг илэрхийлж байна. Нүүрс, зэс болон бусад ашигт малтмалын олборлолт нь төсвийн шилжүүлэг, экспортын орлого, ГШХО-ын чухал эх үүсвэр болж байна.

Уул уурхайгаас тогтвортойгоор орлого олж эхэлсэн 2004 оноос хойш Монгол Улс нийт 28 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Мөн сүүлийн 15 жилд татвар, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого хэлбэрээр 9 тэрбум ам.долларыг төвлөрүүлсэн байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс гадна Монгол Улсын Засгийн газар гол төлөв байгалийн баялгийн орлогоо барьцаалан 8.7 тэрбум ам.долларын зээл авчээ. 2011 оноос эхлэн Монгол Улсын Засгийн газар Тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв санд орлогынхоо тодорхой хэсгийг хуримтлуулж эхэлсэн боловч 2019 оны байдлаар дөнгөж 0.2 тэрбум ам.долларын цэвэр үлдэгдэлтэй байна. Үүнээс харахад Монгол Улс уул

уурхайн орлогынхоо дийлэнхийг хэрэглээд зогсохгүй ирээдүйн орлогоо барьцаалан их хэмжээний зээл авч байгаа учир хойч үедээ өр өвлүүлэхээр байна.^[227] Дэлхийн банкны тооцоогоор Монгол Улс сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд уул уурхайн орлогын нэг ам доллар тутмын 99 центийг нь хэрэглэж, ердөө нэг центийг нь л хуримтлуулсан байна.


Үнэндээ, уул уурхайн ордууд нээгдсэнээр Монгол Улс төсвийн өндөр зарлагатай орон болсон. 2010-2019 онуудад Монгол Улсын төсвийн зарлага дунджаар ДНБ-ий 33.2 хувьтай тэнцэж байсан нь түүхий эдээс хамааралтай орнууд болон багадунд орлоготой бусад орнуудын дунджаас нилээд өндөр байна.^[228] Дэлхийн банкны судалгаанаас харахад эрдэс баялгийн орлогын дийлэнх хувь нь улсын хөрөнгө оруулалт (56 хувь), нийгмийн халамж (28 хувь), цалин, тэтгэвэр (16 хувь) зэрэг улс төрийн амлалтын хөтөлбөрүүдэд зарцуулагдсан байна. Төсвийн зардлын мэдэгдэхүйц өсөлт нь УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийн хугацаатай ч мөн давхцаж байна (Зураг 3.9.1).

226 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газар. (2019). *Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл*. Үзэх <https://sustainabledevelopment.un.org/memberstates/mongolia>

227 Дэлхийн банк. (2020 оны 9 дүгээр сар). *Уул уурхай ба оюун ухаан. Байгалийн баялгийн өгөөжийг институт болон хүний хөгжилд чиглүүлэх нь. Эдийн засгийн хөгжлийн тойм судалгаа*. Үзэх <https://openknowledge.worldbank.org/handle/10986/34551>

228 Дэлхийн банк. (2018). *Өрийн дарамтгүй, тогтвортой бөгөөд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох нь. Төсвийн орлого, зардлын үр ашгийг нэмэгдүүлэх нь*.

Зураг 3.9.1: Уул уурхайн орлогын зарцуулалт 1998-2019



Эх сурвалж: Дэлхийн банк, Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгаа, 2020 оны есдүгээр сар

Монгол Улс дэлхийн өрсөлдөх чадварын индексийн төсвийн зарлагын үр ашигтай байдлын үнэлгээгээр 124 дүгээр байрт жагсаж байгаа нь төсвийн зарлагын үр ашиг муу байгааг харуулж байна.^[229] Дэлхийн банкны судалгаагаар Монгол Улсын хөрөнгө оруулалтын зардлын өсөлтөд зардлын бүтэц (засвар үйлчилгээний зардал хангалтгүй), зардлын газарзүйн хуваарилалт (Улаанбаатарт хангалтгүй), төсвийн үрлэгэн байдал зэрэг гурван том дутагдал байгааг тогтоожээ. Мөн Монгол Улсын Хөгжлийн банк төсвийн орлого бүрдүүлдэггүй дэд бүтцийн төслүүдэд хэт ихээр зээл олгосон^[230] нь Засгийн газарт ихээхэн хэмжээний өр төлбөрийг бий болгож байгааг ОУВС тэмдэглэсэн байна.

Монгол Улсын өр 2021 онд ДНБ-ий 81.5 хувьд хүрэх төлөвтэй байна.^[231] Өрийн эмзэг байдлын нэг чухал асуудал бол гадаад валютын өрөөс ихээхэн хамааралтай байгаа явдал юм. Монгол Улсын өрийн 90 орчим хувь нь гадаад валютын өр байна. Энэ нь мөнгөний бодлогод тулгарч байгаа

том бэрхшээл бөгөөд аливаа валютын ханшны сулрал маш өндөр зардалд хүргэж болзошгүй юм. Засгийн газрын зээл, өрийн өсөлт, Монгол Улсын хөрөнгийн эрсдэлийн хураамж зэргийн хооронд хөгжлийн саад бэрхшээлийн эргүүлэгт харилцаа үүсч болзошгүй бөгөөд энэ нь цаашлаад төсвийн бодлогыг хязгаарлагч хүчин зүйл болж хувирна. Монгол Улсын гадаад өр 2021 оны 2-р улирлын эцсийн байдлаар 33 тэрбум ам.долларт (ДНБ-ий 248%) хүрч, өмнөх оны мөн үеэс 2.1 тэрбум ам.доллараар нэмэгджээ.^[232]

Гадаад өрийн өсөлтөд шууд хөрөнгө оруулалт (компани хоорондын зээллэг) 972.1 сая ам.доллар, бусад салбарын гадаад өр 588.3 сая ам.доллар, нэгдсэн төсвийн гадаад өр 556.0 сая ам.доллар, Төв банкны гадаад өр 110.8 сая ам.доллар болж өссөн зэрэг нь нөлөөлжээ. Нийт гадаад өрийн дийлэнх хувийг (36.4 хувь) шууд хөрөнгө оруулалт (компани хоорондын зээллэг), бусад салбарын гадаад өр (26.4 хувь), Засгийн газрын гадаад өр (25.6 хувь) тус тус бүрдүүлж байна (Зураг


229 Мөн тэнд.

230 ОУВС (2019 оны 9 дүгээр сар). Дүрмийн IV заалтын Зөвлөлдөх уулзалт- Хэвлэлийн мэдээ. Ажилтны тайлан. Гүйцэтгэх захирлын мэдэгдэл.

231 ОУВС (2019 оны 9 дүгээр сар). Дүрмийн IV заалтын Зөвлөлдөх уулзалт- Хэвлэлийн мэдээ. Ажилтны тайлан.

232 Монгол Банк. Үзэх <https://www.mongolbank.mn/eng/default.aspx>

Зураг 3.9.2: Нийт гадаад өрийн бүтэц, улирлаар (ДНБ-д эзлэх хувиар)



Эх сурвалж: Монгол Банк

3.9.2). Засгийн газраас баталгаа гаргасан арилжааны өрийн хэмжээ Засгийн газрын нийт өрийн 4 хувь буюу 955 тэрбум төгрөг^[233] байгаа төдийгүй компаниуд хоорондын өрийн хэмжээ нэмэгдэж байгаа нь түгшүүр төрүүлж байна. Энэ нь хоёр талт арилжааны зээлдүүлэгчидтэй тохиролцож томоохон хэмжээний өрийн бүтцийн өөрчлөлтийг хийхгүй байх аваас санхүүгийн болон эдийн засгийн хямралын хугацааг уртасгаж эмх замбараагүй өрийн давалгааг үүсгэж болзошгүй юм. Түүнчлэн Монгол Улсын зээлийн хүүгийн төлбөрийн зардал нь бусад бага дунд орлоготой орнуудынхаас ихээхэн өндөр байна. 2012 оноос хойш дотоодын болон гадаад өр хурдацтай нэмэгдэж байгаатай холбоотойгоор зээлийн хүүгийн төлбөр 2012 онд ДНБ-ий 0.8 хувь байсан бол 2020 онд ДНБ-ий гурав орчим хувь болж өссөн. ОУВС-гийн тооцоогоор улсын өр, санхүүжилтийн хэрэгцээний тооцоо төсөөлөл нь өрийн өсөлт, валютын ханш, санхүүгийн салбарын болзошгүй өр төлбөрийн шоконд онцгой мэдрэмтгий байна. Энэ нь улсын өрийн үйлчилгээнд шаардагдах санхүүжилтийн нийт хэрэгцээ,

хүү, үндсэн зээлийг 2022-2023 онд ДНБ-ий 20 хувьд хүртэл өсгөж болзошгүй юм. Ингэснээр нийгмийн хамгаалал, эдийн засгийг төрөлжүүлэх, ногоон хөгжил зэрэг шаардагдах үндсэн зардлын багцийн төсвийн орон зайг мэдэгдэхүйц хумина. Монгол Улс 2020 оны дөрөвдүгээр сард эхлүүлсэн Өрийн үйлчилгээг түр зогсоох санаачилгад хамрагдах боломжтой байсан ч Их 20-ийн орнуудад төлөх хоёр талын албан ёсны өрийн үйлчилгээг түр түдгэлзүүлэх зорилгоор оролцоогүй байна.

2020 онд алтны экспорт дөрөв дахин нэмэгдсэний үр дүнд Монголбанк гадаад валютын нөөцөө 2020 оны жилийн эцсийн байдлаар 10 сарын импортоор 4500 сая ам.доллараар хэмжигдэж байсан 2019 оны түвшнээс ялимгүй давуулсан. Хил хаагдаж, алт хууль бусаар хил давуулах боломж хумигдсантай холбоотойгоор ийнхүү алтны экспорт нэмэгдэх боломж гарсан бөгөөд хил нээгдсэнээр энэ хандлага эргэж өөрчлөгдөж магадгүй гэсэн таамаг ч байна. Иймд Монгол Улс алтны хууль бус олборлолт, зуучлагчидтай холбоотой Олон улсын Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмжийг^[234] дагаж мөрдөх нь нэн чухал алхам бөгөөд ингэснээр гадаад валютын нөөцийг хангалттайгаар нэмэгдүүлж, дунд хугацаанд өрийн тогтвортой байдлыг хангах боломж бүрдэнэ.

Дээр өгүүлсэн төсвийн бүрдүүлэлтэд учирч буй сорилт бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд макро эдийн засаг болон төсвийн удирдлагыг бэхжүүлэх, түүнчлэн орлого бүрдүүлэх шинэ арга зам хайх, төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай. Татварын хувь хэмжээг шатлалтайгаар чангаруулж, татварын бааз суурийг өргөжүүлэх замаар орлогын

233 Иргэдийн төсөв 2020

234 Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан чуулганаар тус байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу үүргээ биелүүлсэн гэж үзээд Монгол Улсыг ФАТФ-ын саарал жагсаалт буюу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргасан. ФАТФаас 2019 оны 10-р сард тодорхойлсон стратегийн дутагдалтай холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөөг сайтар даган мөрдөж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дэглэмээ улам сайжруулах чиглэлээр бүс нутгийн байгууллага (APG)-тай нягт хамран ажиллахыг зөвлөсөн.

бүрдүүлэлтийг нэмэгдүүлж^[235] өнөөгийн татварын тогтолцооны шударга байдлыг сайжруулах боломж байна. Тухайлбал, Хүн амын орлогын албан татварын хувь хэмжээг 10 хувиар жигд тогтоосон нь бага ч болов дэвшил болсон нь Дэлхийн банкны судалгаанаас харагдаж байна. Мөн уул уурхайн салбарын шууд хөрөнгө оруулагч, үйлчилгээ үзүүлэгч нарт ашгийн болон НӨАТ-ын хөнгөлөлт үзүүлж байна. Түүнчлэн татварын албыг бэхжүүлэх замаар татварын бааз суурийг тэлэх боломж ч бий.

Хүүхдийн мөнгө хөтөлбөр, орон сууцны хөнгөлөлттэй хүүтэй зээлийн хөтөлбөр зэрэг арга хэмжээнүүд төсвийн зарлагын томоохон хувийг эзэлж байна. Орон сууцны хөнгөлөлттэй хүүтэй зээлийн хүүгийн татаас нь 2019 оны төсвийн зарлагын дийлэнх хувийг (ДНБ-ий 1.2 орчим хувь) эзэлж байгаа хэдий ч өндөр орлоготой хүмүүс ихэвчлэн хамрагдаж байгаагаас бодит тоон утга болон харьцангуй үзүүлэлтүүд тэгш бус байдлыг илэрхийлж байна. Дэлхийн банкны судалгаанаас харахад харьцангуй өргөн цар хүрээтэй Хүүхдийн мөнгөний хөтөлбөр нь тэгш бус байдлыг бууруулах шинж чанарын хувьд харьцангуй нейтрал буюу төвийг сахисан шинж агуулж байна.^[236] Түүнчлэн НҮБ-ын Хүүхдийн сангаас хийсэн хүүхдэд чиглэсэн төсвийн төлөвлөлт, төсөв боловсруулах үйл явц болон боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбаруудын төсвийн зарлагын үнэлгээний үр дүн “хүүхдийн дээд ашиг сонирхлыг” орхигдуулж байгааг харуулж байна.^[237]

Эрчим хүчинд хэр хэмжээний татаас өгч байгаа талаарх тоо мэдээлэл хомс хэдий ч гэр хорооллынхны хэрэглэж байгаа сайжруулсан нүүрсэнд төрөөс татаас олгож байгааг тооцож үзвэл эрчим хүчний татаасын хэмжээ их байх нь ойлгомжтой.

2021 оны долдугаар сарын 1-ний өдрийг хүртэл КОВИД-19 цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний хүрээнд орон сууцны айл өрхүүдийн 100 ам.метр хүртэлх талбайд ногдох халаалтын үйлчилгээний төлбөрийг бүрэн чөлөөлсөн тул 2020 онд цахилгаан эрчим хүч, дулааны татаасыг улам бүр нэмэгдүүлсэн. ОУВС-гийн эрчим хүчний татаасын талаарх судалгаанаас харахад үүнд мөн л өндөр орлоготой айл өрхүүдийн хэрэглээ түлхүү хамрагдсан нь тоон болон харьцангуй үзүүлэлтээрээ урвуу нөлөөллийг буюу тэгш бус байдалд нөлөөлж байна.^[238]

2018 оны Хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ^[239] болон бусад судалгааны үр дүнгээс харахад ТХЗ-ын санхүүжилтийн механизмыг хөгжүүлэхэд тулгарч буй стратегийн гол саад бэрхшээл нь үндэсний хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, улсын төсөв, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд өөр хоорондоо харилцан уялдаагүй байгаа асуудал юм. Тогтвортой хөгжлийн замналд тууштай орох нь зайлшгүй чухал болохыг Монгол Улсын Засгийн газар хүлээн зөвшөөрч ‘Алсын хараа 2050’ үндэсний хөгжлийн урт хугацааны бодлого, таван жилийн хөгжлийн үндсэн чиглэлийг баталсан хэдий ч ижил төстэй чиглэлийг хамарсан өмнөх бодлогуудынхаа хэрэгжилт, үр дүнд нь үнэлгээ хийлгүйгээр эдгээр бодлогын баримт бичгүүдийг боловсруулж баталсныг анхаарах хэрэгтэй юм. Бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, баталж байгаа хэдий ч тэдгээрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх хөтөлбөрүүд, улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсөв гэх мэт дараа дараагийнхаа бодлогын арга хэмжээгээр уялдуулан дэмжихгүй байна. Байгалийн баялаг ихтэй орнуудын хувьд тогтвортой хөгжлийг бий болгоход амаргүй хэдий ч дээр өгүүлсэн олон саад бэрхшээл Монгол Улсад тулгарч байгааг

235 Дэлхийн банк. (2018). *Өрийн дарамтгүй, тогтвортой бөгөөд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох нь. Төсвийн орлого, зардлын үр ашгийг нэмэгдүүлэх нь.*

236 Мөн тэнд.

237 НҮБ-ын Хамтарсан хөтөлбөр. *ТХЗ-ын санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх.* Үзэх <https://www.jointsdgfund.org/programme/rolling-out-integrated-approach-sdg-financing-mongolia>

238 Клементс, Коади, Фабрицио, Гупта, Аллейн, Сдралевич нар. (2013). *Эрчим хүчний татаасын шинэчлэл: Сургаж, Үр дагавар. Вашингтон хот: ОУВС.*

239 Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ, АХБ, бусад. (2018). *Монгол Улсын Хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ.* Үзэх <https://www.undp.org/content/dam/rbap/docs/dg/dev-effectiveness/RBAP-DG-2018-Development-Finance-Assessment-Mongolia.pdf>


анхаарах хэрэгтэй. Одоогоор боловсруулж байгаа Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцооны гол зорилго нь шилдэг туршлагаудыг улам бэхжүүлэх, Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахад шаардагдах санхүүжилтийг хэр их хэмжээгээр төвлөрүүлэх, хэрхэн оновчтой удирдах зэрэгт чиглэсэн зохицуулалтын механизмыг бий болгоход оршино.^[240]

Бага дунд орлоготой шилжилтийн эдийн засагтай орнуудын өвөрмөц нэг онцлог шинж чанар нь тэдгээрийн олон улсын хөрөнгийн урсгалд ГШХО давамгайлж байдаг ч савлагаа ихтэй байдаг явдал юм. 2000-2011 онд Монгол Улсын уул уурхайн салбарын огцом өсөлттэй холбоотойгоор ГШХО эрчимтэй бөгөөд тогтвортой өсч, түүхэндээ хамгийн дээд цэгт буюу 4.5 тэрбум ам.долларт хүрсэн (Зураг 3.9.3). Гэсэн хэдий ч 2012 оноос хойш олон улсын зах зээл дээр түүхий эдийн үнэ буурсан нь Монгол Улс дахь хөрөнгө оруулагчдын идэвх сулрахад хүргэж, эцэстээ Рио Тинто корпорацитай хийсэн өрийн своп хэлцлийн


улмаас 2016 онд ГШХО огцом агшиж, 2019 онд 2.4 тэрбум ам.доллар болсон тухай тооцоо бий. Монгол Улсын ГШХО-ын төвлөрлөөс шалтгаалж эмзэг байдлын хоёр шинж ажиглагдаж байна. Нэгдүгээрт, Монгол Улсын ГШХО-ын талаас илүү хувийг Канад Улс, БНХАУ гэсэн хоёрхон улс бүрдүүлж байгаа нь Монгол Улс эдгээр орнуудын эдийн засгийн төлөв байдлаас хэт хамааралтай болох, мөн хөрөнгө оруулалтын урсгал тогтворгүй байх нөхцөлийг үүсгэж байна. Хоёрдугаарт, ГШХО нь тодорхой нэг салбарт чиглэн төвлөрч байна. Тухайлбал, ГШХО-ын 71 хувь нь уул уурхайн салбарт хийгдсэн байна (зураг 3.9.4)^[241]. ОУВС-ын тооцоогоор Монгол Улсын ГШХО 2020 онд ойролцоогоор 1.5 тэрбум ам.долларт хүрч буурахаар байна.^[242]

Уул уурхайгаас бусад салбарт хийгдсэн ГШХО-ын хувийн жин бага байгаа хэдий ч Оюутолгойн уурхайн үйл ажиллагаа эхэлсэн буюу 2009 оноос өмнөх үеийн ГШХО-ын нийт дотоод урсгалтай харьцуулахад ам.долларын дүнгээр илүү байна. Дэлхийн

Зураг 3.9.3: ГШХО, ХАЁТ, Мөнгөн шилжүүлэг, 2001-2019 (сая ам. доллар)



Эх сурвалж: Дэлхийн банк, Дэлхийн хөгжлийн индексүүд Мэдээллийн сан. <https://databank.worldbank.org/source/world-development-indicators>



Эх сурвалж: Дэлхийн банк, Эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгаа, 2020 оны 9-р сар

240 Монгол дахь НҮБ. (2020). "Монгол Улсад ТХЗ-ын санхүүжилтийн нэгдсэн арга барилыг нэвтрүүлэх нь". Үзэх <https://www.jointsdg-fund.org/article/united-nations-and-government-mongolia-commence-joint-programme-integrated-financing> & <https://inff.org/about>
 241 Дэлхийн банк. Монгол Улс дахь Олон улсын Санхүүгийн корпорацийн Хөрөнгө оруулалтын орчны шинэчлэлийн зураглал.
 242 ОУВС (2019 оны 9 дүгээр сар). Дүрмийн IV заалтын Зөвлөлдөх уулзалт- Хэвлэлийн мэдээ. Ажилтны тайлан. Гүйцэтгэх захирлын мэдэгдэл.

банкны тооцоогоор аялал жуулчлал, зочид буудал, цахим худалдаа, агро-бизнес зэрэг салбарууд нь ГШХО-ыг татах өндөр чадамжтай бөгөөд тогтвортой хөгжилд тодорхой хувь нэмэр оруулна. ГШХО-ын бүхий л боломжийг ТХЗ-ын санхүүжилтад ашиглахын тулд ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй хүчин чармайлтад хувь нэмрээ оруулах замаар нөлөөллийн ерөнхий цар хүрээ, эрчмийг нэмэгдүүлж ГШХО-ыг Монгол Улсын ТХЗ-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулахад цаашид нөлөөлөх нь чухал юм. Түүнчлэн, ТХЗ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийснээр тухайн хөтөлбөрүүд Засгийн газраас хөнгөлөлт, татаас, бодлогын болоод эрх зүйн зохицуулалт хэлбэрээр шууд болон шууд бус дэмжлэг авах боломж үүсэх бөгөөд болзошгүй эрсдэлийг тооцсон санхүүгийн өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой. Энэ нь эргээд хувийн хэвшлийнхэн ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн илүү тогтвортой, урт хугацааны хөрөнгө оруулах нөхцөлийг бүрдүүлнэ.^[243]

Зураг 3.9.3-т хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ) нь 1990-ээд оноос 2004 он хүртэл олон улсын зээл тусламжийн хөрөнгийн гурван урсгалын хамгийн том хувийг бүрдүүлж байсны зэрэгцээ тогтвортой байсныг илэрхийлж байна. Буцалтгүй тусламж, зээл, хөгжлийн албан ёсны тусламж нийлээд 2011 оноос хойш жилд дунджаар 500 сая ам.доллар болж байсан нь улсын төсвийн зарлагын 15 орчим хувьтай тэнцэж байжээ.^[244] Гадаадад амьдарч байгаа 190000 орчим хүн^[245]-ээс илгээж буй мөнгөн гуйвуулга 2000-аад оны эхэн үеэс тасралтгүй өсч байгаа бөгөөд шилжилтийн зарим жилүүдэд ГШХО-той тэнцэх хэмжээний мөнгө илгээж байсан. Гадаадаас илгээж буй мөнгөн гуйвуулга 2019 онд 574.4 сая ам.долларт хүрсэн нь 2019 оны ДНБ-ий 4.1 хувьтай тэнцэж

байна.^[246] Гэхдээ мөнгөн гуйвуулгын нэлээд хэсэг нь албан бус сувгуудаар дамждаг учир мөнгөн гуйвуулгын талаар үнэн бодитой тоо мэдээлэл хомс байна. Зарим албан бус тооцоогоор мөнгөн гуйвуулгын нийт урсгал ДНБ-ий 10 хувьтай тэнцэх^[247] хэмжээний өндөр байж болзошгүй байна. Иймээс мөнгөн гуйвуулга нь өрхийн болон макро эдийн засгийн түвшинд хувь нэмэр оруулах хөгжлийн санхүүжилтийн шинэлэг эх үүсвэр болох боломжтой.

2020-2021 онуудад хатуу хөл хорио тогтоосон, зорчих хөдөлгөөн хязгаарлагдсан, халамжийн дэмжлэгүүд, мөнгөн тусламжууд, татварын чөлөөлөлт, нийтийн ахуйн үйлчилгээний төлбөрөөс чөлөөлсөн зэрэг олон арга хэмжээний үр дүнд айл өрхүүдэд нийтдээ их хэмжээний бэлэн мөнгө хуримтлагдсан. Үүний үр дүнд 2021 оны тавдугаар сарын эцсийн байдлаар тус улсын нийт хадгаламжийн хэмжээ 19 их наяд төгрөгт (мөнгөний нийлүүлэлтийн (M2) 71 хувь, ДНБ-ий 51 хувь) хүрч, үүний 90.3 хувь нь иргэдийн хадгаламж байна.^[248] Хадгаламж нэмэгдсэнээр хөрөнгийн биржийн гүйлгээ мэдэгдэхүйц идэвхжиж, 2021 онд Монголын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ дээд амжилтад хүрсэн. Гэхдээ КОВИД-19 цар тахлын үед хуримтлагдсан энэхүү бэлэн мөнгө айл өрхүүдэд хэрхэн хуваарилагдаж байгаань тодорхойгүй байна. Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын 2016 оны тайланд таван иргэний (бүгд УИХ-ын гишүүд) жилийн дундаж орлого 2016 оны өрхийн дундаж орлогоос 160 дахин их байна. Тэдний мэдээлсэнээр өнгөрсөн санхүүгийн жилд тэдгээр таван иргэний хадгаламж дунджаар 970.7 сая төгрөгөөр (451,963.46 ам.доллар) өссөн нь дундаж болон чинээлэг өрхийн хадгаламжийн өсөлтөөс 900 болон 200 дахин их байна.^[249]

2020 онд банкуудын нийт зээлийн үлдэгдэл буурсны зэрэгцээ иргэдийн цэвэр зээл 7.9

243 НҮБ-ын Даян дэлхийн гэрээ. ТХЗ-ын санхүүжилт. Үзэх <https://globalcompact.no/wp-content/uploads/2020/01/Scaling-SDG-Finance.pdf>

244 Монгол Улсын Засгийн газар. Сангийн яам. АХБ. (2018). *Монгол Улсын Хөгжлийн хамтын ажиллагааны үнэлгээ*.

245 Монгол Улс дахь Олон улсын Шилжилт хөдөлгөөний байгууллага

246 Дэлхийн банк. Үзэх <https://data.worldbank.org/indicator/BX.TRF.PWKR.DT.GD.ZS>

247 АХБ. (2020).

248 Монгол банк. (2020 оны 12-р дугаар сар). *Мөнгө, санхүүгийн статистик*.

249 АХБ. (2020 оны 6-р дугаар сар). *Монгол Улсын Эдийн засгийн хэтийн төлөв*.

хувиар, ЖДҮ-д олгосон цэвэр зээл 11.6 хувиар тус тус агшсан.^[250] Энэ нь эдийн засгийн тодорхой бус байдал, зээлийн эрсдэл нэмэгдсэн зэргээс банкууд болгоомжлох үйл хөдлөл рүү шилжсэнтэй холбоотой.^[251] Эдийн засаг хэвийн байдалдаа эргэн ороход айл өрхүүд ямар үйл хөдлөл үзүүлэх нь тогтвортой хөгжлийн төлөөх сэргэлт, санхүүгийн төлөв байдлыг тодорхойлох томоохон асуултуудын нэг болж байна. Монголчууд ажилгүйдэл улам бүр нэмэгдэж байгаад сэтгэл түгшин^[252] болгоомжлох үүднээс хуримтлалаа нэмэгдүүлэхийг илүүд үзэж байж болзошгүй бөгөөд ийм тохиолдолд тэдний хуримтлал ТХЗ-ын санхүүжилтийн боломжит эх үүсвэр болох нь хумигдах магадлалтай.

Үндсэндээ, арилжааны банкууд санхүүгийн салбарын нийт активын 95 хувь, эдийн засгийн нийт хөрөнгийн 90 гаруй хувийг барьж байгаа хэдий ч санхүүгийн эх үүсвэр нь ихэвчлэн өндөр ашигтай салбаруудад (уул уурхай, тээвэр, худалдаа, барилга, үл хөдлөх хөрөнгө гэх мэт) төвлөрч байгаа нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх бүрэн боломжоо харахан ашиглахгүй, эмзэг бүлгийн хүн амд дорвитой анхаарал хандуулахгүй байгааг илэрхийлж байна. Энэ нь НҮБ-д Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зургаан зарчмыг сурталчлан таниулах таатай боломжийг олгож байна.^[253] Түүнчлэн, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах зэрэг хөтөлбөрүүдийг өдөөх зорилтот хөрөнгө оруулалт руу чиглэсэн санхүүгийн урсгалыг нэмэгдүүлэхийн тулд бодлогын дэмжлэг (санхүүгийн зохицуулалт, арга хэмжээ) зайлшгүй шаардлагатай. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн замын зураглал (2018)-ыг боловсруулсан.^[254] Энэхүү замын зураглалыг баталсны дараахан, 2019 онд Монгол Улсын

Ногоон таксономийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл баталсан. Гэхдээ НҮБ-ын зүгээс онцгойлон дэмжсэн Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн замын зураглалыг бодитой үйл хэрэг болгохын тулд тусгайлсан салбарын тодорхойлолт, шалгуур, үзүүлэлтүүд, баталгаажуулах чадавх, бодлогын дэмжлэгүүд нэн шаардлагатай байна. Үүнээс гадна, багдунд орлоготой зарим орнууд дотоод хөрөнгө оруулалтынхаа бараг долоон хувийг тусгай сангууд, төрийн бус байгууллагуудын хувийн буцалтгүй тусламжаар бүрдүүлж илүү амжилттай ажиллаж байна. Тусгай сангууд болон олон улсын төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх нь Монгол Улсын хувьд ирэх жилүүдэд хөгжлийн санхүүжилтийн урсгалыг нэмэгдүүлэх нэмэлт боломжийг нээх бөгөөд үүнтэй уялдуулсан зорилтоо тодорхойлох шаардлагатай.^[255]

Эцэст нь, Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагаа (ӨӨХА) нь сүүлийн жилүүдэд Өмнөд-Өмнөдийн худалдаа, Өмнөд-Өмнөдийн гадаадын шууд хөрөнгө оруулалт, бүс нутгийн харилцан хамтын ажиллагааг дэмжсэн хөдөлгөөн, технологийн салбар хоорондын хамтын ажиллагаа, шийдэл болон мэргэжилтнүүдээ хуваалцах, солилцох бусад аргууд зэрэг олон хэлбэрээр улам бүр хөгжиж байна. Монгол Улсын хөрш БНХАУ нь ӨӨХА-г дэлхий дахинаа болон төр, хувийн хэвшлийнхний дунд маш өргөн хүрээтэйгээр сурталчлан таниулж байгаа бөгөөд Монгол Улсын хувьд дээрх бүхий л асуудлаа Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааны хүрээнд урагш ахиулах сайхан боломж бий. Энэхүү хүчин чармайлтыг дэмжиж, Монгол Улс дахь НҮБ нь ӨӨХА-ны төлөө гурвалсан хамтын ажиллагааг дэмжих байр суурьтай байна.

250 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. (2021 оны 1 дүгээр сар). *Сарын танилцуулга*.

251 Д. Ган-Очир, Монгол банкны Ахлах эдийн засагч. *Яагаад цар тахлын үед хадгаламж, дансны үлдэгдэл яагаад нэмэгдэв*. Үзэх <https://gogo.mn/r/3k7n3>

252 Хүмүүст үзүүлэх нөлөө. Үзэх www.covidmongolia.mn

253 *Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчим*. Үзэх <https://www.unpri.org/pri/what-are-the-principles-for-responsible-investment>

254 *Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн үндэсний замын зураг*. Үзэх http://unepinquiry.org/wp-content/uploads/2018/11/NationalSustainable_Finance_Roadmap_of_Mongolia.pdf

255 Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, АХБ. (2018). *Монгол Улс: Хөгжлийн хамтын ажиллагаанд хийсэн үнэлгээ*.

3.10 ОРОЛЦОГЧ ТАЛУУД/ ТҮНШЛЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

ТХЗ-г хэрэгжүүлнэ гэдэг нь чухамдаа хөгжлийн хамтын ажиллагааны цар хүрээ, хэлбэр, үр нөлөөний тухай асуудал юм. Харамсалтай нь дэлхий нийтээр тархсан КОВИД-19 цар тахлын дэгдэлт Монгол Улсын хөгжлийн ололт амжилтыг тодорхой хэмжээгээр царцааж 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйлсэд эрсдэл учруулж болзошгүй байна. Иймээс ТХЗ-ыг хэрэгжүүлэхийн төлөөх үр дүнтэй хамтын ажиллагаа урьд өмнөхөөсөө илүү чухал болж байна. Хамтдаа хүчээ нэгтгэн үр дүнтэй ажилласнаар хөгжлийн оролцогч бүх талууд өөрсдийн онцлог бөгөөд хүлээх үүрэг хариуцлагад тулгуурлан хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтэд хувь нэмрээ оруулан тал бүрээсээ хөрөнгө нөөцийн нөлөөллийг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийн үр дүнг бүтээхэд чиглэсэн хөрөнгө нөөцийн шинэ боломжийг нээнэ. Хөгжлийн үр дүнтэй хамтын ажиллагааны зарчмууд^[256]-ын гол баримтлах зорилго нь үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөх, үр дүнд чиглэсэн удирдлагаар хангах, олон талын оролцоог хангасан түншлэл, хариуцлагатай, ил тод байхад оршино. Монгол Улс дахь НҮБ нь төвийг сахисан зуучлагчийн хувиар зээл тусламжийн хөгжлийн хөтөлбөрүүдийн үр нөлөөг дээшлүүлэх ажлыг манлайлж, оролцогч бүх талууд хамтран нэгдэж ажиллах гүүр болон холбож, илүү үр дүнтэй хамтран ажиллахад нь түлхэц өгөх байр суурийг баримталж байна. Үүнтэй холбогдуулан НҮБ-ын зүгээс оруулах хувь нэмрийн үнэ цэн нь гол оролцогч талуудтай гүн гүнзгий ойлголцолд хүрч хоёр талын хамтын ажиллагааг бэхжүүлэх, засгийн газар, хувийн хэвшил (олон улсын болон дотоодын), олон улсын санхүүгийн байгууллагууд, иргэний

нийгмийн болон бусад байгууллагуудын нягт хамтын ажиллагааг хөгжүүлэх, улмаар Монгол Улсад хэрэгжүүлэх боломжгүй байгаа ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон талт түншлэл, платформууд, үр дүнтэй зохицуулалтын механизмыг бий болгоход зуучлалын үүрэг гүйцэтгэснээр илэрнэ. Монгол Улс дахь хөгжлийн оролцогч талууд ТХЗ-ын хэрэгжилтэд дараах байдлаар хувь нэмэр оруулж байна. Тухайлбал,

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого болох “Алсын хараа 2050” болон холбогдох Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн үзэл санаа тусгалаа олсон. Гэхдээ Монгол Улсын Засгийн газраас ТХЗ-ыг хэрэгжүүлэх, улмаар хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар илүү санаачлага гаргах, холбогдох бодлого, хууль тогтоомжийг шинэчлэн сайжруулах, улс орныхоо хэмжээнд Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулж байгаа өнөөгийн арга барилаа сайжруулахад илүү хүчин чармайлт гаргах боломжтой. Одоогийн байдлаар төрийн байгууллагуудын чиг үүрэгт давхардал ажиглагдаж байгаа нь Монгол Улсын Засгийн газрын харьяа байгууллага, агентлагуудын үйл ажиллагааны давхардал, хуваагдлаар илэрч байна (тухайлбал, Засгийн газрын хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ), Сангийн яам, ҮХГ).

Салбарын яамд, агентлагууд өөрийн ногдох чиг үүрэгтэй учраас тогтвортой хөгжлийн үндсэн гурван тулгуур асуудалд өөр хоорондоо уялдаагүйгээр дан дангаар авч үзэх хандлагатай байна. Бусад салбарын чиг үүргийн уялдаа холбоо, тэр дундаа төрийн байгууллагууд хоорондын ажил үүргийн уялдаа холбоог сайжруулах гэхээс

256 Хөгжлийн үр дүнтэй хамтын ажиллагааны зарчмуудыг Зээл, тусламжийн үр нөлөөний асуудлаарх Бусан хотноо болсон Дэд түвшний чуулга уулзалтаар (2011) баталсан. Эдгээр зарчмууд нь Зээл, тусламжийн үр дүнтэй зарчмууд дээр суурилдаг. Парис, Аккра хотноо зохион байгуулагдсан Зээл тусламжийн үр нөлөөний зарчмуудыг баталсан чуулга уулзалтад оролцсон хөгжлийн түншүүд, засгийн газрууд холбогдох амлалтаа бүрэн хэрэгжүүлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэн эрчимжүүлэх болно (ЭЗХАХБ 2011).



Гэрэл зургийг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар / Д. Давааням

илүүтэйгээр тэд зөвхөн өөрсдийн ажил үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд гол анхаарлаа хандуулах хандлагатай байна. Иймд ТХЗ-ын цар хүрээний талаар нэгдсэн ойлголтод хүрч, эдгээр нь зөвхөн үндэсний хэмжээний үүрэг хариуцлага биш салбарууд ч тодорхой үүрэг хүлээх ёстойг талууд хүлээн зөвшөөрөх нь чухал. ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд орон нутгийн оролцоо тун чухал бөгөөд тэдний үйл ажиллагаанаас ТХЗ-ын хэрэгжилт шууд хамаарна гэдгийг ойлгох хэрэгтэй.^[257]

УЛСЫН ИХ ХУРАЛ

Монгол Улсын Их Хурал нь ТХЗ-ыг улс орны хэмжээнд хэрэгжүүлэхэд хяналт тавих чухал үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэргэдэх Мянганы хөгжлийн зорилтууд, Ядуурлын асуудал хариуцсан дэд хороог 2016 онд Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт тавих дэд хороо болгон шинэчлэн байгуулсан. Өнөөгийн УИХ-аас ТХЗ-ын дэд хороог Эдийн засгийн бодлогын байнгын хороонд шилжүүлж, шинэчлэн байгуулсан. Энэхүү дэд хороо нь тогтвортой хөгжлийн

зорилгуудыг хууль тогтоомж болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлэх асуудлыг илүү үр дүнтэй болгох зорилготой ажиллаж байна. УИХ нь Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагаа, ТХЗ-ын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, тайлагнал, төрийн байгууллагуудын үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаарх тайланг тогтмол сонсож хяналт тавин ажиллаж байна. ХЭҮК зэрэг байгууллагууд нь Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнах үүрэг бүхий чухал оролцогч талууд юм.

ХӨГЖЛИЙН ТҮНШҮҮД (ХОЁР ТАЛЫН, ОЛОН ТАЛТ, ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД (ОУСБ))

Сүүлийн 10 жилийн хугацаанд ЭЗХАХБ-ын уламжлалт хандивлагч талууд хөгжлийн тусламжийн хөтөлбөрүүдээ хааж эхэлснээр “уламжлалт бус” хандивлагчдын гүйцэтгэх үүрэг, тэр дундаа БНХАУ-ын нөлөө улам бүр нэмэгдсээр байна. Гэсэн хэдий ч

257 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газар. (2019). *Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл*. Үзэх <https://sustainabledevelopment.un.org/memberstates/mongolia>

Европын Холбооны Төлөөлөгчийн газар Монгол Улсад үзүүлэх дэмжлэгээ ихээхэн өргөжүүлж байна.^[258] Өмнөдөөс (Хятад, Энэтхэг) болон бусад (Солонгос болон бусад) орнуудаас шинээр орж ирж буй хандивлагчдын гүйцэтгэх үүрэг өргөжин тэлж байгаагаас харахад Монгол Улс нь хөрөнгө оруулагчдыг ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглүүлж Өмнөд-Өмнөдийн болон Гурван талт хамтын ажиллагааг улам ахиулах байр суурь баримталж байна. Монгол Улс дахь НҮБ нь гурван талт хамтын ажиллагааны талаарх тулхтай стратеги боловсруулж, энэхүү ирээдүйтэй боломжийг урагш ахиулахад нь Монгол Улсад шаардлагатай чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх байр суурьтай байна.

Монгол Улсын ТХЗ-ын санхүүжилтэд Азийн хөгжлийн банк^[259], Дэлхийн банк^[260], Европын сэргээн босголт, хөгжлийн банк^[261], сүүлийн үед Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк^[262] зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг ихээхэн чухал хэвээр байна. Монгол Улсад төлөөлөгчийн газар нь байдаггүй ч дэлхийн тусгай сангуудтай (жишээлбэл, Уур амьсгалын ногоон сан^[263], Даян дэлхийн байгаль орчны сан) хамран ажиллах боломж ч байна. Ийм хөрөнгө оруулалтыг олон улсын санхүүгийн байгууллагууд байнга дэмжиж ирсэн учир стратегийн түншлэлийн үнэ цэнийг улам бүр нэмэгдүүлж байгаа юм. Эдгээр түншүүд болон бусад гол оролцогч талууд, Засгийн газар хоорондын хөгжлийн үр дүнтэй хамтын ажиллагааны дөрвөн зарчимд нийцүүлэн хүчин чармайлтаа зохицуулах хөгжлийн түншүүдийн зохицуулалтын бүтэц бий болсон. Гэхдээ Засгийн газар дотооддоо уялдуулан нийцүүлэх,

зохицуулах асуудлын орон зай ч нэлээд бий.^[264] Улс орон дотроо хөгжлийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах зорилгоор Хөгжлийн түншлэлийн бүлгийг шинэчлэх, Монгол Улсын Зээл тусламж, хөгжлийн хамтын ажиллагааны бүтцийг эргэн харах үйл явцыг эхлүүлээд байна. Засгийн газрын тууштай оролцоо, тогтвортой байр суурь болон хөгжлийн түншүүдтэйгээ харилцан уялдаатай хамтран ажиллах Засгийн газрын стратегийн хамтын ажиллагаа зэрэг нь хөгжлийн хамтын ажиллагаа үр дүнтэй байх гол оньс нь юм. Иймд, хөгжлийн түншүүд Монгол Улсын Засгийн газартай дангаар болон хамтаараа нягт хамтран ажиллах үйл явц, бүтцийг үргэлжлүүлэн сайжруулах нь нэн чухал байна.

ИРГЭНИЙ НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН ҮЙЛС

ТХЗ-ын талаарх олон нийтийн нөлөөлөл сурталчилгаа, хөндлөнгийн нүнэлгээ (ҮСДИГэх мэт) зэрэг хөтөлбөрүүдэд олон улсын болон дотоодын иргэний нийгэм, хүмүүнлэгийн байгууллагууд, хил дамнасан, бүс нутгийн оролцогч талуудын оролцоо нэн чухал юм. Ийм хөтөлбөрүүдэд талууд оролцож байгаа хэдий ч хамтын ажиллагааг улам бүр гүнзгийрүүлэх шаардлагатай. Тухайлбал, Монгол Улсын анхны Сайн дурын илтгэлийн санааг гаргах, төлөвлөх, боловсруулах, танилцуулах зэрэг бүхий л үе шатуудад эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, ЛГБТИ бүлэг гэх мэт эмзэг бүлгийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулж байсан сайн туршлага байна. Түүнчлэн тус улсад салбарын түвшинд иргэний нийгмийн зохицуулалтын хэд хэдэн платформ байгаа бөгөөд тэдгээрийг улам дэмжиж, бэхжүүлэх боломжтой. Мэргэжлийн холбоод, ажилтан,

258 Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газар. Үзэх https://eeas.europa.eu/delegations/mongolia/1547/about-eu-delegation-mongolia_en

259 Монгол Улс дахь АХБ. Үзэх <https://www.adb.org/countries/mongolia/main>

260 Дэлхийн банк. Үзэх <https://www.worldbank.org/en/country/mongolia>

261 Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Санхүүгийн Байгууллага. Үзэх <https://www.ebrd.com/mongolia.html>

262 Азийн Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк (2020). *Азийн Дэд бүтэц, хөрөнгө оруулалтын банк COVID-19-ийн хариу арга хэмжээг дэмжих зорилгоор Монгол Улсад олгох анхны зээлийг баталлаа*. Үзэх <https://www.aiib.org/en/news-events/news/2020/AIIB-Ap-proves-First-Loan-to-Mongolia-in-Support-of-COVID-19-Response.html>

263 Уур амьсгалын ногоон сан. Үзэх <https://www.greenclimate.fund/countries/mongolia#:~:text=16%20May%202019%20%2F%20The%20Green%20Climate%20Fund,supports%20Mongolia%27s%20ambition%20to%20pursue%20a%20low-emission%20future>

264 Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, АХБ (2018). *Монгол Улсын Хөгжлийн хамтын ажиллагаанд хийсэн үнэлгээ*.

ажил олгогчдын холбоо, үйлдвэрчний эвлэл зэрэг төрийн бус байгууллагуудаар дамжуулан төрийн үйлчилгээг хүн амд хүргэхэд Иргэний нийгмийн байгууллагууд төр засагтай хамтран ажиллаж байсан тохиолдол байдаг ч нийтлэг бус бөгөөд энэхүү харилцааг зохицуулах тогтолцоо сул байна. Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо (МҮЭХ) нь Монгол Улсын 21 аймаг, нийслэл хотын нийт 230 мянган ажилтныг төлөөлж 14 мэргэжлийн холбоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. МҮЭХ нь үндэсний гурван талт яриа хэлцэл, хэлэлцээрт идэвхтэй оролцох замаар ажилчидын эрх ашгийг хамгаалахын төлөө ажилладаг бөгөөд хөдөлмөр, үйлдвэрлэлийн харилцаа, нийгмийн хамгааллын асуудлыг хэлэлцэхэд манлайлах үүрэг гүйцэтгэж байна. Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд яамд, агентлагуудын чиг үүргийн шинжилгээг ч хийж эхэлсэн. Ингэснээр ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлснээр төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодод төрийн ямар чиг үүргийг шилжүүлэх боломжтой болох нь тодорхой болно гэдэгт найдаж байна. ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд сайн дурынхан чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал, 2018 оны байдлаар 27,312 сайн дурын ажилтнууд 3,823,117 цагаар ажиллаж, улсын эдийн засагт 5.5 тэрбум төгрөгийн хувь нэмэр оруулсан тооцоо байна.^[265] Сайн дурынхны хамтын ажиллагаа ТХЗ-ын хэрэгжилтэд шууд хувь нэмэр оруулж байна. Хэрэглээ, үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, нөөц баялгийн шударга ёсны зарчмыг дэмжихийн тулд олон нийтийн хэвшсэн дадал зуршлыг өөрчлөх, эрх тэгш хөгжлийн үр шимийг хүртэгч иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжих, эрхэд суурилсан зарчимд тулгуурлан төрийн бус байгууллагуудын оролцоо, чадавхыг бэхжүүлэх зэрэгт чиглэсэн төрийн байгууллагуудын хариуцлагыг өргөжүүлэх хэрэгтэй. Түүгээр ч зогсохгүй хүний эрх, ялангуяа хөгжлөөс орхигдох эрсдэлтэй хүмүүсийн хүний эрхийг хангах, хамгаалах,

эрх зүйт ёс, хүн бүр хуулийн өмнө адил тэгш байх нөхцөлийг хангахын тулд үндэсний хэмжээнд нийгмийн гэрээ байгуулах, эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, орон нутгийн хөгжлийн гурван талт хэлцэл зэрэг нийгмийн хариуцлагын механизмыг сайжруулах боломжтой. Эцэст нь, хөгжлийн түншүүд болон хүмүүнлэгийн томоохон сангуудаас Монгол Улсад оруулж буй хөгжлийн албан ёсны тусламжийн урсгалыг нэмэгдүүлэхийн тулд олон улсын төрийн бус байгууллагуудыг илүү стратегитайгаар дайчлах боломжтой.^[266]

ХУВИЙН ХЭВШИЛ

Монгол Улсад ТХЗ-ыг санхүүжүүлэх, хэрэгжүүлэхэд гадаад, дотоодын хувийн хэвшлийнхний боломжийг харахан бүрэн ашиглаж чадахгүй байна. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (МАОЭНХ) нь аж үйлдвэр, барилга, зам тээвэр, банк санхүү, даатгал зэрэг эдийн засгийн бүх салбарын 8500 орчим аж ахуйн нэгжийг төлөөлсөн 21 аймгийн ажил олгогч эздийн холбоод, 45 мэргэжлийн холбоод, 12 салбар холбоодын төлөөллөөс бүрдэж байна. МАОЭНХ нь Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороог Засгийн газар, Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран байгуулсан гол оролцогч нь юм. Монгол Улсад олон тооны үндэсний танхимууд (Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын Европын худалдаа аж үйлдвэрийн танхим, Австрали-Монголын худалдааны танхим, Канад Монголын худалдааны танхим, Америк-Монголын худалдааны танхим) байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр танхимууд нь компанийн нийгмийн хариуцлагыг дэмжих, бодлогын бүтээлч яриа хэлэлцүүлэгт оролцох, ТХЗ-д нийцсэн санаачилгуудыг (тухайлбал, инновацийн сорилтууд, нийгмийн хариуцлагын шагнал зэрэг) хэрэгжүүлэх зэргээр ажиллаж байгаа боловч ихэнхдээ ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой стратеги байхгүй байна.

265 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газар. (2019). *Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл*. Үзэх <https://sustainabledevelopment.un.org/memberstates/mongolia>

266 *Мөн тэнд*.

Үйлчилгээний болон хөнгөн үйлдвэрийн салбарын жижиг дунд үйлдвэр, аж ахуйн нэгж, газрууд нь айл өрхүүдэд шаардлагатай эрүүл мэнд, боловсролын зэрэг үйлчилгээг хүртэх боломж олгох орлогын эх үүсвэртэй, ажилтай болох найдварыг төрүүлж байна. Хувийн хэвшлийнхэн, тэр дундаа олон улсын (ялангуяа хил дамнасан болон бүс нутгийн оролцогчид) болон дотоодын технологийн компаниуд, хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны компаниуд нь Монгол Улсыг “Дижитал үндэстэн” болгон хөгжүүлэх Засгийн газрын хүчин чармайлтыг дэмжих гол оролцогч талууд болж байна. Түүнчлэн, гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) нь сэргээгдэх эрчим хүч зэрэг салбаруудад ихээхэн ач холбогдолтой бөгөөд ТХЗ-ын хэрэгжилтэд чухал хувь нэмэр оруулах боломжтой. Гэхдээ ГШХО-ыг ТХЗ-ыг хэрэгжүүлэхтэй үр дүнтэй уялдуулахад зарим хязгаарлалтууд тулгарч байна. Тухайлбал, бодлого, зохицуулалтын тогтолцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих хөшүүрэг нээлттэй бус байгаа нь хувийн хэвшлийнхний болон хөрөнгө оруулагчдын боломжит хөрөнгө оруулалтын хэтийн төлөвт өндөр эрсдэл учруулж байна. Эдгээр хязгаарлалтыг багасгахын тулд НҮБ-ын зүгээс зөвлөмж, дэмжлэг, зуучлалын үйлчилгээ үзүүлж чадна.

Хувийн хэвшлийн гол салбар нь эрсдэл өндөртэй салбаруудад (уул уурхай гэх мэт) үйл ажиллагаа явуулж байгаа нь ТХЗ-ын хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байгаа төдийгүй тус улсын хэмжээнд ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд тэдний гүйцэтгэх үүрэг, нөлөөллийг хэрхэн оновчтой болгох талаар тодорхой стратеги байхгүй байна. Цаашлаад, уул уурхай, дэд бүтэц зэрэг өндөр эрсдэлтэй эдгээр салбаруудад нийгмийн болоод хүний эрхийн нөлөөллийн үнэлгээг зохих ёсоор хийж хэвшээгүй байна. Хувийн банкууд өндөр хэмжээний хөрөнгө оруулалт, зээлийн үнэлгээний шийдвэрийг гаргахдаа байгаль орчин, нийгэм, засаглалын нөлөөллийн үнэлгээ хийж байгаа зарим санаачилгууд ч гарч байна.

Цаашид НҮБ-ын Даян дэлхийн гэрээ^[267]-ний арван зарчмыг хэрэгжүүлэхийг дэмжиж байгуулсан Монгол Улсын НҮБ-ын Даян дэлхийн гэрээний сүлжээг дэмжих, нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалтын зармууд (PSRI)^[268]-ыг дагаж мөрдөх чадавхыг бэхжүүлэх, түүнчлэн холимог санхүүжилт, нийгмийн салбаруудыг дэмжих, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчимд суурилсан төр, хувийн хэвшлийн түншлэлийг гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Хувийн компаниуд үйл ажиллагааныхаа хүрээнд Хүүхдийн эрх болон бизнесийн зарчмууд, Компанийн нийгмийн хариуцлагын стандарт ISO 26000 зэрэг дэлхийн санаачлагуудыг хэрэгжүүлж эхэлсэн нь тэмдэглүүштэй. ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн Төр-хувийн хэвшлийн түншлэлийн платформыг байгуулснаар гадаад, дотоодын хувийн хэвшлийн томоохон компаниуд хөгжлийн гол гол түншүүдтэй уулзаж тогтвортой төслүүдэд чиглэсэн “хөрөнгө оруулалтыг цаашид хэрхэн нэмэгдүүлэх” стратегия боловсруулахад нь НҮБ-ын зүгээс зуучлах, холбох үүргийг гүйцэтгэх боломжтой. Цаашлаад НҮБ-ын Бизнес, хүний эрхийн удирдах зарчмуудыг дагаж мөрдөх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас Бизнес, хүний эрхийн үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг боловсруулж байна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГУУД, БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТӨВҮҮД

Тогтвортой хөгжилд хүрэх бодлогын шийдвэр нь шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд суурилсан судалгааны дүн шинжилгээнд тулгуурласан байх ёстой. Гадаад, дотоодын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд нь ТХЗ-ын талаарх судалгаа шинжилгээ, сургалт, нөлөөлөл сурталчилгааны чиглэлээр үнэлж баршгүй мэдлэгийн эх сурвалжийг бий болгож байна.

Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА)-аас хэрэгжүүлсэн “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн дэмжлэгтэйгээр Монгол

267 НҮБ-ын Даян дэлхийн гэрээ. Үзэх <https://globalcompact.no/wp-content/uploads/2020/01/Scaling-SDG-Finance.pdf>

268 Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчим. Үзэх <https://www.unpri.org/pri/what-are-the-principles-for-responsible-investment>

Улсын Засгийн газар нь ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын хөтөлбөрт^[269] тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг тусгаж, багш нарт зориулан тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын талаарх сургалтуудыг зохион байгуулсан. Энэ нь Монгол Улсын хүүхэд залуучуудын тогтвортой хөгжлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чухал алхам болсон юм.

"Бодлогын судалгааны төвүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд" гэдэг нь олон төрлийн байгууллагуудыг хамарч байгаа бөгөөд эдгээр байгууллагууд нь бодлого шийдвэрийн үндэслэл, үр нөлөөтэй холбоотой мэдлэг мэдээллийг бий болгох, түгээх, олон нийтийн яриа хэлэлцүүлгийг өрнүүлэх, бодлого шийдвэр боловсруулах, гаргах үйл явцыг илүү үндэслэлтэй болгоход хувь нэмрээ оруулж байгааг хүлээн зөвшөөрөх болсон.

Бодлогын судалгааны төвүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд нь уулзалт хэлэлцүүлэг өрнүүлэх үр дүнтэй платформ болж байна. Гэвч бодлогын шийдвэр гаргахад судалгааны төвүүд, шинжлэх ухааны байгууллагуудын нөлөө бүрхэг төдийгүй судалгааны байгууллагуудын санал бодлыг шийдвэр гаргагчид төдийлөн авахгүй байна. Судалгааны болон эрдэм шинжилгээний байгууллагуудын чадавх сул, Засгийн газрын зүгээс ч тэдгээрийн чадавхыг бэхжүүлэх санхүүгийн хангалттай хөрөнгө нөөцийг хуваарилж чадахгүй байна. Эрдэм шинжилгээний болон бодлогын судалгааны төвүүдийн чадавхыг сайжруулах замаар Монгол Улсад ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд тэдгээрийн хүчийг ашиглах маш их боломж байна.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУД

Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд ТХЗ-ын талаар тодорхой мэдлэгтэй, дэмжиж байгаа хэдий ч улс орны хэмжээнд эдгээр зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газар хэвлэл мэдээллийн байгууллагуудтай

хамтын ажиллагаагаа эрчимжүүлж, сурталчлах, идэвхжүүлэх шаардлагатай байна. Тогтвортой хөгжлийн боловсролд Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд илүү хүчтэй үүрэг гүйцэтгэж, мэргэжилтнүүд, иргэний нийгэм, олон нийтийн дунд хөгжлийн асуудлаар яриа хэлэлцүүлгийг өрнүүлэх боломж их байна.

Монголын сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хөгжлийн асуудлыг хөндөх, сурвалжлах талаарх чадавхыг бэхжүүлэх, ТХЗ-ын хэрэгжилтийн асуудалд анхаарал хандуулах, сэтгүүлчдийн клуб байгуулах зэрэг хэд хэдэн арга хэмжээ, санаачлагыг зохион байгуулаад байна. Unread Media-ийн контент бүтээгчид зэрэг бусад хэвлэл мэдээллийн хэрэгслүүд 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн талаар мэдээлэх, сурталчлах зорилгоор тусгайлсан вэбсайтаа (www.2030.mn) хэдийнээ нээгээд ажиллаж байна. Глоб Интернэшнл Төвийн зэрэг хэд хэдэн хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн ажилтнууд, өмгөөлөгчид хэвлэл мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний төлөө дуу хоолойгоо өргөн идэвхтэй ажиллаж байна.

Дэлхий даяар зохион байгуулагдсан НҮБ-75 кампанит ажлын хүрээнд Монгол Улс дахь НҮБ-ын зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтууд дээр сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудын зүгээс дэлхий дахинаа тулгамдаж байгаа асуудлууд, үндэсний тогтвортой хөгжлийн боломжууд, хүмүүнлэгийн болон хөгжлийн хөтөлбөрүүдийн талаар илүү ихээр сурталчлан таниулж НҮБ-ын үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцох сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. Тэдний зүгээс НҮБ-д хандаж олон нийттэй үр дүнтэй хамтран ажиллах замаар олон нийтийн оролцоог дэмжих, тэдгээрийн мэдлэг мэдээллийг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэхийг зөвлөж байсан. Энэхүү зөвлөмж нь мэдээлэл харилцааны үйл ажиллагаа цаашдаа олон нийтэд ойлгомжтой, хүлээн зөвшөөрөгдөхүйц байх шаардлагатай гэдгийг илэрхийлж байна.

269 ШХА. (2015 оны 9-р дүгээр сар). *Тогтвортой хөгжлийн боловсрол*. Үзэх https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/en/2015-Mongolia-ESDfactsheet_EN.pdf





Энэхүү дүн шинжилгээнд нарийвчлан судалсан тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдээс харахад Монгол Улс харьцангуй ахиц дэвшил гаргажээ. Гэхдээ тус улсын тогтвортой хөгжлийн төлөөх эдгээр ахиц дэвшилд саад бэрхшээл учруулж буй бүтцийн (системийн шинжтэй) суурь асуудлууд оршсоор байна. Хэдийнээ амжилтын гараанд ойртож байсан ахиц дэвшлийг КОВИД-19 цар тахлын дэгдэлт ухрааж дордуулаад зогсохгүй, 2015 оноос ажиглагдах болсон эдийн засаг, нийгэм, байгаль орчны салбарын ололт амжилтыг ч хэд хэдэн замаар сааруулжээ. Монгол Улсын Засгийн газраас КОВИД-19 цар тахлын эсрэг өргөн хүрээтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Хамарсан цар хүрээ, хэрэгжүүлсэн хурдны хувьд урьд өмнө хэзээ ч авч байгаагүй эдгээр арга хэмжээ байсан бөгөөд банкны системийн хөрвөх чадварыг хангах, зээлийн эргэн төлөлтийг түр зогсоохоос эхлээд аж ахуйн нэгжүүдэд татварын төрөл бүрийн хөнгөлөлт үзүүлэх, айл өрхүүдэд шууд бэлэн мөнгөний тусламж үзүүлэх зэргээр өргөн цар хүрээг хамарсан. Энэхүү тайлангийн Гуравдугаар бүлэгт Монгол Улсын тогтвортой хөгжлийн эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлууд, тэдгээрийн уялдаа, харилцан нөлөөлөлд дүн шинжилгээ хийсэн бөгөөд үр дүнг хүн зон (people), хүж дэлхий (planet), хөгжилцэцэглэлт (prosperity), хотлоор амгалан (peace), хамтын түншлэл (partnership) {5X} гэсэн таван үндсэн категориор нэгтгэн Хавсралт 5-д оруулсан болно. Энэхүү шинжилгээний үр дүнгээс харахад Монгол Улс ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд, нийт иргэдэд, ялангуяа хөгжлөөс орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдэд дараах салбар дундын хөгжлийн сорилтууд удаан

үргэлжлэн олон талын сөрөг нөлөө үзүүлэхж болзошгүй байна. Үүнд:

Засаглал сул дорой байх нь эдийн засгийн тогтвортой байдал, нийгмийн бодлогоос эхлээд байгаль орчныг хамгаалах зэрэг тогтвортой хөгжлийн бүхий л салбарыг хойш татах гол язгуур хүчин зүйл болсон хэвээр байна. Засаглалд тулгамдаж буй дараах олон асуудал байна. Тухайлбал, эдийн засгийн хурдтай өсөлтийг бий болгож буй макро эдийн засаг, төсвийн мөчлөгийг хүндрүүлсэн мөчлөг дагасан бодлого, үндэсний хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад хүргэж буй уялдаа холбоо, зохицуулалттайгаар бодлого боловсруулах чадавх дутмаг, эрх мэдлийн бүх түвшин дэх авлига их, төр захиргаа байгууллагуудын чадавхи сул, тэр дундаа улс төрийн эрх мэдлийн өөрчлөлтийг дагаж төрийн байгууллагууд ойр ойрхон солигдох, боловсон хүчний халаа сэлгээ, тогтвортой хөгжлийг үндэснийхээ хэмжээнд хүлээн зөвшөөрсөн өндөр түвшний манлайлал дутмаг байгаа зэрэг олон асуудал байна. Түүнчлэн иргэний нийгмийнхэн болон ялангуяа эмзэг бүлгийн хүн амыг үйл ажиллагаандаа системтэйгээр хамруулах институцийн зохицуулалт, механизм дутмаг байгаагаас хэрэгцээ шаардлага, эн тэргүүнд тавигдах асуудлыг шийдвэрлэхэд үндэсний бодлогуудаа чиглүүлж чадахгүй байна. Иймд засаглалыг сайжруулж, төр, засгийн газар, салбарын яамд, иргэний нийгмийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог тасралтгүй бэхжүүлэх нь хүний эрх, эрх чөлөөг хангах, улмаар ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд урт удаанаар нөлөөлсөөр байгаа хөгжлийн сорилтуудыг шийдвэрлэх чухал алхам болно.

Уур амьсгалын өөрчлөлт нь байгалийн гамшгийн (ган, зуд, үер, салхи шуурга, элсэн болон шороон шуурга, хэт халууны давалгаа, гэх мэт) давтамж, хүндрэл нэмэгдэх, угаасаа ховордож байгаа байгалийн нөөц улам бүр доройтох, усны эх үүсвэр хомсдох, газар, бэлчээр доройтох зэрэгт нөлөөлнө. Ган гачиг нь малын тэжээл, улаан буудай, арвайн овъёос, төмс, хүнсний ногоо зэрэг үндэсний газар тариалангийн үйлдвэрлэлд ноцтой нөлөө үзүүлэх бөгөөд зуд турхан нь мал сүргийн хорогдол нэмэгдэх, ялангуяа эмзэг бүлгийн хүн ам, малчид, хөдөө орон нутгийнхан зэрэг олон мянган хүний амьжиргаанд ноцтой нөлөө үзүүлнэ.^[270] Монгол Улсад гамшгийн аюулыг эрт сэрэмжлүүлэх системийг шинээр бий болгож ган, зудын нөхцөл байдалд тогтмол хяналт тавьж байгаа хэдий ч гамшгийн аюултай тэмцэх хариу арга хэмжээг авахдаа зөвхөн гамшгийн нөлөөллийн үнэлгээ, хэрэгцээг тодорхойлох шуурхай үнэлгээнд тулгуурласан хэвээр байна. Иймээс эрт сэрэмжлүүлэх системийг байгаа мэдээлэлтэйгээ холбон улам бэхжүүлэх замаар илүү үр дүнтэй хариу арга хэмжээ авч, нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж эрсдэлийг бууруулж, хүн амын амьжиргааны эрсдлийг сөрөх чадавхыг нэмэгдүүлэх нь чухал байна. Түүнчлэн нэн эмзэг бүлгийн хүмүүсийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн зөвлөмжийг мөрдлөгө болгон уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх амлалтаа хэрэгжүүлэх, улс орноо гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чадавхыг сайжруулах зэрэгт чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна. Малын тоо толгой, байгалийн нөхөн төлжих чадавх хоорондын тэнцвэрийг хангах механизмыг боловсруулж, нэвтрүүлэх замаар үндэсний хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгийн хүн амын амьжиргааг сайжруулахад чиглэсэн бодлогуудад байгаль орчны тогтвортой байдлыг хангах

асуудлыг заавал тусгах шаардлагатай байна. Үүнд газар, усны нөөцийг илүү тогтвортой ашиглах, шинэ технологи, мал аж ахуйн шилдэг туршлагыг нэвтрүүлэх замаар газар тариалангийн бүтээмжийг дээшлүүлэх, жижиг, дунд боловсруулах үйлдвэрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн ухаалаг технологи, тоног төхөөрөмж, газар тариалангийн дадал хэвшлийг нэвтрүүлэх зэрэг хамаарна. Түүнчлэн, ялангуяа ГШХО, төр, хувийн хэвшлийн түншлэл, инновацийн санхүүжилт зэргээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хөтөлбөрүүдэд нэмэлт санхүүжилт татахын тулд төр, хувийн хэвшлийн олон талт түншлэлийг хөгжүүлэх хэрэгтэй байна. Монгол Улс дахь Олон улсын санхүүгийн байгууллагууд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хөтөлбөрүүдэд нэмэлт санхүүжилтийг татахад чухал үүрэг гүйцэтгэж чадна. Үүний тулд бодлого, зохицуулалтын уялдаа холбоо, тодорхой байдал нэн чухал байна.

Зохистой ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх нь эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, залуучууд, эмэгтэйчүүд, хөдөө орон нутгийн хүн ам зэрэг хөгжлөөс орхигдох эрсдэлтэй хүн амын хэсэгт хүрэх хамгийн чухал арга зам юм. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын суурь боловсролын бат бэх тогтолцооны үр дүнд хөдөө аж ахуйн салбараас үйлчилгээний салбар луу чиглэсэн бүтцийн болон ур чадварыг ахиулан дээшлүүлэх эерэг өөрчлөлтүүд гарч байсан. Гэсэн хэдий ч КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр үйлчилгээний салбарт ажиллагсад олноороо ажилгүй болж, ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн оролцоо хумигдаж энэхүү ахиц дэвшлийг урвуугаар нь эргүүлж болзошгүй болсон. Бичиг үсэг, тоо бодлого зэрэг суурь мэдлэгийг анхан шатнаас нь дутуу эзэмшүүлснээр чанар муутай ажиллах хүч

270 Монгол Улс удаан үргэлжилсэн ган гачигт хамгийн их нэрвэгдэх төлөвтэй байгаа бөгөөд жилийн дундаж хохирол (AAL) ойролцоогоор 350 сая ам.доллар (Монгол Улсын нийт хохирлын 84.7 хувь). Эх сурвалж: НҮБАНДЭЗНК, 2020. Зүүн болон Зүүн хойд Азийн гамшгийн эрсдэлийн нөхцөл байдал: Оролцогч талуудад зориулсан гол зөвлөмжүүд, ST/ESCAP/2882.

олноор бий болох нэг хүчин зүйл бий болж байна. Төгсөгчдийн ур чадвар, ялангуяа их, дээд сургууль төгсөгчдийн ур чадвар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байгаа, техник, мэргэжлийн боловсролын тогтолцоо сул байгаа зэрэг нь хөдөлмөр эрхлэлт гацаанд орох, албан бус хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх, хөдөлмөрийн бүтээмж буурах, цалин хөлсний тэгш бус байдал үүсэх, өндөр үнэлэмжтэй ажлын байранд тохирохгүй болох зэрэг асуудал үүсэх үндсэн шалтгаан болж байна. Залуучууд олноороо жижиг бизнест буюу албан бус салбарт ажиллаж байгаа бөгөөд тэдэнд сургаж зөвлөх хүн, сүлжээ, хөрөнгө оруулагч олдохгүй байна. 21-р зууны хөдөлмөрийн зах зээл нь ажиллагчдаас мэргэжлийн ур чадвар шаардах төдийгүй өнөөгийн боловсролын тогтолцоонд дутагдаж байгаа суурь боловсролоос нь олгох ёстой “зөөлөн” ур чадваруудыг шаардаж байна. Мэдээллийн технологийн дэвшил нь үйлчилгээний салбар болон уламжлалт хөдөө аж ахуйн салбараас гадна үйлдвэрлэлийн томоохон өсөлтийг авчрах боломжтой. Үүнтэй холбогдуулан дижитал бичиг үсгийн мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах нь чухал юм. Бизнес эрхлэх шалгуур үзүүлэлтүүд^[271] сайжирсан хэдий ч хувийн хөрөнгө оруулагчид Монгол Улсыг өндөр эрсдэлтэй орчин гэж ойлгосоор байгаа нь хууль тогтоомж нь байнга өөрчлөгддөг, эрх зүйн зохицуулалтын мэдээлэл, тусгай зөвшөөрөл, санхүүжилтийн хүртээмж жигд бус зэрэгтэй холбоотой бөгөөд үүнээс шалтгаалж ГШХО мэдэгдэхүйц буурч байгаа нь илт ажиглагдаж байна.

Хүний нөөц бололцоог дутуу ашиглаж, байгалийн баялгийг нийгмийн сайн сайхан болгон хувиргаж чадахгүй байгаа нь эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалахад тулгарч буй гол бэрхшээл болж байна. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд ерөнхийдөө сайжирч байгаа хэдий ч халдварт бус өвчний тохиолдол ихээхэн нэмэгдэж, хүн амын нас

баралтын дийлэнх хувийг эзэлж байна. Нөгөө талаар гэр бүлийн хүчирхийлэл, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэх, бус нутгуудад нийгмийн үйлчилгээний хүртээмж харилцан адилгүй байгаа зэрэг олон асуудал байна. Эдгээр сорилтууд нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг өргөжүүлж, чанарыг нь сайжруулах, түүнчлэн халдварт бус өвчний эмчилгээний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах үүднээс эмнэлгийн тогтолцоонд илүү үр дүнтэй дэмжлэг хэрэгтэйг харуулж байна. Монгол Улс хүн ам бүтцийн хувьд залуу, хотжилт хурдацтай явагдаж байгаа зэргээс шалтгаалж өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангахын тулд бага насны хүүхдийн боловсролын нэмэлт үйлчилгээг яаралтай эхлүүлэх шаардлагатай байна. Мөн эдийн засгийн хямралыг даван туулах, санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглүүлж нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийг илүү боловсронгуй болгох шаардлагатай. Боловсрол, эрүүл мэнд, суурь дэд бүтэц, мэдээлэл харилцааны технологи зэрэг салбарт илүү чанартай хөрөнгө оруулалт хийснээр Монгол Улсын ирээдүйн өндөр бүтээмжтэй ажиллах хүчийг бэлтгэх урьдчилсан нөхцөл бүрдэнэ. Энэ асуудлыг шийдвэрлэхэд Засгийн газар, иргэний нийгэм, хувийн хэвшил, хөгжлийн түншүүд болон НҮБ аль аль нь чухал үүрэг гүйцэтгэх учир эдгээр байгууллагуудын нягт хамтын ажиллагаа, зохицуулалтыг сайжруулснаар ялангуяа нэн эмзэг бүлгийн хүмүүст илүү их үнэ цэнэ, үр нөлөөг бий болгоно.

Дэд бүтцийн хөгжил сул байгаа нь тус улсын хувьд хүн амдаа сайн чанарын нийгмийн үйлчилгээ үзүүлэх, олон улсад өрсөлдөх чадварыг бэхжүүлэх зэрэгт саад тээг болж буй гол хүчин зүйл болж байна. Нийгмийн дэд бүтцэд мэдэгдэхүйц ахиц гарч байгаа хэдий ч тус улсын нийт айл өрхийн дөнгөж 33.5 хувь нь улс орны онцлогт тохирсон сайжруулсан ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ авч байна. Салбарын яамд ашиглалтад байгаа эд хөрөнгийнхөө

271 Дэлхийн банкны Бизнес эрхлэхүй судалгаагаар Монгол Улс 2020 онд 190 орноос 81-р байрт эрэмбэлэгджээ. Үзэх <https://www.doingbusiness.org/en/data/exploreconomies/mongolia>

ашиглалт, засвар үйлчилгээнд хангалттай санхүүжилт өгөх гэхээсээ илүү шинэ төслүүдэд анхаарлаа төвлөрүүлсээр байна. Түүнчлэн, дэд бүтцийн томоохон төслүүд (эрчим хүч, дулаан, ус, тээвэр) нь төрийн оролцоо давамгайлсан, хувийн хэвшлийн оролцоо хязгаарлагдмал, улс төрийн бодлогод баригдах эрсдэлтэй байна. Далайд гарцгүйгээс тээвэр, ложистикийн асуудал хурцаар тавигдаж, агро бизнесийг хөгжүүлэхэд саад тээг болж байгаагаас гадна энэ чиглэлээр бүс нутгийн зангилаа төв болох боломж ч ашиглагдаагүй хэвээр байна. ГШХО, хосолсон санхүүжилт, Төр хувийн хэвшлийн түншлэл зэрэг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг түлхүү татсанаар төсвийн дарамт, өсөн нэмэгдэж буй улсын өрийг бууруулж, хүн амд илүү сайн технологи, засаглал, төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэх боломжийг нэмэгдүүлнэ.

КОВИД-19 цар тахлын дэгдэлт болон вирусын тархалтыг хязгаарлах зорилгоор авч хэрэгжүүлсэн онцгой арга хэмжээ нь Монгол Улсын эдийн засагт огцом цохилт өгч, эдийн засаг 2020 онд -5.3 хувь хүрч агшсан. Төсвийн нийт алдагдал ДНБ-ий 12 хувьд хүрч, улсын нийт өр ДНБ-ий 80 хувиас давсан тооцоо бий. Гадаад худалдааны салбарын хөгжилд тулгарч буй бэрхшээлээс шалтгаалж экспорт буурсны зэрэгцээ бусад олон сувгаар эдийн засагт сөрөг нөлөө илэрч байна. Нэгдүгээрт, хатуу хөл хорио, тодорхой бус байдал үүссэн, ирээдүйн талаарх хүлээлт улам суларч, цэвэр орлого буурсан зэрэг нь айл өрхүүдийн амьжиргаанд ихээхэн нөлөө үзүүлж, тэдний зарлагыг нь хязгаарласан. Хоёрдугаарт, ГШХО 2020 онд буурч, ирэх жилүүдэд хөрөнгө оруулалтын идэвхжил, хөрөнгийн ирээдүйн нөөц, боломжит бүтээгдэхүүний ирээдүйн өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна. Эцэст нь, цэцэрлэг, сургууль хаагдах нь хүүхдүүдийн сургуульд суралцах дундаж хугацаанд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй түүнээс улбаалан нийт хүчин зүйлийн бүтээмжийн өсөлт болон боломжит эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлнө. Хорио цээрийн үеэр эрүүл мэндийн боловсрол олгох сурталчилгаа, дархлаажуулалт зэрэг эрүүл мэндийн зарим үйлчилгээний хүртээмж буурсан. Энэ нь ялангуяа тав хүртэлх

насны хүүхдүүдийн дунд халдварт болон урьдчилан сэргийлэх боломжтой өвчлөл нэмэгдэхэд хүргэж болзошгүй юм. Эдийн засгийн сэргэлтийг түргэтгэх, ирээдүйд тулгарч болзошгүй хямралыг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн шийдвэртэй арга хэмжээг Засгийн газар нэн даруй авахгүй бол дээрх бүх хүчин зүйлүүд хуримтлагдан хавсарч Монгол Улсын дунд болон урт хугацааны эдийн засгийн өсөлт, санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлж, улмаар ТХЗ-ын хэрэгжилтийг хүнд эрсдэлд оруулна. Цаашдаа ч энэхүү цар тахлын нэгэн адил тохиож болзошгүй ямарваа хямралд бэлтгэлтэй, бэлэн байх нь нэн чухал байна.

Бодлого шийдвэр гаргачдад эрүүл мэндийн болоод эдийн засгийн олон асуудал тулгарч байгаа энэ үед 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл хэрэг нь бүрхэг байдалд орж байна. Гэхдээ одоо ч үргэлжилсээр байгаа КОВИД-19 цар тахлын дэгдэлттэй зэрэгцүүлэн богино хугацаанд бүтцийн шинэчлэлийг хийх боломж Засгийн газарт хараахан гараагүй байж магадгүй ч энэхүү цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хямрал нь өөрчлөлт шинэчлэлийг үргэлжлүүлэх, олон талт идэвхтэй түншлэлийг өрнүүлэх, Монгол Улсын эдийн засгийг түргэн сэргээж, гадны нөлөө, хямралыг даван туулах чадвартай байх чиглэлээр засаглалыг улам сайжруулах нь нэн чухал болж байна.

КОВИД-19 цар тахал нь байгалийн баялгийн олборлолт, экспортод суурилсан Монгол Улсын хөгжлийн замнал тогтворгүй байгааг, мөн эдийн засгийг төрөлжүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг анхааруулж байна. Хөдөө аж ахуйн салбар нь 2020 онд нэмүү өртгийн өсөлтийг бий болгосон эдийн засгийн цорын ганц салбар байсан гэдэг бол Монгол Улс илүү төрөлжсөн, эрсдлийг даах чадвартай эдийн засгийн хөгжлийн алсын хараатай байх нь чухал болохыг нотолж байна. Өргөн уудам бэлчээр нутаг, тариалангийн талбай, мал аж ахуйн эртний уламжлал, хөдөө аж ахуйд суурилсан үйлдвэржилтийг өргөжүүлэх асар их нөөц бололцоо зэрэгтээ түшиглэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн зохистой загвар, аялал жуулчлалын хөгжил

зэргийг бизнесийн зөв орчин, дэд бүтцээр холбож дэмжсэн тохиолдолд зохистой ажлын байр бий болгож, экспортын зах зээл, дотоодын хэрэгцээнд нийцсэн өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаль орчны зорилтуудыг биелүүлэх бүрэн боломж бий. Үнэн хэрэгтээ олон улс орон хөдөө аж ахуйн салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтоос татгалзаж байсан ч Монгол Улс хөдөө аж ахуйн салбартаа шийдвэртэй арга хэмжээ авч болох боломжийг ашигласан. Монгол Улсын Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтод хөдөө аж ахуйн салбарын буюу ялангуяа мал аж ахуйн салбарын хүлэмжийн хийн ялгарлыг 5,283.3 мянган тонн CO₂-экв-аар бууруулах зорилт тавьсан нь хөдөө аж ахуйн салбарын хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах стратеги нь богино хугацаанд агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг бууруулах чухал элемент бөгөөд үр нөлөөтэй арга зам^[272] гэдгийг засгийн газар болон түншүүдэд өгсөн тодорхой анхааруулга болсон.

Мөн боловсрол, эрүүл мэндийн салбарт шинэчлэл хийж, онцгой байдлын үед бэлэн, бэлтгэлтэй байх зайлшгүй хэрэгцээ байгааг КОВИД-19 цар тахал нотолж өгсөн. Цахим сургалтын тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр хийгдэж буй өнөөгийн ажил нь Монгол Улсын бүх шатны боловсролын үйлчилгээ хүүхэд бүрт тэгш хүртээмжтэй, чанартай, хэрэгцээ шаардлагад нь нийцсэн байхад чиглэгдэж байна. Засгийн газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хоёр, гурав дахь шатлалын тусламж үйлчилгээтэй уялдуулж, илүү үр нөлөөтэй эрүүл мэндийн тогтолцоонд шилжихийн тулд стратегийн худалдан авалтыг ашиглан нийгмийн эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг хүргэх засаглал, эрүүл мэндийн салбарын удирдлагыг бэхжүүлж эхэлсэн. Хямралын эсрэг дорвитой хариу нөлөө үзүүлэх нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж нэн эмзэг

бүлгийн хүн амыг бүрэн хамруулж тэдний санхүүгийн тогтвортой байдлыг хангах шаардлагатай байна.

КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн улмаас хил хааснаар БНХАУ руу ачааны машинаар экспортлох нүүрсний хэмжээ мэдэгдэхүйц буурахад хүргэсэн нь ашигт малтмалын тээвэрлэлтийг тасалдуулахгүйн тулд төмөр замын нэн чухал дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна. Мөн хил хаасан нь алт хууль бусаар хил давуулан худалдаалахыг хязгаарлаж, Монголбанк алт, валютын нөөцөө нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Иймд алтны хууль бус олборлолт, зуучлагчидтай холбоотой Олон улсын Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмжийг Монгол Улс үргэлжлүүлэн дагаж мөрдөх нь нэн чухал юм. Цар тахлын үед ачаа тээврийн үйл ажиллагаанд учирсан том цохилт нь Монгол Улсын хувьд дамжин өнгөрөх тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэгч түншүүдтэйгээ илүү нягт хамтран ажиллах, хил дамнасан тээврийг цаашид хөнгөвчлөх, томоохон саатлын үед зайлшгүй шаардлагатай ачаа тээврийн урсгалыг тогтвортой хадгалахын тулд онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх протоколуудыг тохиролцох зайлшгүй хэрэгцээ байгааг харуулсан.

Монгол Улс далайд гарцгүй гэдэг нь нэг талаас сорилт боловч нөгөө талаас хил дамнасан хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж юм. Монгол Улс хил орчмын бүс нутгууддаа эдийн засгийн чөлөөт бүс байгуулах өргөн боломж бий бөгөөд ингэснээр бараа бүтээгдэхүүнийг саадгүй шилжүүлэх нөхцөл бүрдэнэ. Эрчим хүчний хамтын ажиллагааг хөгжүүлэх цар хүрээ ч өргөн байна. Тухайлбал, Зүүн хойд Азийн эрчим хүчний супер сүлжээгээр Монгол Улсыг БНХАУ, ОХУ (мөн Япон, Бүгд Найрамдах Солонгос Улстай холбосон)-тай холбох боломжтой. Энэхүү хамтын ажиллагаа нь Монгол Улс дангаар байснаас харьцуулшгүй

272 Хөдөө аж ахуйн салбарт мал аж ахуй зонхилж байгаа учраас Монгол Улсын нөхцөлд метан зонхилох хүлэмжийн хийг ялгаруулж байна. Метан нь илүү хүчтэй боловч богино хугацааны үйлчлэлтэй уур амьсгалын бохирдуулагч учраас метан хийн ялгаруулалтыг арилгах ойрын хугацаанд авах арга хэмжээ нь ойрын хугацаанд агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг сааруулах үр дүнтэй арга юм.

том зах зээлийг нээж сэргээгдэх эрчим хүчний технологийг нэвтрүүлэх нутаг дэвсгэрийг тэлнэ. Монголын гол мөрнүүд дэлхийн хамгийн том эх газрын цэвэр усны нөөц болох ОХУ-ын Байгаль нуурт цутгадаг тул хойд хилийн бүс нутагт усан цахилгаан станц байгуулах ч өргөн боломж байна. Мөн саяхан Ази-Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орж, БНХАУ-Монгол Улс-ОХУ-ын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлсэн нь Монгол Улсад ложистик болон худалдааг хөнгөвчлөхөд тулгарч буй бэрхшээлийг арилгах, дамжин өнгөрөх ачаа тээврийн зангилаа болох хүсэл зорилгоо алхам ахиулах асар том боломжийг нээж байна.

Монгол Улсын Засгийн газар нь 181 төрлийн төрийн үйлчилгээг үзүүлэх "Цахим Монгол" дижитал платформыг нээж саяхан ашиглалтад орууллаа. Монгол Улс технологийн дэвшил, дижитал боломжууд, инновацийг ашиглан нийгмийн бүхий л бүлгүүдийн тэгш бус байдал, боловсролын ялгааг арилгаж чадна. Цахим засаглалыг өргөжүүлэн тэлснээр нийгмийн болоод төрийн үйлчилгээг хүн амын бүлгүүдэд улам ойртуулна. Үйлчилгээ, уул уурхай, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр зэрэг эдийн засгийн салбаруудыг цахимжуулах нь тогтвортой хөгжилд чиглэсэн суурь алхам юм. Эцэст нь Монгол Улс нь БНХАУ, ОХУ гэсэн хоёр том хөрштэйгөө шилэн кабелийн олон сүлжээгээр холбогдсоноороо Интернет солилцооны цэг^[273] болох онцгой байр суурьтай билээ. Энэ нь эдийн засгийн ихээхэн ач холбогдолтой боломжуудыг бий болгож, гадаад, дотоодын төр, хувийн хэвшлийн олон оролцогч талуудтай стратегийн түншлэлийг хөгжүүлэхэд тусална.

Эцэст нь, Монгол Улсын иргэд төрөөс үүргээ гүйцэтгэхийг нь хүлээх хандлага улам бүр нэмэгдэж, эрсдэлийг удирдах хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлэх буюу төр засаг хариуцахыг улам ихээр шаардах болсоныг КОВИД-19 цар тахал

харууллаа. 2021 оны нэгдүгээр сард болсон эсэргүүцлийн жагсаал, түүнээс шалтгаалж Засгийн газар огцорсны дараа Монгол Улсын шинэ үеийн удирдагч хэмээн нэрлэгдэж буй Ерөнхий сайдын тэргүүлсэн шинэ Засгийн газар нь төрийн бодлого, төрийн үйлчилгээг цахимжуулах, эдийн засгийн интеграцчилалд оролцох, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэх, тогтвортой хөгжлийн төлөөх үйлс зэрэгт анхаарлаа төвлөрүүлж байна. Өмнө нь ЗГХЭГ-ын даргаар ажиллаж байсан одоогийн Ерөнхий сайд нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн төлөөх Алсын хараа 2050 хөтөлбөрийг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Шинэ Ерөнхий сайд Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийг НҮБ-ын хөгжлийн систем, иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөллийг хамруулан өргөжүүлэн шинэчлэн зохион байгуулж, хөгжлийн түншүүд, ОУСБ зэрэг бусад оролцогч талуудтай хамтран ажиллах чин хүсэл эрмэлзлэлтэй байгаагаа илэрхийлсэн. Түүнчлэн Монгол Улс олон талын оролцоотойгоор 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх амлалтаа биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Тогтвортой хөгжлийн олон талт хамтын ажиллагааны зөвлөлийг байгуулснаа Монгол Улсын Их Хурал саяхан зарласан билээ.

273 Монголын интернет цэгийн үйлчилгээний журам. Үзэх <https://crc.gov.mn/en/k/2lm/1e>





ХАВСРАЛТ 1: МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ БАЙГУУЛЛАГА ДУНДЫН АЖЛЫН ХЭСГИЙГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

UNITED NATIONS  MONGOLIA NATIONS UNIES
OFFICE OF THE RESIDENT COORDINATOR IN MONGOLIA
INTEROFFICE MEMORANDUM #4

Date: 11 September 2020

To: UNCT Mongolia

From: Tapan Mishra, Resident Coordinator

Subject: Appointment of the Inter-Agency Task force for the preparation of the 2020 Common Country Analysis of Mongolia

Dear Colleagues,

I am pleased to inform you that the 2020 Common Country Analysis Inter-Agency Task Force members are hereby appointed as per details below:

Chair of the Task Force:

1. Doljinsuren Jambal, DCO, Strategic Planning and Team Leader, RCO

Members of the Task Force:

2. Nurjema Jalilova, DCO, Economist, RCO
3. Altansuvd Tumursukh, ADCO, Data management, monitoring and reporting, RCO
4. Bolorsaikhan Badamsambu, Human Rights Analyst, RCO
5. Nyamjargal Gombo, Assistant Representative, FAO
6. Egiimaa Tsolmonbaatar, Policy Consultant, IOM
7. Iliza Azyei, Assistant Representative, UNFPA
8. Bolormaa Purevsuren, National Coordinator, ILO
9. Enkhnasan Nasan-ulzii, Chief of Social Policy, UNICEF
10. Khurelmaa Dashdorj, M&E Officer, UNICEF
11. Buyandelger Ulziikhuu, M&E Officer, UNDP
12. Sodbayar Demberelsuren, Program Management Officer, WHO
13. Munkhbolor Gungaa, National Project Manager, UNIDO
14. Enkhsetseg Shagdarsuren, National Project Manager, UN-HABITAT
15. Robert Parua, Education Specialist, UNESCO
16. Mongolkhatan Tsevegmed, Protection Associate, UNHCR
17. Focal Points from UNESCAP, UNDESA, UNOPS, UNCTAD, UNEP, UNDRR, ITU, UN DPPA, OCHA.

The Concept Note is the integral part of this memo and attached herewith.

Хуулбар:

МОНГОЛ УЛС ДАХЬ НҮБ-ЫН СУУРИН ЗОХИЦУУЛАГЧИЙН МЕМОРАНДУМ

2020 оны 9-р сарын 11

Хэнд: НҮБ-ын Удирдлагын багт

Хэнээс: Суурин Зохицуулагч Тапан Мишра

Агуулга: Монгол Улсын Хөгжлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх Байгууллага-дундын Ажлыг хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Хөгжлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх Байгууллага-дундын Ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсныг мэдэгдэж байна. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

1. Жамбалын Должинсүрэн, Хөгжлийн зохицуулалтын ажилтан, Стратеги төлөвлөлт хариуцсан НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын ахлагч

Ажлын хэсгийн гишүүд:

1. Нуржимал Жалилова, Хөгжлийн зохицуулалтын ажилтан, Эдийн засагч, НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар
2. Төмөрсүхийн Алтансүвд, НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын Мэдээллийн удирдлага, хяналт шинжилгээ, тайлагнал хариуцсан ажилтан
3. Бадамсамбуугийн Болорсайхан, Хүний эрхийн шинжээч, НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар
4. Гомбын Нямжаргал, Шадар суурин төлөөлөгч, ХХААБ
5. Цолмонбаатарын Эгиймаа, Бодлогын зөвлөх, ОУШХБ
6. Азией Илийза, Шадар суурин төлөөлөгч, НҮБХАС
7. Пүрэвсүрэнгийн Болормаа, Үндэсний зохицуулагч, ОУХБ
8. Насан-Өлзийгийн Энхнасан, Нийгмийн бодлогын дарга, НҮБХС
9. Дашдоржийн Хүрэлмаа, Хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан, НҮБХС
10. Өлзийхүүгийн Буяндэлгэр, Хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан, НҮБХХ
11. Дэмбэрэлсүрэнгийн Содбаяр, Төслийн удирдлагын ажилтан, ДЭМБ
12. Гунгаагийн Мөнхболор, Төслийн үндэсний менежер, НҮБАҮХБ
13. Шагдарсүрэнгийн Энхцэцэг, Төслийн үндэсний менежер, НҮБХАБИТАТ
14. Роберт Паруа, Боловсролын мэргэжилтэн, НҮБ БШУСБ
15. Цэвэгмэдийн Монголхатан, Хамгааллын ажилтан, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар
16. Хариуцсан ажилтнууд - НҮБХАС, НҮБХС, НҮБХХ, НҮБАҮХБ, НҮББШУСБ, НҮБДАЭДКГ, НҮБАНДЭЗНК, НҮБЭЗНАЭГ, НҮБТУА, НҮБСТАТ, НҮББОХ, НҮБГЭБГ, ОУЦХБ, НҮБУТЭСАХХ, НҮБХХЗГ

Ажлын хэсгийн мөрдлөгө болгон ажиллах Удирдамжийг энэхүү меморандумд хавсаргасан болно.

Баярлалаа

ХАВСРАЛТ 2: ОРХИГДОХ ЭРСДЭЛТЭЙ ХҮН АМЫН БҮЛГҮҮДТЭЙ ХИЙСЭН (LNOB) ФОКУС БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГЫН ТАЙЛАН

ФОКУС БҮЛЭГ: 1. ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ: ХҮҮХДҮҮД (ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮД, БАЙГУУЛЛАГЫН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЖ БҮЙ ХҮҮХДҮҮД).

1

ДЭД БҮЛГҮҮД,
ТЭДГЭЭРИЙН ШИНЖ
БАЙДАЛ

- 15 болон түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд,
- Дотуур байранд амьдардаг хөдөөгийн хүүхдүүд (Хөдөөгийн сургуулийн дотуур байранд амьдардаг хүүхдүүд),
- Дотуур байранд амьдардаг МСҮТ-ийн оюутнууд,
- Өмгөөлөгчид, Хүүхдийн төлөөх шударга ёс хорооны гишүүд, ГБХЗГ-ын хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд,
- Мөрдөн байцаагчид, прокурор, анхан шатны шүүхийн шүүгчид

2

ОРХИГДОХ
ЭРСДЭЛТЭЙ ДЭД
БҮЛГҮҮД

- Хурдан морь унаач хүүхдүүд
- Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутан сурагчид /улсын сургуулиудаас/
- Ядуу, бага орлоготой өрхийн хүүхдүүд
- Хараа хяналтгүй орхигдсон (neglected) хүүхдүүд
- Шилжин суурьшигчдын хүүхдүүд

3

ЯЛГАВАРЛАГДАХ
ХЭЛБЭРҮҮД
(ОРХИГДОХ/
ЯЛГАВАРЛАГДАХАД
ХҮРГЭЖ БҮЙ ЯМАР
ШАЛТГААНУУД
БАЙНА ВЭ? ҮНДСЭН
ШАЛТГААН НЬ ЮУ
ВЭ?

Хурдан морь унаач хөвгүүдийн дунд сургууль завсардах, хичээл сургуулиасаа хоцрогдох тохиолдол гарсаар байна. Ийм хүүхдүүд эцэг эхийнхээ хяналт дор бус уяач айлын эрхшээлд орж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сум, хөдөө орон нутагт сурч боловсрох боломж, орчин нөхцөл тун тааруу болохыг бүлгийн ярилцлагад оролцсон охид, хөвгүүд онцолсон. Цар тахлын үеэр малчин өрхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тусгай сургууль, цэцэрлэг, сургуулийн өмнөх боловсролын цахим хөтөлбөрөөс бүрэн тасарсан хэмээн бүлгийн ярилцлагад оролцсон хүүхэд хамгааллын мэргэжилтэн ярьж байсан.

Сурагчдын (6 болон түүнээс дээш насны) цахим сургалтын гол хэрэглүүр нь гар утас бөгөөд удаан хугацаагаар гар утас хэрэглэх нь хүүхэд, өсвөр насныхны эрүүл мэнд, өсөлт хөгжилтөд муугаар нөлөөлж нүдний хараа муудах, хөдөлгөөн нь хомсдох, толгой өвдөх, гар утсанд донтох зэрэг олон сөрөг нөлөө үзүүлж байна. Цаашлаад, хүүхдүүдийн цахим хичээл үзэх анхаарал нь сарниж утсаараа тоглоом тоглох, видео үзэх нь зонхилох болсон.

Цар тахлын улмаас малчин өрхийн хүүхдүүдэд тулгараад байгаа хамгийн том бөгөөд гол бэрхшээл бол цахим сургалтаас хоцрох, хичээл таслах явдал юм. Энэ нь малчин өрхүүд, сүлжээнд хамрагдаагүй бүс нутагт амьдардаг хүүхдүүдэд хичээл номоо хийхэд тохирох хангалттай техник хэрэгсэл байхгүй (ялангуяа цөөн малтай, санхүүгийн боломж муутай залуу малчин эцэг эхчүүд), сургуулийн насны бүх хүүхдийн хэрэгцээнд нийцсэн хөтөлбөрүүд хүрэлцээгүй, нэг өрхөд нэг л гар утас хэрэглэдэг, эцэг эх нь хүүхдийнхээ хичээл номонд анхаарах цаг завгүй, хүүхдүүдээ мал маллагааны ажилд оролцуулдаг зэрэгтэй холбоотой байна.

Кейсе 1. Цахим сургалттай холбоотой саатал, таслалт

Интернетийн сүлжээнд бүрэн холбогдсон бүс нутгуудад амьдарч байгаа хүүхдүүд цахим сургалтын хөтөлбөрийн хичээлд суух боломжтой байгаа бол сүлжээнд холбогдоогүй бүс нутгийн хүүхдүүд хичээлд суух боломжгүй орхигдож байна. Манай ангийн 49 сурагчийн 10 нь интернэт сүлжээнд бүрэн холбогдоогүй газар амьдардаг бөгөөд долоо хоногт нэг удаа сүлжээ нь холбогдоход тэд хичээлээ бүрэн авч чаддаггүй. Малчны хүүхдүүдээс гадна ядуу өрхийн хүүхдүүд ч бас хүндрэлтэй байдаг. Тухайлбал, нэг айл гурван хүүхэдтэй гэхэд бүгдэд нь хичээлийн хэрэгсэл хүрэлцдэггүй.

Аймгийн төвд ч гэсэн хичээлийн ирц 50 хувьтай байна. Ялангуяа аймгийн төв, сумдад ирц маш бага байна. Бодит байдал дээр суманд бараг л хичээл ордоггүй. Боловсролын чанарын баталгаа байхгүй, хүүхэд хичээлээ ойлгож байгаа эсэхэд ч итгэлгүй байна.

Малчин эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ хичээл сурлагад маш бага анхаарч байна. Зарим нь хүүхдээ дагуулаад мал маллаж, алт олборлох тохиолдол ч байна. Аймгийн төвд суралцахаар ирсэн хүүхдүүд дотуур байр, орон байр олдохгүй байгаагаас буцаад гэрлүүгээ харьдаг.

(Сургуулийн нийгмийн ажилтнууд, багш нар, хүүхдийн өмгөөлөгчид, хуульчидтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

Ажил олгогч малчид өөрсдийнхөө хүүхдүүдийг сургуульд сургах хандлагатай байдаг ч 35-аас дээш насны туслах малчид, гэрээт малчдаа гэр бүлийнхэнтэйгээ хамт байхыг шаардаж байгаа нь тэдний хүүхдүүдийн сургуульд сурах боломжийг хязгаарлаж байна. Туслах малчин авч чадахгүй байгаа малчид ган, зуд зэрэг байгалийн гамшиг ихсэх тусам өөрсдийн хүүхдүүдийг мал дээрээ байлгахыг илүүд үзэж байна. Өнөө цагт санхүүгийн хүндрэлд орсон малчин эцэг эхчүүд 1990-ээд оны хуучин хэвшилдээ эргэн орж, санхүүгийн боломж гарвал эхлээд охиноо, дараа нь хүүгээ сургах талаар бодож эхэлсэн байна.

Охид, хөвгүүд сургууль дээрээ эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж байна. Ийм үзлэгийг нийтлэг стандарт, журмын дагуу хийдэггүй, ялангуяа охид, хөвгүүдийг тусгаарласан өрөөнд оруулаагүй, үзлэгийн зорилго, үр дүн нь тодорхойгүй, хүүхдүүдэд мэдээлээгүй, хувийн нууцлалыг нь хангаагүй талаар Фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан 15 болон түүнээс дээш насны охид, хөвгүүд ярьж байсан.

Кейс 2. Охидын үзлэгийг зориулалтын бус газарт хийсэн

“Охидын үзлэг болсон. Сумын эмч нар сургууль дээр очиж охидын үзлэг хийдэг бөгөөд ямар нэгэн асуудал илэрвэл дороо л тарж хүүхдийн эмзэг сэдэв болж хувирдаг. Урьдчилан мэдэгдэлгүйгээр биднийг ийм үзлэгт оруулж байсан. Зарим тохиолдолд охид, хөвгүүдийг хамт нэг өрөөнд дуудаж оруулаад, дундуур нь ердөө л хөшиг татчихна. Эмчийн надтай юу ярьж байгааг хөвгүүд сонсох бүрэн боломжтой. Би ер нь тусдаа өрөөнд нэг ч удаа үзлэгт орж байгаагүй юм байна”.

(Сумын ахлах сургуулийн охидтой хийсэн фокус бүлгийн ярилцлагаас)

Улаанбаатар хот болон орон нутагт байдаг МСҮТ, коллежийн дотуур байранд амьдарч байгаа өсвөр насныханд (охид, хөвгүүд) нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол эзэмших хөтөлбөр байдаггүй. Тэд эрүүл мэндийн боловсролыг тодорхой хэмжээгээр хэдийнээ авсан боловч нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, бэлгийн хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийллээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сургалтад хамрагдахгүй байгааг онцолсон. Оюутны дотуур байранд амьдардаг охид, хөвгүүдийн аль аль нь шаардлага гарсан тохиолдолд ийм үйлчилгээг хотын хаанаас, хэрхэн авах боломжтой талаар ямар ч мэдлэггүй гэдгээ фокус бүлгийн ярилцлагад оролцогчид ярьж байсан. Түүнчлэн, ярилцлагад оролцогчид бүгд 15 наснаасаа хойш эсрэг хүйстэнтэйгээ болзож байсан аж.

Хөдөөнөөс хот руу шилжиж байнга оршин суудаг газраа сольж байгаа айл өрхүүдийн хүүхдүүд сургуулиас завсардах, хараа хяналтгүй гэртээ үлдэх зэрэг эрсдэлтэй тулгарч байна.

Кейс 3.

Хөдөө орон нутгаас шилжиж ирсэн хүмүүсийн дунд хүүхдүүдийнхээ сургууль, өөрийн ажлыг солих бүрт амьдрах газраа өөрчилж байдаг хүмүүс байдаг. Заримдаа хүүхдүүд нь сургуулиас гарч хараа хяналтгүй гэртээ үлдэх тохиолдол ч гарч байна. Хөдөөнөөс хот руу шилжиж ирсэн хүмүүст ажил олох тун хэцүү учир эцэст нь архинд орно. Энэ нь хороодод хамгийн их санаа зовоосон асуудлын нэг болоод байгаа.

(ГБХЗГ, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

4

ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХЛЫН ЯМАР
ХЭЛБЭРҮҮД БАЙНА
ВЭ?

Ялгаварлан
гадуурхал (өөрийнх
нь болон өөрийг
нь илэрхийлж буй
ондоошил буюу
шинж байдлаар)

Засаглал (Хүний
эрхэд суурилан
хөгжих хандлагын
хүрээнд тулгарч
буй чадавхын
бэрхшээл, хууль
тогтоомж, бодлого,
татвар, төсөв,
хуваарилалтын
нөлөөлөл, засгийн
газрын шийдвэр
гаргах үйл явцад
оролцох чадвар гэх
зэрэг нөлөөллийг
харгалзах)

Хөгжлийн бэрхшээлтэй сурагч, оюутнууд, амьжиргааны түвшин доогуур айлын хүүхдүүд үе тэнгийнхнийхээ гадуурхалд өртөж байна. Сургуулийн сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй сурагч, оюутнуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын хэлж байгаагаар өсвөр насныханд (13 болон түүнээс дээш насны) бие бялдар, эдийн засгийн байдлаар нь ялгаварлан гадуурхах явдал их тохиолдож байна. Багш, нийгмийн ажилтнуудын анхаарал оролцоо сул байгаа бөгөөд ялангуяа өсвөр насныхны дунд тэдний ойлголт, хандлагыг өөрчлөх хүмүүжлийн ажил орхигдсон хэвээр байна.

Хөдөө орон нутгийн хөгжлийн хоцрогдол, сул дорой байдал нь олон мянган залуусыг хөдөөгөөс хот руу шилжин суурьших, ялангуяа Улаанбаатар хот руу шилжин суурьших, мэргэжлийн болоод их дээд боловсрол эзэмшин хот суурин газарт ажиллаж амьдрах хүсэл сонирхолыг нь төрүүлэх түлхэх хүч болж байна. Хөдөө орон нутгийн сумдын сургуулиудын боловсролын чанар муу, ялангуяа цахим сургалтад шилжиж буй энэ үед төгсөх ангийн сурагчид их, дээд сургуульд элсэх шалгалтаа өгөхийн тулд аль болох Улаанбаатар хот руу шилжихээр тэмүүлж байна. Түүнчлэн ажлын байр хомс, өөрийгөө хөгжүүлэх боломж хязгаарлагдмал учраас мэргэжлийн сургалтад хамрагдсан ч сум, аймагтаа буцах дургүй байгаа хүмүүс давамгайлж байна. Олон хүн УБ хотод үлдэхийг хүсч байна. Цахим сургалт үргэлжилсээр байвал Улаанбаатар хотод байдаг ах дүү хамаатан садных руугаа явж хоцрогдолоо нөхөж, ахлах сургуулиа төгсөх төлөвлөгөөтэй байгаа хэмээн фокус бүлгийн ярилцлагад оролцсон төгсөх ангийн сурагчид ярьж байсан. Фокус бүлгийн ярилцлагад оролцсон төгсөх ангийн охид, хөвгүүд бүгд Улаанбаатар хотод ах дүү, хамаатан садныдаа байх бүрэн боломжтой гэж хариулсан нь сонирхол татаж байсан.

Кейс 4. Хөдөө орон нутгийн сургуулиудын боловсролын чанар муу байгаа нь залуучууд нийслэл хот руу шилжин суурьших нэг гол шалтгаан болж байна.

Сумандаа боловсрол, спортоор хоцрогдолд орох нь үнэхээр хэцүү санагддаг. Гол асуудал нь бид хөгжлөөс хоцорч байна, энд ямар ч боломж алга. Манай сум хэдийгээр аймагтай ойр ч хоттой харьцуулахад хөгжил муутай. Боловсролын тогтолцоо муу байгаа учраас сургуульд тэнцэхгүй байх вий гэж санаа зовж байна. Хэрвээ дахин онлайнаар хичээллэх юм бол би аймаг юмуу хотын сургуульд шилжих бодолтой байгаа. Бид хоцрогдлоо нөхөх хэрэгтэй. Технологийн болон гадаад хэлний хичээлүүд маш муу орж байгаа. Манай ангийн хүүхдүүдийн бараг тал хувь нь 9-р ангиа төгсөөд хот руу шилжсэн. Улсын аврага шалгаруулах уралдаан тэмцээнд оролцох боломж бүр хязгаарлагдсан.

Сургуулиа төгсөөд хотод сурна даа. Хөгжил муутай нутаг орондоо бид эргэж ирэхгүй. Манай хамаатан садны зарим нь хотод байгаа, би ч гэсэн дүү нараа хот руу авч явахыг хичээнэ. Оюутан болоод ирэхээр мал маань ч дуусна.

(Сумын сургуулийн дотуур байранд амьдардаг эрэгтэй хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас)

Насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэргүүдийн дунд хүний эрүүл мэндэд хохирол учруулах, мөн хулгайн, хүчингийн, зам тээврийн осол зэрэг гэмт хэрэг зонхилж байна. Энэ нь тэдний гэр бүлийн амьдралын нөхцөл, эцэг эхийн хараа хяналт сул, эцэг эх нь алт олборлохоор, эсвэл удаан хугацаагаар тээвэрт явж эзгүй байх зэргээс шалтгаалж байгаагийн зэрэгцээ амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур амьдралтай айлын хүүхдүүд гэмт хэрэгт холбогдох эрсдэл өндөр байна. Түүнчлэн эцэг эх, асран хамгаалагчийн хараа хяналт сул байгаагаас хүүхдүүд гэмт хэргийн хохирогч болох, ялангуяа бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогч болох магадлал өндөр байна.

Мөрдөн байцаалтын явцад янз бүрийн гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүд бие биенээ таньж мэдсэнээр насанд хүрээгүй хүүхэд давтан гэмт хэрэг үйлдэх, гэмт хэрэгт байнга холбогдох нь ихэсч байгааг фокус бүлгийн ярилцлагад оролцсон цагдаа, шүүхийн ажилтнууд онцолж байна.

Кейс 5. Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй хүчин зүйлүүд

Баянхонгор аймаг хүчингийн хэргээр нэгдүгээрт эрэмбэлэгддэг бөгөөд энэ нь алт олборлох, мал маллах шалтгаанаар эцэг эхчүүд нь эзгүй, хараа хяналтгүй маш олон тооны хүүхдүүд амьдарч байгаатай холбоотой. Цар тахалтай холбоотой цахим гэмт хэрэг ч өсч байна. Улам олон хүүхэд онлайнаар харсан зүйлээ дууриан (порно сайт, зодоон, хулгай) үйлдэж байна. Нөгөөтэйгүүр, нэг гэмт хэрэг үйлдсэн хүүхэд давтан гэмт хэрэг үйлдэх нь элбэг тохиолдож байна.

(Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн албан хаагчид, нийгмийн ажилтнууд, өмгөөлөгчид, шүүхийн ажилтнуудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

Төлбөрийн асуудлаас болж насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг өмгөөлөх өмгөөлөгчид байнга солигдож байгаагаас хүүхдүүд өмгөөллийн чанартай үйлчилгээ авч чадахгүй байна. Мөрдөн байцаалтын шатанд ийнхүү хамгаалалт авч чадахгүйгээсээ болж тэд дахин сэтгэл санаагаар унаж, гэмт хэргийн шинжтэй үйлдэл давтан гаргаж байна.

Кейс 6. Насанд хүрээгүй хүүхдийн гэмт хэргийн өмгөөлөгч байнга солигдож байгаагаас тэд өмгөөллийн бодитой тусламж авч чадахгүй байна.

Өмгөөлөгчид байнга солигддог. Бүлэглэлийн гэмт хэрэг шөнө дөлөөр үйлдэгддэг. Шөнө оройн цагаар газар дээр нь байцаалт авахад өмгөөлөгч олдохгүй байна. Бид хүүхдийг байцаахдаа өмгөөлөгчийг нь заавал байлцуулах ёстой. Хүүхдийг цагдан хорьсон тэр даруйд нь мэдүүлэг авбал бүх зүйл тодорхой болж шийдэгдэх боломжтой. Гэтэл өмгөөлөгч ойр ойрхон солигдох тусам хүүхэд худлаа ярьж эхэлдэг. Шөнө оройн цагаар насанд хүрээгүй хүүхдийг байцаахад прокурор байлцмаар байгаа юм. Шүүх хурал дуусан дуустал өмгөөлөгч байлцах ёстой. Мөрдөн байцаагчдын зүгээс өмгөөлөгчдийг байлцахыг байнга гуйдаг. Эцэг эхийн зүгээс мөнгө төлөх чадваргүй бол өмгөөлөгчид өмгөөллийн үйлчилгээнээс татгалздаг, аль эсвэл зүгээр л нэр төдий оролцдог.

Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдийг өмгөөлөгчид бүрэн төлөөлж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Бусад төлбөртэй өмгөөлөгчдийн нэгэн адил тэд бүрэн хэмжээгээр үйлчлэхгүй байна.

(Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн албан хаагчид, өмгөөлөгчид, хуульчид, прокуроруудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Кейс 7. Хамгаалах байр хүрэлцээгүйгээс гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүд сэтгэл санааны хямралд орж, гэмт хэргийн шинжтэй үйлдэл дахин гаргах хандлагатай.

Хохирогч хүүхдүүдийг хамгаалах байр байдаг. Гэсэн хэдий ч гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдэд ийм байр байдаггүй. Нэгэнт гэр бүлийн дэмжлэг байхгүй болохоор гэмт хэрэгт буруутгагдсан үедээ тэрээр өөрөө өөрийгөө хариуцах хэрэгтэй болдог. Иймээс хууль зөрчиж хүүхдийг хамгаалах байранд авч байна. Гэсэн хэдий ч тэд сэтгэлийн хямралд орж, дахин гэмт хэрэг үйлдэх, бүр амиа хорлох ч тохиолдол гарч болзошгүй байдалд орж байна.

(Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн албан хаагчид, өмгөөлөгчид, хуульчид, прокуроруудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Нийгэм-эдийн засгийн байдал (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхдүүдийн олон талт ядуурлын байдлыг нь харгалзах)

Сумын дотуур байранд амьдардаг хөвгүүдтэй хийсэн ярилцлагаас харахад ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа өсвөр насныхан мал сүргээ өвлөн авч, өсгөж үржүүлэх гэхээс илүүтэй мэргэжлийн боловсролын сургалтын төлбөр, өдөр тутмын гэр ахуйн зардалд мөнгөө илүү зарцуулах хүсэлтэй байна.

Ковид-19 цар тахлын үед цахимаар суралцаж байгаа нь орон нутгийн хүүхдүүдэд чөлөөт цагаа нэмэгдүүлэх боломж гарч, мал маллагаанд туслахаас гадна барилга, худалдаа, үйлчилгээний ажилд тусалж мөнгө олж байгаа талаар фокус бүлгийн ярилцлагад оролцсон охид, хөвгүүд ярьж байсан. Энэ нь хүүхдүүдэд даалгавраа цаг тухайд нь хийхгүй байх, хичээлээ таслах, илүү цагаар ажиллах, гэмтэж бэртэх, аюултай нөхцөлд хүнд хүчир ажил хийх зэрэг олон эрсдэл дагуулж байгаа бөгөөд ялангуяа барилга дээр туслах ажил хийж байгаа хөвгүүдэд илүү ноцтой байна.

Кейс 8. Өсвөр насны хөвгүүд ихэвчлэн барилга дээр туслах ажил хийж байна

Ар гэрийнх нь амьдрал тааруу учраас хүүхдүүд ажил хийх тохиолдол олон гардаг. Ер нь миний үе тэнгийнхэн өдөрт 30 мянган төгрөгөөр барилга дээр ажилладаг. Миний нэг найз бэртэж нүд нь гэмтээд хотод эмчлүүлж байгаад ирсэн. Тэр одоо сургуульдаа сурч байгаа ч ажил хийсээр л байгаа. Өнгөрсөн зун би бас барилга дээр ажилласан. Тэнд 16-17 насны олон хөвгүүд ажиллаж байсан.

(Сумын сургуулийн дотуур байранд амьдардаг эрэгтэй хүүхдүүдтэй хийсэн

фокус бүлгийн ярилцлагаас)

Хууль сахиулах болон эрүүл мэндийн байгууллагууд хамтран эмзэг бүлгийн хүүхдүүдэд зориулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх онлайн сургалт зохион байгуулах үед цахим орчинд нэвтрэх боломжгүй болон хөдөө орон нутагт амьдарч байгаа зорилтот бүлгийн хүүхдүүддээ хүрч үйлчлэхэд хүндрэлтэй байсан тухайгаа Фокус бүлгийн ярилцлагад оролцсон нийгмийн ажилтан тэмдэглэж байсан. Үнэн хэрэгтээ ийм төрлийн сургалтыг сургуулиуд дээр нийт хүүхдүүдийн дунд нэр төдий зохион байгуулж байсан бөгөөд хүүхдүүдийн ирц ч хангалтгүй байжээ.

Газарзүйн байршил (байгаль орчны доройтол, тээвэр, технологи зэрэг байршлаас шалтгаалсан алслагдмал байдал, эрсдэл, орхигдол)

Сургалтын орчин болон ерөнхий боловсролын чанар муу байгаа нь хөдөө орон нутгийн хүүхдүүдийн адил тэгш сайн боловсрол эзэмших, хөгжих эрхийг зөрчиж байна. Фокус бүлгийн ярилцлагад оролцсон 10-12-р ангийн охид, хөвгүүд бүгд хот суурин газар үргэлжлүүлэн суралцах төлөвлөгөөтэй байгаагаа илэрхийлж байв.

Эмзэг байдал, хямрал (байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшиг, хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, эдийн засгийн болон бусад хямралд өртөмтгий нутаг дэвсгэр, хүн ам)

Дотуур байранд амьдардаг ахлах ангийн хөвгүүд бага ангийн хөвгүүдийг байнга дээрэлхэн дарамталж хувцас хунараа угаалгаж, өрөөгөө цэвэрлүүлдэг хэмээн Фокус бүлгийн ярилцагад оролцсон охид ярьсан.

Насанд хүрээгүй хүүхдүүд халаасны хулгай, ахуйн хулгай зэрэг хулгайн гэмт хэрэгт холбогдож байна. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн шинж байдлыг судалж үзэхэд орлого багатай, ядуу, эцэг эх нь анхаарал халамжгүй, архины хамааралтай айл өрхийн хүүхдүүд, мөн чинээлэг амьдралтай ч эцэг эх нь үр хүүхэддээ анхаарал тавьдаггүй, завгүй амьдралын хэв маягтай, хэт задгай шинжтэй айл өрхийн хүүхдүүд байна. Үе тэнгийнхний дарамт шахалт, эцэг эх, асран хамгаалагчийн анхаарал халамжгүй байдал зэрэг нь насанд хүрээгүй хүүхдүүдийн гэмт хэрэгт өртөх гол хүчин зүйл болж байна.

Сүүлийн жилүүдэд өсвөр насны хүүхэд оролцсон хүчингийн хэрэг цөөнгүй бүртгэгдсэн байна. Энэ нь бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэг дутмаг, харилцааны ур чадвар дутмаг, мөн насны залуугаас гэнэдэх зэргээс шалтгаалж байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон өмгөөлөгчид онцолж байна.

Кейс 9.

“Хүчин гэдэг нь хүсээгүй байхад нь хүч хэрэглэн бэлгийн харьцаанд орохыг хэлдэг. Бодит байдал дээрээ хүүхдүүд харилцан тохиролцсон үйлдлийнхээ төлөө 10-12 жил, аль эсвэл бүх насаараа хорих ялаар шийтгүүлж байна”.

“Сүүлийн үед бид нэг цэгийн үйлчилгээний төв, хүчирхийллийн эсрэг төвтэй болж, хүүхдүүдтэй биечлэн уулзаж мэдээлэл түгээх ажлыг сайн хийж байгаа. Эрэгтэй, эмэгтэйгээр нь тус тусад нь сургалт явуулж мэдээллийг сурагчдад сайн хүргэж байгаа. Гэхдээ ийм төрлийн сургалт явуулахад санхүүжилт дутагдалтай байгаа нь саад болдог”.

Сургуулийн нийгмийн ажилтан, багш, өмгөөлөгч, хуулийн ажилтнуудтай хийсэн

Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

Ахлах ангийн сурагчдад үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагууд (ихэнхдээ цагдаа нар) 1-2 цагийн сургалт зохион байгуулахдаа сургуулийн анги танхимд бус ихэвчлэн цахимаар, мөн зайнаас явуулж байгаа нь сэдвийн хувьд хүнд, сургалтад оролцогчдын нас, хүйс, ойлгож хүлээн авах чадварт тохирохгүй байх тохиолдол олон байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон хүүхдүүд, багш нар, нийгмийн ажилтнууд тэмдэглэж байсан. Ийм төрлийн сургалтууд хот, аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулиуд дээр зохион байгуулагдаж байгаа бөгөөд хөдөө орон нутагт амьдардаг болон малчин залуус оролцох боломжгүй ихэвчлэн орхигдож байна. Ийм сургалтын агуулгыг оролцогчдын нас, хүйсийн онцлогт нийцүүлэн нарийвчилсан судалгаанд тулгуурласан кейс хэлбэрээр зохион байгуулах нь илүү хэрэгтэй хэмээн Фокус бүлгийн ярилцлагад оролцсон охид, хөвгүүд онцолж байлаа.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэг хөл хорио тогтоосон үеэр эрс нэмэгдэж байсныг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон цагдаа, хуульчид онцолж байсан. КОВИД-19 цар тахлаас сэргийлж тогтоосон хөл хорионы үеэр охидын үзлэг зохион байгуулагдаагүй бөгөөд есдүгээр сараас эхлэн сургуулиудын хичээл танхим болон цахимаар ээлжлэн орох үед охидын үзлэг зохион байгуулахад хэд хэдэн жирэмсэн охид бүртгэгдсэн хэмээн Фокус бүлгийн ярилцлагад оролцсон багш, нийгмийн ажилтнууд ярьж байсан.

Хараа хяналтгүй орхигдох, үл тоомсорлогдоход ямар хүчин зүйлүүд нөлөөлж байна вэ?

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт эрүүл мэндийн боловсрол, гэр бүл төлөвлөлтийн талаарх агуулгыг оруулсан байдаг. Гэсэн хэдий ч үр нөлөө нь маш муу байна. Сургалтын сэдэв нь зөвхөн архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээний асуудлаар хязгаарлагдаж байгаа тухай Фокус бүлгийн ярилцлагад оролцсон хөвгүүд тэмдэглэж байсан. Мөн эрт болон хүсээгүй жирэмслэлт, сургуулиас завсардах тохиолдол илт ажиглагдаж байна.

Сумдад хүүхдийн аюулгүй амьдрах орчин нөхцөл бүрдээгүй байна. Гудамжууд гэрэлтүүлэггүй учир гол замуудаар хөндлөн гарахдаа автомашины осолд өртөх, золбин ноходод хазуулах, гэмтэж бэртэх зэрэг аюул эрсдэл их байна.

Хөдөө орон нутгийн ахлах ангийн сурагчдын дийлэнх нь хот суурин газар үргэлжлүүлэн суралцахаар төлөвлөж байна. Тэдний дийлэнх нь сумандаа буцаж очих бодолгүй байна. Энэ нь сумд хөгжлөөр хоцрогдсон, хүүхэд залуучуудын өсч хөгжих боломж хязгаарлагдмал, нийгмийн харилцаа, өрсөлдөөн сул, ажлын байр хомс зэрэгтэй холбоотой байна.

Өсвөр насны хүүхдүүд сургуульд сурахаар хөдөө орон нутгаас хот суурин рүү шилжихдээ ихэвчлэн хамаатан садныдаа, аль эсвэл дотуур байранд амьдардаг хэмээн Фокус бүлгийн ярилцлагад оролцсон хөвгүүд онцолж байсан. Иймээс тэд эцэг эхийн хяналтаас холдож санхүүгийн хэрэгцээгээ хангахын тулд цагийн ажил хийх, мөрийтэй тоглох тохиолдол ч гарч байна.

Хүүхэд хамгааллын ажлын чанар суларч байгаагийн нэг шалтгаан нь гэмт хэрэгт холбогдсон хүүхэдтэй ажиллах болон түүнтэй холбоотой эрсдэлийн шалгуур байхгүй, үр дүнд нь хяналт тавьдаггүйтэй холбоотой байна.

Кейс 10.

Хорооны алба хаагчдын ажлын гүйцэтгэлийг жил бүр үнэлж дүгнэдэг. Манай хороонд л гэхэд үнэлгээ хийх зүйл байхгүй. Ямар хэрэг хянан шийдвэрлэсэн, ямар үр дүн гараад байгаа талаар ямар нэгэн үнэлгээ хийгээгүй. Үнэлгээ хийгээгүй болохоор хүүхэд хамгааллын асуудал орхигдож, хэн ч санаа зовохгүй байна.

(ГБХЗГ, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

5

ЭНЭ БҮЛГИЙГ
ДЭМЖИХИЙН
ТУЛД ЭРХ
ЭДЛЭГЧИД, ҮҮРЭГ
ХҮЛЭЭГЧДИЙН
ЗҮГЭЭС ЯМАР
АРГА ХЭМЖЭЭ,
САНААЧЛАГА ГАРГАЖ
БОЛОХ ВЭ?

Хүүхдийг хурдан морь унаач болгох асуудал уламжлалт өв соёл гэхээсээ илүү эцэг эх, уяачид хоорондын ашиг сонирхол, мөнгөний асуудал болж байна. Үүнийг таслан зогсоохын тулд хуулиа маш тодорхой болгох, уяачид, эцэг эхийн хариуцлагыг нэмэгдүүлэх, унаач хүүхдийн насны хязгаарыг тогтоох, хурдан морь унаач хүүхдийн насны онцлогт тохирсон бие бялдрын хөгжлийн шалгуурыг тогтоох зэрэг өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай гэдгийг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон орон нутгийн захиргааны ажилтнууд онцолж байсан.

Насанд хүрээгүй хүүхдүүдийн үйлдсэн гэмт хэргийн мөрдөн байцаалтын болон шийдвэрлэх ажиллагаа нь олон улсын стандартад нийцэж байгаа хэдий ч зарим шийдвэр, заалт нь хүүхдэд ээлгүй, зохисгүй байх тохиолдол гарч байна. Ямар ч тохиолдолд насанд хүрээгүй хүн өмгөөлөгч авах ёстой бөгөөд шүүх хурал болохоос өмнө хүүхдэд мэдээлэл өгч, өмгөөлөгчийн хамт шүүх хуралд оролцуулах ёстой. Харамсалтай нь насанд хүрээгүй хүүхдүүдийн гэмт хэргийн мөрдөн шалгалтын үйл ажиллагаа сүүлийн шатандаа орох үед л хууль зүйн туслалцаа авахаар хөөцөлдөж байгаа тохиолдол гарч байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон орон нутгийн цагдаа, хуульчид онцолж байв.

Кейс 11.

“Зарим тохиолдолд цагдаа нар хүүхдийг өмгөөлөгчгүй байцааж байсан. Гурван жилийн өмнө нэг хүүхэд өмгөөлөгчгүйгээр байцаагдаж, айсандаа цагдаагийн байрны дээвэр дээрээс үсэрсэн. Ийм тохиолдол хааяа гардаг” гэв.

Кейс 12.

"Хүүхдийн гарыг гавалж, тогоор цохиулах зэргээр хэргийг нь хүлээлгэх гэж сэтгэлзүйн дарамтад оруулах явдал бий. Цагдаа нар тэднийг "Чи хийгээ биздээ" гэж буруутгадаг. Ийм тохиолдолд хүүхдийн сэтгэл зүйд ихээхэн нөлөөлнө. Манайд сэтгэл зүйч байхгүй, бид гомдол гаргадаг. Цагдаа нар цагдаа нарынхаа л төлөө зогсоно. Цагдаа нарт зориулсан хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар сургалт явуулах хэрэгтэй. Цагдааг мөрдөн шалгалтын ажлынх нь үр дүнгээр шагнаж болно."

(ГБХЗГ, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Хот суурин, хөдөө орон нутагт хүүхдийн гэмт хэргийн шинжээч, хуулийн төлөөлөгч ихээхэн дутагдалтай байгаа бөгөөд эдгээр мэргэжилтнүүдийн ачаалал ч хэт их байна. Тэд мөн энэ чиглэлээр тусгайлан бэлтгэгдээгүй байна. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн нас, хүйсээс хамаарч эрэгтэй, эмэгтэй өмгөөлөгчийн аль тохирохыг нь сонгох боломж ч байхгүй байна. Тухайлбал, Баянхонгорт хийсэн чанарын судалгаагаар гэмт хэрэгт холбогдсон хүүхдэд үйлчлэх ердөө хоёр л эмэгтэй хуулийн төлөөлөгч байна. Үүнээс гадна шүүх хурал, хүүхдийн үнэлгээ хийх, мэдүүлэг, ярилцлага хийх тусгай өрөө байхгүй байна. Мөн хүмүүстэй уулзаж ярилцаж байгаа бусад олон алба хаагчидтай нэг өрөөнд хүүхдүүдээс байцаалт, мэдүүлэг, ярилцлага авч байгаа нь хувийн нууц, хамгаалалт, ил тод байдал, итгэлцэл зэргийг алдагдуулж, зөвхөн холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх үйлчилгээ үзүүлэх боломж л олгож байна.

Кейс 13.

Цагдаа нар гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг насанд хүрсэн хүнтэй хамт байхад нь байцааж байна. Мөн өөр том хүмүүсийн дэргэд, наад захын нөхцөл хангагдаагүй өрөөнд хүүхдийг байцаадаг. Тэд хүчирхийлэлд өртсөн үедээ гэмт хэрэг үйлдсэн мэт санагддаг. Одоо л бид хүүхдийн мөрдөн байцаагчтай болж байна.

Насанд хүрээгүй охин мэдүүлэг өгөх үедээ 7 настай байсан. Гэтэл тэр өрөөнд нь эрэгтэй цагдаа нар, өөр хэд хэдэн цагдаа нар сууж байж. Ийм нөхцөлд хүүхдийн бэлгийн хүчирхийллийн талаар хэн ярих вэ? Яллагдагчийн мэдүүлгийн дагуу хүчирхийлэлд өртсөн хүүхдээс шууд мэдүүлэг авч байна. Цагдаа нарыг хандлага, сэтгэл зүйн сургалтад заавал хамруулах хэрэгтэй.

(ГБХЗГ, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Хүүхэдтэй холбоотой гэмт хэргийн асуудлаар ажилладаг албан хаагчид нэмэлт сургалт, семинарт хамрагдаагүйгээс мэргэжлийн ёс зүй, мэргэжил мэдлэгийн алдаа гаргаж байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон мөрдөн байцаагчид онцолж байв. Мөн насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг шүүгч мэргэжилтнүүд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, насны онцлогийг нь харгалзах талаар няхуур хандах ёстой хэмээн тэд тэмдэглэж байсан.

Сум, хорооны ажилтнууд тогтвор суурьшилгүй байнга солигдож байна. Ажлын байрны тодорхойлолт байнга шинэчлэгдэн өөрчлөгддөг, хүлээх үүрэг хариуцлага, үйлчилгээний цар хүрээ маш өргөн байдаг ч тус хороо (тухайлбал, Баянзүрх дүүргийн тавдугаар хороо нийт 29,000 хүн амтай) нь ганцхан нийгмийн ажилтантай учир хүчирхийлэл, гэмт хэргийн тохиолдлуудыг бүрэн зохицуулах ямарч боломж байдаггүй хэмээн Фокус бүлгийн ярилцлагад оролцсон нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд үзэж байна.

Кейс 14. Үндсэн нэгжид ажиллаж байгаа нийгмийн ажилтнууд тогтвор суурьшилгүй байна.

Нийгмийн ажилтан бол хамгийн их ачаалалтай бөгөөд сэтгэл санааны хүнд дарамт дор ажилладаг. Тэд хэргийн менежментийн практик болон нөхцөл байдлаасаа болж стресст ордог. Биднийг дэмжих сэтгэл зүйч байхгүй. КОВИД-19 цар тахлын үед стрессээ хэрхэн удирдах талаар ямар нэгэн сургалт зохион байгуулагдаагүй. 108 дугаарын шууд утсанд байнга дуудлага ирнэ. Хороо бүрт нэг л нийгмийн ажилтан ажилладаг. Бид ажил үүргийнхээ хүрээнд эргэлдэх, хорооныхоо хүүхдүүдийн талаар мэдээ тайлан бэлтгэх зэргээр ажилласаар хүмүүстэй харилцах бодит боломж олдоогүй. Сонгуулийн дараа дээд байгууллагаас тушаал гарч ажлын байранд өөрчлөлт орсон. Нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт ч өөрчлөгдсөн. Иймээс л хүмүүс байнга өөрчлөгдөж байдаг.

Цалин орлого ажилтнуудын тогтвор суурьшилд нөлөөлнө. Нийгмийн хамгаалал байхгүй, хийх ажил ч их байна. Гэнэтийн тогтоол, шийдвэрүүд байнга гардаг. Уялдаа зохицуулалт байхгүй. Хэдийгээр энэ ажилд ороод нэг жил болоогүй ч 6 сарын дотор шууд л мэдэрсэн. Миний ажлын гүйцэтгэлийг муу биш гэж үнэлдэг. Хамгийн том асуудал миний орлого. Миний цалин зээлэнд маань л таарна. Би сард 580 мянган төгрөгийн цалин авч, өглөө 8-17 цаг хүртэл ажилладаг. Бид тэр бүр 17 цагтаа тарж гэртээ харьдаггүй, зарим тохиолдолд 22 цаг хүртэл, өдөрт дунджаар 10 цаг ажилладаг. Би гэр бүл, үр хүүхдээ ардаа орхисон ажлаа хурдан дуусгахыг л хичээдэг. Хэрэв өөр газар судлаачийн орон тоо олдвол би явж магадгүй.

Би энэ хороонд нийгмийн ажилтнаар найман жил ажиллаж байна. Хорооны нийгмийн ажилтан Гэр бүлийн хөгжлийн газарт бус Нийгмийн хөгжлийн хэлтэст харьяалагддаг. Гэхдээ хуулийн дагуу бид олон салбарыг хамарсан хамтарсан багийн нэг хэсэг болж ажиллах ёстой. Дээд байгууллагуудаас ирж байгаа тушаал шийдвэр, бичиг баримтаар өгсөн үүргийг биелүүлэх гэсээр өөрийнхөө өмнөх ажил үүрэг даалгаврыг гүйцээж чаддаггүй. Үүнтэй холбоотойгоор гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, гэмт хэрэгт холбогдсон эмзэг бүлгийн хүүхдүүдтэй харилцах, хэрэг хянан шийдвэрлэх ажил сайн биш, үйлчилгээ тааруу байгаа. Хэргийг бүртгэж байгаа боловч хариу шийдвэр гардаггүй. Хотын захын дүүрэгтэй харьцуулахад төвийн дүүргүүд харьцангуй гайгүй байж болох юм. Уг нь зүгээр л хэрэг нээхэд дараагийнх нь гараад ирнэ тэгээд өмнөх нь нээлттэй үлдэнэ. Зарим тохиолдлыг яаралтай шийдвэрлэх санаатай гүйсээр байгаад шөнийн 1-2 цагийн үед гэртээ харих бол хэвийн үзэгдэл. Ер нь 17.00 цаг гэхэд гэртээ харьдаг онцгой хүн байхгүй дээ.

Кейс 15.

Сургуулийн нийгмийн ажилтан нь захиргааны ажил хийх, судалгаа хийх, янз бүрийн сургалт семинарт оролцох үүрэгтэй. Энэ хооронд гэмт хэрэг үйлдэгдэнэ. Бидэнд илүү олон нийгмийн ажилтан хэрэгтэй байна. Энэ асуудлыг шийдэхгүй бол ямар ч шийдэлд хүрэхгүй.

(ГБХЗГ, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Насанд хүрээгүй хүнтэй холбоотой гэмт хэргийн мөрдөн байцаалтыг заавал өмгөөлөгчтэй явуулах тухай заалттай. Харин хүүхдүүдийн үйлдсэн, холбогдсон гэмт хэрэг ихэвчлэн шөнийн цагаар үйлдэгддэг. Өмгөөлөгчдийн тоо хязгаарлагдмал байдаг тул шөнө дундын цагаар өмгөөлөгч хайх нь хамгийн хэцүү ажил гэдгийг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон мөрдөн байцаагчид онцолж байв.

ФОКУС БҮЛЭГ: 2. ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ: ХҮҮХЭД, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУД

1

ДЭД БҮЛГҮҮД,
ТЭДГЭЭРИЙН ШИНЖ
БАЙДАЛ

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд (10-16 насны)
- Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд
- Хөгжлийн бэрхшээлтэй хөдөө орон нутгийн хүүхдүүд
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчид

2

ОРХИГДОХ
ЭРСДЭЛТЭЙ ДЭД
БҮЛГҮҮД

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд /сургуульд сурч байгаа/
- Алслагдсан сумын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд
- Байнгын халамж асаргаа шаардлагатай хөгжлийн хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүд
- Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд

3

ЯЛГАВАРЛАГДАХ
ХЭЛБЭРҮҮД
(ОРХИГДОХ/
ЯЛГАВАРЛАГДАХАД
ХҮРГЭЖ БУЙ ЯМАР
ШАЛТГААНУУД
БАЙНА ВЭ? ҮНДСЭН
ШАЛТГААН НЬ ЮУ
ВЭ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүмүүсийг олон нийт, үе тэнгийнхэн нь хүндлэхгүй, ойлгохгүй байх, нийгмийн сөрөг хандлага, ялгаварлан гадуурхал зэрэг нь тэдний сургуульд сурах хүсэл тэмүүллийг няцаах гол шалтгаан болж байна.

Кейс 1. Найзууд маань надтай хамт явахаас ичдэг, ангийнхан маань миний асуултанд огт хариулдаггүй.

Би ердөө хоёрхон найзтай байсан. Өсөх тусам би бүр муу алхаж гишгэх минь улам муудаж байна. Найзууд маань ч холбоо тасарч байна (эхэр татан уйлав). Бид гурав хөл хорио тавигдсаны дараа уулзсан. Хэдийгээр ялгаварлан гадуурхалтын сэдвээр хичээл ордог ч үеийнхэн маань аажмаар надтай тэд холбоо барих нь ховордсон. Би хэзээ ч сэтгэл зүйч дээр очиж үзээгүй. Надтай бусад маань хэрхэн өөрөөр харьцаж байгааг багш маань мэддэг ч тэр надтай хэзээ ч уулздаггүй. Нийгмийн ажилтанд яаж хандахаа мэдэхгүй байна. Би том болохоороо сэтгэл зүйч болно. Ээж намайг эмчийн буруугаас болж хөгжлийн бэрхшээлтэй болсон гэж хэлсэн (дахин уйлав). Манай ангийн хэн ч надтай ярьдаггүй. Групп чатаар хичээлтэй холбоотой асуултууд илгээхээр хэн ч надад хариулдаггүй. Би эцэг эхийнхээ санааг зовохгүйн тулд асуудлаа ярьдаггүй. Бага сургуульд байхад гайгүй байсан, одоо бол үнэхээр хэцүү санагдаж байна (уйлав).

(Хөдөлгөөний бэрхшээлтэй 6 настай охин, Баянхонгор аймаг)

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн сургалтын орчин бүрдээгүй, цар тахлын үед сургуулиуд цахимаар хичээлээ явуулсан боловч хөдөө орон нутгийн болон орлого багатай, сургуулийн насны хүүхэдтэй ядуу айл өрхүүдэд боломж нөхцөл хомс учир хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үнэндээ хаягдсан. Үнэн хэрэгтээ энэ нь тэдний хичээлээс хоцрох, завсарлага авах, сургуулиас гарах гол шалтгаан болж байна.

Зарим хувийн хэвшлийнхний санаачлага, олон улсын байгууллагуудын төслийн дэмжлэгтэйгээр хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмшүүлэх, сургах ажлыг эхлүүлж байгаа нь сайшаалтай. Гэвч анги танхим, багшлах боловсон хүчин хүрэлцэхгүйн улмаас сургуулийн хүүхдүүдийг нас, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг нь харгалзалгүйгээр бага, дунд ангийн хүүхэд гэж хуваагаад зөвхөн бүлгээр зохион байгуулан хичээллүүлж байна. Энэ нь эзэмшвэл зохих боловсролын түвшин, сургалтын тогтолцооны стандарт шаардлага (ялангуяа сургалтын хөтөлбөрийн агуулга, эзэмших мэдлэг, ур чадвар), тусгай хэрэгцээт боловсролд тавигдах наад захын шаардлага зэрэг нь огт хангагдахгүй байгааг харуулж байна.

Кейс 2. Тэд сургалтад хамрагдсан ч эзэмшвэл зохих боловсролын түвшингээс хол хоцорч байна.

Манай ангийнхан хөгжим, дуу зэрэг хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцдог, би хөгжим тоглох дуртай, гэхдээ гэртээ тоглодог. Намайг волейбол сонирхож эхлэх үед багш нар маань намайг хөлөө улам муутгаж, бэртэнэ гээд санаа нь зовж байсан. Гэхдээ тэд миний сонирхлыг хэзээ ч дэмждэггүй. Би онлайн байхыг илүүд үздэг. Цаг зав гарах л юм бол би өөрийнхөө сонирхолд цагаа зарцуулдаг. Компьютер дээр цахим хичээл хийх нь илүү хялбар байдаг ч эгч компьютерээ аваад явчихсан. Заримдаа сүлжээ доголдох юмуу интернетийн хугацаа дуусчихдаг.

Би олон хүүхдийн дунд байгаа болохоор энд суралцах үнэхээр сайхан байна. Гэхдээ ном байхгүй. Мөн хүүхдэд зориулсан таяг байхгүй.

Би хуруугаараа мэдэрдэг ном уншиж сураагүй. Би брайл үсэг уншиж чадахгүй. Хотын 116-р сургуульд байхад биеийн тамирын хичээл орж байсан. Дотуур байранд байхад хүүхдүүд намайг дээрэлхдэг байсан. Би харж чадахгүй ч тавиураа шидчихсэн чинь яв, тавиураа өөрөө олж ав гээд л, байнга шоолуулж байсан. Ээж багшид хэлдэг байсан. Тэгээд би энд буцаж ирсэн. Би тийшээ дахиж хэзээ ч очихгүй. Манай ангид математик, англи хэлний хичээлүүд ордог. Би эдгээр хичээлүүдэд дуртай.

(Албан бус сургалтад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

Хөдөөгийн сумдын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд үе тэнгийнхний зүгээс үзүүлэх ялгаварлан гадуурхах явдал хүүхдүүд томрох тусам нэмэгдэж байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд онцолж байлаа. Харамсалтай нь, ангийн багш, нийгмийн ажилтан нь үл тоомсорлож, тэдэнтэй ойр дотно харьцах дургүй байдаг тухай Фокус бүлгийн ярилцлагад оролцсон эцэг эх, асран хамгаалагчид шүүмжилж байсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрх нь хөдөө орон нутагт бүрэн зөрчигдөж, боломж нь тун хязгаарлагдмал байна. Эцэг эхчүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургах ёстой гэж сайн ойлгож байгаа боловч хөдөө орон нутагт тусгай сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ муу ийм боломж зөвхөн Улаанбаатар хотод л байна. Хөдөө орон нутгийн эцэг эхчүүдэд хүүхдээ хотод дотуур байранд байлгах, аль эсвэл ах дүү хамаатан садныдаа байлгах гэсэн хоёрхон сонголт байна.

Хөдөөгийн зарим эцэг эх, асран хамгаалагчдын дунд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хөдөө гарч, мал маллаж амьдрахаас өөр аргагүй гэсэн хэвшмэл ойлголт нийгэмд бий болсон нь тун харамсалтай.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, гол тэжээгч нь хөдөлмөр эрхэлдэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ ах, эгчийнх нь асрамж, халамжид үлдээж, тэдний цаг зав, суралцах боломжийг хязгаарлаж, хичээлээс нь хоцроож байгаа тухай Фокус бүлгийн ярилцлагад оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хоёр ихэр хүүхэдтэй ээж өгүүлж байв.

Тусгай хэрэгцээт хүүхэдтэй хосуудын гэр бүл салалт өндөр байгааг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эхчүүд онцолж байна. Ихэнхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэйгээ ээжүүд үлдэж эцгүүд нь үүрэг хариуцлагаа үл тоомсорлож, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлдэггүй тохиолдол олон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн аль нэг нь ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй гэртээ хүүхдээ асран хамгаалах шаардлагатай болдог. Гажигтай хүүхэд төрүүлсэн гэсэн шалтгаанаар эмэгтэйчүүд халдлагад өртөж, гадуурхагдаж, бие, сэтгэл санааны дарамтад өртөж байгаагаас гэр бүлийн амьжиргаа эрс доройтож байгаа нь гэр бүл салалтын бас нэг гол шалтгаан болохыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эхчүүд онцолж байна. Үүний уршгаар элэг бүтэн гэр бүлд амьдарч байсан эрүүл хүүхдүүд ганц бие эцэг, эхтэй болж хохирч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг голдуу эмээ нарынх нь анхаарал халамжид үлдээдэг хэдий ч асран хамгаалагчийн мөнгийг нь эхчүүд өөрсдөө авдаг болох нь Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын шинж байдлаас ажиглагдаж байна. Энэ нь нэг талаас ахмад настнуудад давхар ачаалал өгөөд зогсохгүй нөгөө талаас хүүхдүүдэд тавих анхаарал халамж сул болох, тусгаарлагдах зэрэг сөрөг үр дагаварт хүргэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд халамж үйлчилгээ үзүүлдэг хүмүүс болон асран хамгаалагчдынх нь хамгийн их хүсдэг зүйл бол энэ ажлаасаа хэд хоног чөлөөлөгдөх аж. Үүнээс тэд цаг наргүй ажиллаж, хэр их цаг хугацаа, зүтгэл гаргадаг, өдөр тутам ямар их дарамттай тулгардаг нь тодорхой харагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өсч томрох тусам тавих халамж анхаарал нь үлэмж нэмэгдэж байхад эсрэгээрээр хүүхэд томрох тусам асран хамгаалагчдад олгодог мөнгө эрс багасч байгааг тэд хатуу шүүмжилж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бага насандаа болон шилжилтийн үедээ янз бүрийн сорилттой тулгардаг бөгөөд тэдгээрийг даван туулахад сэтгэл зүйн болоод нөхөн үржихүйн эрүүл мэндийн (ялангуяа хөвгүүд, залуучууд) ихээхэн дэмжлэг шаардлагатай байдгийг эцэг, эхчүүд онцолж байв. Харамсалтай нь энэ чиглэлээр тэдэнд үзүүлэх зөвлөх үйлчилгээ байхгүй байна.

Кейс 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн бэлгийн бойжилтын талаар эрүүл мэндийн зөвлөгөө авах боломж байхгүй байна.

Миний хүү багадаа гайгүй байсан. Өсч том болох тусам хүүгийн маань нөхөн үржихүйн хөгжил үргэлжилж байна. Би аль болох хамт байхыг хичээдэг. Янз бүрийн асуудалд орчихвий, хүчингийн хэрэгт орооцолдох вий гэж айж байна. Эхнэр маань эрт өөд болсон болохоор энэ хүүгээ төрснөөс хойш найз нөхөдтэйгээ уулзах, гадуур явах эрхгүй болж би өөрийгөө бүрэн золиосолсон.

Манай гудамжинд 20 гаруй насны оюуны хомсдолтой залуу байдаг. Заримдаа тэр бүх хувцсаа тайлаад гудамжинд нүцгэн зогсоход хүмүүс айж эмээж, ээжийг нь бүх зүйлд буруутгаж, хүүгээ зайлуулахыг шаарддаг. Энэ ээжид яг юу гэж зөвлөхөө мэдэхгүй байна. Хүү маань хүртэл эпилепси өвчнөөр ухаан алдаж гудамжны буланд 2-3 цаг хэвтэж байхад би бас тийм дарамтад орж байсан. Архичин байна гээд хүмүүс тоохгүй байсан аж. Аз болж жаахан хүүхдүүд гүйж ирж надад хэлсэн юм.

(Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд, асран хамгаалагч нартай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

4

**ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАЛТЫН
ЯМАР ХЭЛБЭРҮҮД
БАЙНА ВЭ?**

**Ялгаварлан
гадуурхал (өөрийнх
нь болон өөрийг
нь илэрхийлж буй
ондоошил буюу
шинж байдал)**

Хөгжлийн бэрхшээлтэй, алхаж чаддаггүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүд эдгээр бэрхшээлээс болж үе тэнгийнхэндээ нь гадуурхагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон хөгжлийн бэрхшээлтэй асран хамгаалагчдыг ажилгүй, гэртээ юу ч хийлгүй суудаг, зүгээр л халамжлуулагчид хэмээн буруутган гадуурхах хандлага нийгмийн харилцаанд, ялангуяа төрийн албан хаагчидтай харилцахад түгээмэл ажиглагдаж байна. Тэдний үйлчилгээнд илт дургүйцэл илэрч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төв, сургагч багш нарын эмчилгээ сувилгааны чанар сул, сэтгэлгээ тааруугаас гадна сургалтын орчин, нөхцөл бүрдээгүй байна.

Эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтнууд, өсвөр үеийнхний санаачлага, идэвхтэй оролцоо дутагдаж байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн талаарх үе тэнгийнхнийх нь мэдлэг ойлголт дутмаг, сургалт, хүмүүжил, нийгмийн үйл ажиллагаа орхигдож байна.

Кейс 4.

Бид хүүхдүүдээ дагуулаад явахдаа ялгаварлан гадуурхалтын том дарамт мэдэрдэг. Хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүд дэлгүүрээр явж байхад тоомжиргүй хандах, юм ярихгүй байгааг нь буруутгах хандлага тохиолдоно. Иймээс тэднийг байнга дагуулж явах хэцүү ч, гэрт хүнгүй үед орхих бүр хэцүү байдаг. Тэднийг дагуулж явахад гудамжинд хүмүүс үргэлж эргэж харах, зайгаа барих нь ч бий.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асрах тэтгэмж маш бага, ялангуяа оюуны бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатай хүүхэдтэй тохиолдолд цалинтай ажил хийх боломж байдаггүй. Хүүхэддээ эм тариа авах мөнгө хуримтлуулж чадаагүй учир хүмүүс хот руу явахыг л зөвлөж байгаа. Нийгмийн халамжийн ажилтнуудын хэлж байгаагаар авах боломжтой бүх халамжийн мөнгөө авчихсан учраас гадуурхагдаад байгаа.

(Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд, асран хамгаалагч нартай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

Засаглал (Хүний эрхэд суурилан хөгжих хандлагын хүрээнд тулгарч буй чадавхын бэрхшээл, хууль тогтоомж, бодлого, татвар, төсөв, хуваарилалтын нөлөөлөл, засгийн газрын шийдвэр гаргах явцад оролцох чадвар гэх зэрэг нөлөөллийг харгалзан үзэх)

Хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, хүмүүст зориулсан нийгмийн хөтөлбөрүүд хязгаарлагдмал, тэднийг хөгжүүлэх материал, ном, бусад хэрэглэгдэхүүн хүрэлцээгүйгээс тэдний сурч боловсрох эрх нь зөрчигдөж байна.

Хөдөөгийн сумдад онлайнээр суралцах нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулан сургах боломж юм шиг харагдаж байна. Гэвч өрх бүр, өрхийн хүүхэд бүр интернэтийн нэгж, компьютер, ухаалаг утас ашиглах боломжгүй. Ялангуяа цар тахлын ийм эгзэгтэй үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрх бүрэн хязгаарлагдсан.

Өнөөгийн тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хэвээр байгааг нотлох баримт болгон жил бүр Улаанбаатар хотод эрүүл мэндийн үзлэгт оруулахыг шаардаж байна. Энэ нь бага орлоготой гэр бүлүүдэд санхүүгийн болон цаг хугацаа, сэтгэл санааны дарамт шахалт үзүүлж байна хэмээн эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хатуу шүүмжилж байсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ авахад хамгийн их саад тээг болж байгаа зүйл бол нийслэлд эмчилгээ, оношилгооны цаг авах явдал гэдгийг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон эцэг эхчүүд онцолж байсан. Харамсалтай нь бүх шинжилгээг нэг дор авах боломжгүй (наад зах нь 10 хоногоос 2 сарын хугацаа шаардагдана), санхүүгийн ихээхэн зардалтай, очих хонох газаргүй, хамаатнууд дээрээ очсон ч удаан хугацаагаар байх боломжгүй.

Кейс 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эмчийн үзлэг их үнэтэй.

Би хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүүхэдтэй. Хөгжлийн бэрхшээлийн тэтгэмжийг сунгахын тулд бид хот орж зүрхний цахилгаан бичлэг хийлгэх шаардлагатай. Манай хүүхэд өнгөрсөн жил хагалгаанд орох ёстой байсан. Гэтэл КОВИД-19 цар тахлаас болоод чадаагүй. Бид түүний хагалгаанд шаардлагатай чөмөгний захиалга өгчихөөд 6-р сарын 9-нд хот руу явсан, хагалгаа 6-р сарын 12-ны өдөр товлогдсон байсан. Давтан үзлэгийн цаг 7-р сарын 20-ноос нааш байхгүй байсан. Эх хүүхдийн эрүүл мэндийн төвд нүдний шил солихоо больчихсон байсан. Харин 260,000 төгрөг төлж хувийн нүдний эмчид очих хэрэгтэй болсон. Бид санхүүгийн бүх асуудлаа зохицуулаад 8-р сарын 9-нд буцаж ирсэн. Хотод 2 сар шахам байх хугацаандаа нийт 7 сая төгрөгийг банкны таван хувийн хүүтэй зээл авч шийдвэрлэсэн. Хөгжлийн бэрхшээлийн тэтгэмжийн данс нь зээлийн үйлчилгээний банкны данстай холбоотой байгаа. Хүүхдийн мөнгө, миний таксины үйлчилгээнээс олсон орлого нийлээд хоёр сая төгрөг болсон. Банкнаас таван сая төгрөгийн зээл авсан. Бид хотод нэг айлд амьдардаг байсан. Эх хүүхдийн эрүүл мэндийн төв рүү талдаа 14,000 төгрөг төлдөг. Ганцаараа бол автобусанд суучихна, хүүхэдтэйгээ явбал такси авдаг байсан. Бидний амьдарч байсан айл ганц бие эгчийнх маань байсан бөгөөд сүүлдээ биднийг хэтэрхий шуугиж байна хэмээн зэмлэх болсон. Бид гэртээ ирээд эмнэлгийн бүртгэл дэвтэрээ үзсэн чинь эмнэлэгийн бичлэг бүрэн хийгдээгүй байгааг олж мэдсэн. Есдүгээр сард хөгжлийн бэрхшээлийн тэтгэмжийг сунгахад эмнэлгийн энэ дэвтэр маш чухал шүү дээ. Бид үнэхээр бухимдаж байна.

(Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд, асран хамгаалагч нартай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

Дээр дурдсан хэд хэдэн шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ялангуяа хөдөөгийн сумдын эцэг эхчүүд хүүхдүүдээ ялгаварлан гадуурхалаас зайлуулахын тулд шууд мал дээр гаргахыг илүүд үзэж байна. Нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ нийгмийн болоод хүмүүжлийн асуудалд ихээхэн санаа зовдог орон нутгийн зарим эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдүүдээ тусгай сургуульд сургадаг ч суурь хичээлүүд чанаргүй, багш нарын хандлага, сурган хүмүүжүүлэх чадвар сул, мөн дотуур байранд хүчирхийлэл, дээрэлхэл их байгаад ихээхэн шүүмжлэлтэй хандаж байна.

Нийгэм-эдийн засгийн байдал (эмэгтэй, эрэгтэй хүмүүс, хүүхдийн олон шалтгаант ядуурлын байдал)

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал болж хэн нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран халамжлах шаардлагатай болдог. Иймээс ихэвчлэн эмэгтэйчүүд ажил хийхээ хойш тавьж байна. Орлого олдог нэг хүн нь хасагдсанаар тухайн өрхийн орлого эрс буурч, амьжиргааны түвшин нь доройтож ядууралд өртөх эрсдэлтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эмнэлгэд байнга хандаж байдаг бөгөөд эмийн хэрэгцээ нь өндөр, гэтэл нийгмийн халамжийн тэтгэмжийн хэмжээ маш бага байна. Иймээс эрүүл мэндийн зардлаас үүдэлтэй ядуурлын эрсдэл энэ бүлэгт хамгийн өндөр байна.

Цар тахлын нөхцөл байдлын улмаас бүх шатны боловсролын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн. Гэсэн хэдий ч цахим сургалтанд интернет холболт, дата багц, компьютер, ухаалаг утас ашиглах гээд олон төрлийн нэмэлт хэрэглэгдэхүүн шаардлагатай байдаг. Харамсалтай нь, ийм нөхцөлийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, сургуулийн насны олон хүүхэдтэй, санхүүгийн боломж муутай, орлого багатай өрхүүд, хөдөөгийн, алслагдсан хот суурин газрын өрхүүд хангаж чадахгүй орхигдож байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн унааны мөнгөний тэтгэмж хасагдсан нь тэдэнд эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөргөөр нөлөөлж байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид онцолж байна.

Газарзүйн байршил (байгаль орчны доройтол, тээвэр, технологи зэрэг байршлаас шалтгаалсан алслагдмал байдал, эрсдэл, орхигдол)

Алслагдсан хөдөө орон нутагт амьдарч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн халамжийн үйлчилгээг авах боломж буурах нэг гол шалтгаан болж байна. Ялангуяа бүх шатны сургалтад хамрагдах, тэдгээрийн ашиг тусыг хүртэх боломж хязгаарлагдмал хэвээр байна.

Орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, суралцах орчин, нийгэм хамт олонтой хамтран ажиллах, тэднийг дэмжих таатай орчин үгүйлэгдэж байна.

Эмзэг байдал, хямрал (байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшиг, хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, эдийн засгийн болон бусад хямралд өртөмтгий нутаг дэвсгэр, хүн ам)

Өсвөр насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эсрэг үе тэнгийнхний дарамт шахалт, ялгаварлан гадуурхалт нь өсвөр насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж байна. Үүнээс болж тэд нийгмээс шахагдах, сургуулиа орхих, тусгаарлагдах, өөртөө итгэх итгэлээ алдах, амиа хорлох хүртэл эрсдэлд өртөж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй залуу эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар мэдлэггүй, үйлчилгээний хүртээмж хангалтгүй зэрэг хүчирхийллийн хэлбэрт байнга өртөж, бусдын шийдвэрийг шууд дагаж мөрдөж, сэтгэл зүйн дарамт шахалтад орж байна.

Кейс 6. Миний анхаарал болгоомжгүй байдал, охины минь нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг дутмаг зэргээс болж хөгжлийн бэрхшээлтэй охин маань жирэмсэн болсон.

Охин маань Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвд сургалтанд хамрагдаж байх хугацаандаа өөрөөсөө 18 насаар ах залуутай танилцаад жирэмсэн болсон (охин маань 18 настай, залуу 36 настай). Хоёулаа 50 хувийн оюуны хомсдолтой. Тэд хамтдаа амьдрахаа больсон. Бэлгийн бойжилтын улмаас сэтгэл нь хөдөлж, мэдрэмж төрдөг байх л даа. Магадгүй тэр залуу ч ижил бэлгийн дур хүсэл, мэдрэмжтэй байсан байх. Би охиноо юм сургах гэж л тэр сургалтанд явуулсан. Үр дүн нь энэ. Тэр цагаас хойш би охиноо асарч байгаа. Одоо би насан туршдаа түүний хүүхдийг харах үүрэгтэй. Би охиндоо ингээд тэвэр гээд л заана, сурдаггүй. Энэ л толгойны өвчин болоод байна.

(Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд, асран хамгаалагч нартай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

Ялгаварлагдах буюу орхигдоход хүргэж буй ямар хүчин зүйлс, илрэлүүд байна вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй өсвөр насныхан, залуучуудад чиглэсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх зөвлөх үйлчилгээ маш хязгаарлагдмал байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай хөтөлбөр хүртээмж муутай, аль эсвэл огт байдаггүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд байдаг ч зорилтот бүлэг, хүмүүстээ хүрч чаддаггүй. Тийм чадавч ч байхгүй. Ийм чадавч олон улсын төслүүдэд байдаг боловч үр нөлөө, хүртээмж нь хязгаарлагдмал байдаг.

Хэдийгээр асаргаа сувилгааны тэтгэмж байдаг ч хэмжээ нь бага. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд насанд хүрмэгц хөгжлийн бэрхшээлийн төрлөөс нь үл хамааран тэтгэмж нь мэдэгдэхүйц буурдаг. Гэхдээ томрох тусам тэдэнд илүү их анхаарал халамж хэрэгтэй болдог.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, асран хамгаалагчдад зориулсан сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх тусгай үйлчилгээ байхгүй, тэдний хэрэгцээнд тохирсон нөхцөлтэй ажлын байр, хөдөлмөр эрхлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

5

ЭНЭ БҮЛГИЙГ
ДЭМЖИХИЙН
ТУЛД ЭРХ
ЭДЛЭГЧИД, ҮҮРЭГ
ХҮЛЭЭГЧДИЙН
ЗҮГЭЭС ЯМАР
АРГА ХЭМЖЭЭ,
САНААЧЛАГА ГАРГАЖ
БОЛОХ ВЭ?

Хөгжийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний асран хамгаалагчдад хувийн бизнес, гар урлалын чиглэлээр хөдөлмөр эрхлэх хүсэл, хэрэгцээ их байдаг. Гэвч төрөөс үзүүлж буй тэтгэмжийн хэмжээ бага учир эм тариа, хоол хүнсээ бүрэн авч чадахгүй, бизнес эхлүүлэх гарааны хөрөнгө, санхүү байхгүй байна. Энэ бүлгийн хүмүүсийг тендер, уралдаан тэмцээнд оролцуулан дэмжин ажиллаж байгаа нь тэд жирийн хүмүүстэй адилхан ур чадвар, боломжтой хэмээн үнэлэгдэж байгаагийн хамгийн тод илрэл юм. Гэсэн хэдий ч тусгай хэрэгцээтэй хүмүүст арай өөрөөр хандаж, тэдний амьдралаа сайжруулах хүсэл эрмэлзэл бүрийг нь ойлгосон шууд дэмжлэг хэрэгтэй байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид онцолж байв.

Хуулийн зарим заалтын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлдэг ч энэ нь ажил олгогчдод төдийлөн нөлөөлөхгүй байна. Энэ нь ажил олгогчдод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллахаас илүү татвар, хураамж төлөхөд хялбар байгаатай шууд холбоотой. Иймээс ажил олгогчдод нийгмийн хариуцлага ухамсарын үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн амьдралд оролцуулж, дэмжих нь чухал гэдгийг ойлгуулах явдал тун чухал байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний асран хамгаалагчдыг дэмжихэд чиглэсэн төслүүдэд зорилтот бүлгийг нийгмийн нэн даруй оролцох боломжийг олгох шаардлагатай байна.

Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж байгаа багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн цалин хөлсний үнэлэмжийг судалж сайжруулах хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт хүүхдүүдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх замаар дэмжих орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

ФОКУС БҮЛЭГ: 3. ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ: ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ (ЖСХ), ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ (ГБХ)-ИЙН ХОХИРОГЧИД

1

ДЭД БҮЛГҮҮД,
ТЭДГЭЭРИЙН ШИНЖ
БАЙДАЛ

- Өсвөр насны охид
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс
- ЛГБТИ хүмүүс
- Ажилгүйчүүд, санхүүгийн хувьд хараат эмэгтэйчүүд

2

ОРХИГДОХ
ЭРСДЭЛТЭЙ ДЭД
БҮЛГҮҮД

- Охид
- Өсвөр насны жирэмсэн охид
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс
- ЛГБТИ хүмүүс

3

ЯЛГАВАРЛАГДАХ ХЭЛБЭРҮҮД (ОРХИГДОХ/ ЯЛГАВАРЛАГДАХАД ХҮРГЭЖ БУЙ ЯМАР ШАЛТГААНУУД БАЙНА ВЭ? ҮНДСЭН ШАЛТГААН НЬ ЮУ ВЭ?

Гол төлөв эцэг эх, гэр бүлийн гишүүд, ялангуяа ойр дотны хүмүүсийнх нь хайр халамж, хараа хяналт дутагдсанаас охид гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байна. Хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон өсвөр насны охидтой хийсэн ярилцлагаас үзэхэд эцэг, эх нь архи хэтрүүлэн хэрэглэдэг орчинд өссөн охид хойд эцэг, хүргэн ах, танил талынхаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байжээ.

Ярилцлагад оролцогчид 108 руу залгах, цагдаад мэдэгдэх, эцэг эхдээ мэдэгдэх, ангийн багш, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй холбогдох зэрэг боломж байгааг мэдэж байсан. Гэвч ээж, ар гэрийнхнээсээ эмээх, мэдээлэл задрахаас айх, ичиж зовох зэргээс болж дээр дурдсан хувилбаруудад хандаж тусламж, дэмжлэг авахгүй байх нь нийтлэг байна. Энэ нь асуудлыг нуун дарагдуулж, улам хурцатгахад хүргэж байна.

Эмэгтэйчүүдийг нөхөр, хамтран амьдрагч, хадам эцэг эх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрүүллээ хэмээн гэрээсээ хөөх, хүүхэдтэй нь хэрцгий харьцах, уур хилэнгээ гаргах, нийгмээс гадуурхах зэргээр доромжлох нь цөөнгүй бөгөөд үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, асрах үүрэг нь зөвхөн эхчүүдэд ирдэг хэмээн гэр бүлийн хүчирхийлэл, дарамтад өртөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэйгээ хамгаалах байранд түр байрлаж байгаа ээж хэлж байв. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас ахих тусам ийм хүчирхийлэлд илүү өртдөг гэдгийг ч тэрээр онцолсон юм.

Бэлгийн цөөнхийн эрхийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа нь нийгэмд сөрөг хандлага нэмэгдэхийн суурь үндэс болж, тэднийг доромжлох, ажлаас халах, хөөж туух зэрэг бэлгийн цөөнхийн эрхийг ноцтой зөрчсөн үйлдлүүд буурахгүй байна.

ЖСХ/ГБХ үйлдэгч этгээдийг цагдан хорьсон тул шүүхэд гаргасан нэхэмжлэлээ буцааж татан авахыг шаардаж, ял зэм авахгүй, шийтгүүлэхгүй байхын төлөө тэрээр айлган сүрдүүлж байсан тухай өөрийн жишээнд тулгуурлан Фокус бүлгийн ярилцлагад оролцсон хохирогч эмэгтэй ярьж байсан.

4

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫН ЯМАР ХЭЛБЭРҮҮД БАЙНА ВЭ?

Ялгаварлан гадуурхал (өөрийнх нь болон өөрийг нь илэрхийлж буй ондоошил буюу шинж байдал)

Хохирогч охидын хэлснээр ЖСХ/ГБХ-д өртсөн хүүхдүүд өөртөө итгэх итгэлээ алдаж, нийгмийн харилцаанд оролцохоос зайлсхийж эхэлдэг бөгөөд бусад хүмүүс хэргийн талаар мэдсэнээр тэд гадуурхагдах, доромжлол, бэлгийн дарамтад өртөх эрсдэлд ордог хэмээн хохирогч охид ярьж байлаа. Ийм байдал нь зарим охид сургууль завсардах, амиа хорлохыг завдах, гэрээсээ зугтах, хэн нэгний халамжинд орж эрт гэрлэх, эрт жирэмслэх, биеэ үнэлэх зэрэгт хүргэж байна.

Кейс 1. Багш намайг зүгээр л зугт гэж хэлсэн.

Ээж үргэлж архи уудаг. Надад ярих хүн байхгүй. Нэг найз маань манай ангийнханд намайг бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухай ярьчихсан. Тэгээд хүүхдүүд намайг байнга доромжилж, дээрэлхдэг. Түүнээс хойш би найзгүй болсон. Сургуулийн бүх хүүхдүүд биднийг “бөөс” гэж доромжилдог. Сургуулийн багш, нийгмийн ажилтнууд биднийг дээрэлхэж байгааг мэдсэн ч хамгаалах арга хэмжээ авдаггүй. Би нэг удаа өмнөх багшдаа хэлсэн чинь битгий тоо гэж зөвлөсөн. Харин намайг тоохгүй байх тусам улам ихээр дээрэлхэх болсон. Багшийн хэлснээр бол би зугтах ёстой. Багш намайг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч рүү ч явуулаагүй.

(Хоёр удаа хүчирхийлэлд өртөж байсан 14 настай охин, Өсвөр насны охидтой хийсэн ярилцлагаас Улаанбаатар хот)

Кейс 2. Би юуны төлөө энэ хорвоод мэндэлсэн юм бол..

Хамаатан саднууд маань үргэлж намайг тарган, удаан гэж хэл амаар доромжилж, дээрэлхдэг байсан. Би итгэлээ ч алдсан. Би юуны төлөө энэ хорвоод мэндэлсэн юм бол, яагаад энэ хорвоод амьдарч байгаа юм бол гэж бодогддог.

(Бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан 17 настай охин, Өсвөр насны охидтой хийсэн ярилцлагаас Улаанбаатар хот)

Кейс 3. Гэрлэчихвэл аз жаргалтай амьдарна гэж бодсон маань алдаа болсон.

Нэг талаар нөхөртэй байх нь амар ч нөгөө талаар хэцүү. Би бүрэн дүүрэн сэтгэл хангалуун байж чадахгүй л байна. Би гэрлэвэл аз жаргалтай болно гэж бодож байсан чинь миний алдаа болсон. Нийгмийн ажилтан, эгч хоёртойгоо хамт сууж ярилцаад асуудлаа шийдсэн байсан бол илүү байсан байх.

(Хойт аавдаа хүчиндүүлж байсан 18 настай охин, нөхөр, 3 сартай хүүхэдтэйгээ амьдардаг, одоо жирэмсэн. Өсвөр насны охидтой хийсэн ярилцлагаас)

Бэлгийн цөөнхийн эсрэг ялгаварлан гадуурхах, шууд ажлаас халах, хөөж туух, гүтгэх, үзэн ядах зэрэг хүчирхийллийн хэлбэрүүд өргөн тархаж байна. Ганц хоёр төрийн бус байгууллага л төрийн үүргийг биелүүлэх үүрэгтэй бөгөөд тэд хөдөө орон нутгийн хүмүүст хүрч ажиллаж чадахгүй байна.

Засаглал (Хүний эрхэд суурилан хөгжих хандлагын хүрээнд тулгарч буй чадавхын бэрхшээл, хууль тогтоомж, бодлого, татвар, төсөв, хуваарилалтын нөлөөлөл, засгийн газрын шийдвэр гаргах үйл явцад оролцох чадвар гэх зэрэг нөлөөллийг харгалзах)

Түр хамгаалах байр, асрамжийн газарт байх хугацаа хязгаарлагдмал, цагдаагийн дэмжлэг үзүүлэх орчин, үйлчилгээний чанар тааруу, цагдаа нарын зан авир муу зэргээс шалтгаалан хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүд юуны түрүүнд найз нөхөд, хамаатныдаа очдог ч тэндээ удаан байх боломжгүй учир эргээд л гэр орондоо очихоос өөр аргагүй болдог.

Хохирогчид төрийн байгууллага гэхээсээ илүү төрийн бус байгууллагуудыг илүүд үзэж байгаа нь тэдгээрийн үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотойг илэрхийлж байна.

Кейс 4. Та баян тансаг амьдралтай байж яагаад хүүхдүүдээ зочид буудалд биш энд байлгаж байгаа юм бэ?

Би гурван хүүхэдтэйгээ цагдаагийн хамгаалах байранд (108-ын дуудлагаар) сар гаруй байсан. Тэнд байнга ирдэг болохоор ажилчид нь намайг мэднэ. Хамгаалах байрны хүн (эмэгтэй) миний хүүхдүүдийг “баян айлын хүүхдүүд” гэж хэл амаар доромжилж, намайг тансаг зочид буудалд очихын оронд энд юу хийж байгаа юм бэ гэж байнга буруутгадаг. Тэр үнэхээр муухай царайтай, бусдыг их муухай доромжилдог. Цагдаагийн хамгаалалттайгаар гадагшаа гарахдаа би хүүхдүүдээ тусгай хамгаалалттай машинд суулгаад авч явж байсан. Энэ нь надад огтхон ч таалагдаагүй. Харин ч үнэхээр аюулд орсныг маань ухааруулан улам бүр айлгаж байсан. Сарын дараа бид бараг л хөөгдсөн. Би хүчирхийлэгч нөхөр лүүгээ буцаж орж чадахгүй байсан тул байрныхаа үүдэнд хүүхдүүдтэйгээ зогсоод л байсан. Өвөл их хүйтэн байсан болохоор хүүхдүүдээ дааруулахгүйн тулд гэртээ орохоос өөр аргагүй болсон. Хэд хэдэн удаа надад хадам ээж, нөхрөө алах бодол орж ирж байсан. Цагдаагийн хамгаалалт гэхээс илүүтэй төрийн бус байгууллагын түр хамгаалах байранд байх нь хамаагүй дээр. Иймээс би энд ирсэн дээ.

(ГБХ-д байнга өртөж байсан хохирогч, 3 хүүхэдтэй, Улаанбаатар хот)

Багш, нийгмийн ажилтнуудын дэмжлэг туслалцаа бага, нууц задардагаас зарим хохирогчид илүү хүнд байдалд орох тохиолдол гарч байна. Сургуулийн нийгмийн ажилтан нь эрэгтэй учир хохирогч охид асуудлаа ярихаас эвгүйрхдэг, хорооны нийгмийн ажилтан эрэгтэй мөн л айлган сүрдүүлэх, эвгүй байдалд оруулах, гүтгэх, бэлгийн дарамт үзүүлэхийг оролдох зэргээр төвөгтэй байдалд оруулж байсныг өсвөр насныхантай хийсэн Фокус бүлгийн ярилцлагад оролцсон охид ярьж байсан.

Кейс 5. Нийгмийн ажилтан яагаад надад ингэж ханддаг юм бол...

Би 15 настайдаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн. Хүчирхийлэгч нь миний эгчийн найз залуу байсан. Тухайн үед би эмэгтэйчүүдийн үзлэгт орохоос айдаг байсан. Би сургуулиа төгсөөд мэргэжилтэй болно л гэж боддог байсан. Үнэндээ би 9-р ангиа ч төгсөж чадаагүй. Хорооны нийгмийн ажилтан залуу намайг сургуулиас гаргасан. Түүний худал яриа намайг амьдралын сонирхолгүй болгосон. Нийгмийн ажилтан надад яагаад тэгж хандсаныг ойлгодоггүй, багшид намайг өөр сайн сургуульд оруулсан гэж худлаа хэлсэн байсан. Тэр намайг янз бүрийн сургалтад хамруулах гэж их оролдсон боловч чадахгүй болохоороо сүүлдээ намайг барьж дийлэхгүй байна, архи дарс их уудаг гэж эгчид худлаа хэлсэн байна лээ. Сургуулиа үргэлжлүүлээд есдүгээр ангиа төгссөн бол байдал арай өөр байх байсан. Яаж ийгээд сургуульдаа ороод 9-р ангиа төгсчихвөл зүгээр юм шиг санагддаг.

(18 настай, 1 хүүхэдтэй, жирэмсэн, Өсвөр насны охидтой хийсэн ярилцлагаас, Улаанбаатар хот)

ЖСХ/ГБХ-ээс урьдчилан сэргийлэх сургалт ховор (жилд 1-2 удаа) зохион байгуулагддаг бөгөөд эдгээр сургалт нь хүүхдүүдийн нас, хүйсний онцлогт тохирдоггүй (тэд ойлгодоггүй), сонирхол татахуйц хэлбэрээр зохион байгуулдаггүй учир сургуулийн сурагчдын оролцоо, ирц хангалтгүй (хүүхдүүд ийм сургалтаас зайлсхийдэг) байна.

Гэмт хэрэг үйлдэгчид, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид нэг удаагийн арга хэмжээ авсны дараа шууд суллагдаж байгаа болон зөвхөн нэг удаагийн дэмжлэг, үйлчилгээ нь хангалтгүй, дорвитой үр нөлөө үзүүлэхгүй байгаа учир хүчирхийлэл дахин давтагдаж байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон нийгмийн ажилтнууд нар ярьж байв.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох нь өрхийн орлогод сөргөөр нөлөөлж, хохирогчид санхүүгийн давхар дарамтад өртөж, торгууль төлж байгаа нь зөвхөн эмэгтэйчүүд/эхнэрүүд төдийгүй хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдэд нөлөөлж байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид шүүмжилж байна.

ЖСХ/ГБХ-ийн хохирогчийг хамгаалах үйлчилгээ үзүүлдэг цөөн тооны сэтгэл зүйч байдаг бөгөөд харамсалтай нь хохирогчийн нас, хүйсийн хэрэгцээнд нийцүүлэн тэдгээрийг сонгох боломжгүй байна. Жишээлбэл, 21-22 насны сэтгэл зүйчээс зөвлөгөө авахад сэтгэл зүйч, үйлчлүүлэгчийн аль алинд нь таагүй, тохиромжгүй гэдгийг Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид онцолж байсан.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидод сэтгэлзүйн зөвлөгөө, эмчилгээ шаардлагатай байхад зөвлөгөө авч буй охидыг илүү мэдэх гэж сэтгэл судлаачид тэдний өнгөрсөн үеийн аймшигтай хэцүү дурсамжийг нь сануулах асуулт асуудаг. Иймээс охид дахин зөвлөгөө авах, түүхээ дахин дахин хуваалцахыг хүсэхгүй, дургүй болж байна.

Нийгэм-эдийн засгийн байдал (эмэгтэй, эрэгтэй хүмүүс, хүүхдийн олон шалтгаант ядуурлын байдал)

ЖСХ/ГБХ-ийн хохирогчид болох эмэгтэйчүүд, охидын нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэг муу байна. Өсвөр насандаа жирэмсэн болсноор хүүхэд хүмүүжүүлэх ур чадвар байхгүй, мэдэхгүй, мөн өөрт тохиолдсон сэтгэл санааны шархаасаа болоод хүүхдүүдээ гадагш гаргадаггүй, аав болон эрэгтэй хүнд үлдээхээс айдаг хэмээн Фокус бүлгийн ярилцлагад оролцсон залуу ээж ярьж байв.

Кейс 6.

Хүүхдээ цэцэрлэгт оруулах хүртэл хичээл сургуулиа үргэлжлүүлж, ажил хайхад хэцүү байна. Уг нь би маш их төлөвлөж байсан ч дахиад жирэмсэн болсон. КОВИД-19 цар тахлын хөл хорионы үеэр өрхийн эмнэлгүүдэд жирэмслэхээс сэргийлэх хэрэгсэл олдоогүй, эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж чадаагүйн улмаас урьдчилан сэргийлж чадаагүй. Би одоогоор 4 сартай жирэмсэн. Охин маань 1 нас 2 сартай. Хоёр дахь удаагаа жирэмслээд нөхөртэйгөө ярилцаад хоёулаа үр хөндүүлэхээр болсон. Дээрээс нь эгч маань намайг нэг жил суралцаж мэргэжилтэй болохыг зөвлөсөн. Гэхдээ үр хөндүүлэх нь эрүүл мэндэд маань сөрөг үр дагавартай гэдгийг хадам ээжээсээ мэдээд би хүүхдээ төрүүлэхээр шийдсэн. Хадам ээж хааяа архи уудаг, согтуу байхдаа хүүхэд бэртээж, түлчих вий гэхээс их айдаг. Манай нөхөр ч муу хүн биш л дээ. Гэхдээ л охиноо түүнтэй үлдээхээс айж байна.

(18 настай, жирэмсэн, Өсвөр насны охидтой хийсэн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Газарзүйн байршил (байгаль орчны доройтол, тээвэр, технологи зэрэг байршлаас шалтгаалсан алслагдмал байдал, эрсдэл, орхигдол)

Хөдөө орон нутагт шинэ техник, технологи дутмаг байгаагаас эмч, эмнэлгийн ажилтнууд мэргэжлийн ур чадвараа байгаа газраа ахиулах боломж хязгаарлагдмал байна. Эх барихын асуудалд ихээхэн анхаарч байгаа хэдий ч эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээ сул байгаа талаар орон нутгийн эрүүл мэндийн ажилтнууд шүүмжлэлд өртөж байна. Иймээс хөдөөгийн охид, эмэгтэйчүүд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахаар хот сууринг зориход хүрч улмаар тэдний гэр бүл, эмэгтэйчүүдийн санхүүгийн эрсдэл буюу ачааллыг нэмэгдүүлж байна. Ялангуяа, хөдөө орон нутагт үргүйдлийг эмчлэх эмчилгээ болон төрсний дараах тусламж үйлчилгээ хомс бөгөөд чанаргүй, дээр нь эмч нар нь энэ чиглэлээр бэлтгэгдээгүй байна.

Хөдөө орон нутагт бэлгийн цөөнхийн эрхийг хамгаалах, тусламж үйлчилгээ үзүүлэх боломж байхгүй байна.

Эмзэг байдал,
хямрал (байгалийн
болон хүний
хүчин зүйлээс
үүдэлтэй гамшиг,
хүчирхийлэл, гэмт
хэрэг, зөрчил,
эдийн засгийн
болон бусад
хямралд өртөмтгий
нутаг дэвсгэр, хүн
ам)

ЖСХ/ГБХ-ийн хохирогч болсон өсвөр насны охидын ойр дотны найз нөхөд нь холдож, харилцаа холбоо нь тасарч байгаагаас тэдний нийгэмд эзлэх байр суурь өөрчлөгдөж, өөрийгөө үнэлэх үнэлэмж нь буурч, хүсэл зорилгод нь мэдэгдэхүйц өөрчлөлт ороход хүрч байна.

Кейс 7. Би хүмүүстэй харьцах дургүй учир мөрөөдлөө өөрчилж, технологийн мэргэжил сонгох бодолтой байгаа.

Тэр явдлаас хойш сэтгэл санааны гутралд орж эмнэлэгт хэдэн сар хэвтсэн. Одоо бүх зүйл хэвийн байна. Миний мөрөөдөл байнга өөрчлөгддөг. Эхэндээ цагдаа, дараа нь эмч, одоо ээжийнхээ зөвлөснөөр инженер болно гэж боддог болсон. Би хүмүүстэй харилцах дургүй болохоор технологитой холбоотой мэргэжлийг сонгож байгаа. Ангийнхантайгаа нэг их харьцдаггүй. Сургуульдаа шилжиж ирээд 4 жил болж байгаа ч найз нөхөд цөөхөн. Доод ангийн хүүхдүүд намайг зожиг гэж шоолдог. Хичээлийн талаар асуулт асуухад багш нар манай ангийнхнаас илүү хариулж өгдөг. Хүүхдүүд хэсэг хэсгээрээ бүлэг, фракцтай болохоор хүүхдүүд миний асуултад хариулдаггүй.

(ЖСХ-ийн хохирогч 17 настай, Өсвөр насны охидтой хийсэн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Хүчирхийлэлд өртсөн хохирогчид бие махбодийн шаналлаас гадна амьдралын чанар, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн байдал, харилцаанд нь нөлөөлөх сэтгэл зүйн хүнд цочрол авч байна.

Кейс 8. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 70 хувь нь нүдэндээ гэмтэл авч байна.

Нүдний гэмтлээс гадна нөхөж баршгүй, эмчлэхэд хэцүү сэтгэл зүйн гэмтэл их байна. Сэтгэлийн хямрал, айдас түгшүүр нь маш муу зүйл бөгөөд сэтгэлийн хямрал, түгшүүрийн шинж тэмдгийг бий болгодог. Би хямаараа зүрх өвдөх, чичрэх, тэнцвэрээ алдах зэргээр бүх бие хямардаг. Сэтгэцийн эмчид үзүүлэхээр сэтгэл мэдрэлийн антидепрессант, тайвшруулах эм бичиж өгдөг. Монголд сэтгэл заслын эмчилгээ хөгжөөгүй, цөөхөн эмчтэй.

Гадагшаа гарахаараа би ухаан алдаж унах магадлал өндөр байдаг тул заавал хүнтэй, хүүхдүүдтэйгээ хамт явдаг. Би үнэ цэнэгүй болж, хүүхдүүддээ дараа болж эхэлсэн. Одоо би шил хагарах чимээнээр л цочиж байна.

(Гэр бүлийн хүчирхийллээс болж хөгжлийн бэрхшээлтэй болсон 40 настай иргэний ярианаас, Улаанбаатар хот)

Ялгаварлагдах буюу орхигдоход хүргэж буй ямар хүчин зүйлс, илрэлүүд байна вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй байна. Тухайлбал, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй эмэгтэйг хүүхэд төрүүлэхэд тусламж үйлчилгээ үзүүлэх бэлтгэгдсэн эмч, эх баригч, сэтгэл зүйч, ядаж сэтгэл заслын эмчилгээ хийх мэргэжилтэн байхгүй байна.

Кейс 9.

Аймгийн төрөх эмнэлэгт соснголын бэрхшээлтэй эх амаржиж байв. Сумынх шиг нь дохионы хэл мэддэг хүн байхгүй, гэр бүлээс нь хүн байхгүй, хэнтэй ч харилцаж чадахгүй тэр эх төрөхдөө маш их сандарч хямарсан. Төрөлтийг зохицуулах гээд үзэг цаастай хүн байлгаж, биеэр дууриалгаж үзүүлэх гээд эмчээс маш их ур чадвар шаардсан ажил болсон. Үүнээс болж төрөх үед эх, хүүхэд хоёул маш их зовж шаналсан. Хүүхдийг нь хөхөөр хооллуулах гэж нилээд удаан хугацаа шаардсан (эх нь сүү багатай байсан). Эндээс үзэхэд дохионы хэлний чадвартай эх баригч, эмэгтэйчүүдийн эмч маш их хэрэгцээтэй байна.

(Аймгийн эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нартай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

Эмэгтэйчүүд хүчирхийллийн талаарх эрх зүйн мэдлэггүй, гэр бүлийнхээ нэр төр, үр хүүхдийнхээ төлөө тэвчээр гаргаж байгаа нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна. Амь насанд аюултай л бол гэрээ орхиод гарна хэмээн нэгэн ГБХ-ийн хохирогч хариулжээ. Жишээ нь, дээд боловсролтой хуульч эмэгтэй ГБХ-д олон жил өртсөн боловч хамт төгсөгчид, багш нараасаа санаа зовоод өөрөө ямар ч арга хэмжээ авдаггүй тухайгаа ярьсан байна.

5

ЭНЭ БҮЛГИЙГ
ДЭМЖИХИЙН
ТУЛД ЭРХ
ЭДЛЭГЧИД, ҮҮРЭГ
ХҮЛЭЭГЧДИЙН
ЗҮГЭЭС ЯМАР
АРГА ХЭМЖЭЭ,
САНААЧЛАГА ГАРГАЖ
БОЛОХ ВЭ?

ЖСХ/ГБХ-ээс урьдчилан сэргийлэх болон хохирогчдод дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хохирогчид, хүүхэд, гэр бүлд ээлтэй байдлаар зохион байгуулах хэрэгтэй байна.

Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд эцэг эхчүүдийн үүрэг тун чухал бөгөөд тэд охидоо сонсож, тайван хандаж туслах хэрэгтэй гэдгийг бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид онцолж байна. Хэдийгээр тэд сэтгэл зүйчээс тусламж хүсдэг ч үйлчилгээний чанарт сэтгэл хангалуун бус байдаг учир эхний тусламжийг аваад эргэж холбогдох нь ховор байна.

Хүүхдийн хамгийн их цаг зарцуулдаг мэдээллийн эх сурвалж, цахим орчныг судалж хэрэгтэй мэдээллийг нь түүгээр дамжуулан түгээх, сургуулиуд дээр хүүхдийн нас, хүйсийн онцлогт тохирсон сонирхолтой сургалт явуулах, хамгаалах байрны тоог нэмэгдүүлж илүү хүртээмжтэй болгох, сэтгэл зүйчдийн тоог нэмэгдүүлэх зэрэг асуудал нэн чухал байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид онцолж байлаа. Ингэснээр хохирогчид өөрийн хэрэгцээнд нийцсэн өмгөөлөгч, сэтгэл зүйчийг сонгох боломжийг бүрдүүлэхэд тус болно.

Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх төвийн үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд асран хамгаалагч, үйлчилгээ эрхлэгчдийн хандлага, зан хандлагыг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт этгээдийг хорихоос гадна дахин хүчирхийлэл, гэмт хэрэг үйлдэхгүй болгох үүднээс сэтгэл зүйн зөвлөгөө сайтар өгч ухуулах ёстой. Хохирогчдод сэтгэл зүйн болоод нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй хэрэгтэй байна. Ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид насан туршдаа хохирогч хэвээр байх явдлаас сэргийлэх нь нэн чухал.

ФОКУС БҮЛЭГ: 4. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖ БАЙДАЛ: АЖИЛГҮЙЧҮҮД, МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРГҮЙ ЗАЛУУЧУУД (15-24 НАСНЫ)

1

ДЭД БҮЛГҮҮД,
ТЭДГЭЭРИЙН ШИНЖ
БАЙДАЛ

- 1. Цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг болон албан салбарт ажилладаг залуучууд (эмэгтэй, эрэгтэй)
- 2. Албан бус салбар дахь залуучууд (эмэгтэй, эрэгтэй)
- 3. Хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй залуучууд

2

ОРХИГДОХ
ЭРСДЭЛТЭЙ ДЭД
БҮЛГҮҮД

Цалин хөлстэй ажилд шинээр орсон залуучууд, ялангуяа шинэхэн гэрлэсэн залуус нь халагдахаас айж илүү цагаар ажиллах, ажлын тэгш бус ачаалал, хандлага дор ажиллах нь нийтлэг байна. Мөн олон жил ажилласан туршлагатай, ажлын ачаалал ихтэй ахмад багш нар залуу багш нарт дарамт шахалт үзүүлж байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон бага сургуулийн хэд хэдэн залуу багш нар онцолж байв. Ялгаварлан гадуурхсан ажлын орчин нь ажлаас халах хүртэл шийдвэр гаргахад хүргэж байна.

Ахлах ангийн сурагчид болон насанд хүрээгүй хүүхдүүд барилгын туслах ажилтан, онлайн худалдаа, дэлгүүр, кофе шоп зэрэгт худалдагчаар ажиллах нь элбэг байгаа боловч тэд зөвхөн аман гэрээгээр ажиллаж байна. Охид ажлаасаа цагтаа тардаггүй, илүү цагаар ажилладаг, цалингаа цагт нь авч чаддаггүй, үйлчилгээний ажлаа дуусгаж байж оройтож тарах зэргээр ажлын байран дээрээ бэлгийн хүчирхийлэл, дарамтад өртдөг талаар Фокус бүлгийн ярилцлагад оролцсон охид хэлж байв.

Ажил олох гол арга нь танил талаараа дамжуулах, аль эсвэл цахимаар хайлт хийх арга байна. Зөвхөн эмзэг бүлгийнхэн нийгмийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвүүдэд ханддаг гэсэн ойлголт түгээмэл байна. Сул ажлын байруудын дийлэнх нь залуучуудын мэргэжил, сонирхолд нийцэхгүй, мэргэжлийн тодорхой ур чадвар шаардахгүй туслах ажлууд, цалин багатай ажлууд байна.

Цар тахлын үед албан бус салбарт ажилладаг, цагийн ажил хийдэг залуусын ажил эрхлэх боломж бүрэн хязгаарлагдаж, орлого нь багассан.

3

ЯЛГАВАРЛАГДАХ
ХЭЛБЭРҮҮД
(ОРХИГДОХ/
ЯЛГАВАРЛАГДАХАД
ХҮРГЭЖ БУЙ ЯМАР
ШАЛТГААНУУД
БАЙНА ВЭ? ҮНДСЭН
ШАЛТГААН НЬ ЮУ
ВЭ?

Залуучуудыг ажил мэргэжлээрээ шинэ, мэргэжлийн ур чадвар дутмаг, туршлагагүй гэх шалтгаан зааж ажил олгогчид залуучуудыг бага цалинтай ажилд авч байна. Мэргэжлээрээ 2-3 жил ажилласан байх гэсэн шалгуур нь залуу, шинэхэн төгсөгчдийг ажилд ороход хамгийн том саад тээг болж байна. Ялангуяа, цагийн ажил хийж мөнгө олох, мэргэжлээрээ дадлагажих боломжгүй оюутнуудад энэ нь бүр их саад болж байна.

Амьжиргааны түвшин доогуур айлын оюутан хүүхдүүд л цагийн ажил хийдэг гэдэг нь үнэнд нийцэхгүй. Бие даан мөнгө олох, эцэг эхдээ дэмжлэг болох, харилцаа холбоо тогтоох, ажлын туршлага хуримтлуулах гэх зэрэг олон шалтгаанаар залуус олноор цагийн ажил хайж байгаа нь цагийн ажлын эрэлт хэрэгцээг бий болгож байна. Харамсалтай нь, найдвартай цагийн ажил хомс, ихэнх нь хичээлийн цагтай давхцдаг нь зарим оюутнууд зорилгоо хойш тавин сургуулиа орхих гол шалтгаан болж, хичээлдээ бага анхаарал хандуулах, жилийн чөлөө авах, сургуулиа хаях зэрэг асуудлууд үүсч байна.

Хөдөлмөр эрхэлж буй залуучуудын хууль эрх зүйн мэдлэг, ялангуяа хөдөлмөрийн болон хөдөлмөрлөх эрхийн талаарх мэдлэг маш муу байна. Энэ нь ажилд авах, халах үйл явц шударга бус байх, цалингаа өгөхгүй байх, ажлын байрыг нь байнга солих, хөдөлмөрийн хортой нөхцөлд (ялангуяа барилгын талбарт) ажиллуулах, ажлын гүйцэтгэлийг нь шударгаар үнэлэхгүй байх зэрэг олон хүнд нөхцөлд оруулж байна.

Фокус бүлгийн ярилцлагын үеэр их, дээд сургуулийн цагийн ажил хийж байгаа эрэгтэй оюутнууд хамгийн боломжийн цалинтай ажил хийх, илүү цагаар ажиллахгүй байх, ачаалал багатай ажил хийх, ажлын тав тухтай орчин зэргийг илүүд үзэж байгаа нь ажиглагдаж байсан.

4

ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАЛТЫН
ЯМАР ХЭЛБЭРҮҮД
БАЙНА ВЭ?

Ялгаварлан
гадуурхалт
(өөрийнх нь
болон өөрийг нь
илэрхийлж буй
ондоошил буюу
шинж байдал)

Залуу ажилчдад тэгш бус хандаж байгаа нь ажил олгогчид тэднийг залуу хэмээн илүү их ажил өгөх, гэрлэлтийн байдлыг нь шалгаж ганц бие, хүүхэдгүй залуучуудыг ажлын байрны гол шаардлага болгох нь нийтлэг байна. Ганц бие, хүүхэдгүй зэрэг гэр бүлийн байдлаасаа болж ахмад ажилтануудын ажилд дарагддаг байсан тухай Фокус бүлгийн ярилцлагад орсон залуучууд ярьж байв.

Өнчин өрөөсөн, ядуу гэр бүлээс гаралтай, аль эсвэл даруу томоотой, ичимхий зан чанартай бол удирдлага болон ажилтнуудын зүгээс ажлын байран дээрх ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, үл тоомсорлох явдал илт илүү ажиглагдаж байна.

Кейс 1. Залуу, өнчин болохоор дарамт шахалт ихтэй байдаг учир мэргэжилдээ дуртай ч ажлаа ойр ойрхон сольдог.

Би тогооч мэргэжилтэй, Японд дадлагажигч байсан. Би өөрийгөө сайн тогооч гэж боддог. Намайг Багануурт ресторанд ажиллаж байхад залуу, бас өнчин аав, ээжгүй болохоор намайг дорд үзэж, бүдүүлгээр дээрэлхэж байсан. Дараа нь би И-март дахь солонгос эзэнтэй ресторанд ажилласан. Дарга болон хамт ажиллагсаддаа нийтийн хоолны газарт тавигдах чухал стандарт шаардлагуудын талаар сануулах болгонд амаа хамхиж дуугүй байхыг сануулдаг байсан. Шударга, зөв ажиллахыг шаардах тусам илт ялгаварлан гадуурхагддаг байсан.

(Ажил хайж байгаа залуучуудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Хөдөлмөр эрхэлж буй залуучуудын нийгмийн асуудал, хэрэгцээ шаардлагыг үл тоомсорлох, хайхрахгүй байх явдал их байна.

Кейс 2. Багш нарт зориулсан байр, орон сууцны талаарх шийдвэр гаргахдаа залуу багш нарыг орхигдуулж байна.

Багш нарын ихэнх нь зээлтэй. Багш нарын нийгмийн асуудлыг судалгаа хийж шийдэж байгаа мэт боловч бодит байдал дээр залуу багш нар орхигдож байна. Бид орлого багатай, давхар орлого олох боломж хомс. Бид амьдралаа шинээр эхлүүлж байгаа тул бүх зүйл зайлшгүй шаардлагатай. Хадгаламж байхгүй. Биднийг эхний жилдээ ажиллаж байгаа болохоор тэр юм уу ердөө тоодоггүй. Ахлах багш нар анхаарлын төвд байдаг. Иймээс залуучууд боломжийн ажил, орлоготой болохыг л хүсч байна. Хүүхэд байхаасаа л би багш болохыг хүсдэг байсан. Одоо хэр удаан ингэж ажиллахаа мэдэхгүй байна. Би ахтайгаа хамт амьдарч байгаа болохоор арай л гэж болгож байна гэж бодож байна.

(Албан бус салбарт ажиллаж байгаа залуу эмэгтэйчүүдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Ulaanbaatar)

Засаглал (Хүний эрхэд суурилан хөгжих хандлагын хүрээнд тулгарч буй чадавхын бэрхшээл, хууль тогтоомж, бодлого, татвар, төсөв, хуваарилалтын нөлөөлөл, засгийн газрын шийдвэр гаргах үйл явцад оролцох чадвар гэх зэрэг нөлөөллийг харгалзах)

Залуучуудын дийлэнх нь хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрлөх эрхийн талаар мэдлэггүй байна. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал төлөх эсэх нь залуучуудад хамаагүй мэт ойлгох түгээмэл байна. Тэд ашиг орлого олохыг л урьтал болгож аливаа зөрчил, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал төлөхийн ач холбогдол зэрэг хөдөлмөрийн харилцааны үр дагаврыг үл тоож байна. Зарим тохиолдолд дээд боловсрол эзэмшсэн буюу эзэмшихээр бодож байгаа залуучууд цалингийн хүснэгтээ харж задаргааг нь, ямар суутгал авсан талаар ажил олгогчоосоо асууж болох ч ажил олгогч нар ийм мэдээллийг хэлж өгдөггүй байна.

Хувийн хэвшлийн дийлэнх компаниуд ажилдаа яг цагтаа ирэхийг хатуу баримталдаг ч ажлаасаа хэдэн цагт тарахыг хатуу баримтлахгүй байна. Албан бус салбарт ажилладаг хүмүүсийн дийлэнх нь илүү цагаар буюу олон цагаар (өдөрт 8 цагаас дээш) ажилладаг. Илүү цагаар ажиллаж байгаа нь хувь хүний өөрийнх нь зохион байгуулалтгүйгээс болдог гэж ажил олгогчид тайлбарлаж байна. Ажил олгогч нь хөдөлмөрийн норм, нэг хүнд ногдох ажлын хуваарилалтыг баримтлахгүй байна. Түүнчлэн хөдөлмөрийн гэрээг ихэвчлэн амаар хийдэг тул ажлын байрны тодорхойлолт байхгүй, аль эсвэл тодорхойгүй байгаагаас болж илүү цагаар ажиллах, илүү цагийн хөлсийг ч авч чадахгүй байх тохиолдол цөөнгүй гарч байна.

Кейс 3. Хорооны нийгмийн ажилтны хувьд бид бүх зүйлд оролцдог.

Ажлын байрны тодорхойлолт байгаа. Харин ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүрэг, даалгаврыг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан гүйцэтгэдэг. КОВИД-19 цар тахалтай холбоотой тусгаарлах байрны үйлчилгээ, цэвэрлэгээг ч хийдэг. Төрийн албан хаагчийн хувьд бид цар тахлын онцгой байдлын үеэр, амралтын өдрүүдээр ч гэсэн гудамж талбайд эргүүлийн үүрэг гүйцэтгэдэг. Илүү цагийн хөлс олгодоггүй. Гомдоллох гэхээр бүгд л адилхан байгаа шүү дээ гэдэг.

Энэ удаад хэрэг дээр ажиллаж, судалгаагаа дуусгах цаг хугацаа алга. Тийм цаг гаргах боломж байхгүй байна. Би одоо жирэмсэний амралт авсан ажилтныг орлож байгаа. Дахиж хэзээ ч хорооны нийгмийн ажилтнаар ажиллахгүй. Энэ бол маш хэцүү, төвөгтэй ажил.

(Хөдөлмөр эрхэлдэг залуу эмэгтэйчүүдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

Эцэг эх, танилынхаа ажлын газар болон ажиллаж байсан газар, томоохон сүлжээ ресторан, дэлгүүрт ажилладаг залуучуудад цалин хөлсөө цаг тухайд нь авч чадахгүй байх, ажлын байран дээрх дарамт шахалт зэрэг асуудал тулгарахгүй байна. Харин эсрэгээрээ, хувиараа ажил олсон, ажил олгогч нь хувь хүн буюу хувийн жижиг компани зэрэгт ажилладаг залуучуудад цалин хөлсөө авч чадахгүй байх, дарамт шахалт, илүү цагаар ажиллах зэрэг асуудал тулгарч байна.

Zangia.mn, Shuurhai.mn, Unegui.mn, анкет сайтууд, фэйсбүүк групп зэрэг цахим хуудсуудаас нээлттэй ажлын байрын зарыг харж болно. Эдгээр зарууд дээр тавигдсан ажлын байрны нөхцөл нь бодитой бус, эхний хэдэн өдрийн цалин хөлс олгогдож байснаа аажмаар орлого, санхүүжилтгүйн улмаас буурч байна.

Фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан ажилгүй, идэвхтэй ажил хайгч 5 залуугийн хоёр нь Засгийн газрын санаачилга болох Залуучуудын оролцоо төсөлд хамрагдсан. Тэдний нэгнийх нь эмээ тус төслийн хорооны идэвхтэй гишүүн, бүлгийн ахлагч байсан учир залуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төвд бүртгүүлсэн байсан. Харин нөгөөх нь өмнөх ажил олгогчтойгоо харилцаатай байсан учраас төсөлд хамрагдсан. Энэ хооронд бусад оролцогчдод огт мэдээлэл ирээгүй. Мэдээлэл ирээгүйн шалтгаан нь залуус түрээсийн байраа байнга сольж хаяг нь өөрчлөгдөж байсан бөгөөд тэр тухайгаа хороондоо мэдээлдэггүй байсантай холбоотой байсан аж.

Кейс 4. Залуучуудын оролцоо төсөлд хэн ч хамрагдах боломжгүй

Эмээ намайг бүртгүүлсэн байсан учир хорооноос утсаар мэдэгдсэн. Залуучуудын оролцоо төсөл нь залуучуудын бизнесийн төсөл учир 600 гаруй залуусыг нэг газар 14 хоног байрлуулдаг. Намайг энэ сургалтад оролцохыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын газраас мэдэгдэж дуудсан. Сургалт надад үнэхээр таалагдсан. Хөтөлбөрийн агуулгад бизнесийг хэрхэн явуулах, төрийн албан хаагч ямар байх ёстой зэргийг оруулсан байсан. Олон залуус бие биентэйгээ танилцсан. Гэхдээ тэнд надад хагас цэргийн дэглэм нь таалагдаагүй. Оролцоог хичээл зүтгэлээр үнэлж байсан. Над шиг бүрэн дунд сургууль төгссөн залуучууд байсан. Төсөл 200 гаруй байгууллагатай гэрээ байгуулж, тэдгээр нь ажлын байр санал болгодог. МОНОС зэрэг зарим байгууллагатай холбоотой гэсэн. Уг төсөлд 2000 гаруй залуус хамрагдах ёстой байсан ч нийт 1400 гаруй залуус оролцсон байна. Найрамдал зуслан руу явсан. Тэнд 18-35 насныхан байсан.

(Ажил хайж байгаа залуучуудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Худалдаа үйлчилгээний чиглэлээр бизнес эрхэлдэг залууст тулгардаг нийтлэг асуудал бол түрээсийн ажлын байр боловч түрээслүүлэгчийн үйлчилгээний цагийн хуваарьт өөрчлөлт орох, ойр ойрхон болон гэнэтийн өөрчлөлтүүд зэргээс шалтгаалан олон хүнд үйлчлэх өдөр, цагийг бүрэн ашиглаж чадахгүй байна.

Нийгэм-эдийн засгийн байдал (эмэгтэй, эрэгтэй хүмүүс, хүүхдийн олон шалтгаант ядуурлын байдал)

Ялангуяа хувийн их дээд сургууль, коллежид суралцдаг хөдөө орон нутгийн оюутан хөвгүүд эцэг эхдээ туслах үүрэг хариуцлагаа ухамсарлан ажил хайж, сургуулиас гарах хандлага ажиглагдаж байна.

Эмэгтэй оюутнууд хөнгөн чанарын болон үйлчилгээний чиглэлийн цагийн ажлыг амжилттай хийж байгаа жишээ олон байна. Харин эрэгтэй оюутнууд дулааны улиралд барилгын хүнд ажил хийж гэмтэл бэртэлд өртөх магадлал өндөр байна.

Нийгмийн үйл ажиллагаанд залуучуудын оролцоо бага байна. Тухайлбал, судалгаа шинжилгээнд идэвхтэй оролцдоггүй, ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаанд оролцдоггүй, тулгамдаж буй асуудлаа илэрхийлэх, санал бодлоо солилцох харилцааны ур чадвар сул байна.

Газарзүйн байршил (байгаль орчны доройтол, тээвэр, технологи зэрэг байршлаас шалтгаалсан алслагдмал байдал, эрсдэл, орхигдол)

18-24 насны залуучууд хот суурин газар цагийн ажил хийх хандлагатай байгаа бөгөөд ажлын ачааллаас шалтгаалж ажлаа солих нь элбэг байдаг бол хөдөө орон нутагт эсрэгээрээ байна. Иймээс энэ насны залуучуудын дунд хөдөөнөөс хот руу чиглэсэн ажиллах хүчний урсгал их байна.

Төр, хувийн хэвшлийн аль алинд ажлаас хоцорсон минут бүрийг цалингаас хасч, илүү цагаар ажилласныг үнэлэхгүй, цалин хөлс тооцохгүй байна. Мөн ажлаасаа хол, ялангуяа алслагдсан дүүрэг, хотын захад амьдардаг залуучууд нийтийн тээвэр хүлээх, замын түгжрэлд гацах, хувийн автомашины зогсоол олдохгүй байх, ажлаасаа хоцрох, ажил дээрээ хонох зэрэг асуудалтай тулгарч байна.

Кейс 5. Ажлаас хоцорсон цагийг маань цалингаас хасчихсан, гэр хол болохоор замын түгжрэлд орохоос болгоомжлоод ажил дээрээ хоносон.

Би “Газар шим” компанид сарын 500 мянган төгрөгийн цалинтай ажиллаж байсан. Ажлаас хоцорсон минут тутамд 1000 төгрөг хасдаг байсан. 2 сар гаруй ажилласны эцэст би бүх хасалтаа аваад ажлаасаа гарсан. Хүн болгонттой минутаар тооцоо хийдэг учир эмчийн бичиг авчирч байж цалингаа бүрэн авна. Өглөө 8.00 цагт эхэлнэ. Би Нисэхийн хороололд (нисэх буудлын суурьшлын бүсэд) амьдардаг тул автобус саатсанаас болж хэд хэдэн удаа хоцорсон. Дараа нь ажил дээрээ хоносон.

(Ажил хайж байгаа залуу эмэгтэйчүүдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Хөдөө орон нутагт амьдарч байгаа гэр бүлтэй, хөдөлмөр эрхэлж байгаа залуус харьцангуй тогтвортой амьдралаа хадгалахыг хүсч байгаа бол хөдөө орон нутагт ажлын байр хомс, амьдрах орчин тааруу, зугаа цэнгэл, чөлөөт цагаа өнгөрөөх, хөгжих, боловсрол эзэмших боломж хомс учир тогтвортой, найдвартай ажилгүй, гэрлээгүй, ажилгүй залуучууд хот сууринд, ялангуяа Улаанбаатар хотод ажиллах, амьдрах боломжийг эрэлхийлэх хандлагатай байна.

Кейс 6. Боловсрол эзэмшихээр хотыг зорьсон залуус эргэж ирдэггүй. Ямар нэгэн аргаар тэд ажил олчихдог.

Манай сумын нэг залуухан бүсгүй ямар ч мэргэжилгүй мөртлөө энд байнга ажил хайдаг, их хөдөлгөөнтэй байдаг байсан. Би түүнд ажил олж өгч чадаагүй харин сургуулийн өмнөх насны боловсролын багшийн сургалтад хамруулсан. Сургалтаа дүүргээд тэр хот руу ажил хийхээр яваад буцаж ирээгүй. Уг нь тэр буцаж ирэх ёстой байсан ч түүнтэй хамгийн сүүлд холбоо барихад хотод байхаар болсноо мэдэгдсэн. Уг нь сургалтын бүх зардлыг сумаас гаргасан юм.

(Ажил хайж байгаа эрэгтэй залуучуудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

Эмзэг байдал,
хямрал (байгалийн
болон хүний
хүчин зүйлээс
үүдэлтэй гамшиг,
хүчирхийлэл, гэмт
хэрэг, зөрчил,
эдийн засгийн
болон бусад
хямралд өртөмтгий
нутаг дэвсгэр, хүн
ам)

Ажлын байран дээр эрэгтэй ажилчид эротик хошигнол ярих, шоолох, айлган сүрдүүлэх, ичээх, илж таалах, бэлгийн сэдлийг шууд болон нууцлаг үгээр илэрхийлэх зэргээр залуу эмэгтэйчүүдийг бэлгийн дарамтад оруулж байна.

Кейс 7. Манай ажлын нэг залуу намайг айлгаж дарамталж, гэр хүртэл араас минь дагадаг байсан.

Үйлдвэрт ажиллаж байхад нэг ахмад ажилтан хажуугаар өнгөрөхдөө надаас утасны дугаарыг минь байнга асуудаг байсан. Тэр бас ажлын дараа намайг дагаад байсан. Би хамт ажилладаг нэг найздаа ярьсан чинь даргад хэлчих гэж зөвлөсөн. Ахлах менежерийг хажууд байх үед яах ч үгүй. Би байнга гомдол гаргадаг болохоор ахмад эмэгтэй ажилтанууд янз бүрээр ярина.

(Ажил хайж байгаа залуу эмэгтэйчүүдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Шууд удирддаг дарга нар, удирдах албан тушаалтнууд, ахлах ажилтнууд залуучуудыг залуу гэдгээр нь дарамталж, зарим нь бүр ажлаасаа халагдах хүртэл тохиолдол гарч байсныг Фокус бүлгийн ярилцлагад оролцогсад ярьж байсан.

Кейс 8.

Би их тэвчээртэй учир ихэнхдээ буруутгагдана. Гэхдээ би гэртээ ирээд л уйлна. Бусад багш нарт их нөлөөтэй нэг ахмад багш бий. Надаас тэр 200,000 төгрөг зээлсэн. Намайг мөнгөө нэхэхэд тэр намайг өөр ямар ч ажил хийх чадваргүй, хэрэв чи ажлаасаа гарвал, чамайг гудамжинд харвал гайхах зүйл байхгүй гэж хүртэл хэлж байсан. Бусад ахмад багш нар хүртэл чи хэл ам хийдэг ч гэсэн чамд энэ ажлаас өөр ажил олдохгүй л дээ гэж хэлнэ. Тэд манай ангийнхан болон эцэг эхчүүдэд миний талаар элдэв хов тараадаг байсан. Удаан тэвчсэний эцэст захиралд мэдэгдэж гомдол гаргасан чинь ахмад багш уйлаад л байсан. Ажиллаад 30 жил болоход ийм гомдол ирж байгаагүй гээд л байсан. Тэр залуу багш нарыг үргэлж загнадаг байсан бөгөөд зарим багш нар түүний зан аашнаас болж ажлаас гарч байсан. Тэр ахмад багш нь дөрвөн хүүхэдтэй бөгөөд нөхөр нь архичин байсан. Захирал намайг тэр ахмад багшаас уучлалт гуй, ахмад хүн шүү дээ гэж байсан. Чи залуу байна, ахмад багш нарын үгэнд орох ёстой гэж хэлсэн. Бас захирал их дарамтална. Эцэст нь би бууж өгөөд ажлаасаа гарсан. Одоогоор би жирэмсний чөлөөтэй хүний ажлыг орлон ажиллаж байна. Намайг харин хамгийн бага уйлсан хүн гэж ярьдаг. Өмнө нь ажиллаж байсан хүмүүс их уйлж, тэвчээр нь алдагдаж байсан юм билээ.

(Хөдөлмөр эрхэлж байгаа залуу эмэгтэйчүүдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

Ялгаварлагдах буюу орхигдоход хүргэж буй ямар хүчин зүйлс, илрэлүүд байна вэ?

Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа залуучуудын дунд улирлын чанартай ажилгүйдлийн түвшин өндөр, гол төлөв хүйтний улиралд тэд ажилгүй байна.

Хөдөө орон нутагт ажилд орохын тулд танил тал, арын хаалга их чухал байна.

Хөдөө орон нутагт туслах малчин шаардлагатай байгаа ч залуучууд үе тэнгийн эмэгтэйчүүд болон бусад хүмүүсээс ичээд тийм ажил хийхгүй байна.

Кейс 9. Туслах малчнаар ажиллахаас ичиж байна

Би боловсролгүй. Багадаа дүү бид хоёр сургуулиас гарч өөр хүн байхгүй тул эмээгээ асарч хамт амьдарч байсан. Эмээгээ нас барахаар бид УБ хотод ирсэн. Зоогийн газарт туслах ажилтнаар орох гэхээр наад зах нь 9-р ангийн гэрчилгээ шаардддаг. Надаас ч муу амьдралын нөхцөлтэй охинтой найзалсан. Би түүнтэй нийгмийн халамжийн газар танилцсан. Би ямар ч сургуульд сураагүй болохоор найз нөхөдгүй. Саяхан найзтайгаа уулзсан чинь тэр хөгшин хүнтэй суугаад бүр мянган малтай малчин болчихож. Одоо 4-5 хүүхэдтэй, хөөрхөн эмэгтэй болсон байна лээ. Энэ жил тэд туслах малчин авсан ч, удахгүй солих төлөвлөгөөтэй байгаа намайг тэнд ажиллах уу гэж асууж байсан. Гэвч бодит байдал тулаад ирэхээр хүнд ичиж зовох мэдрэмж төрдөг юм байна. Хачирхалтай.

(Ажилгүй эмэгтэйчүүдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

Залуус ямар ч мэргэжилгүй, боловсролгүй байгаагийн гол шалтгаан нь сургалтын төлбөр болон суралцахтай холбоотой бусад зардалтай холбоотой байна. Амьжиргааны түвшин доогуур өрхүүдэд ийм боломж байхгүйгээс хүүхдүүд 13-14 наснаас хөдөлмөр эрхэлж эхэлдэг. Хөдөөгийн залуучууд, ялангуяа боловсрол муутай, хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй залууст мал маллахаас өөр найдвартай ажил алга байна.

Албан бус эдийн засгаас албан эдийн засаг руу шилжихгүй байгаагийн хамгийн том шалтгаан нь орлого багатай иргэд өндөр татвар төлдөг, томоохон компаниудын нэгэн адил санхүүгийн тайлан гаргадаг, түүндээ ажиллах боловсон хүчин авч чадахгүй байгаа явдал гэж судалгаанд оролцогчид үзэж байна.

5

ЭНЭ БҮЛГИЙГ ДЭМЖИХИЙН ТУЛД ЭРХ ЭДЛЭГЧИД, ҮҮРЭГ ХҮЛЭЭГЧДИЙН ЗҮГЭЭС ЯМАР АРГА ХЭМЖЭЭ, САНААЧЛАГА ГАРГАЖ БОЛОХ ВЭ?

Хөдөлмөрийн хуулийн шинэчлэлийн хүрээнд цагийн ажил, хөдөлмөрийн тогтолцоог боловсронгуй болгож, хүний нөөц, цалин хөлсийг цаг тухайд нь олгодог байх зэрэг асуудлыг анхаарах нь чухал байна.

Шинэ ажилтныг дадлага хийлгэх нэрээр дарамтлах, цалин хөлс олгохгүй байх зэрэг хөдөлмөрийн мөлжлөгөөс чөлөөлөх хэрэгтэй байна.

Хууль эрх зүйн болон нийгмийн бусад ур чадварын сургалт, нийгмийн харилцааны үйл ажиллагааг сайжруулах үүрэг амлалт авах хэрэгтэй,

Албан бус салбарт ажиллаж байгаа залууст тулгамдаж буй хамгийн том асуудал бол цалингаа хугацаанд нь авдаггүй, эсвэл огт авахгүй байгааг өөрчлөх хэрэгтэй.

ФОКУС БҮЛЭГ: 5. ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ: ХӨДӨӨГИЙН ЯДУУ, ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮМҮҮС

1

ДЭД БҮЛГҮҮД,
ТЭДГЭЭРИЙН ШИНЖ
БАЙДАЛ

- 1. Малчид, туслах малчид, гэрээт малчид
- 2. Хөдөөгийн ядуу хүмүүс

2

ОРХИГДОХ
ЭРСДЭЛТЭЙ ДЭД
БҮЛГҮҮД

- Сумын төвөөс алслагдсан багийн малчид
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдаагүй малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, ажилгүй иргэд.
- Бага, дунд сургуулийн насны хөдөөгийн хүүхдүүд
- Туслах малчид, тэдний гэр бүл, үр хүүхэд
- Мэргэжил, ур чадвар эзэмшээгүй хөдөөний залуучууд

3

ЯЛГАВАРЛАГДАХ
ХЭЛБЭРҮҮД
(ОРХИГДОХ/
ЯЛГАВАРЛАГДАХАД
ХҮРГЭЖ БУЙ ЯМАР
ШАЛТГААНУУД
БАЙНА ВЭ? ҮНДСЭН
ШАЛТГААН НЬ ЮУ
ВЭ?

Сумын төвөөс алслагдсан багийн залуус, бичиг үсэг тайлагдаагүй, нийгэмшээгүй малчид үзэл бодлоо илэрхийлж чадахгүй нийгмийн үйлчилгээ авч чадахгүй хоцрогдох эрсдэлтэй байна.

Хөдөө орон нутгийн иргэд нийгмийн эрүүл мэндийн үнэ төлбөргүй үйлчилгээ авч чадахгүй байх нь түгээмэл. Тэдний эрүүл мэндийн боловсрол сул, сум, багийн хэмжээнд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хангалтгүй, ялангуяа орчин үеийн тоног төхөөрөмж дутмаг, эмнэлгийн ажилтнуудын ур чадвар тааруу байгаа зэрэг нь үүний гол шалтгаан болж байна. Малчид ихэвчлэн Улаанбаатар хот руу явж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахаар зорьдог боловч улсын эмнэлгүүдийн урт дараалал, хүнд суртлыг тэвчихийн аргагүй тул хувийн болон өндөр өртөгтэй эрүүл мэндийн үйлчилгээнд голчлон ханддаг хэмээн Фокус бүлгийн ярилцлагад орсон малчид онцолсон. Тэд эрүүл мэндийн үйлчилгээний зардлаас гадна унаа, байр, хоолонд багагүй зардал гаргаж байна.

Цар тахлын үед хөдөө орон нутаг, ялангуяа хөдөөгийн сум, багийн малчдын хүүхдүүд бага, дунд боловсролын бүх шатанд орхигдож, хоцрогджээ. Хичээлийг цахим хэлбэрээр явуулах үед (танхимын болон онлайн хичээлийг хослуулсан ч) интернетэд холбогдох боломжгүй, шаардагдах төхөөрөмж, компьютер байхгүйгээс гадна дийлэнх нь дата багц худалдан авах замаар ухаалаг гар утсаа бусадтай хувааж хэрэглэдэг бөгөөд танхимын сургалт ч тогтвортой зохион байгуулагдаагүй байна. Үүний уршгаар хүүхдүүд хичээлээ үзэх бус гэр орныхоо мал маллагаанд туслах, дүү нараа харж асрах, барилга, дэлгүүр болон бусад үйлчилгээний газруудад бага цалингаар (өдөрт 10.000-20.000 төгрөг) уртасгасан цагаар ажил хийж байгаагаас хичээлээсээ ихээхэн хоцорч байна.

Түүгээр ч зогсохгүй танхимаар бүрэн хичээллэхгүй байгаа учир эцэг эхийн хайхрамжгүй байдлаас болж хүүхдүүд хөдөө гэртээ харьж нэр төдий хичээл, даалгавраа хийж байгаа дүр эсгэх явдал түгээмэл болсон. Өөрөөр хэлбэл, ийм хүүхдүүд хичээлийн хөтөлбөрөөс бүрэн хоцорч байгаа нь ажиглагдаж байна.

Цахим сургалтын үед хүүхдийн гэрийн даалгавар хийлгэх, хичээлийг нь цагт нь үзүүлэх асуудал ээжүүдийн үүрэг болсныг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон малчин эмэгтэйчүүд болон сумын төвийн эмэгтэйчүүд онцолж байлаа. Гэвч ээжүүдийн малаа маллах цаг наргүй ажлын ачаалал, боловсролын түвшин, заах арга, ялангуяа математик, дүрмийн хичээлд нь одоогийн зааж байгаа арга барилд нь нийцүүлж хүүхдүүддээ тусалж чадахгүй байх, мөн нэг айлын олон хүүхэд утсаа булаалдан холбогдох хичээлдээ нэвтэрч орж чадахгүй байх гээд олон бэрхшээл байна.

Хууль эрх зүйн мэдлэггүйн улмаас боловсролгүй, ажилгүй, амьжиргааны түвшин доогуур залуучууд танил тал, холбоо сүлжээгээр дамжуулан ямар нэгэн тусгай ур чадвар, мэргэжил шаардахгүй хүнд хэцүү ажил (ихэвчлэн барилгын туслах ажилтан) олж ямар нэгэн гэрээгүйгээр, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангалгүйгээр ажиллаж байна. Харамсалтай нь ийм ажилтнуудад ажил олгогчид цалин хөлсийг нь цаг тухайд нь өгөхгүй байх, заримдаа огт өгөхгүй, хөдөлмөрийн норм, стандарт баримтлахгүй хэт ачааллах, бага цалингаар, тоног төхөөрөмжгүй гар аргаар хөдөлмөр эрхлүүлж байгаа зэрэг олон ноцтой зөрчлүүд энгийн үзэгдэл болсон байна. Ийм ажил хийдэг хүмүүс ядарч туйлдахын зэрэгцээ ийм хүнд ажлыг хийх дургүй учир орхиод гарах нь олон байдгийг Фокус бүлгийг ярилцлагад оролцогчид онцолж байсан.

4

ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАЛТЫН
ЯМАР ХЭЛБЭРҮҮД
БАЙНА ВЭ?

Төрөөс малчдын талаар баримталж буй бодлого, дэмжлэг цаг үеэ олоогүй, тэр дундаа залуу малчдад чиглэсэн бодлого нь оновчгүй бөгөөд залуу малчдын санал бодлыг сонсдоггүй, зарим авч буй арга хэмжээ нь бүр дордуулсан, доромжилж байгаа мэт хэмээн Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид үзэж байна.

Ялгаварлан
гадуурхал (өөрийнх
нь болон өөрийг
нь илэрхийлж буй
ондоошил буюу
шинж байдал)

Кейс 1. Авч буй арга хэмжээ нь залуу малчдын хүсэл сонирхолд нийцдэггүй буюу хоцрогдсон

Малчид юу хүсч байгаа, яаж байгаа нь хэзээ ч сонин биш. Авч буй арга хэмжээ нь үнэндээ үр дүнгүй байна. Ихэнхдээ малжуулах талаар ярьдаг ч авч буй арга хэмжээ нь хоцрогдсон, аль эсвэл цаг хугацаанаас хоцорч байгаа нь үнэхээр инээдтэй. Зарим зохион байгуулж байгаа үйл ажиллагаа нь ямар ч үйлчилгээний үр ашиггүй байдаг. Жишээ нь малын эрүүл мэндийн үйлчилгээ байж болно. Бид бүгдээрээ бараг малын эмч болсон. Өнөөдөр бараг малчин өрх бүр малынхаа наймааны хүчээр машинтай болцгоосон. Малчин болох боломжтой бараг бүх хүмүүс хотод орон сууцтай, хүүхдүүдээ хотод сургаж байна. Малчдын бодит амьдрал ийм болчихоод байхад төрөөс энгийн л бодлого баримталж байна.

(Залуу малчидтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

Кейс 2. Эрх баригчид залуу малчдыг дэмжихгүй, харин мал маллагааны удаан жилийн туршлагатай, олон малтай хүмүүсийг дэмжиж байна

Залуу малчдыг ердөө дэмжихгүй, харин олон малтай, удаан жил мал маллаж байгаа малчдыг илүү дэмжиж байна. Залуу малчид өвөлжөө байхгүй. Олон жил мал малласан малчид 5-6 өвөлжөөтэй, үр хүүхэд нь эзэмшиж байдаг. Иймээс өвөлжөө олоход маш хэцүү байдаг. Бага насны хүүхдүүдтэй учир урт удаан хугацаагаар бусад аймаг, сумд руу отроор явах боломжгүй. Сүүлийн үед хүүхдүүдээ сургуульд орохоор мал маллахаа больё гэж бодож байгаа. Бид олигтой боловсрол эзэмшээгүй болохоор үр хүүхдүүдээ зовоож амьдруулах бодолгүй байна.

(Залуу малчидтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

Ахмад настнууд, өндөр албан тушаалтнуудын өмнөөс хамаагүй дуугарч болохгүй гэсэн буруу ойлголт залуу малчид, боловсрол тааруу малчдын дунд түгээмэл байна. Үүний уршгаар тэд өөрсдийнхөө санал бодлыг илэн далангүй илэрхийлж, нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож чадахгүй байна.

Кейс 3. Залуу малчид дарга нарын өмнө үзэл бодлоо илэрхийлэхээс айж байна.

Манай өвөлжөө, худагтай холбоотой асуудал их байна. Худаг гаргая гэвэл хоёр сая төгрөг болно. Үнэндээ мэдэхгүй байна. Дарга нартай ахмад малчид уулзаад яриад л байсан өөрсдөө худагтай болчихсон. Эсрэгээрээ, залуучууд дарга нартай хэзээ ч нээлттэй байж болохгүй. Малчдын дунд насны ялгаа байна. Бид бас нөхрүүдийнхөө өмнө хамаагүй юм ярьж чаддаггүй.

(Залуу малчидтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

Ихэвчлэн олон хүүхэдтэй айлыг туслах малчнаар ажиллуулах хандлага ажиглагдаж байгаа нь ялгаварлал байгаагийн илрэл юм. Ганц бие хүмүүс болон залуучууд туслах малчинаар ажиллах боломж хомс байна. Туслах малчид ихэвчлэн мал маллагааны аман гэрээ хийдэг аж. Цалин, урамшууллыг нь цаг хугацаанд нь олгодоггүй, туслах малчны гэр бүлийн бүх гишүүдийг мал маллагааны бүхий л ажилд татан оролцуулдаг зэрэг хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэрүүд илт ажиглагдаж байна. Малчин эзэд хүүхдүүдээ төв, суурин газрын сургуульд сургаж байхад туслах малчны хүүхдүүд сургуулиас завсардах, хоцрох эрсдэлд орж эрх ашиг нь зөрчигдөж байна.

Туслах болон гэрээт малчид улирлын чанартай цалин хөлс, урамшуулал авдаг ч үнэлэмж нь маш бага, ихэвчлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байдаг тул өдөр тутмын хоол хүнсэнд нь ч хүрэлцэхгүй байна. Тэд ихэвчлэн хувийн малтай болохыг хүсдэг. Малжуулах төсөл хэрэгжиж байгаа ч залуучуудад хязгаартай тооны мал хуваарилах буюу авах эрх олгож байгаа нь ялгаварлалын бас нэг хэлбэр болж байна. Цөөн тооны мал өсгөхөд олон тооны мал өсгөхтэй адил арчилгаа, маллагаа шаардлагатай. Тэжээлийн үнээс бусад бүх зардал бараг ижил болно.

Хөдөө орон нутагт ганц бие залуу эрчүүд, ялангуяа залуу малчин эрчүүд олширч байгаагийн гол шалтгаан нь дундаж амьдралтай болон боловсрол муутай малчин эцэг, эхчүүд охидоо боловсрол эзэмшүүлэхээр хот руу явуулах нь болсонтой холбоотой хэмээн малчид онцолж байсан. Тэд хотоос буцаж ирдэггүй учир ядаж нэг хүүгээ мал дээр өсгөж хүмүүжүүлдэг. Хөдөөгийн залуусыг нэгэнт боловсролтой болсон охид үл тоомсорлох болсон нь өнөө үеийн хүн ам зүйн тулгамдсан асуудал болж байна. Эсрэгээрээ, чинээлэг малчид мал аж ахуйгаа үр хүүхэддээ өв болгон үлдээхийн оронд хүүхдүүдээ хот суурин газар бараадуулж оронд нь туслах болон гэрээт малчин хөлслөхийг илүүд үзэж байна. Малчидтай хийсэн ярилцлагаас харахад мал маллах маш хэцүү хөдөлмөр тул тэд үр хүүхдээ хүйс харгалзахгүй малчин болгохыг хүсэхгүй байна.

Засаглал (Хүний эрхэд суурилан хөгжих хандлагын хүрээнд тулгарч буй чадавхын бэрхшээл, хууль тогтоомж, бодлого, татвар, төсөв, хуваарилалтын нөлөөлөл, засгийн газрын шийдвэр гаргах үйл явцад оролцох чадвар гэх зэрэг нөлөөллийг харгалзах)

Ядуурлыг арилгахад чиглэсэн бодлого:

Төрөөс малчдын талаар баримтлах бодлого хэвлэл мэдээллийн хэрэгслээр их гарч байгаа ч бодлого, хөтөлбөр нь газар дээрээ яаж хэрэгжиж байгаа нь бүрхэг байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон малчид шүүмжилж байв.

Сумын төвд төрийн үйлчилгээний байгууллагууд болон банкуудаас өөр байнгын ажиллагаатай, найдвартай, цалин хөлстэй ажлын байр байхгүй. Өсвөр үе, залуучуудын хэрэгцээнд нийцсэн амьдрах орчин нөхцөл бүрдээгүй байна. Хааяа барилгын туслах ажил гардаг ч тодорхой шалтгааны улмаас цалин хөлс нь найдвартай олгогддоггүй. Иймээс би сумандаа бүртгэлтэй ч ажил хайж үргэлж ийш тийш шилжиж байдаг. КОВИД-19 цар тахлын дэгдэлт, хөл хорионы улмаас ажилгүй олон залуус сум орон нутаг руугаа буцаж ирсэн.

Хүнсний талон олгох хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийг багийн хуралд танилцуулдаггүй, хөтөлбөрөөс хасагдсан шалгуур, үндэслэлийн талаар иргэдэд мэдээлэл өгдөггүй, хариуцаж буй халамжийн ажилтнууд нь "дээрээс сонгон шалгаруулдаг" гэсэн ганцхан хариултыг өгдөг аж. Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, нийгмийн халамжийн системийн мэдээг цаг тухайд нь шинэчилж чадаагүй, засаг захиргааны анхан шатны нэгжийн түвшинд өрхийн амьжиргааны түвшинг дахин үнэлж, тодорхой болгож чадаагүй, нөхцөл байдал бодит байдалтай нийцэхгүй байгаа зэрэг нь эмзэг, ядуу зорилтот бүлгийн хүмүүст энэхүү хөтөлбөр хүрч чадахгүй байх гол шалтгаан болж байгааг фокус бүлгийн үр дүнд хийсэн шинжилгээ харуулж байна. Мөн халамжийн тогтолцоо нь шууд мэдээлэл авах боломжтой хүмүүс болон улс төрийн бүлэглэлд (ялсан нам) чиглэсэн үйлчилгээнд илүү чиглэж байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид шүүмжилж байв.

Баг, сумын Засаг дарга нарын үйл ажиллагаа, санаачилгаас иргэдийн амьдрал шууд хамааралтай байна. Засаг даргынх нь ажлын гүйцэтгэл удаан, тааруу байгаа сумдын иргэд аймгийн төвд ойр байсан ч мэдээллээр дутагдаж байна.

Эрүүл мэнд, нийгмийн даатгал:

Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажилгүй иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалт маш муу байна. КОВИД-19 цар тахлын дэгдэлт өрхүүдийн орлого, зарлагад хүчтэй нөлөөлсний улмаас ихэнх хүмүүс (эрэгтэй, эмэгтэй аль аль нь) эрүүл мэндийн даатгал төлөхөө зогсоосон байна. Мөн хөдөө орон нутаг төрийн албанд ажиллаж байгаа хүмүүсээс бусад айл өрхүүдийн нөхөрүүд буюу эрэгтэйчүүд сүүлийн хоёр жил нийгмийн даатгал төлөөгүй байна. Түүнчлэн, ихэнх эрүүл мэндийн үзлэг, оношилгоо ямар нэгэн байдлаар төлбөртэй байгаагийн зэрэгцээ эрүүл мэндийн даатгал тэдгээрт хамаарахгүй байна.

Малчдын дийлэнх нь нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийж байгаа нь нийгмийн даатгал өвлөгддөггүй учир малын ашиг шимээр өөрсдийгөө хангах нь чухал гэж үзэн даатгалын тогтолцоог ямар ч утгагүй, үр ашиггүй гэж үзэж байна. Тэтгэврийн нас нь дөхсөн хөдөөгийн эмэгтэй, эрэгтэй хүмүүс л сайн дураар нийгмийн даатгалын шимтгэл төлөх нь түгээмэл байна. Гэхдээ л нийгмийн даатгалд эмэгтэйчүүд илүү хамрагдаж, эрэгтэйчүүд хамрагдахгүй байна. Хөдөө орон нутгийн ажилтнуудын цалин хөлс бага учраас аливаа даатгал, хураамжаас зайлсхийх нь өрхийн орлогоо бууруулахгүй байх гол боломж гэж тэд үзэж байна.

Эрх зүйн асуудал:

Хүн амынхаа тоог тогтвортой байлгахын тулд зарим сумд малчин өрхийн хүүхдийг өөр хот, аймаг, сум руу шилжүүлэхийг хориглож 9-р анги хүртэл сумынхаа сургуульд элсүүлэхийг шаардаж байна. Энэ шаардлагыг биелүүлэхгүй бол газар, өвөлжөөг нь хураан авна хэмээн малчдад дарамт шахалт үзүүлж байгааг өөрийнхөө жишээгээр малчин эмэгтэй ярьж байсан.

Сумын төвд эрэгтэйчүүд голдуу гал сөнөөгч, мотоциклийн засварчин, харуул (манаач), барилгын туслах зэрэг ажил хийж байгаа бол эмэгтэйчүүд тогооч, үйлчлэгч, оёдолчин, засварчин зэрэг ажил хийж байна. Гэхдээ эдгээр ажлын байр ховор, ихэвчлэн улирлын чанартай байдаг бөгөөд байнгын ажлын байр тун ховор байна. Эдгээр төрлийн ажил хийж байгаа сум, орон нутгийн иргэдэд тулгамдаж буй нийтлэг асуудал бол ажил олгогчид бичгээр гэрээ байгуулдаггүй, ихэнхдээ амаар тохирдог, цалин хөлсөө хугацаанд нь олгодоггүй, амласан цалингаа өгдөггүй, цалин хөлсөө дутуу олгодог, илүү цагаар ажиллуулдаг зэрэг олон асуудал байна. Эдгээр нь хөдөлмөр болоод хөдөлмөрлөх эрхийн зөрчил их байгааг харуулж байгаа бөгөөд иргэд ч өөрсдөө хууль эрх зүйн мэдлэггүй гэдгээ хүлээн зөвшөөрч байна.

Төрийн бусад үйлчилгээ:

Хөдөөгийн багийн малын эмч ганцхан байгаагаас үүдэн үйлчилгээ хүлээгдэх, тоног төхөөрөмжийн хүрэлцээ, чанар муу, хүчин чадал сул зэрэг асуудал байнга гарч байна. Иймд малчид ямар ч мэдлэггүйгээр малаа дур мэдэн эмчилж байгаа нь олон эрсдэл (амьтнаас хүнд халдварлах, эрүүл ахуйн шаардлага хангаагүй мах, сүүн бүтээгдэхүүн) дагуулж байна.

Кейс 4. Бид малаа дураараа эмчилдэг

Бид өөрсдөө л шийддэг. Вакцин сар дотроо шингэдэг юм уу, үгүй юм уу, ямар ч хяналт байхгүй нь хачирхалтай. Хотын иргэд ямар малд ямар вакцин хэрэглэж байгааг мэддэггүй болохоор өрөвдөлтэй л юм. Өнгөрсөн өвөл бидэнд маш хэцүү байсан. Эмийн сангаас хугацаа нь дууссан эм худалдан авч тарьсан. Дуудлага өгөөд ч малын эмч ирдэггүй.

(Малчидтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

Нийгмийн халамж:

Хүнсний талон хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нийгмийн халамжийн тогтолцоо шинэчлэгдээгүй, одоо мөрдөгдөж буй шалгуур үзүүлэлтүүд нь дахин судлагдаагүй, төрийн эрх барих анхан шатны байгууллага болох сумын засаг дарга, халамжийн ажилтнууд тусламж хэрэгтэй байгаа зорилтот бүлгийн хүмүүсийн бодит хэрэгцээг цааш уламжилдаггүй, хөтөлбөрт хамрагдах хүмүүсийн нэрсийг зүгээр л дээрээс ирүүлдэг хэмээн тайлбарладаг аж. Хөдөлмөрийн идэвхтэй насны залуу хос 5 жилийн өмнө ажилгүй тус хөтөлбөрт хамрагдаж байжээ. Тэр үед тэд 2-3 хүүхдээ өсгөж, аав, ээжтэйгээ хамт амьдарч байж. Одоогоор хүүхдүүд нь эцэг эхээсээ бие даан тусдаа амьдарч байгаа ч Хүнсний талон хөтөлбөрт хамрагдсан хэвээр байгаа тухай Фокус бүлгийн ярилцлагын үед яригдаж байлаа.

Кейс 5. Өрхийн мэдээлэл шинэчлэгдэхгүй байгаагаас эмзэг бүлгийн өрхүүд Хүнсний талон хөтөлбөрт хамрагдахгүй байна.

Манайх ам бүл тавуулаа эхнэр, гурван хүүхэдтэй. Би цэцэрлэгийн харуулын ажилтай. Өмнөговь аймагт уурхайд ажиллаж байгаад гэр бүлдээ ойртох гээд эргэж ирсэн. Би хүнсний талон хөтөлбөрт ханддаг. Би цалингийн зээлтэй. Засгийн газар цалингийн зээлийг нэг удаа ч болов тэглэчихээсэй гэж хүсдэг. Би 6 сая төгрөгийн цалингийн зээл авсан сар бүр цалингаасаа суутгуулж байна. Зээлийн мөнгөө хүүхдийн сургалтад зарцуулсан.

(А. 29 настай, эрэгтэй, гэрлэсэн, эхнэр, 3 хүүхдийн хамт амьдардаг, Баянхонгор аймаг)

Нийгэм-эдийн засгийн байдал (эмэгтэй, эрэгтэй хүмүүс, хүүхдийн олон шалтгаант ядуурлын байдал)

Хосууд тус тусдаа амьдарч байна:

Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт тус тусдаа амьдарч байгаа залуу гэр бүлийн тоо эрс нэмэгдэж байна. Үүнд эхнэр нь хүүхдүүдээ сургуульд сургахаар даган хот, аймаг, сумын төвд амьдрах, аль эсвэл нөхөр нь суманд байнгын ажил олдохгүйгээс улирлын чанартай ажил хайн хот суурин руу явах, тухайлбал, хот хоорондын тээвэрт явах, уул уурхай, барилга дээр ажиллах гэсэн хоёр хүчин зүйл нөлөөлж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж:

Хөдөө орон нутгийн иргэд, малчдын дунд эрүүл мэндийн даатгал төлдөг хүн цөөн байна.

Кейс 6. Эрүүл мэндийн даатгалтай байсан ч яаралтай тусламжийн үед нэмэлт зардал гардаг.

Хувийн эмнэлэгт хандсан нь хамаагүй дээр. Би нөхрөө хагалгаанд орсон тэр үед үүнийг мэдэрсэн. Түргэний тэргээр биднийг аймгийн түргэн тусламжийн тасагт хүргээд эмч яаралтай уулзалтад явсан. Бид эрүүл мэндийн даатгалтай байсан ч 81,000 төгрөг авсан. Мөнгөгүй бол тэд бидэнд үйлчлэхгүй байсан. Нэмээд эмийн зардалд 100,000 төгрөг төлсөн. Нөхрийнхөө хоолыг бас зөөж байсан. Малчид бид тэр бүр бэлэн мөнгөтэй байдаггүй. Биднийг эмнэлэгт байхад манай нутгийн малчин эмэгтэй 40,000 төгрөгийн төлбөр төлж чадахгүй буцаж байсан. Түүнээс хойш бид бэлэн мөнгөтэй явах нь чухал гэдгийг ойлгосон. Өмнөх өрөө төлж дуусаагүй байгаа учир одоогоор бид даатгалын шимтгэлээ төлж чадахгүй байгаа.

(Д., малчин, эмэгтэй, 29 настай, гэрлэсэн, 5 хүүхэдтэй, Баянхонгор аймаг)

Малчдад эрүүл мэндийн боловсрол, тэр дундаа нөхөн үржихүйн боловсрол авах боломжгүй байна. Өнөөдөр тэд интернетээс мэдээлэл авч байгаа боловч ихэнхдээ Facebook гэх мэт баталгаагүй эх сурвалжаас мэдээлэл авч байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, орчин үеийн тоног төхөөрөмж дутмаг, эмч, эмнэлгийн ажилтнуудын ур чадвар сул, малчид, сумын иргэд үйлчилгээний чанарт сэтгэл дундуур байна

Кейс 7. Сум, орон нутагт эмчилгээний нууц алдагддаг учир зарим нь эмчилгээ хийлгэхгүй байх, аль эсвэл дур зоргоороо өөрийгөө эмчлэх, хот суурин газар руу явж эрүүл мэндийн үйлчилгээ авах зэрэгт хүргэж байна.

Аймгийн хэмжээнд ганц урологийн эмч байдаг, ерөнхийдөө орон нутаг өөрийн гэсэн онцлогтой. Эрчүүдэд эрүүл мэндийн асуудал гарвал жижиг газар учраас айж, ичих асуудал гарна. Нууцлал гэж байхгүй орон нутагт цуурхал дороо л тарчихна. Иймээс зарим нэг нь хот суурин газар руу явахыг илүүд үздэг бол зарим нь өөрсдөө дур зоргоороо, сайн дураараа эмчилнэ. Сүүлдээ залуучуудын дунд үргүйдэх, хүүхэдтэй болж чадахгүй байх зэрэг асуудал түгээмэл болж байна.

(Сумын төвийн хүмүүстэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагас, Баянхонгор аймаг)

Хөдөөгийн хүүхдүүдийн боловсролын хоцрогдол:

Амьжиргааны түвшин доогуур өрхүүд хичээлийн хэрэгсэл байхгүй, 3-4 хүүхэдтэй айл өрх нэг гар утастай, аймаг, сумаас алслагдсан айл өрхүүд сүлжээнд холбогдоогүй зэргээс хүүхдүүд цахим сургалтад хамрагдаж чадахгүй байна. Ингэснээр тэд боловсролын үйлчилгээний хүртээмжгүй байдлаас шалтгаалсан ядууралд өртөх эрсдэлтэй байна. Мөн хүүхдүүдээ цахим сургалтад хамруулахын тулд ах дүү, хамаатан садан, бусдын гэрт байлгаснаар хүчирхийлэлд өртөх, хичээл сургуулиасаа хоцрох, цахим орчин, мөрийтэй тоглоом зэрэгт донтох зэрэг олон асуудал гарч байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон малчид, сумын иргэд онцолж байлаа.

Газарзүйн байршил (байгаль орчны доройтол, тээвэр, технологи зэрэг байршлаас шалтгаалсан алслагдмал байдал, эрсдэл, орхигдол)

Цар тахлын нөхцөл байдал, санхүүгийн хүндрэлээс болж ган, зудтай жилүүдэд малчид ойр ойрхон бэлчээр сэлгэн нүүдэллэхээ больсон. Энэ нь бэлчээрийн доройтол, хомсдлын гол шалтгаан болж байна. Мөн бэлчээр нутгийг улирлын чанартайгаар сэлгэн сэргээж байдаг нүүдэлчдийн уламжлалт мал маллагаа өөрчлөгдөж, бэлчээрийн төлөвлөлт алдагдаж байна. Малчдын дунд тэгш бус байдал улам илрэх болж, чадавх, нөөц сайтай малчид цөөн малтай, ам бүл цөөтэй, ядуу өрх, ядуу малчдыг гадуурхаж байна. Айлын өвөлжөө бараадан амьдрах зардал маш өндөр байна. Иймээс хэдэн малтайгаас үл хамааран ядуу малчид өвөлжөөтэй болох нь маш чухал байна.

Эмзэг байдал, хямрал (байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшиг, хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, эдийн засгийн болон бусад хямралд өртөмтгий нутаг дэвсгэр, хүн ам)

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө малчдад, тэр дундаа бог малтай иргэдэд хүндээр тусч байна. Өвөлжилтийн бэлтгэл, хашаа хороо, өвөлжөө муутайгаас болж ядуу малчид сумын төв рүү ойртон бууж байна. Цөөн малтай хэсэг нь малаа орхин аймаг, сумын төв рүү ажил хайн нүүж, мэргэжлийн ур чадвар шаардахгүй, бага цалинтай түр ажилд орж, хөдөлмөрийн хууль, тогтоомжийн мэдлэггүйгээс болж эрсдэлд орж байна. Иймээс хөдөөгийн иргэдэд орон сууцны асуудал хамгийн хүндрэлтэй байна.

2017 оноос хойш байгалийн гамшгийн улмаас малаа алдсан, бүртгэлгүйгээс болж нийгмийн анхан шатны үйлчилгээ авч чадахгүй байгаа хүмүүсийн тоо нэмэгдсэн. Нөгөө талаас, олон малчид зээлтэй байгаа бөгөөд нэг хэсэг малчид зээл авах сонирхолдоо хөтлөгдөн нүүж шилжиж чадахгүй байна.

Сум, орон нутгийн орлого багатай өрхийн гишүүд болон хөдөлмөр эрхэлж байсан хүмүүс КОВИД-19 цар тахлын улмаас байнгын орлогогүй болж, ажлаа алдаж, өрхийн зарлага нь орлогоосоо давах болж санхүүгийн болон сэтгэл санааны хүнд хямралд орж байна. Төрөөс нийт хүн амд тодорхой хэмжээний тусламж (хүүхдийн мөнгөнөөс бусад) үзүүлсэн ч урт хугацааны хүндрэлийг даван туулахын тулд хөдөөгийн иргэдэд байнгын ажилтай, тогтвортой цалинтай байх нь хамгийн чухал бөгөөд том дэмжлэг болох юм.

Ялгаварлагдах буюу орхигдоход хүргэж буй ямар хүчин зүйлс, илрэлүүд байна вэ?

Нийгэм, соёлын хоцрогдол:

Хөдөө орон нутгийнхан, малчид урлаг соёлоос хоцорч байна.

Хөдөөгийн малчид, иргэд нөхөрлөл, хоршоо байгуулж чадахгүй байна. Бэлчээр ихээхэн доройтсон нь малчдын хамтран ажиллах урам зориг сэргэхгүй байх гол шалтгаан болж байна.

Кейс 8. Хүүхдүүдээ яасан ч малчин болгохгүй.

Надад ийш тийшээ явах цаг байхгүй, бид хэдүүлхэнээ цаг боломж хэзээ ч гардаггүй. Миний санаж байгаагаар, би хамгийн сүүлд 2018 онд залуучуудын концерт үзсэн. Надад зугаа цэнгэлд зориулах чөлөөт цаг байдаггүй. Хэдэн малтайгаа зууралдаад завгүй. Заримдаа би залуу насаа ингэж өнгөрөөж байгаадаа харамсдаг. Би хүүхдүүдээ яасан ч малчин болгохгүй.

Байнгын ажил хийхэд саад болж буй асуудал:

- Насны хязгаар
- Холбоо сүлжээ, хахууль (бэлэн мөнгөн) шаардлагатай
- Цалин хөлс хугацаандаа олгогддоггүй
- Хүүхэд асрах (ач, зээгээ харах, хот суурин руу явах, ажил олдохгүй байх, шинэ газар нийгмээс тусгаарлагдах)

Боловсролын тогтолцоонд тулгарч буй асуудал:

- Залуус олгож буй боловсролын чанарыг нь үл анзааран хамаагүй сургуульд элссэнээс төгсөөд мэргэжлээрээ ажиллах боломж олдохгүй, ажиллахгүй байх тохиолдол олон байна.

Кейс 9. Зах зээл хязгаарлагдмал учраас хамтарч ажиллах, орлогоо хуваалцах дургүй

Би мотоциклийн засварын газартай болмоор байна. Би хамтарч ажиллах дургүй. Ганцаараа байх нь дээр. Өөр хүнтэй хамтран ажиллах юм бол хийсэн жаахан ажлынхаа орлогыг нөгөө хүнтэй хуваах болно. Манай суманд тогтмол ажилладаг автомашин, мотоциклийн засвар үйлчилгээ байхгүй.

(Залуу малчид, сумын төвийн иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Баянхонгор аймаг)

5

ЭНЭ БҮЛГИЙГ
ДЭМЖИХИЙН
ТУЛД ЭРХ
ЭДЛЭГЧИД, ҮҮРЭГ
ХҮЛЭЭГЧДИЙН
ЗҮГЭЭС ЯМАР
АРГА ХЭМЖЭЭ,
САНААЧЛАГА ГАРГАЖ
БОЛОХ ВЭ?

Бага хүүтэй, урт хугацааны хөнгөлөлттэй зээлийг хүртээмжтэй болгох,

Соёлын өвийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, хамгаалах,

Малчдын хүүхдүүдэд чанартай, хүртээмжтэй сургалтын үйлчилгээ үзүүлэх,

Мал аж ахуй эрхлэх нөхцөлийг сайжруулах, тухайлбал, өвс тэжээл хадгалах зэрэгт хөрөнгө оруулах,

Өвөлжөө, хаваржааг тохижуулж, хүртээмжийг нэмэгдүүлэх,

Худаг, ус хамгаалалтын цэгийн тоог нэмэгдүүлэх замаар бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг сайжруулж хэрэгжүүлэх,

Малчид, ялангуяа залуу малчин хосуудыг орчин үеийн шийдэл бүхий явуулын нүүдлийн орон сууцанд амьдрах нөхцлийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх,

Малчдын орлого, амьжиргааны түвшин байгалийн нөхцөлөөс хамааралтай байна. Төрөөс үүнд чиглэсэн урьдчилан сэргийлэх, дэмжих арга хэмжээг авах хэрэгтэй байна.

Кейс 10.

Амьжиргаагаа дээшлүүлэх, өндөр ашиг шимтэй мал худалдан авах, өвс тэжээл нөөцлөх зэргээр хашаа хороогоо сунгах бүртээ бэлэн мөнгөний асуудалтай байнга тулгардаг. Байнгын орлого байхгүй учир хавар, өвлийн улиралд олсон орлого маань ихэвчлэн хоол хүнс, сургалтын төлбөрт зарцуулагддаг. Малжуулах төслөөр цөөн малтай, орлого багатай залуу малчдыг дэмжвэл нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдах шаардлагатай болно.

(Баянтүмэн сумын туслах малчин, Дорнод аймаг)

ФОКУС БҮЛЭГ: 6. ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ: ХОТ СУУРИН ГАЗРЫН ЯДУУС (ШИЛЖИН СУУРЬШИГЧИД, ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮМҮҮС)

1

ДЭД БҮЛГҮҮД,
ТЭДГЭЭРИЙН ШИНЖ
БАЙДАЛ

- Байнгын оршин суугчид (ядуу, бага орлоготой, ажилгүй)
- Шилжин суурьшигчид (ядуу, бага орлоготой, ажилгүй)

2

ОРХИГДОХ
ЭРСДЭЛТЭЙ ДЭД
БҮЛГҮҮД

- Амьжиргааны түвшин тааруу шилжин суурьшигчид
- Хөдөлмөрийн насны ур чадвар эзэмшээгүй, ажилгүй шилжин суурьшигчид
- Орон гэргүй хүмүүс
- Шилжин суурьшигчдын сургуулийн өмнөх насны хүүхдүүд болон бага сургуулийн хүүхдүүд

3

ЯЛГАВАРЛАГДАХ
ХЭЛБЭРҮҮД
(ОРХИГДОХ/
ЯЛГАВАРЛАГДАХАД
ХҮРГЭЖ БУЙ ЯМАР
ШАЛТГААНУУД
БАЙНА ВЭ? ҮНДСЭН
ШАЛТГААН НЬ ЮУ
ВЭ?

Шилжин суурьшигчдын бүртгэлийн асуудал: Улаанбаатар хотод шилжин ирсэн бүртгэлгүй иргэдийн хүүхдүүд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын бага, дунд сургуулиудад хамрагдах боломж хязгаарлагдмал байна. Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийг ерөнхий боловсролын сургуульд авахгүй байна. Иймд оршин суух газаргүй шилжин ирэгсэд хээл хахууль өгч танил талаараа дамжуулан хүүхдээ цэцэрлэгт оруулж байна. Малчид зээл авахын тулд шилжилт хөдөлгөөнөө бүртгүүлэхгүй байгаа учраас тэдний хүүхдүүд боловсролын үйлчилгээ авч чадахгүйд хүрдэг тухай Фокус бүлгийн ярилцлагад оролцсон бүртгэлгүй шилжин суурьшигчид ярьж байсан.

Шилжин суурьшигчдын хүүхдүүдийн боловсрол: Малчид хүүхдүүддээ чанартай боловсрол эзэмшүүлэхийн тулд хөдөө орон нутгаас хот суурин газар руу шилжин суурьшиж байна.

Газар эзэмшил, өмчлөлийн асуудал. Шилжин ирэгсэд ойрын хамаатан садныхаа хашаанд гэрт амьдрах нь түгээмэл байна.

Эмэгтэйчүүд ихэвчлэн хүүхдүүдээ асарч байна: Хоёр хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд төрөөс олгодог тэтгэмж (сар бүр 50 мянган төгрөг) нь эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үүрэг хариуцлагад дэмжлэг болохгүй байна. Мөн ойр ойрхон жирэмсэлж байгаа эмэгтэйчүүд цалин хөлстэй ажлаасаа халагдаж байгаа нь айл өрхүүдийг ядуурах эрсдэлд оруулдаг аж. Үүнд сургуульд орж буй хүүхдүүддээ тавих анхаарал халамж хүртэл хамрагдаж байна. Өөрөөр хэлбэл, бага насны болон бага ангийн хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эмэгтэйчүүд ажил хийх ямар ч боломжгүй байна. Хот суурин руу шилжиж ирсэн хүмүүст ойрын хэдэн хамаатан садангаас нь өөр танил тал байдаггүй учир нийгмээс тусгаарлагдсан мэт мэдрэмж тэдэнд төрдөг аж.

4

ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАЛТЫН
ЯМАР ХЭЛБЭРҮҮД
БАЙНА ВЭ?

Цагдаа нар гудамжинд согтуу хүмүүстэй ялгаварлалтай харьцаж байна. Өмссөн хувцас нь гайгүй, цэвэрхэн байвал торгууль ногдуулах тал дээр илүү анхаарч, ноорхой, муухан хувцастай хүмүүсийг төлбөрийн чадваргүй хэмээн үл тоомсорлож байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон хотын иргэд шүүмжилж байна.

Ялгаварлан
гадуурхал (өөрийнх
нь болон өөрийг
нь илэрхийлж буй
ондоошил буюу
шинж байдал)

Олон нийтийн ажилд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ялгавартай хандаж байна.

Кейс 1. Олон нийтийн ажлын хамгийн хэцүүг нь биднээр хийлгэдэг, аль эсвэл туслах ажилтнаар авдаг

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан төсөлд эрүүл ч бай, өвчтэй ч бай хүмүүсийг ажилд авдаг. Жишээлбэл, би хөгжлийн бэрхшээлтэй эгчтэйгээ хамт ногооны талбайд ажилладаг байсан. Нийт 8 хүний 3 нь хөгжлийн бэрхшээлтэй, 5 нь эрүүл байсан. Гэхдээ тэдгээр эрүүл хүмүүст худагт ойрхон, илүү сайн газрыг хуваарилсан. Харин бидэнд худгаас хол, хэцүү газрыг хуваарилсан. Бид хөгжлийн бэрхшээлтэй учраас үндсэн бус, туслах ажилтанаар ажиллаж байсан. Энэ нь маш шударга бус явдал байсан. Биднийг хулгайн хэрэгт гүтгэж байсан төдийгүй илт гадуурхаж байсан. Бид эдгэрсэн ч ажлын байр олдохгүй, эмзэг бүлгийнхэнд үзүүлдэг аливаа тусламж дэмжлэгээс хасагдах эрсдэлтэй хэвээр байна.

(Шилжин суурьшигчидтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Дархан-Уул)

Засаглал (Хүний эрхэд суурилан хөгжих хандлагын хүрээнд тулгарч буй чадавхын бэрхшээл, хууль тогтоомж, бодлого, татвар, төсөв, хуваарилалтын нөлөөлөл, засгийн газрын шийдвэр гаргах үйл явцад оролцох чадвар гэх зэрэг нөлөөллийг харгалзах)

Цахим үйлчилгээтэй холбоотой асуудал: цахимаар эмнэлэгт үзүүлэх цаг авч байгаа ч үйлчилгээ найдваргүй (жишээ нь: цахимаар цаг авчихаад эмнэлэгт очиход жагсаалтад өөр хүний нэр байсан), химийн бодистой олон жил ажилласнаас болоод миний хурууны хээ маань төхөөрөмжид уншигдахгүй асуудал тулгарч байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, түүнд тавих хяналт шалгалт дутмаг, иргэдийн эрхийг үл тоомсорлож байгаагаас хөдөлмөрийн эрх зөрчигдөж байна. Ялангуяа өдрийн цалин хөлстэй ажилд бичгээр гэрээ хийхгүй аман гэрээ хийх тохиолдол олон байна. Бодит байдал дээр сул ажлын байруудын зарласан нөхцөл мөрдөгдөхгүй байна. Эхний өдрүүдийн цалин хөлсийг амласан ёсоороо төлж байгаад эцэст нь санхүүжилт хязгаарлагдсан шалтгаан тоочих, аль эсвэл хэн нэгэнд ажлаасаа гарах мэдрэмж төрүүлж, ажлаасаа гарахаар нь өөр хүн оронд нь оруулах зэргээр цалин хөлсийг нь өгөхгүй байх тохиол цөөнгүй байна. Ажил олгогчдын зүгээс хөдөлмөрийн дотоод журмыг баримталж байгаа учир хүсвэл шүүхэд хандаарай гэсэн заналхийлэл байнга ирдэг бөгөөд түр ажлын байр зонхилж байдаг болохоор хөөцөлдөх цаг хугацаа ч байхгүй, шинээр дахин ажилд орохын тулд илүү цаг хугацаа хэрэгтэй болдог аж. Ийм тохиолдолд цалин хөлсний талаар ярих ч боломжгүй болдог хэмээн хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүстэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид ярьж байв. Цаашлаад хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг хүмүүсийн нийгмийн даатгал төлөгдөхгүй байгаа нь ажиллагчдыг зээл авах эрхгүй болгож байна.

Хувийн хэвшилд ажиллаж байгаа хөдөлмөрийн насны хүмүүсийн нийгмийн даатгалыг төлж байгаа гэсэн нэрийдлээр цалингаас нь суутган авдаг боловч нийгмийн даатгалын санд шимтгэл төлсөн эсэхийг шалгах боломжгүй, бүртгэлийн мэдээлэл нээлттэй биш, ажилтнуудад нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нотлох баримт үзүүлэхгүй байна. Хувийн хэвшлийнхэн ажилтнуудынхаа нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүйгээс тэтгэвэр авагч хохирч, тэтгэвэр нь буурах бас нэг шалтгаан болж байна.

Кейс 2. Ажилтны цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэл нь нийгмийн даатгалын санд шилжсэн эсэхийг шалгах боломжгүй, ажил олгогч шимтгэл шилжүүлээгүй байснаас тэтгэвэр буурсан.

Тэтгэвэрт гарчихаад ажил хийх юм бол нийгмийн даатгалын шимтгэл заавал төлөх ёстой. Миний ажил цалин багатай ч хувийн компаниуд нийгмийн даатгалын шимтгэл заавал төлөх ёстой гэдэг. Цалингаас нийгмийн даатгалын шимтгэл суутгана. Миний нэр дээр шимтгэл төлсөн эсэхийг шалгах гэхлээр миний нэрийг системээс хассан учир системээс харах боломжгүй гэсэн. Би олон газар цагийн ажил хийдэг. Хувийн аж ахуйн нэгжүүд ажилтнуудынхаа нийгмийн даатгалын шимтгэлийг нэгдсэн санд бүрэн шилжүүлдэг эсэх нь эргэлзээтэй. Уг нь цалингаас суутгачихдаг.

(Шилжин сууршигчид болон байнгын оршин суугчидтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Хүнд гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажлын байр олдохгүй байна. Ийм хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мэргэжлийн сургалтад хамруулах юм бол тэд гар утас, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар, хяналтын камерын хяналт зэрэг ажилд ажиллах боломжтой гэдгийг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс онцолж байсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авбал хөдөлмөрийн онцгой нөхцөл шаардагдах, эрүүл ажилчидтай харьцуулахад хөдөлмөрийн бүтээмж багатай, өвчний чөлөө ойр ойрхон авах байх гэсэн үзлээр аж ахуйн нэгж, ажил олгогчид тэднийг ажилд авахдаа хойрго ханддаг гэж ярьж байлаа.

Кейс 3. Ажил хийх чадвартай ч хөдөлмөрийн чадвараа 80 хувиар алдсан гээд ажилд авдаггүй тэгсэн хирнээ залуу гээд хөгжлийн бэрхшээлийн тэтгэмжийг сунгадаггүй.

Гурав, дөрвөн жилийн өмнө оёдлын жижиг цех байгуулахаар халамжийн төвд хандсан ч та хөдөлмөрийн чадвараа 80 хувиар алдсан байна гээд тоогоогүй. Хөдөлмөрлөх чадварыг 50-иас доош хувиар үнэлдэг. Мөн ажил хайхаар та хөдөлмөрийн чадвараа 80 гаруй хувиар алдсан байна гээд хүлээж авдаггүй. Тэгэхээр нь хөгжлийн бэрхшээлийн тэтгэмж авах гэхээр хугацааг сунгаж өгөхгүй ихэвчлэн хойшлогддог. Мөн эрүүл мэндээрээ ийм тэтгэмж авах гэлээ гэж намайг буруутгадаг. Би 27 настайдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүлэгт хамрагдсан ч зүгээр суугаагүй янз бүрийн ажил хийж байсан. Заримдаа юу хийхээ ч мэдэхгүй л байна.

(Байнгын оршин суугч эмэгтэйчүүдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Дархан-Уул аймаг)

Цахим сургалт нь ялангуяа бага орлоготой өрхийн зарлагыг нэмэгдүүлж байна. Хичээлдээ онлайнаар орохын тулд дата болон интернетийн эрх худалдан авах төлбөр өндөр байгаагаас ядуу өрхүүд хүнсний хэрэглээгээ багасгаж байна. Сургуулийн насны олон хүүхэдтэй айлууд хүүхэд бүртээ ухаалаг утас авч өгөх шаардлага гарч байна. Улаанбаатар хотод гар утас, цахилгаангүйгээс хүүхдүүдээ цахим сургалтад хамруулж чадахгүй байгаа айл өрх ч олон байна. Мөн гар утасгүй хүүхдүүд хичээлээ үзэх, даалгавраа хийх боломжгүй, сургалтын хөтөлбөрөөс хоцрох тохиолдол ч цөөнгүй байна.

Кейс 4. Ухаалаг утасгүй болохоор англи хэлний хичээлээ үзэж чадаагүй.

Манай хүү NTV телевизээр теле хичээлээ үзэж байх үед охин маань ангийнхаа онлайн группээр ордог. Надад Nokia байгаа. Манайд ухаалаг утас байхгүй, хүү маань миний нөхцөл байдлыг сайн ойлгож байгаа, ухаалаг гар утас авч чадахгүй л байна.

Саяхан хүүгийн маань англи хэлний хичээл фэйсбүүкээр 2 группээр орж байгааг мэдсэн. Ангийн багш нь намайг, миний амьдралын байдлыг сайн мэддэг. Ухаалаг гар утастай болохоороо хичээлээ яаж нөхөх талаар түүнтэй ярилцсан. Англи хэлний хичээлийг нь өөр багш заадаг тул аль болох утас хурдан авахыг зөвлөсөн.

(Байнгын оршин суугч эмэгтэйчүүдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Дархан-Уул аймаг)

Хүнсний талон олгох хөтөлбөрт эмзэг бүлгийн өрхүүд, тэр дундаа оршин суух бүртгэлгүй шилжин ирэгсэд, тусламж дэмжлэг хэрэгтэй хүмүүс хамрагдахгүй орхигдож байна. Нийгмийн халамжийн үйлчилгээнийхэнтэй холбоо сүлбээгүй л бол хуучин, шинэ ялгаагүй машин, гэр ахуйн цахилгаан хэрэгсэлтэй л бол халамжийн үйлчилгээнээс шууд хасагдаж байгааг эмзэг бүлгийнхэн шүүмжилж байв. Айл өрхүүдийн хүнсний талон авах шалгуур, үндэслэлийг асуухаар удирдах байгууллагаас ийм нэрс өгсөн гэсэн хариултыг өгч байна.

Фокус бүлгийн ярилцлагад оролцсон тухайн орон нутагтаа харъяалалтай иргэд засгийн газраас үзүүлж буй үйлчилгээнд ихэвчлэн сэтгэл хангалуун байгаа бол шилжин ирэгсэд хүнд суртлыг буруутгаж сэтгэл зовниж байна.

Гэр хорооллын иргэд газар өмчлөхөд ихээхэн арын хаалга, хээл хахууль өгхө шаардлага гардаг, газар өмчлөх эрхийн гэрчилгээгээ хаанаас авахаа мэдэхгүй, газрын асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг барагдуулах асуудалд хариу өгдөггүй, шийдвэр гардаггүй талаар хотын иргэд ихээхэн бухимдалтай байна. Дүүргээс газар олгож байгаа ч зөвшөөрөл өгч байгаа газрууд нь хэт хол, ус, цахилгаан, зам, нийтийн тээвэр гэх мэт дэд бүтэцтэй холбогдоогүй байдаг бөгөөд тэдгээр газраа хураалгачихгүйн тулд хашаа хатгах шаардлага гарч байна. Мөн ядуу, орлого багатай өрхүүдэд ийм боломж ч олдохгүй байна.

Кейс 5. Газраа ашигламаар байна, гэтэл ил задгай газар ус, цахилгаан ч байхгүй.

Төрөөс өгч байгаа газар бидэнд хэрэгтэй юу? Хүн бүр газар эзэмших, өмчлөх эрхтэй гэж байсан. Газрын гэрчилгээг авсан. Ашиглах гэсэн чинь ус, цахилгааны боломж байгаа эсэхийг мэдэхгүй. Жишээ нь, хөдөөнөөс ирсэн найз маань газар дээр чинь бууж болох уу гэж асууж байсан. Боломжтой эсэхийг би мэдэхгүй.

(Шилжиж ирсэн болон байнгын оршин суугч хүмүүстэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Нийгэм-эдийн засгийн байдал (эмэгтэй, эрэгтэй хүмүүс, хүүхдийн олон шалтгаант ядуурлын байдал)

Боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн байдал нь шилжин ирэгсэд болон байнгын оршин суугчид, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд харилцан ялгаатай байна.

Шилжин ирсэн залуус ихэвчлэн бүрэн дундаас доош боловсролтой, ихэвчлэн барилгын ажил хийж байгаа бол 50-иас дээш насны эрэгтэйчүүд жолооч, харуул хамгаалалтын ажил хийж байна. Өндөр барилгууд дээр барилгын материал зөөх, төмөр өргөх зэрэг хүнд хүчир ажил хийж байгаагаас эрэгтэйчүүд заримдаа бэртэж, хөдөлмөрийн чадвараа алддаг тухай Фокус бүлгийн ярилцлагад оролцсон эрэгтэйчүүд онцолж байсан. Эсрэгээрээ, шилжиж ирсэн эмэгтэйчүүдийн дийлэнх нь бүрэн дунд боловсролтой, наад зах нь богино хугацааны сургалт, дамжаанд хамрагдсан байна. Шилжиж ирсэн эмэгтэйчүүд цэвэрлэгч, үйлчлэгч, орон сууцны цэвэрлэгч зэрэг ажилд орох магадлал өндөр байгаа ч эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад ажил олж орох нь цөөн байна.

Байнгын оршин суугч эмзэг бүлгийн хүмүүс ихэвчлэн бүрэн дунд боловсролтой, аль эсвэл богино хугацааны мэргэжлийн сургалт, МСҮТ-д суралцсан байх магадлалтай байгаа боловч мэргэжлээрээ ажиллахгүй байгаа нь олонхи нь байна. Нас, мэргэжлийн ур чадвар дутмаг, эрүүл мэндийн хувьд тааруу, хүүхэд асрах хүнгүй зэрэг шалтгаанаар ажил хийх боломжгүй байна.

Өвлийн улиралд ажилгүйдэл нэмэгдэж байгаа нь хотын ядуу, эмзэг бүлгийнхэн улирлын чанартай ажил голчлон хийдэгтэй холбоотой байна. Ядуурлын асуудлыг шийдвэрлэх гол арга зам бол ажилтай байх, ялангуяа, цаг тухайд нь цалин хөлсөө олгодог, найдвартай, тогтвортой ажлын байртай байх явдал гэж Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид бүгд хүлээн зөвшөөрч байсан.

Сургууль, цэцэрлэгийн ажлын эхлэх, дуусах цагийн хуваарь уян хатан бус, тогтворгүй, тогтмол өөрчлөгдөж байгаагаас нийслэлийн ядуу, эмзэг бүлгийн хөдөлмөр эрхэлдэг эцэг эхчүүдэд хүндрэлтэй байдаг бөгөөд хүүхдүүдээ хичээл сургуулиас нь хоцроох, таслуулахад хүргэж байгааг анхаарах хэрэгтэй байна. Энэ нь эргээд өрхийн орлого буурах, өрхийн нэг гишүүн л цалин хөлстэй ажил хийх зэргээр өрхийн эдийн засгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж ядууралд ороход хүргэж байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид хэлж байв.

Кейс 6. Ажлын цаг, сургуулийн цаг өөр хоорондоо тохирдоггүй, сургуулийн автобус хүрэлцээгүй зэрэг нь хүүхдүүд сургууль завсардахад хүргэж байна.

Манай хороонд өөрчлөлт орсноор хүүхдүүд шороон замаар явдаг өөр сургууль руу шилжсэн. Хичээллэх цаг ердөө 8.00-11.00 цаг хүртэл байдаг. Хичээлийн дараа манай хүүхдийг хэн авах вэ? Үүнээс болж ах эгч нь сурч боловсрох эрхээ хасуулж болохгүй. Би хүүхдүүдийнхээ сургуулийг зохицуулахын тулд ажлаасаа гарахаас өөр аргагүйд хүрсэн. Шар хадны эцсээс шинэ сургууль хүртэл 1км 300м зайтай. Сургуулийн автобус байхгүй. Хүүхдийнхээ унааны асуудлаар сургуулийн захиралд хандахад холбогдох төрийн байгууллагад хүсэлт гарга гэсэн. Харамсалтай нь би яг одоо бага хүүгээ сургуулиас гаргаж өөрөө ажилдаа явж байна. Үүнийг ямар нэгэн байдлаар шийдэх хэрэгтэй. Шинэ сургууль хүртэл зам ч байхгүй гэрэлтүүлэг ч байхгүй. Өвлийн улирал ойртож байгаа болохоор эрт харанхуй болох нь хүүхдүүд байтугай хүүхдээ үүрч яваа хүмүүст ч маш хэцүү байх болно.

(Шилжин суурьшигчидтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Би нийгмийн даатгалд хамрагдаагүй, барьцаа хөрөнгөгүй учраас албан ёсны зээлийн үйлчилгээ авч чадахгүй байна. Иймээс би мобайл аппликейшн, ТҮЦ зэрэг орчин үеийн дэвшилтэт онлайн зээлийн системийг ашиглан зөвхөн банк бус санхүүгийн байгууллагуудаас өндөр хүүтэй жижиг зээл авдаг. Эмэгтэйчүүд хүүхдүүдийнхээ мөнгийг барьцаалж, гэрийнхээ өдөр тутмын хэрэгцээг хангаж байгаа талаар ярилцлагад оролцогчид хэлж байлаа.

Хот суурин газрын хувийн эмнэлэгүүд бүртгэлгүй хүмүүст өндөр үнээр үйлчилдэг, улсын эмнэлгийн үйлчилгээний чанар муу, ялангуяа харилцаа муутай, хүнд суртал ихтэй, иргэдийг ялгаварлан гадуурхсан хандлагатай, олон хоног хүлээж байж үзлэг оношилгоонд хамрагддаг, түүгээр ч барахгүй хойшлуулсаар заримдаа бүтэлгүйтдэг зэрэг олон асуудал байна. Амьжиргааны түвшин доогуур, эмзэг бүлгийн иргэд эмнэлгийн үйлчилгээнд сэтгэл дундуур байгаа ч цаашид үзүүлэх, эм авах шаардлагатай тул гомдол, санал хүсэлтээ шууд гаргаж чадахгүй байна.

Кейс 7. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахын тулд их хичээж хүнд суртлыг давах хэрэгтэй болдог.

Даваа гаригт шүд минь айхтар өвдөж байсан ч Пүрэв гаригт л цаг авч чадсан. Би урт дараалалд зогсох хэрэгтэй болсон. Би өөр 2 хүнтэй ээлжлэн харуулын ажил хийдэг. Пүрэв гаригт жижүүртэй байсан ч хамт ажилладаг хүнээ орондоо байж байхыг гуйж, чөлөө аваад цагтаа ирсэн. Гэсэн хэдий ч миний өмнө цаг авсан хүмүүс ороогүй урт дараалал үүссэн байв. Би ганцхан цагийн чөлөө авсан болохоор амжихгүй гараад явсан. Шүдний өвдөлт тэсэхийн аргагүй байсан тул маргааш нь архи ууж байгаад шүдээ өөрөө сугалсан.

(Шилжин суурьшигч эрэгтэйчүүдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Дархан-Уул аймаг)

Хөнгөлөлттэй эм авах асуудал гардаг. Өрхийн эмнэлгүүд даралт бууруулах эмийг шууд бичдэг бөгөөд бусад эмийг зөвхөн нарийн мэргэжлийн эмчийн жороор өгдөг. Иймээс бид энэ боломжийг үргэлж ашиглаж чаддаггүй. Заримдаа эмийн сангуудад хямдралтай эмүүдийн хангамж муу байхад эсрэгээрээ хямдралгүй эмүүд элбэг байдаг. Эм тариа олгох хугацааг тогтоочихдог, хугацаа хэтэрвэл эм олгохгүй байгааг Фокус бүлгийн ярилцлагад оролцсон хүмүүс шүүмжилж байсан.

Хүмүүс хөдөөнөөс хот руу шилжин суурьшиж байгаа гол зорилго нь хүүхдүүдээ хотын сургуульд сургах явдал юм. Тэд сайн боловсрол эзэмшээгүй, ур чадвар муутай учраас өөрсдийнхөө алдааг хүүхдүүд дээрээ давтахгүйн тулд эхнэр, ээжүүд нь дагалдан явж хүүхдүүдээ хотын сургуульд сургаж, асарч халамжилж байна. Эмэгтэй хүн гэр бүл, үр хүүхдээ асарч халамжлах ёстой гэж үздэг хүмүүс, ялангуяа эрчүүд олон байна.

Кейс 8. Эмэгтэй хүн өглөө эрт ажилдаа гарахад гэрийн бүх ажил тэр хэвээрээ үлдэнэ.

Эмэгтэйчүүд ихэвчлэн нийтийн хоол, гал тогоо, нарийн боовны газарт ажилладаг. Өглөө эрт 5.00 цагт би эхнэртэйгээ талх нарийн боовны газарт ажилладаг байсан. Бидэнд цалин хөлсийг маань цаг тухайд нь өгдөггүй байсан. Эцэст нь гурилан бүтээгдэхүүнээ дэлгүүрээр дамжуулан хямд үнээр зардаг болсон. Эмэгтэй хүн өглөө эрт ажилдаа гарахад гэрийн бүх ажил тэр хэвээрээ үлддэг.

(Шилжин суурьшигч эрэгтэйчүүдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Дархан-Уул аймаг)

Газарзүйн байршил (байгаль орчны доройтол, тээвэр, технологи зэрэг байршлаас шалтгаалсан алслагдмал байдал, эрсдэл, орхигдол)

Багийн засаг дарга, захиргааны ажилтнуудтай ойр дотно амьдардаг бол тэднээс түр байр, гурил болон бусад хүнсний зүйлс олж авах боломжтой, харин эмзэг бүлгийнхэн бүртгэлгүй л бол асуудал улам хүндэрнэ гэж шилжин суурьшигчидтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид ярьж байсан.

Оршин суугаа газартаа бүртгэлгүй бол сонгуульд оролцох боломжгүй, халамжийн мөнгө, хүнсний талон авч чадахгүй байна. Шилжин ирэгсэдийг урьдаггүй учир тэд багийн хуралд оролцож чаддаггүй гэж ярьж байлаа.

Кейс 9: Харьяа хороо дүүрэгтээ бүртгэлгүй учраас халамжийн мөнгө авч чаддаггүй.

Манай баг надаар орон сууцны үүдний цэвэрлэгээг 3 удаа халамжийн мөнгөөр хийлгэсэн. Эхний удаад нь багийн засаг дарга Дарханд оршин суудаг хүний нэрээр мөнгийг нь гаргаж надад өгсөн. Дараа нь би УБ-ын хаягтай учраас хөлс өгөөгүй. Гурав дахь удаад нь би ажлаа хийсэн ч мөнгөө авч чадаагүй.

(Шилжин суурьшигч эмэгтэйчүүдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Дархан-Уул аймаг)

Эмзэг байдал, хямрал (байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшиг, хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, эдийн засгийн болон бусад хямралд өртөмтгий нутаг дэвсгэр, хүн ам)

Хотод агаарын бохирдлоос илүү хөрсний доройтол, нүхэн жорлонгийн асуудал хурцаар тавигдаж байна. Жорлон/нийтийн траншейны асуудлыг шийдвэрлэхээр АХБ-ны төсөл хэрэгжиж байсан ч чанар нь маш муу байсан гэж Фокус бүлгийн ярилцлагад оролцсон гэр хорооллын оршин суугчид хэлж байна. Хөрсний асуудал шийдэгдчихвэл газар дээрээ ногоо тарьмаар байна.

Архидан согтуурах явдал их байна. Мөн хулгай бол гэмт хэрэг бөгөөд хохирол бага биш ч гомдлыг хүлээж авдаггүй. Гудамжны гэрэлтүүлэг муу, автобусны буудал дор хаяж 4-10 км зайтай учир шавар шавхайтай замаар зорчиход хүнд байдаг.

Хотын ядуу хүмүүсийн хувьд КОВИД-19 цар тахлын үеэр орлогын бүх гол эх үүсвэрүүд нь зогссон учир тэд зөвхөн халамжийн мөнгөөр амьдарч байна хэмээн Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид ярьж байв.

Ялгаварлагдах буюу орхигдоход хүргэж буй ямар хүчин зүйлс, илрэлүүд байна вэ?

Иргэдийн өөрсдийнх нь нийгмийн оролцоо, идэвх сул байна. Хүнсний ногоо хураах, хог цэвэрлэх ажилд тэднийг хүчээр оролцуулж байна. Оногдсон үүргээ биелүүлэхгүй тохиолдолд хүнсний талон авах эрхийг хасах жишээтэй.

Малчны зээлд хамрагдах эрхээ хадгалахын тулд шилжиж ирсэн газраа бүртгүүлэхгүй байна. Энэ нь тэдний хүүхдүүд сургуульд орох боломжгүй болох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

5

ЭНЭ БҮЛГИЙГ ДЭМЖИХИЙН ТУЛД ЭРХ ЭДЛЭГЧИД, ҮҮРЭГ ХҮЛЭЭГЧДИЙН ЗҮГЭЭС ЯМАР АРГА ХЭМЖЭЭ, САНААЧЛАГА ГАРГАЖ БОЛОХ ВЭ?

Ажлын байр, цагийн ажил, хөдөлмөрийн норм, норматив, цалин хөлсний асуудлаарх ажил олгогчдод чиглэсэн хяналтыг сайжруулж хөдөлмөрийн хуулийн талаар тодорхой тайлбарлаж өгөх шаардлагатай.

ФОКУС БҮЛЭГ: 7. ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ: АХМАД НАСТАН

1

ДЭД БҮЛГҮҮД,
ТЭДГЭЭРИЙН ШИНЖ
БАЙДАЛ

- 56-78 насны ахмад настан

2

ОРХИГДОХ
ЭРСДЭЛТЭЙ ДЭД
БҮЛГҮҮД

- Бага тэтгэвэртэй ахмад настан
- Хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй ахмад настан
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өндөр настай эцэг эхээ асран халамжилж байгаа ахмад настан
- Хүүхэдгүй ганц бие ахмад настан
- Хөдөлмөр эрхэлж байгаа ахмад настан

3

ЯЛГАВАРЛАГДАХ
ХЭЛБЭРҮҮД
(ОРХИГДОХ/
ЯЛГАВАРЛАГДАХАД
ХҮРГЭЖ БУЙ ЯМАР
ШАЛТГААНУУД
БАЙНА ВЭ? ҮНДСЭН
ШАЛТГААН НЬ ЮУ
ВЭ?

Тэтгэврийн доод хэмжээ амьжиргааны доод түвшинд ойр байгаа нь орлого багатай ахмадууд ядуу амьдарч байгаагийн гол шалтгаан болж байна.

Инфляци, үнийн өсөлтөөс шалтгаалж хүнс, өргөн хэрэглээний бараа, эм тарианы үнэ нэмэгдэж байна. Энэ нь тэтгэврээс өөр орлогогүй ахмадуудыг ядуурах эрсдэлд оруулж байна.

Ахмад настнууд нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгт хамрагдах эсэх нь засаг захиргааны нэгж, хороо, сумдын эрх барьж байгаа намаас ихээхэн шалтгаалдаг хэмээн Фокус бүлгийн ярилцлагад оролцсон ахмадууд шүүмжилж байлаа.

Кейс 1. Намын харьяалал, аль намыг дэмжиж байгаагаас нийгмийн халамж хүртэх эсэх нь шалтгаалдаг

Өнөөдөр намын харьяалал ихээхэн нөлөөтэй болсон, эрх баригч намыг дэмждэггүй, нам бус ахмадууд хорооноос олгодог нийгмийн халамжаас хасагдаж, зохион байгуулсан арга хэмжээнд оролцох боломжгүй байна. Миний олон жилийн ажиглалтаар аль нам нь тухайн багт эрх барьж байгаагаас хэн тусламж авах вэ гэдэг нь шалтгаална. Энгийнээр хэлбэл, дэмжлэг авах эсэх нь аль намд харьяалагдахаас хамаарна. Та аль намыг дэмжиж байна тэр нам нь дэмжинэ гэсэн үг.

(Г. Эрэгтэй. 65 настай, бүлгийн ахлагч, Ахмад настнуудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Дархан-Уул аймаг)

4

ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАЛТЫН
ЯМАР ХЭЛБЭРҮҮД
БАЙНА ВЭ?

Ялгаварлан
гадуурхал (өөрийнх
нь болон өөрийг
нь илэрхийлж буй
ондоошил буюу
шинж байдал)

Хөгжлийн бэрхшээлтэй ахмад настнууд үйлчилгээний төв, хороонд хүртэл шууд ялгаварлагдаж байна.

Ахмад настнуудын эрүүл мэнд, чөлөөт цагаа өнгөрөөх боломж хомс байна

Халамжийн тэгш бодлого нь нэн ядуу, эмзэг бүлгийн ахмадуудад ямар ч нөлөө үзүүлэхгүй байна.

Тэтгэврийн зөрүү их байна.

Ахмад настнуудыг орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжсэн боловч зорилтот бүлэгт хүрч чадаагүй, шударга бус хуваарилагдсан.

Захиргааны түвшинд ахмадуудыг намын харьяалал, үзэл бодлоор нь ялгаварлаж байна.

Кейс 2. Төрийн үйлчилгээг ахмад настнуудад ялгавартай хүргэж байна.

Тухайлбал, банкинд дараалалд байгаа тэргэнцэртэй иргэдийг ялгаварлаж, өөрөөр ханддаг. Ахмадууд ч дотроо бие биенээ ялгаварлаж ханддаг. Тэтгэвэрт гарсан хуульч, хөгжлийн бэрхшээлтэй хүн аль нь ч байсан боловсролын түвшин, амьжиргааны байдлаар нь ялгаж харьцах хандлага ажиглагддаг. Ийм ялгаварлан гадуурхах хандлага нь халамжийн байгууллага ахмадуудад амралтын эрхийн бичиг олгоход хүртэл илт ажиглагддаг. Жирийн нэг хөгшин орж ирээд амралтын эрхийн бичиг гуйхад тэр дороо татгалздаг бол өндөр албан тушаал эрхэлж байсан, чинээлэг маягийн ахмадууд орж ирээд л шууд авна. Ийм ялгаварлан гадуурхалт их байна.

(Ахмад настнуудтйн хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Засаглал (Хүний
эрхэд суурилан
хөгжих хандлагын
хүрээнд тулгарч
буй чадавхын
бэрхшээл, хууль
тогтоомж, бодлого,
татвар, төсөв,
хуваарилалтын
нөлөөлөл, засгийн
газрын шийдвэр
гаргах үйл явцад
оролцох чадвар гэх
зэрэг нөлөөллийг
харгалзах)

Тэтгэврийн доод хэмжээ хэт бага /350,000 төгрөг/ байна.

Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хэрэгжиж байгаа ч нэн шаардлагатай ахмадуудад хүрэхгүй байна.

Ахмадуудын тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг бага зэрэг нэмэгдүүлснээр өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх нь гарцаагүй. Өрхийн зарлага тэтгэврийн нэмэгдлээс илүү нэмэгдэж байна.

Орлого багатай ахмадууд шаардлагатай эм тариагаа авч чадахгүй байна.

Эрүүл мэндийн даатгалаас хөнгөлөлттэй үнээр авах эмийг ихэвчлэн нарийн мэргэжлийн эмчид ганц хоёр удаа биечлэн ирж бичүүлж авдаг. Ихэнхдээ урт дараалал үүсдэг тул хэвтэрт байгаа ахмад настнууд хурууны хээгээ уншуулах шаардлагатай болдогийг Фокс бүлгийн ярилцлагад оролцсон ахмадууд хамгийн хүнд сурталтай үйл явц гэж үзэж байна.

Төрөөс ахмадуудад үзүүлж буй дэмжлэгийн арга хэмжээ нь тэдний хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, тэгш хүртээмжгүй байна.

Кейс 3. Авч буй арга хэмжээ нь ахмад настнуудын бодит хэрэгцээнд нийцэхгүй байна.

Тэтгэвэрт гарсан л бол ахмадууд нийгэмд хэн ч биш болж байна. Чадварлаг хэсэг нь зөвлөх, өмгөөлөгчөөр ажиллаж байгаа бол дийлэнхэд нь тийм боломж байдаггүй. Тэтгэвэрт гарах нас эхлэнгүүт ахмадуудаа дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Олон улсын төсөл хөтөлбөрүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илүү чиглэсэн байдаг бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаа нь ахмад настнуудад илүү их цаг зарцуулах болно гэж үзэж байна.

(Ахмад настануудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Дархан-Уул аймаг)

Нийгэм-эдийн засгийн байдал (эмэгтэй, эрэгтэй хүмүүс, хүүхдийн олон шалтгаант ядуурлын байдал)

Нас ахих тусам эрүүл мэндийн асуудал нэмэгддэг. Гэвч орлого багатай, ядуу өрхийн ахмад настнууд нэмэлт тэжээл, дархлааг нь сайжруулах, дэмжих тэжээллэг бүтээгдэхүүн хэрэглэх боломжгүй байна.

Хөдөө орон нутагт амьдарч буй ахмад настнуудын хувьд тэтгэвэр тэтгэмжээс гадна мал аж ахуйгаас орлого олох боломж харьцангуй илүү байдаг бол хот, аймгийн төвийн ахмадууд нэмэлт орлого олох боломжоор хомс байна.

Тэтгэвэр бага, амьжиргааны түвшин хангалтгүйгээс тэтгэвэрт гарсан ч ахмадуудын ажилд орох эрэлт өндөр байна. Энэ нь ялангуяа дээд боловсролтой хүмүүс, ялангуяа хуульч/нягтлан бодогч/багш нарын хувьд илүү ашигтай байна. Харин боловсролгүй, бага боловсролтой ахмад настнуудын боломж маш хязгаарлагдмал байна.

Хөгжлийн бэрхшээлтэй ахмад настанд үзүүлэх халамж шаардлагатай настнуудын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Ганц бие өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, хэвтэрт байгаа ахмадуудыг асарч халамжлах асуудал маш хүнд байна. Ялангуяа КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн үеийн хөл хорионы үед тэд халамж анхаарлаас гадуур орхигдсон.

Ахмад эмэгтэйчүүд хөгжлийн бэрхшээлтэй ач зээ, өндөр настай эцэг эх/хадам эцэг эх, ах эгч нараа асарч халамжлах давхар үүрэг хариуцлага хүлээж байна.

Кейс 4: Ахмад настнууд хөгжлийн бэрхшээлтэй ач, зээ нараа асрах ажилд хамгийн их оролцож байна.

Би 9 настай хөгжлийн бэрхшээлтэй ач охинтойгоо амьдардаг. Би түүнийг төрснөөс нь хойш асарч байгаа. Ээж нь хөгжлийн бэрхшээлийнх нь тэтгэмжийг авдаг.

Би хүү, 3 ач зээгийн хамт амьдардаг. Манай бэр биднийг орхиод явсан. Миний нэг ач хүү хөгжлийн бэрхшээлтэй. Миний хүү ганцаараа ажилладаг. Би ач хүүгээ асардаг.

Би 96 настай ээжтэй. Манайх Дарханд ирээд 3 жил болж байна түрээсийн байранд амьдардаг. Өрхийн орлого маань ээж бид хоёрын тэтгэвэр, дээрээс нь ахмад настан асарсны тэтгэмж зэргээс бүрддэг. Орлого маань эм тариа, түрээсийн зардалд зарцуулагддаг. Би бас эм уух хэрэгтэй. Заримдаа ээжийнхээ эмийг зохицуулахын тулд өөрийнхөө эмийг багасгана.

Би 90 гарсан хадам аавыгаа асардаг. Би тэтгэвэрт гарсан.

Ах маань ганц бие, оюуны бэрхшээлтэй. Тэр бидэнтэй хамт амьдарч байгаа. Гурван ахмад настан хамт амьдардаг. Хэрэв бид өөд болвол ах маань яаж амьдрах бол гэж санаа зовж байна.

(Хөдлмөрийн бэрхшээлтэй хүүхэд, настнууд асардаг ахмадуудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг)

Газарзүйн байршил (байгаль орчны доройтол, тээвэр, технологи зэрэг байршлаас шалтгаалсан алслагдмал байдал, эрсдэл, орхигдол)

Хот суурин, хөдөө орон нутгаас (алслагдсан дүүрэг, хороог оролцуулан) хэр алслагдсан байдлаас шалтгаалан төрөөс ахмадуудад үзүүлж буй эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ, төсөл хөтөлбөрүүдийн хүртээмж, чанар тэгш бус байна.

Уур амьсгалын өөрчлөлт нь мал аж ахуй эрхэлдэг хөдөөгийн ахмад малчдаас илүү их хүчин чармайлт шаардаж байна.

Эмзэг байдал, хямрал (байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшиг, хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, эдийн засгийн болон бусад хямралд өртөмтгий нутаг дэвсгэр, хүн ам)

Хөгжил дэвшилд идэвхтэй хувь нэмрээ оруулж байсан ахмадууд 55, 60 насандаа тэтгэвэрт гардаг бөгөөд нийгэмд тэднийг орон гэргүй, хүүхэд асрагч мэтээр ойлгох хандлага түгээмэл байгаа нь тэтгэвэрт гарсан эхний жилүүдэд тэдэнд сэтгэл санааны дарамт, стресс ихээхэн учруулж байна.

Настай хүмүүс ганцаардлаас айж байраа зарах, орон гэргүй болох, тэтгэврээ бие даан өөрөө авч хэрэглэж чадахгүй байх зэрэг эдийн засгийн болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртөж байна.

Кейс 5. Хүүхдүүдийнхээ амлалтаас болж байраа алдсан.

Эцэг эхээ хууран мэхэлж, өмч хөрөнгийг нь үрэн таран хийж, залилан мэхэлж, гэр оронгүй орхисон олон жишээ бүртгэгдсэн. Миний ойлгосноор, ялангуяа ухамсаргүй, хариуцлагагүй хүүхэдтэй өндөр настай хүмүүс хүчирхийлэлд илүү өртөмтгий байдаг. Манай найзын 2 өрөө байрны нэг өрөөг дандаа ашиггүй, хоосон байна нэг өрөөгөөр сольж өгье гээд хүүхдүүд нь байрыг нь зараад байргүй болгочихсон. Байрыг нь зарчихаад хүүхдүүд нь амлалтаа биелүүлээгүй. Тэгээд хүүтэйгээ хамт амьдарч байгаад хөөгдсөн. Ийм харамсалтай тохиолдол олон бий.

(Өндөр настнуудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Кейс 6. Тэтгэврээ зарцуулах эрхгүй, бүр хэзээ ч авч байгаагүй.

Охин маань миний тэтгэврийг итгэмжлэлээр банкнаас авдаг. Ихэнхдээ нийтийн ахуйн үйлчилгээний төлбөр, хүүхдийн сургалтын төлбөрт зарцуулсан гэж тэр ярьдаг. Уг нь би өөрөө тэтгэврээ авдаг байсан бол өөрт хэрэгтэй зүйлдээ зарцуулна, Гэсэн ч тэд бид бүгдийг дааж байна гэж намайг буруутгах нь олонтаа. Намайг анхаарахаа больчих вий гэж айгаад ярьж чадахгүй байна.

(Өндөр настнуудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Улаанбаатар хот)

Ялгаварлагдах буюу орхигдоход хүргэж буй ямар хүчин зүйлс, илрэлүүд байна вэ?

Настай хүмүүс ажил хийх хүсэлтэй байдаг. Энэ нь нэг талаас бага хэмжээний тэтгэвэр авч байгаа тохиолдолд өрхийн орлогыг нэмэгдүүлэх, нөгөө талаас ганцаардах биш, хамт олонтой байхыг хүсдэг. ӨЭМТ-ийн ахмад настнуудын хэлснээр, нийгмийн сүлжээ нь ялангуяа эрт тэтгэвэрт гарсан хүмүүс, байгууллага нь татан буугдсан, эсвэл дампуурсан, хөдөө орон нутгаас шилжиж ирсэн, ганцаардсан, хаана амьдарч байгаагаа мэдэхгүй хүмүүст онцгой ач холбогдолтой гэж Фокус бүлгийн ярилцлагад оролцсон ахмадууд ярьж байна.

Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй өндөр настан, хэвтрийн ахмад настан, түүнчлэн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ахмад настнуудад эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, тасалдалгүй хүргэх, шаардлагатай бол гэрээр тусламж үзүүлэх хэрэгцээ их байна.

Хүнсний талон нь бодит судалгаанд тулгуурлаагүй байгаа бөгөөд зорилтот бүлэг буюу нийгмийн идэвх султай ахмад настнууд тус хөтөлбөрт хамрагдахгүй байна.

Кейс 7. Улсад олон жил ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан ч тэтгэвэр тогтоолгох боломжгүй.

Би тэтгэвэрт гарах асуудлаар олон жил хөөцөлдсөн. Би бичиг баримтаа бүрдүүлж дуусгаад өгсөн ч хариу арга хэмжээ аваагүй. Нийгмийн даатгал дутуу төлөгдсөн бол гүйцээж төлөөд тэтгэвээ авах бүрэн боломжтой. Гэсэн хэдий ч миний ажилласан жилүүдийг тооцоод урт хугацаанд ямар ч зохицуулалт хийгээгүй. Уг нь миний нийгмийн даатгалын дэвтэрт нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн бүртгэсэн байгаа. Нийгмийн даатгалын ажилтнууд дэмжихийн оронд хүнд суртал гаргаж ахмад настныг боловсрол, ажил мэргэжил, гадаад төрхөөр нь ялгаварлан гадуурхдаг.

Нийгмийн даатгалын ажилтнууд, аж ахуйн нэгжийн нягтлан бодогч нараас болж иргэд их хохирч байна. Олон хүмүүс ижил асуудалтай тулгарсан. 1990-ээд оноос хойш нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээллийг компьютерт бүртгэдэг болсон гэсэн. 1995 оноос хойш 4 жил нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй байна гэсэн. Нийгмийн даатгалын дэвтрээ үзүүлсэн чинь бүртгэл нь системд байхгүй байна гэсэн. Миний ажиллаж байсан байгууллага бүртгэлд ордог эсэхийг мэдэхгүй. Намайг олон жил ажиллачихаад байхад яагаад ийм асуудалтай тулгараад байгаа талаар тэд бодож үзэхгүй байна.

(Ахмад настнуудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Дархан-Уул аймаг)

Кейс 8. Хөгжлийн бэрхшээлтэй, хэвтэрт байгаа, байнгын асаргаа сувилгаатай өндөр настнуудын хувьд халуун ус, тохьтой бие засах газартай байх нь маш чухал.

Би түрээсийн байранд амьдарч ээжийгээ асардаг. Ээж маань 90 гаруй настай, хөгжлийн бэрхшээлтэй. Халуун ус, дулаан тохьтой бие засах газартай байх нь бидний хувьд маш чухал. Сарын түрээс 360,000 төгрөг. Хямдхан орон сууцанд халуун ус байдаггүй, бие засах газар нь ихэвчлэн гадаа байдаг. Ийм байр хямд ч тэр даруй олдохгүй. Би астма өвчтэй, зүрх муутай. Эрүүл мэндийн асуудалтай, өндөр настай эцэг эхээ асарч буй өндөр настнуудын орон сууцны асуудлыг төрөөс анхаарах хэрэгтэй.


(Ахмад настнуудтай хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас, Дарха-Уул аймаг)

5

ЭНЭ БҮЛГИЙГ
ДЭМЖИХИЙН
ТУЛД ЭРХ
ЭДЛЭГЧИД, ҮҮРЭГ
ХҮЛЭЭГЧДИЙН
ЗҮГЭЭС ЯМАР
АРГА ХЭМЖЭЭ,
САНААЧЛАГА ГАРГАЖ
БОЛОХ ВЭ?

- Ахмад настнуудад зориулсан орон сууц,
- Тэтгэврийн шинэчлэл,
- Ахмад настнуудын асаргаа сувилгаа,
- Эрүүл мэнд, хоол тэжээлийн хөтөлбөрөөр ахмад настнуудыг хүнсний нэмэлт тэжээлээр хангах,
- Ахмад настнуудын тэтгэвэрт гарсны дараах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг төрөөс дэмжих нь чухал байна.

ХАВСРАЛТ 3: ХҮНИЙ ЭРХИЙН ЭЭЛЖИТ ДҮГНЭЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (UPR), НҮБ-ЫН ГЭРЭЭНИЙ ХОРООДООС МОНГОЛ УЛСАД ӨГСӨН ЗӨВЛӨМЖҮҮД: ТХЗ-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

ТХЗ	Зөвлөмжүүдийн хураангуй	Хүний эрхийн асуудлууд, Зорилтот хүн ам
 <p>ТХЗ 1 ЯДУУРЛЫГ УСТГАХ</p>	<p>A/HRC/46/9 (UPR 2020)</p> <ul style="list-style-type: none"> • хүн амын, ялангуяа нэн эмзэг бүлгийн амьдралын чанарыг сайжруулахын тулд халамж, нийгмийн хөтөлбөрүүдийг бэхжүүлэх, • ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн салбар дундын уялдаа, хэрэгжилтийг сайжруулах, • зохистой орон сууцаар хангагдах эрхийг хангахад онцгой анхаарч, ядууралтай тэмцэх, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх. <p>CEDAW/C/MNG/CO/8-9 (CEDAW 2016)</p> <ul style="list-style-type: none"> • эмэгтэйчүүд, ялангуяа хөдөө нутгийн болон өрх толгойлсон эмэгтэйчүүд, өндөр настай эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийн нэгэн адил төсөл, хөтөлбөрүүдэд эрх тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэх замаар эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд эрх мэдэлжүүлэх, • хөдөөгийн эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн хууль зүйн үйлчилгээ, боловсрол, орон сууц, хөдөлмөр эрхлэлт, ур чадвараа хөгжүүлэх, орлого олох боломж, газар өмчлөх, ашиглах боломж зэрэг бүхий л боломж нөхцөлийг хангахад чиглэсэн хөдөөгийн эмэгтэйчүүдийн ядууралтай тэмцэх бодлогыг боловсруулах. 	<ul style="list-style-type: none"> • Хүний эрх, ядуурал • Амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрх • Нийгмийн хамгаалалд хамрагдах эрх <p>Зорилтот хүн ам:</p> <ul style="list-style-type: none"> • Ядуурлын түвшинд амьдарч байгаа хүмүүс • Хүүхэд, эмэгтэйчүүд



ТХЗ 2 ӨЛСГӨЛӨНГ ЗОГСООХ

A/HRC/46/9 (UPR 2020)

- Нийгмийн халамжийн тусламж дэмжлэг шаардлагатай айл өрхүүдэд үзүүлж буй хоол тэжээлийн дэмжлэгийн үйлчилгээг үргэлжлүүлэх

CERD/C/MNG/CO/23-24 (CERD 2019)

- цаатан хүмүүстэй харилцан зөвшилцсөний үндсэн дээр ан агнуурын болон загас агнуурын хамгийн бага квотыг тогтоож, тэдэнд соёлын эрх, ёс заншлаа тасралтгүй эдлэх боломжийг олгох,
- цаа буга маллаж ирсэн уламжлалт бэлчээр нутгаа ашиглах эрхийг нь цаатан хүмүүст эдлүүлж, тэднийг Тэнгис, Шишгэдийн тусгай хамгаалалттай газрын удирдлагын үйл ажиллагаанд оролцуулах.

CRC/C/MNG/CO/5 (CRC 2017)

- Тав хүртэлх насны хүүхдүүдэд нэн шаардлагатай бичил тэжээлийг хүртээмжтэйгээр хангах, ялангуяа, хөдөө орон нутгийн болон амьжиргааны түвшин доогуур айл өрхийн хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулж, хүнс түгээх явцад хоол тэжээлийн талаар зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах,
- хүүхдийг эхийн сүүгээр хооллох асуудлаарх үндэсний бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг баталгаажуулах, сурталчлан таниулах арга хэмжээ авах,
- эрүүл бус хоол, ундааны сурталчилгааг хүүхдэд чиглүүлэхгүй байх хууль тогтоомжийг боловсруулж, эрүүл хооллолтыг сурталчлах, тэр дундаа сургуулиудад үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх

- Хүний эрх, ядуурал
- Хүнсний эрх
- Амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрх
- Нийгмийн хамгаалалд хамрагдах эрх

Зорилтот хүн ам:

- Ядуурлын түвшинд амьдарч байгаа хүмүүс
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс
- Хүүхэд, эмэгтэйчүүд



ТХЗ 3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ

A/HRC/46/9 (UPR 2020)

- хөдөө орон нутагт нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах,
- эх, хүүхэд асрах чиглэлээр үндэсний эрүүл мэндийн нэгдсэн дэд бүтцийг хөгжүүлэх,
- хүүхдийн эндэгдлийг бууруулах,
- хүүхдийн насны онцлогт тохирсон эрүүл мэндийн хичээлийг сургуулийн хөтөлбөрт тусгах,
- бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдээлэл, үйлчилгээг бүх эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байлгах, бүхий л үйл ажиллагаанд тэд чөлөөтэй, мэдээлэлтэй оролцож, шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх
- хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах
- хүмүүсийн нийгэмд оролцох оролцоо дэмжихэд чиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх

CEDAW/C/MNG/CO/8-9 (CEDAW 2016)

- хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд, лесбиян, бисексуал, трансжендер, интерсекс эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, ялангуяа бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх мэдлэг, мэдээллийг сайжруулах, тэдний хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр эмнэлгийн ажилтнуудыг сургах
- умайн хүүзүү, хөхний хорт хавдрын тархалтын талаарх мэдээллийг нарийвчлан цуглуулж, өвчнийг эрт илрүүлэх талаарх сургалтыг хөдөө орон нутгийнхныг хамруулан эмнэлгийн болон эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулах

CCPR/C/MNG/CO/6 (CCPR 2017)

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрт илрүүлэг, эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бүрэн хамрагдах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг яаралтай авах

- Эрүүл мэндээ хамгаалуулах эрх
- Хүний эрх ба ядуурал
- Жендэрийн эрх тэгш байдал

Зорилтот хүн ам:

- Хүүхэд
- Эмэгтэйчүүд, охид
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс
- Хөдөө нутагт амьдарч байгаа хүмүүс



ТХЗ 4 ЧАНАРТАЙ БОЛОВС- РОЛЫГ ДЭМЖИХ

A/HRC/46/9 (UPR 2020)

- хүүхэд бүрийг боловсролын бүх шатны үйлчилгээнд тэгш хамруулан суралцахыг баталгаажуулах, ялангуяа эмзэг бүлгийнхний хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулах
- үндэстний болон хэлний цөөнхийн боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж бэхжүүлэх
- хүний эрхийн боловсролыг төрийн бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгон хэрэгжүүлэх
- орчин үеийн боловсролын арга барил, шинэ технологийг насан туршийн боловсролын үйлчилгээнд нэвтрүүлэхийг дэмжих
- хүмүүсийн бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийллийг агуулсан ялгаварлан гадуурхалтгүй байх бодлогыг бүх шатны боловсролын байгууллагад нэвтрүүлэх
- эрүүл мэндийн ажилтнууд, шүүх, цагдаа, хорих ангийн ажилтнуудад хүний эрх, ялгаварлан гадуурхалттай тэмцэх чиглэлээр сургалт зохион байгуулах

CERD/C/MNG/CO/23-24 (CERD 2019)

- угсаатны бүлэг, уугуул иргэдэд зориулж төрийн албан ёсны хэл болон тэдний төрөлх хэл дээр боловсролын чанартай үйлчилгээг үзүүлэх, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тусгай арга хэмжээ авахад шаардагдах төсөв хөрөнгийг хуваарилах
- устах аюулд орсон долоон эх хэлийг хамгаалах
- Цаатан (Духа) оюутнуудыг их сургуульд элсэн суралцах боломжийг нэмэгдүүлж тусгайлсан квот тогтоож, тэтгэлэг олгох

- Сурч боловсрох эрх
- Эрх тэгш байх, ялгаварлан гадуурхахгүй байх
- Хүний эрхийн боловсрол, сургалт, сурталчилгаа нөлөөлөл

Зорилтот хүн ам:

- Хүүхэд
- Эмзэг бүлгийн хүн, хүмүүс
- Боловсролын ажилтнууд, сурагчид
- Төрийн албан хаагчид



ТХЗ 5 ЖЕНДЭРИЙН ЭРХТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ

A/HRC/46/9 (UPR 2020)

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн салбар дундын болон засгийн газрын үйл ажиллагааг үргэлжлүүлэх,
- шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх,
- эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, хүчирхийлэх, тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн хууль тогтоомжийн бүрэн, үр дүнтэй хэрэгжилтийг хангах,
- эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг тэмцэх, хохирогчдод зохих тусламж, дэмжлэг үзүүлэх,
- гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлж, салбар хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх,
- нөлөөлөл сурталчилгааны ажлыг зохион байгуулж, хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг үр дүнтэй, хохирогч төвтэй арга хандлагад сургах,
- ажлын байран дахь жендэрт суурилсан асуудал, өрөөсгөл хандлагыг даван туулах арга барилыг эмэгтэйчүүдэд эзэмшүүлэх, чадваржуулах сургалтын хөтөлбөр боловсруулах.

CEDAW/C/MNG/CO/8-9 (CEDAW 2016)

- уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшгийн эсрэг харму арга хэмжээ авах, эрсдэлийг бууруулах зэрэгтэй холбоотой үндэсний бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөнд жендэрийн асуудлыг тусгах,
- өрх толгойлсон эхчүүд, эмэгтэйчүүдэд олгох гэр бүлийн тэтгэмжийн хэмжээг дахин хянаж, эхчүүд, эмэгтэйчүүд болон тэдгээрийн хүүхдийн амьжиргааны зохистой түвшинг хангах хэмжээнд хүргэх,
- өрх толгойлсон эхчүүдийг эдийн засгийн хувьд чадавхжуулах, тэдэнд төлбөрийн чадварт нь нийцсэн орон сууц, боловсрол, мэргэжлийн сургалт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй байлгах зорилтот арга хэмжээ, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл
- Хохирогч, гэрчүүдийг хамгаалах
- Эрх зүйн тусламж, үйлчилгээний хүртээмж
- Бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл

Зорилтот хүн ам:

- Хууль сахиулах байгууллага, цагдаа, хорих ангийн ажилтнууд
- Эмэгтэйчүүд, охид
- Шүүгчид, хуульчид, прокурорууд



**ТХЗ 6
БАТАЛГААТ
УНДНЫ
УС, АРИУН
ЦЭВРИЙН
БАЙГУУЛАМ-
ЖААР ХАНГАХ**

A/HRC/46/9 (UPR 2020)

- хүний амьдрах цэвэр орчин, ундны усаар хангагдах эрх, ялангуяа газар тариаланчид, уламжлалт мал аж ахуй эрхлэгчдийн амьжиргаа, соёл, аж байдлыг хүндэтгэн хамгаалахын тулд тэдний эрхийг хамгаалах.
- хөдөөгийн хүн амын ундны ус, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэх.

CRC/C/MNG/CO/5 (CRC 2017)

- агаарын бохирдлын хүүхдэд үзүүлэх нөлөөллийг бууруулах, өвлийн улиралд нүүрснээс бусад аргаар халаах боломжит хувилбаруудын хүртээмжийг нэмэгдүүлж хүүхдэд зориулсан тусгай арга хэмжээ авах,
- ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг баталгаажуулж, хүүхдийг агаарын бохирдлын хор уршгаас хамгаалахыг үндэсний бодлогын тэргүүлэх чиглэл болгон тунхаглах,
- орчны бохирдлоос хүүхдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг үр дүнтэй бууруулахад чиглэсэн хөтөлбөрүүдэд техник, санхүүгийн хангалттай хөрөнгө нөөцийг хуваарилах,
- орон нутагт ажиллаж буй албан хаагчдыг агаар, ус бохирдуулагчдад хяналт шинжилгээ, зохицуулалт хийх мэргэжлийн мэдлэг, чадвар, арга хэрэгслээр хангах.

A/HRC/39/55/Add.2 (SR Water & sanitation 2018)

- сургуулиудын ариун цэврийн байгууламжийг сайжруулахад шаардагдах санхүүгийн дэмжлэгийг шийдвэрлэх замаар боловсролын байгууллагуудын ариун цэврийн байгууламжийн тасралтгүй үйлчилгээг хангах,
- зохих шаардлагыг хангасан ариун цэврийн байгууламж, дэд бүтэц, хангамжийг сайжруулах замаар охидын сарын тэмдгийн үеийн хэрэглээ, ариун цэврийн шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг сургууль, дотуур байруудад хэрэгжүүлэх.

- Хүний эрх, байгаль орчин
- Баталгаатай ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрх
- Сурч боловсрох эрх
- Эрх тэгш байх, ялгаварлан гадуурхалгүй байх эрх

Зорилтот хүн ам:

- Хөдөө орон нутгийн хүн ам
- Хүүхэд
- Боловсролын байгууллагын ажилтнууд, суралцагчид
- Төрийн албан хаагчид



ТХЗ 8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ

A/HRC/46/9 (UPR 2020)

- Үндэсний хэмжээнд хөдөлмөрийн хяналтын дүрэм журмыг сайжруулах,
- ажилгүйдлийн түвшинг бууруулах, ялангуяа малчид, залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах,
- эмэгтэйчүүд, охид, тэдний гэр бүлийнхний боловсрол, эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх,
- эмэгтэйчүүдийн эдийн засгийн албан ёсны үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих,
- ажлын байранд эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах, бэлгийн дарамт үзүүлэхийг таслан зогсоох,
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулах,
- хүүхдийг бие махбодийн болон сэтгэл зүйн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийг аюултай болон хортой нөхцөлд хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлэх,
- шилжин суурьшигчдыг хөдөлмөрийн ижил нөхцөлтэй болгоход чиглэсэн үр дүнтэй хяналтын механизмыг бий болгох замаар шилжин суурьшигчдын амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулах.

CEDAW/C/MNG/CO/8-9 (CEDAW 2016)

- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүх төрлийн хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй болгохын зэрэгцээ мэргэжлийн сургалт, зээлийн таатай нөхцөл, орлого нэмэгдүүлэх зэрэг эмэгтэйчүүдийн бизнес эрхлэхийг дэмжих зорилго агуулсан бүх төрлийн хөтөлбөрийн үр ашгийг эмэгтэйчүүд бүрэн хүртэх нөхцөлийг бүрдүүлэх.

CCPR/C/MNG/CO/6 (CCPR 2017)

- хүүхдийн хөдөлмөрийг устгах, ялангуяа, хүүхдийг хурдан морь унуулж уралдуулахыг хориглох арга хэмжээ авах

CRC/C/MNG/CO/5 (CRC 2017)

- хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах цогц бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө батлан, хүний, техникийн болон санхүүгийн хангалттай хөрөнгө нөөц зарцуулахжил бүрийн 11 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-ний хооронд 16-аас доош насны хүүхдийг хурдан морины уралдаанд оролцуулахыг хориглох.

- Хөдөлмөрийн эрх, хөдөлмөрлөх эрх
- Хүүхэд: хөдөлмөрийн мөлжлөгөөс хамгаалах
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс: бие даасан байдал, тэгш хамруулах

Зорилтот хүн ам:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс
- Хүүхэд
- Эмэгтэйчүүд, охид
- Шилжин суурьшигчид



ТХЗ 9

ИННОВАЦ, ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

CEDAW/C/MNG/CO/8-9 (CEDAW 2016)

- Хөдөө орон нутагт дэд бүтцийг сайжруулах, хөдөөгийн эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрх зүй, боловсрол, орон сууц, аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламж, албан ёсны хөдөлмөр эрхлэлт, ур чадвараа хөгжүүлэх, сурах, орлого нэмэгдүүлэх, бичил зээл, газар эзэмших, өмчлөх, ашиглах зэрэг бүхий л боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн ядууралтай тэмцэх бодлого боловсруулах, шаардлагатай тохиолдолд олон улсын тусламж, хамтын ажиллагааны хөтөлбөрүүдэд хандах,
- Бүлэг, хамт олны түвшинд шийдвэр гаргах үйл явцад хөдөөгийн эмэгтэйчүүдийн оролцоог эрэгтэйчүүдтэй адил тэгш хангах;
- хөдөөгийн хөгжлийн эдийн засаг, нийгмийн стратегийн эмэгтэйчүүдийн хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг судалж, хөдөөгийн эмэгтэйчүүдийн талаар тодорхой, нарийвчилсан задаргаатай тоо мэдээлэл цуглуулах;
- уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигтай тэмцэх хариу арга хэмжээ, эрсдэлийг бууруулах, түүнчлэн уул уурхай зэрэг үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаанаас үүдэх байгаль орчин, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар зэрэг асуудлыг хөндсөн үндэсний бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөнд жендерийн үзэл баримтлалыг тусгах, ингэхдээ эмэгтэйчүүд зөвхөн хохирогч бус эдгээр бодлого хөтөлбөрийн идэвхтэй оролцогч гэсэн агуулгаар оруулах.

- Улс хоорондын хамтын ажиллагаа, тусалцаа
- Хууль эрх зүйн болон институтийн шинэчлэл
- Газар, эд хөрөнгө өмчлөх эрх
- Зохиистой орон сууцаар хангагдах эрх

Зорилтот хүн ам:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс
- Эмэгтэйчүүд, охид
- Төрийн албан хаагчид



ТХЗ 10 ТЭГШ БУС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ

A/HRC/46/9 (UPR 2020)

- нийтийн болон хувийн амьдралын аль алинд хамаарах шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтын эсрэг цогц хуулийг баталж хэрэгжүүлэх,
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалттай тэмцэж, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг бүрэн хэрэгжүүлэх талаар эдгээр хүмүүсийн эрх ашгийг хамгаалах байгууллагуудад зөвлөгөө өгөх албан ёсны болон байнгын механизмыг бий болгох,
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цогц хөгжлийг дэмжих бодлого боловсруулах,
- гудамжны нөхцөлд байгаа хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн тэдний боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ авах, амьжиргааны баталгаажих доод түвшинг хангуулах эрхийг хамгаалах асуудлыг хүн амын эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын бодлогод тусгаж шийдвэрлэх,
- эмзэг бүлгийн хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудын эрхийг хамгаалах,
- шийдвэр гаргах үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх,
- Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар ижил хүйстэн хосын гэрлэлтийг хууль ёсоор хүлээн зөвшөөрч, хамгаалах.

CCPR/C/MNG/CO/6 (CCPR 2017)

- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас хамгаалж, тэдний боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, нийтийн тээвэр, барилга байгууламжид зорчих хүртээмжтэй орчинг бүрдүүлэх,
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхахтай тэмцэх, тэдний талаарх эерэг хандлагыг бий болгох зорилгоор төрийн албан хаагчид, олон нийт, гэр бүлд чиглэсэн нөлөөлөл сурталчилгааны ажлыг зохион байгуулах

CCPR/C/MNG/CO/6 (CCPR 2017)

- албадан нүүлгэлтийн эсрэг зохих эрх зүйн хамгаалалтыг бий болгож, нөлөөлөлд өртсөн хүмүүсийг зохих орон сууцаар хангахыг баталгаажуулах,



ТХЗ 11 ЭЭЛТЭЙ ХОТ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ

- Үндсэн хууль, хууль тогтоомж
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс: ерөнхий зарчим; хамгаалал
- Хүүхэд: тодорхойлолт; ерөнхий зарчим; хамгаалал
- Эмэгтэйчүүдийн дэвшил

Зорилтот хүн ам:

- Хүүхэд
- Ахмад настан
- Эмзэг бүлгийн хүн/хүмүүс
- Эмэгтэйчүүд, охид
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

- Үндсэн хууль, хууль тогтоомж
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс: ерөнхий зарчим, хамгаалал

Зорилтот хүн ам:

- Эмзэг бүлгийн хүн/хүмүүс
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс



ТХЗ 13

УУР
АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛ-
ТИЙН
НӨЛӨӨЛЛИЙГ
БАГАСГАХ

A/HRC/46/9 (UPR 2020)

- уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулах зэрэг салбар дундын байгаль орчны сорилтуудыг шийдвэрлэх шаардлагатай хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх

- Хүний эрх, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин
- Үндсэн хууль, хууль тогтоомж

Зорилтот хүн ам:

- Хөдөө орон нутгийн хүн ам
- Төрийн албан хаагчид



ТХЗ 16

ЭНХ ТАЙВАН,
ШУДАРГА
ЁСЫГ
ЦОГЦЛООХ

A/HRC/46/9 (UPR 2020)

- үндэсний болон салбарын бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх замаар олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх,
- олон улсын хүний эрхийн тогтолцоо, ялангуяа Гэрээний хороод, Хүний эрхийн зөвлөл, Тусгай журмыг хэрэгжүүлэгчидтэй хамтран ажиллах
- олон улсын хүний эрхийн байгууллагууд, механизмудаас гаргасан тайлангийн зөвлөмж, зохицуулалтуудыг дагаж мөрдөх, зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын байнгын бүтэц бий болгон хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавих үндэсний механизмыг бий болгох,
- Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээ, Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенц, Хүн харьяалалгүй байх явдлыг бууруулах тухай конвенц, Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц, Цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц, Гэрийн үйлчилгээний ажилчдын тухай конвенц, 2011 (№ 189) зэрэг олон улсын гэрээ конвенцийг соёрхон батлах асуудлыг судалж үзэх,
- Хувь хүний мэдээлэл гаргах журмын хүрээнд Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх,
- Монгол Улсын Үндсэн хуулиас цаазаар авах ялын тухай заалтыг хасах,
- шүүгч болон бусад албан тушаалтныг дур мэдэн халахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэргээр шүүхийн хараат бус байдал, авлигын эсрэг хяналтыг бэхжүүлэх, хуулийн хамгаалалтыг тууштай хэрэгжүүлэх,
- Парисын зарчмуудад бүрэн нийцүүлэн ХЭҮК-ын хүний нөөц, төсвийн санхүүжилтыг зохистой хэмжээгээр бэхжүүлэх,
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол (OPCAT)-ын шаардлагын дагуу эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бий болгох,
- хүний эрхийг хамгаалагчдыг хүлээн зөвшөөрч, хамгаалсан хууль тогтоомжийг баталж хэрэгжүүлэх,
- Төрийн бус байгууллагын тухай хуулийн төслийн бүртгэл, санхүүжилтийн талаарх заалтыг олон улсын жишигт нийцүүлж шинэчлэн найруулах,

- Үндсэн хууль, хууль тогтоомж
- Олон улсын конвенц, баримт бичгийг соёрхон батлах, нэгдэх
- Хүний эрхийн механизмүүдтэй хамтран ажиллах, техникийн туслалцаа хүсэх
- Хамтын ажиллагаа, Гэрээний хороод, ХЭЭДХ, Тусгай журамууд
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм (NPM)
- Бие махбодийн болон ёс суртахууны нэгдмэл байдлыг хангах эрх

- Бизнес болон хүний эрхийн удирдах зарчмуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө боловсруулах,
- авлигатай тэмцэх, шүүх эрх мэдэл, төрийн албаны хүрээнд авлигатай холбоотой бүх хэргийг шалгах, уул уурхай, дэд бүтцийн төслүүдэд хүний эрх болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх,
- эрх зүйн болон зохицуулалтын орчныг хангах замаар шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг дэмжих,
- хууль ёсны, зайлшгүй шаардлага, пропорциональ байдлын зарчмын дагуу хувийн нууцыг хамгаалах эрхийг илүү сайн хамгаалах, дэмжих үр дүнтэй мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийг батлах,
- хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх, олон нийтийн боловсрол, нөлөөлөл сурталчилгааны хөтөлбөр хэрэгжүүлэх замаар гэр бүл, сургуулийн орчин дахь бие махбодийн шийтгэлийг арилгах.
- асрамжийн газарт байгаа хүүхдэд чанартай халамжийн үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийг дэмжих үйлчилгээг бий болгох, сайжруулах, нийгмийн үйлчилгээ үзүүлэгчдийг чанартай сургалтад хамруулах, хүүхэд, эцэг эхийг шаардлагагүйгээр тусгаарлахаас урьдчилан сэргийлэх,
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд шаардагдах хөрөнгө санхүүжилтыг хуваарилж, хариуцаж буй албан тушаалтнуудад сургалт зохион байгуулах замаар хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх,
- лесби, гей, бисексуал, трансгендэр, интерсекс хүмүүсийн талаарх хэвшмэл ойлголт, өрөөсгөл үзэлтэй тэмцэх, олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулах, хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг үр дүнтэй сургалтад хамруулах,
- эрүүдэн шүүлтийн талаарх гомдлыг шалгах үр дүнтэй, хараат бус гомдлын механизмыг бий болгох,
- хүн худалдаалах гэмт хэргийн мөрдөн байцаалт, яллах ажиллагааг үр дүнтэй явуулах, хохирогчдод үзүүлэх үйлчилгээг илүү сайжруулах,
- орогнол хүсэгчдийг буцаан шилжүүлэхгүй байх зарчмыг хамруулсан олон улсын холбогдох хэм хэмжээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж хамгаалах,

CRC/C/MNG/CO/5 (CRC 2017)

- хөрөнгө нөөцийн хуваарилалтын зохистой харьцаа, үр ашиг, тэгш байдлыг хянаж, үнэлэхэд ашиглах тодорхой шалгуур үзүүлэлт, хяналтын систем бүхий хөтөлбөр, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт хийхэд чиглүүлж төрийн санхүүгийн удирдлагыг шинэчлэх,
- олон нийт, ялангуяа хүүхдийн санал бодлыг сонсох хэлэлцүүлгүүд зохион байгуулах замаар ил тод, иргэдийн оролцоог хангасан төсвийн төлөвлөлт хийх, төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх,
- үр дүнтэй зохицуулалтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх, хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, улмаар бэлгийн мөлжлөгийг устгахад шаардагдах хууль тогтоомж, захиргааны болон нийгмийн бүхий л шаардлагатай арга хэмжээг авах,
- цахим орчинд хүүхдийг хамгаалахад чиглэсэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөр зэрэг интернэт дэх хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах механизмыг хэрэгжүүлэх,
- гудамжны нөхцөлд байгаа хүүхэд бүрийг аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүмүүжүүлэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн тогтвортой, уялдаатай арга хэмжээг тодорхойлоход чиглэсэн үндэсний бодлого, зохицуулалтын тогтолцоог боловсруулж, хангалттай хөрөнгө нөөцийг хуваарилах,

- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрх

Зорилтот хүн ам:

- Хүний эрхийг хамгаалагчид, идэвхтнүүд
- Төрийн албан хаагчид
- Эмзэг бүлгийн хүн/хүмүүс
- Эмэгтэйчүүд, охид
- Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүс, цагдан хоригдогсод
- Шилжин суурьшигчид
- Иргэншилгүй хүмүүс

- морь унаач хүүхдүүд бие махбодын болоод сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх, улмаар сургуулиас завсардах, гэмтэж бэртэх, амь насаа алдах зэрэг эрсдэлтэй хэвээр байгаа тул хүүхдийг морь унаачаар үргэлжлүүлэн ашиглахыг хориглох;
- хурдан морины уралдааны улмаас хүүхэд хүнд бэртсэн, амь насаа алдсан тохиолдлыг шалгаж, буруутай этгээдэд хариуцлага тооцох;
- морин уралдааныг оролцуулан аюултай, хортой нөхцөлд хүүхэд ажиллуулдаг аж ахуйн нэгж, бизнесийн үйл ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагчдын хувийн сонирхол, албан үүргийн хооронд ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхийг судалж хариу арга хэмжээ авах, авлигатай тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх.

[CEDAW/C/MNG/CO/8-9 \(CEDAW 2016\)](#)

- биеэ үнэлэх үзэгдэлтэй тэмцэх, хамгаалах байр, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвүүдээр үйлчилгээ үзүүлэх, нийгэмд нэгдэхэд туслах хөтөлбөрүүд, орлого олох өөр боломжуудыг нээх зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэх,

[CCPR/C/MNG/CO/6 \(CCPR 2017\)](#)

- хохирогчийг ялган тодорхойлох өнөөгийн механизмыг бэхжүүлж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг уг гэмт хэрэгт холбогдсоны төлөө хариуцлага тооцох, буруутгахгүй байх, хохирогчдод зохих эмнэлгийн тусламж, нийгмийн болон эрх зүйн тусалцаа үзүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээ авах боломжоор хангах, нөхөн төлбөр олгох, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байраар хангах зэрэг үйлчилгээ үзүүлэх.



ТХЗ 17 ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

CRC/C/MNG/CO/5 (CRC 2017)

- мэдээлэл цуглуулах тогтолцоог нэн даруй сайжруулах. Тоо мэдээллийг нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, газарзүйн байршил, үндэстэн, угсаатны угсаа гарал, нийгэм-эдийн засгийн байдал зэргээр ангилж, хүүхэд бүрийн нөхцөл байдал, ялангуяа эмзэг бүлгийн хүүхдүүдийн нөхцөл байдалд нарийвчилсан дүн шинжилгээ хийх,
- тоо мэдээлэл, шалгуур үзүүлэлтүүдийг холбогдох яамдад түгээж, конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр, төслийг боловсруулах, хянах, үнэлэхэд ашиглах,
- статистикийн тоо мэдээллийг тодорхойлох, цуглуулах, түгээхдээ НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газраас (ОНСНР) гаргасан Хүний эрхийн үзүүлэлтүүд: статистикийн мэдээллийг тодорхойлох, цуглуулах, түгээхэд баримтлах хэмжилт, хэрэгжүүлэлтийн удирдамжид тусгасан үзэл баримтлал, аргачлалыг анхаарч, нэвтрүүлэх,

CEDAW/C/MNG/CO/8-9 (CEDAW 2016)

- хөдөөгийн хөгжлийн эдийн засаг, нийгмийн стратеги нь эмэгтэйчүүдийн хүний эрхэд хэрхэн нөлөөлж байгааг судалж, хөдөөгийн эмэгтэйчүүдийн талаар тодорхой, нарийвчилсан задаргаатай тоо мэдээллийг цуглуулах,

- охид, эмэгтэйчүүдийг худалдаалах гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчдийг ялласан, ял шийтгэгдсэн байдал, биеэ үнэлж буй эмэгтэйчүүдийн талаарх дэлгэрэнгүй тоо мэдээллийг цуглуулах,

CRPD/C/MNG/CO/1 (CRPD 2015)

- нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр нь ангилан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд суурилсан загварыг ашиглан тоо мэдээлэл цуглуулах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан байгууллагад болон нийгмийн хамгааллын хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх тоо мэдээллийг цуглуулах,

- Хүний эрхийн асуудлууд:
- Хүний эрхийн механизмуудтай хамтран ажиллах, техникийн тусалцаа хүсэх
- Мэдээлэл цуглуулах, судалгаа шинжилгээ
- Нийгмийн хамгаалалд хамрагдах эрх
- Үндсэн хууль, хууль ТОГТООМЖ

Зорилтот хүн ам:

- Төрийн албан хаагчид
- Эмзэг бүлгийн хүн/хүмүүс
- Эмэгтэйчүүд, охид

ХАВСРАЛТ 4: ОЛОН ХЭМЖЭЭСТ ЭРСДЭЛИЙН МАТРИЦ

Эрсдэлүүд (цаашид тулгарах асуудлууд)
Асуудлууд (өнөөгийн тулгарч байгаа асуудлууд)
Нөлөөлөл: Бага, Дунд, Өндөр
Магадлал: Бага, Дунд, Өндөр

ТХЗ	Эрсдлийн хүрээ	Тайлбар	Хамрах хүрээ	Эрсдэлүүд (цаашид тулгарах асуудлууд)	Магадлал	Нөлөөлөл
ТХЗ 16, 17	Улс төрийн тогтвортой байдал	Улс төрийн хүчин зүйлээс үүдэж тухайн нутаг дэвсгэрт тогтсон улс төр, засаглалын тогтвортой байдалд тулгарах эрсдэл	<ul style="list-style-type: none"> Улс төрийн тогтолцоо/ засгийн газарт тулгарах сорилтууд Улс төрийн хувьд засгийн газар/ байгууллагууд харилцан хүлээцтэй хандах Засаглалын бүтэц, зарчимд гэнэт өөрчлөлт орох 	Улс төрийн тогтворгүй байдал давтагдаж хурцадмал байдал үүсэх, Засгийн газар солигдох бүрт Гүйцэтгэх албан тушаалтнууд тогтмол өөрчлөгдөж төрийн албаны чадавх, засаглалын институтуц сулрахад хүргэх, Улс төрийн намууд болон бүх түвшинд авлига газар авах, Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд улс төрчид болон бизнесийн бүлэглэлүүдийн зүгээс үзүүлэх нөлөөлөл нэмэгдсэнээр иргэний орон зай хумигдах.	Бага Өндөр	Өндөр Өндөр
ТХЗ 16, 17	Ардчиллын орон зай	Иргэний орон зай хумигдах, ялгаварлагдах, хэлмэгдүүлэх, айлган сүрдүүлэх зэргээс үүдэж ардчилсан болон хүний эрхийн институтууд, иргэний болон улс төрийн эрхэд учирч болзошгүй эрсдэлүүд	<ul style="list-style-type: none"> Ардчиллын эрх, эрх чөлөөг зүй бусаар хязгаарлах Иргэний нийгэм, хүний эрхийн зүтгэлтэнүүд, эрхийн байгууллагууд хязгаарлагдах Иргэний нийгэм, хүний эрхийн зүтгэлтэнүүд болон бусад хүмүүсийг хүчтэй хэлмэгдүүлэх 	Иргэний орон зай хумигдах, Хүний эрхийг хамгаалагчид болон нийгмийн цөөнхийн бүлгүүдийн эсрэг үзэн ядсан үг хэллэг, ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт, гутаан доромжлол, бие махбодийн халдлага зэрэг асуудлууд гарах	Бага	Өндөр Дунд

ТХЗ 7, 8, 9, 10, 11, 17	Эдийн засаг, санхүү өсөлт, хөгжил цэцэглэлтэд саад учруулах эрсдэл	<ul style="list-style-type: none"> • Саад болох хүчин зүйлс: Эдийн засаг, худалдааны бодлогууд • Олон улсын худалдааны зах зээлийн нөхцөл байдлын таатай нөхцөл, хандлага • Санхүүгийн зах зээл • Эдийн засаг, санхүүгийн өнөөгийн байдал • ТХЗ-ын санхүүжилтийн стратеги • Хот-хөдөөгийн хөгжил • Хот суурин дахь хөнгөн үйлдвэрийн салбарын ажлын байр хомсдох 	<p>Байгалийн нөөцийн орлогын удирдлагыг эдийн засгийн бус харин улс төрийн зорилгоор тодорхойлох,</p> <p>Хөрөнгө оруулалтын орчин тогтворгүй болсноос ГШХО-ын урсгал буурахад хүргэх,</p> <p>Нийгмийн хамгаалал, эдийн засгийг төрөлжүүлэх, ногоон хөгжил зэрэгт шаардагдах үндсэн зардлын төсвийн орон зай хумигдах,</p> <p>Экспортын түүхий эдийн үнэ буурах</p> <p>Дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйл ажиллагааны нөлөөгөөр түүхий нүүрс ашиглахыг хориглох, БНХАУ-ын нүүрсний хэрэглээ буурах,</p> <p>КОВИД-19 цар тахлын дэгдэлт болон хөл хорионоос үүдэлтэй эдийн засгийн хямралаас шалтгаалж дотогш чиглэсэн мөнгөн гуйвуулгын урсгал буурах,</p> <p>УБ хотод тохиож болзошгүй газар хөдлөлтийн эрсдэл дэд бүтцийн хөрөнгө оруулалтад нөлөөлж, өртөг, нөхөн сэргээлтийн зардал нэмэгдэх,</p> <p>Зудын гамшиг нь мал сүргийн хорогдол болон Засгийн газрын онцгой байдлын санд нөлөөлөх,</p> <p>КОВИД-19 цар тахал удаан үргэлжлэх нь хүний амь нас хохирох, улс орны эдийн засаг, худалдаа, улмаар хөгжилд шаардлагатай хөрөнгө оруулалт зэрэгт нөлөөлөх.</p>	Өндөр Дунд Өндөр Дунд Өндөр	Дунд Өндөр Өндөр
ТХЗ 1, 5, 10, 17	Нийгмийн нэгдмэл байдал, жөндөрийн эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхалгүй байх	<ul style="list-style-type: none"> • Ялгаварлан гадуурхах зуршил • Нийгэм дэх эрх мэдлийн тэнцвэргүй байдал • Жөндөрт суурилсан хүчирхийлэл 	<p>Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн бүс нутгийн эмзэг бүлгийнхэн эдийн засгийн тэгш бус байдлын улмаас мөлжлөгөд өртөх</p>	Дунд	Дунд

ТХЗ 16 + 17	Бүс нутгийн болон олон улсын нөлөө	Гадныхны үйл ажиллагаа, гадаад үйл явдлын нөлөөнөөс үүдэж нутаг дэвсгэр, ард иргэдийн халдашгүй бүрэн бүтэн байдал, тогтвортой, аюулгүй байдал, хөгжил цэцэглэлт зэрэгт учирч болзошгүй эрсдэлүүд.	<ul style="list-style-type: none"> Олон улсын хурцадмал байдал Хөрш орнуудын эмзэг байдал. Хориг арга хэмжээ, мөлжлөг, хараат байдал. 	Өргөн уудам хил хязгаар, хил гаалийн хяналт шалгалтын чадавх сул зэрэг нь Монгол Улсыг зэрлэг амьтны хууль бус худалдааны бай болгох (зэрлэг амьтан, соёлын үнэт зүйлсийн хууль бус худалдаа, хүн худалдаалах, хар тамхины импорт, гэх мэт)	Бага	Бага
ТХЗ 16 + 17	Дотоод аюулгүй байдал	Аюулгүй байдлын асуудлаас үүдэж нутаг дэвсгэр, хүн ам, дэд бүтцийн аюулгүй байдал, олон улсын хамтын нийгэмлэгийн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадварт учирч болзошгүй эрсдэл.	<ul style="list-style-type: none"> Дотоод зөрчил, баталгаагүй байдал. 	Мөнгө угаах (алт хууль бусаар хил нэвтрүүлэх, оффшор данс)	Бага	Өндөр
ТХЗ 16 + 17	Дотоод аюулгүй байдал	Аюулгүй байдлын асуудлаас үүдэж нутаг дэвсгэр, хүн ам, дэд бүтцийн аюулгүй байдал, олон улсын хамтын нийгэмлэгийн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадварт учирч болзошгүй эрсдэл.	<ul style="list-style-type: none"> Дотоод зөрчил, баталгаагүй байдал. 	Усны нөөц, усан цахилгаан станц барих асуудлаар ОХУ, БНХАУ-тай зөрчилдөж болзошгүй	Бага	Өндөр
ТХЗ 16 + 17	Дотоод аюулгүй байдал	Аюулгүй байдлын асуудлаас үүдэж нутаг дэвсгэр, хүн ам, дэд бүтцийн аюулгүй байдал, олон улсын хамтын нийгэмлэгийн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадварт учирч болзошгүй эрсдэл.	<ul style="list-style-type: none"> Дотоод зөрчил, баталгаагүй байдал. 	Кибер аюулгүй байдлын асуудал	Өндөр	Өндөр
ТХЗ 16 + 17	Дотоод аюулгүй байдал	Аюулгүй байдлын асуудлаас үүдэж нутаг дэвсгэр, хүн ам, дэд бүтцийн аюулгүй байдал, олон улсын хамтын нийгэмлэгийн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадварт учирч болзошгүй эрсдэл.	<ul style="list-style-type: none"> Дотоод зөрчил, баталгаагүй байдал. 	Улс төрийн тогтворгүй байдал	Дунд	Дунд
ТХЗ 16 + 17	Дотоод аюулгүй байдал	Аюулгүй байдлын асуудлаас үүдэж нутаг дэвсгэр, хүн ам, дэд бүтцийн аюулгүй байдал, олон улсын хамтын нийгэмлэгийн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадварт учирч болзошгүй эрсдэл.	<ul style="list-style-type: none"> Дотоод зөрчил, баталгаагүй байдал. 	Авлига	Өндөр	Өндөр
ТХЗ 16 + 17	Дотоод аюулгүй байдал	Аюулгүй байдлын асуудлаас үүдэж нутаг дэвсгэр, хүн ам, дэд бүтцийн аюулгүй байдал, олон улсын хамтын нийгэмлэгийн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадварт учирч болзошгүй эрсдэл.	<ul style="list-style-type: none"> Дотоод зөрчил, баталгаагүй байдал. 	Энэхүү шинжилгээгээр тодорхойлсон улс төр, эдийн засаг, байгаль орчны эрсдэлүүд нь дотоод аюулгүй байдлын асуудал үүсгэж болзошгүй	Бага	Өндөр
ТХЗ 16 + 17	Дотоод аюулгүй байдал	Аюулгүй байдлын асуудлаас үүдэж нутаг дэвсгэр, хүн ам, дэд бүтцийн аюулгүй байдал, олон улсын хамтын нийгэмлэгийн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадварт учирч болзошгүй эрсдэл.	<ul style="list-style-type: none"> Дотоод зөрчил, баталгаагүй байдал. 	Улам нэмэгдэж буй уул уурхайн үйл ажиллагаа болон орон нутгийн иргэд хоорондын зөрчил	Бага	Дунд

ТХЗ 16 + 17	Шударга, эрх зүйт ёс	Шударга ёс, эрх зүйт ёс, хариуцлагын зарчмуудыг шударга, үр дүнтэй, цогцоор нь хэрэглэх, хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэл.	<ul style="list-style-type: none"> • Сул буюу харилцан хүлээцтэй хандах • Эрхийг үгүйсгэх, ял шийтгэл хүлээхгүй байх зуршил. 	Сонгогдсон төлөөлөгчдөд итгэх итгэл сул байгаа нь ялгаварлан гадуурхсан хандлагатай нийлээд Монголын нийгмийн эв нэгдлийг улам бүр эмзэг болгох.	Өндөр	Өндөр
ТХЗ 4, 6, 7, 9, 11 + 17	Дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмж	Биет дэд бүтэц болон/буюу нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжгүй, хязгаарлагдмал байдлаас үүдэн нийгэм болоод хүн амд учирч болзошгүй эрсдэл.	<ul style="list-style-type: none"> • Суурь үйлчилгээ буюу технологи хангалтгүй. • Үйлчилгээ, дэд бүтэц, эрчим хүч, тээврийн үйлчилгээ тасалдах. • Суурь үйлчилгээ буюу дэд бүтцийн тэгш бус хүртээмж. 	Хүний эрхийн ноцтой зөрчил, зохион байгуулалттай гэмт хэрэгт хариуцлага тооцохгүй байх нь хүчирхийлэлд турхирсан тэмцэл, улс төрийн тогтворгүй байдалд хүргэх,	Бага	Өндөр
ТХЗ 4, 6, 7, 9, 11 + 17	Дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмж	Биет дэд бүтэц болон үзэл бодлоо илэрхийлэх тайван жагсаал хийх эрх чөлөөнд хатуу хязгаарлалт тавих нь хүчирхийлэл, тэвчээр алдагдах, хууль дээдлэх ёсыг үл хүндэтгэх байдалд хүргэх,	<ul style="list-style-type: none"> • Суурь үйлчилгээ (хоол тэжээл, ундны ус, ариун цэврийн байгууламж, тээвэр) хүртээмжгүй байгаа нь хүүхдийн хөгжлийг доройтуулах, 	Бизнесийн дүрэм журам болон үзэл бодлоо илэрхийлэх тайван жагсаал хийх эрх чөлөөнд хатуу хязгаарлалт тавих нь хүчирхийлэл, тэвчээр алдагдах, хууль дээдлэх ёсыг үл хүндэтгэх байдалд хүргэх,	Бага	Дунд
ТХЗ 4, 6, 7, 9, 11 + 17	Дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмж	Шүүхэд хандах, хүний эрхийн зөрчлийг арилгах боломж хязгаарлагдмал байх нь иргэдийн дунд Засгийн газар болон түүний байгууллагуудын хууль ёсны байдлыг алдагдуулж болзошгүй.	<ul style="list-style-type: none"> • Суурь үйлчилгээ буюу эрчим хүч, тээврийн үйлчилгээ тасалдах. • Суурь үйлчилгээ буюу дэд бүтцийн тэгш бус хүртээмж. 	Шүүхэд хандах, хүний эрхийн зөрчлийг арилгах боломж хязгаарлагдмал байх нь иргэдийн дунд Засгийн газар болон түүний байгууллагуудын хууль ёсны байдлыг алдагдуулж болзошгүй.	Бага	Дунд
ТХЗ 4, 6, 7, 9, 11 + 17	Дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмж	Биет дэд бүтэц болон үзэл бодлоо илэрхийлэх тайван жагсаал хийх эрх чөлөөнд хатуу хязгаарлалт тавих нь хүчирхийлэл, тэвчээр алдагдах, хууль дээдлэх ёсыг үл хүндэтгэх байдалд хүргэх,	<ul style="list-style-type: none"> • Суурь үйлчилгээ (хоол тэжээл, ундны ус, ариун цэврийн байгууламж, тээвэр) хүртээмжгүй байгаа нь хүүхдийн хөгжлийг доройтуулах, 	Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг (ган, зуд, элсэн болон шороон шуурга гэх мэт), бэлчээрийн доройтлоос үүдэлтэй гадаад хүчин зүйлүүд малчдын амьжиргааг доройтуулах,	Бага	Дунд

ТХЗ	Нүүлгэн шилжүүлэлт, шилжих шилжилт хөдөлгөөн	Нүүлгэн шилжүүлэлт болон/буюу шилжилт хөдөлгөөн зэргээс шалтгаалсан дарамт шахалтаас үүдэн хүн ам, нутаг дэвсгэрийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэл	<ul style="list-style-type: none"> • Хүмүүсийн нутаг дэвсгэр дотроо болон ирэх, явах шилжих хөдөлгөөн. • Шилжин суурьшигчдын эрх, хамгааллын түвшин. • Шилжилт хөдөлгөөний нийгэм эдийн засаг, соёл, байгаль орчинд үзүүлэх нөлөө 	Хэрэв шилжилт хөдөлгөөнийг зөв зохицуулахгүй бол энэ нь хүн худалдаалах, орчин үеийн боолчлол зэрэг хууль бус хөдөлгөөн, шилжилт хөдөлгөөний эмзэг байдлыг нэмэгдүүлж болзошгүй.	Бага	Дунд
			<ul style="list-style-type: none"> • Шилжин суурьшигчдын эрх, хамгааллын түвшин. • Шилжилт хөдөлгөөний нийгэм эдийн засаг, соёл, байгаль орчинд үзүүлэх нөлөө 	Цаг агаарын эрс тэс нөхцөл байдлын улмаас хөдөө орон нутгийн иргэд, малчдыг нүүлгэн шилжүүлэх,	Өндөр	Бага
			<ul style="list-style-type: none"> • Шилжилт хөдөлгөөний нийгэм эдийн засаг, соёл, байгаль орчинд үзүүлэх нөлөө 	Хөдөө орон нутгаас хот суурин газарт шилжин ирэгсэд суурь үйлчилгээ (бүртгэлгүй, нийгмийн үйлчилгээ авах боломжгүй) авч чадахгүй, орхигдох магадлалтай.	Өндөр	Дунд
			<ul style="list-style-type: none"> • Шилжилт хөдөлгөөний нийгэм эдийн засаг, соёл, байгаль орчинд үзүүлэх нөлөө 	Хөдөө орон нутгаас хот суурин руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдсэний улмаас дотоодын шилжин суурьшигчдыг нийгэмд гутаан доромжлох үзэгдэл ихсэх нь дотоод зөрчилдөөнийг үүсгэж болзошгүй.	Бага	Өндөр
				Залуучуудын дунд ажилгүйдэл их байгаагаас гадаад орнууд руу оюуны чадавх шилжих магадлалтай.	Дунд	Дунд

ТХЗ 3+17	Нийгмийн эрүүл мэнд	Бодит болон шинээр гарч ирж буй эрүүл мэндийн онцгой байдлын улмаас хүн ам, эдийн засаг, газар нутгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэл.	<ul style="list-style-type: none"> Урьдчилан сэргийлэх буюу эмчлэх боломжтой эрүүл мэндийн асуудлууд нэмэгдэж, хүүхдийн хөгжил хоцрогдох, Халдварын дэгдэлт, цар тахал, халдварт өвчин. Хими, цацраг идэвхт бодис болон биологийн бусад бодисууд. Үр нөлөөгүй үйлчилгээ, эрүүл мэндийн тэгш бус байдал 	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээлэл, боловсрол дутмаг байгаагаас өсвөр насны хүүхдийн төрөлт цаашид нэмэгдэх, Хүүхэд болон насанд хүрэгчдийн илүүдэл жин, таргалалт нэмэгдэх, Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн цус багадалт нэмэгдэх, Өсвөр үе, залуучуудын дундах амиа хорлох тохиолдол гарах, Хүмүүсийн халааснаас гарах зардал нэмэгдэж байгаагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанар тэгш бус байх, КОВИД-19 цар тахлын дарамтаас үүдэн эрүүл мэндийн систем доголдох,	Бага	Дунд
ТХЗ 2, 3, 7, 8, 17	Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй, газар нутаг	Ургац, хүнсний үйлдвэрлэл, мал аж ахуй, холбогдох бусад асуудлаас үүдэж тухайн нутаг дэвсгэрт хүн ам, газар тариалан болон/ буюу хүнсний үйлдвэрлэлд учирч болзошгүй эрсдэлүүд	<ul style="list-style-type: none"> Тариалангийн талбай, ургац хураалт хангалтгүй, Хүнсний хангамж хязгаарлагдмал байх, Газрын ашиглалт, газар эзэмших, өмчлөх эрх, Тогтвортой эх үүсвэртэй мал аж ахуйн бүтээгдэхүүний эх үүсвэрийг бүрдүүлэх, гэрчилгээжүүлэлт, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх 	Түүхий болон боловруулсан нүүрсний хэрэглээ, утаа маш ихээр ялгаруулдаг хуучин тээврийн хэрэгсэл, чанар муутай түлшний хэрэглээ зэргээс агаарын бохирдол улам дордох. Нэн эмзэг бүлгийн хүмүүс хоол тэжээлийн дутагдалд орсноор ядуурал улам гүнзгийрэх - сургуулийн цайны хөтөлбөр хэрэгжээгүй тохиолдолд, Хэрэглээний үнийн индекс өсөх нь эмзэг бүлгийн хүмүүсийг гүн гүнзгий ядуурал руу түлхэж, хүнсний аюулгүй байдлыг алдагдуулах, Ой хээрийн түймэр, ган, зуд, онц аюултай үзэгдлүүд зэрэг нь газрын доройтол, хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдалд ноцтой нөлөө учруулах, Газар тариаланд хэрэглэх усны нөөц хомсдох, Малын тоо толгой хэт их өссөнөөр газар нутаг, биологийн олон янз байдал доройтох устахад хүргэх,	Өндөр	Өндөр

ТХЗ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцтэй холбоотой асуудлаас үүдэж тухайн нутаг дэвсгэрийн экологи, түүний экосистем, хүн амд учирч болзошгүй эрсдэлүүд.	<ul style="list-style-type: none"> Байгалийн гамшиг буюу цаг агаарын эрс тэс үзэгдэл. Хот суурингийн орчны бохирдол, эрүүл мэнд; Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр (NDC) болон ТХЗ-ын уялдаа холбоо, салбар хоорондын зохицуулалт, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйл ажиллагаанд салбар бүрийн хүлээх үүрэг, хариуцлага тодорхойгүй байгаа зэрэг асуудлууд; Байгалийн нөөцийн зохисгүй хэрэглээ, түүнд тавих хяналт сул байгаагаас үүдэн дэлхийн дулаарал нэмэгдэж, биологийн олон янз байдал алдагдаж байгаа нь экосистем улам бүр эмзэг болгох, Байгалийн баялгийг зүй бохисгүй ашиглах нь байгаль орчны доройтлыг улам бүр нэмэгдүүлэх, Экологийн хохирол, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө. 	Газрын даацыг 2,3 дахин хэтрүүлж байгаагаас газрын доройтол улам бүр нэмэгдэх, Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй ой хээрийн түймэр, хортон шавьжны нөлөөгөөр бэлчээр нутаг, эдэлбэр газар, хүлэрт намаг, ой мод доройтох, устах, цөлжих. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан байгалийн гамшиг (ган, зуд, элсэн болон шороон шуурга) ихсэж байгаагаас газар тариалангийн салбар улам эмзэг болох, байгалийн нөөц, байгаль орчноос ихээхэн хамааралтай орон нутгийн иргэдийн амьжиргааг улам доройтуулах, Байгалийн нөөцийн хомсдол (ус, бэлчээр нутаг, ашигт малтмал) нь байгалийн нөөц, ялангуяа гүний усны нөөцийн судалгаа шинжилгээ, үнэлгээ өндөр өртөгтэй байгаатай холбоотой. Нүүрсэд суурилсан эрчим хүчний хэрэглээний улмаас хот суурин газрын агаарын бохирдол улам нэмэгдэж, нэг хүнд ногдох нүүрстөрөгчийн давхар исэлийн ялгарал маш өндөр байх, Малын тоо толгой өссөн, уул уурхай, дэд бүтцийн бүтээн байгуулалт, зэрлэг амьтдын хууль бус худалдаа, зохисгүй хэрэглээ, дэлхийн дулаарал зэргээс шалтгаалан биологийн төрөл зүйлийн амьдрах орчин сүйтгэгдэж устаж үгүй болох, Уул уурхайн компаниуд болон малчдын бүлгүүдийн хооронд газар ашиглалтын улмаас үүсч болзошгүй зөрчил маргаан, малчдын дунд гарч болзошгүй бэлчээр нутгийн талаарх маргаан зэрэг нь тусгай хамгаалалттай газар нутгийг нэмэгдүүлэх сонирхол бүхий орон нутгийнхан (сум, орон нутгийн бүлгүүд) болон төв засгийн газар хоорондын байгалийн нөөцийг ашиглах талаарх шийдвэр зөрчилдөж байгаатай холбоотой;	Өндөр	Өндөр	Өндөр
11,				Хот суурин газруудын төвийн хөрс, усны бохирдол, хатуу болон аюултай хог хаягдлын зохисгүй менежмент, бохир ус цэвэршүүлэх байгууламж хангалтгүй зэргээс үүдэлтэй усны бохирдлын ноцтой асуудал үүсэх;	Өндөр	Өндөр	Өндөр
12,				Хууль бусаар алт олборлож байгаа бус нутгуудийн гадаргын болон гүний ус, хөрс мөнгөн усаар бохирдож, улам доройтох.	Өндөр	Бага	Өндөр
13,					Өндөр	Өндөр	Өндөр
14,					Өндөр	Өндөр	Өндөр
15 +					Өндөр	Өндөр	Өндөр
17					Өндөр	Өндөр	Өндөр

ХАВСРАЛТ 5: МОНГОЛ УЛСЫН 2030 ХҮРТЭЛХ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР, ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ТАВАН ҮНДСЭН КАТЕГОРИОР (5Х)

Хүн зон (People) - Монгол Улс өндөр боловсролтой, чадварлаг хүн амтай боловч тэдний чадавхыг дутуу ашиглаж байна. Тус улсад тулгарч буй гол сорилт бол байгалийн арвин нөөцтэй нь холбоотой. Монгол Улс уул уурхайн салбартаа асар их хөрөнгө оруулалт хийж байгаа хэдий ч хүнд чиглэсэн хөрөнгө оруулалтыг цаашид эн тэргүүний зорилт болгож, эрүүл чийрэг, ур чадвартай, тэсвэр хатуужилтай хүний нөөцийг хөгжүүлэх, хүмүүсийг үр бүтээлтэй ажлын байраар хангах, улмаар албан бусаас албан хөдөлмөр эрхлэлтэд шилжихэд дэмжлэг үзүүлж хөдөлмөрийн нөхцөл, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна. Сүүлийн 10 жилд нэг хүнд ногдох ДНБ гайхалтай өссөн хэдий ч хүн амын дундаж наслалт, боловсрол, орлогын нийлмэл үзүүлэлт болох Хүний хөгжлийн индексээс харахад хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл, эрүүл мэнд, боловсролын үзүүлэлтүүд харьцангуй дундаж түвшинд сайжирсан байна. Хүн бүрийн хэрэгцээнд нийцсэн, аливаа хямралд дорвитой хариу өгөхүйц нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, эдийн засгийн үйлчилгээ авах боломжийг хангах замаар юун түрүүн ядуу хүмүүсийг илүү сайн хамгаалах шаардлагатай байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл, эмзэг бүлгийн хүмүүсийг нийгмээс ялгаварлахад хүргэж байгаа суурь шалтгааныг арилгахад чиглэсэн нийгмийн үйлчилгээг хүн амын бүлгүүдэд хүргэж чадахгүй хэвээр байна. Хөдөө орон нутгийн сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролын үйлчилгээ, өсвөр насныханд зориулсан амьдрах ухаан, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ зэргийн хүртээмжийг сайжруулж, эмзэг бүлгийн эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зохистой хөдөлмөр эрхлэх, чанартай дээд болон мэргэжлийн боловсрол эзэмшихэд онцгой дэмжлэг хэрэгтэй байна. Хөдөө орон нутгаас шилжин ирж Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч байгаа айл өрхүүдийн хүнсний баталгаат байдал нь алдагдаж,

хоол тэжээлийн дутагдал, ядууралд орж, нийгмийн суурь үйлчилгээ авч чадахгүй олон гачигдал зовлонтой тулгарч нэн эмзэг хэсэг болж байна. Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг бүс нутаг болоод орлогоос хамааран хэдийнээ ялгаатай хүртдэг байсан нь КОВИД-19 цар тахлын уршгаар улам бүр гүнзгийрэхийн зэрэгцээ гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн тоо олширч, гадаад улс орнуудад монголчууд олноороо орон байр, амьдрах зардалгүй гацсан зэрэг цөөнгүй сорилтыг бий болгожээ.

Хүж дэлхий (Planet) - Монгол орны жилийн дундаж агаарын температур 1940-2015 оны хооронд 2.24°C болж, дэлхийн дунджаас гурав дахин нэмэгдсэн нь хэт хуурай уур амьсгалтай орон болоход нөлөөлсөн. Жилд унах хур тунадасын хэмжээ буурч, хур тунадасны улирлын хэв маяг ч тогтворгүй болсон. Эдгээр өөрчлөлтүүд улам эрчимжих төлөвтэй байгааг цаг уурын төсөөлөл тооцоо харуулж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр газар тариалан, мал аж ахуй, ус, газар, ойн нөөц, дэд бүтцийн хөгжил, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй байгалийн гамшгийн (ган, зуд, үер, салхи шуурга) давтамж, далайц нэмэгдэж байна. Уул уурхайд тулгуурласан эдийн засгийн хурдацтай өсөлт, түүхий нүүрсний татаас зэрэг нь байгаль орчинд ноцтой ул мөрөө үлдээж байгаагаас айл өрх болон үйлдвэр, аж ахуйн газруудын эрчим хүчний хэмнэлт, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн шинэ хөшүүрэг бий болгох шаардлагатайг харуулж байна. Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийг ахиулж 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтыг 27.2 хувиар бууруулах шинэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд агаар, орчны бохирдлыг бууруулах илүү шийдэмгий арга хэмжээ авах шаардлагатай болж байна. Усны нөөц хомсдож, газрын доройтол нэмэгдэж байгаа нь усны үр ашиггүй хэрэглээ, бэлчээрийн даац хэтрүүлэлтийг хязгаарлах, экосистем, байгалийн нөөцийг тогтвортой

удирдах зэрэгт чиглэсэн усны нөөц болон газрын хамгаалал, удирдлагын үр дүнтэй бодлого хэрэгжүүлэхийг шаардаж байна. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлүүдээс гадна газар хөдлөлт нь Монгол орны байгалийн томоохон эрсдлийн нэг юм. Монгол Улс ногоон хөгжил, биологийн олон янз байдал, байгалийн нөөцийг хамгаалах чиглэлээр дэвшилтэт зохицуулалт, бодлогын тогтолцоотой. Гэсэн хэдий ч засгийн газар болон оролцогч талууд байгалийн нөөцийн тогтвортой удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд институцийн чадавх, хөшүүргийн механизмыг сайжруулах шаардлагатай. Тус улсын ногоон хөгжилд оруулж буй хөрөнгө оруулалт маш бага (2021-2025 оны нийт хөрөнгө оруулалтын 2 хүрэхгүй хувь) хэвээр байгаа нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Парисын хэлэлцээрийн хүрээнд үндэсний хөгжлийн бодлогоороо олон улсын өмнө хүлээн зөвшөөрсөн үүрэг амлалтаа хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал хүлээж байна.

Хөгжил цэцэглэл (Prosperity) – Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр нүүрсний үйлдвэрлэлд түшиглэсэн хэвээр байна. Нөгөөтэйгүүр нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах талаар олон улсын хэмжээнд гарч буй хүчин чармайлтуудыг БНХАУ дэмжиж байгаагаас ажиглахад цаашид БНХАУ-ын нүүрсний эрэлт буурч болзошгүй тул Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлэх талаар дорвитой, нухацтай арга хэмжээ авахгүй бол тус улсын экспортын хэмжээ буурч, эдийн засгийн өсөлт саарахаар байна. Юун түрүүн хувийн хэвшлийг хөгжихөд нь илүү дэмжлэг үзүүлэх, ялангуяа ЖДҮ-ийг хөгжүүлэх, бизнесийн болоод хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, уул уурхайн бус салбарт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад илүү дэмжлэг үзүүлэх шаардлага тавигдаж байна. Хөдөө аж ахуйн салбар нь тус улсын нийт ажиллах хүчний 27 хувийг ажлын байраар хангадаг эдийн засгийн гол салбар хэвээр байна. Газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нэмүү өртгийг нэмэгдүүлэхийн

тулд илүү их хөрөнгө оруулалт хийснээр эдийн засгийн хөгжилд түлхэц өгч, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах чадварыг бэхжүүлж, хот, хөдөөгийн хүн амд илүү бүтээмжтэй ажлын байр бий болгож чадна. Хөдөө аж ахуйн салбарт оруулж буй төсвийн хөрөнгө оруулалт нь бага хэвээр байгаа буюу 2021-2025 онд төлөвлөж буй нийт хөрөнгө оруулалтын дөнгөж 2.6 хувийг бүрдүүлж байна. Эдийн засагт томоохон хувийг эзэлж байгаа үйлчилгээний салбарт мэдээллийн технологийн дэвшлийг шуурхай нэвтрүүлж чадвал үйлчилгээний салбарын үйлдвэрлэлд ихээхэн ашиг авчирч Монгол Улсын эдийн засаг үр шимийг нь хүртэх боломжтой юм. Хүний нөөц дутуу ашиглагдсан хэвээр байгаа учир макро эдийн засгийн хүчтэй удирдлагыг хөгжүүлэх, төрийн үйлчилгээг хүргэх, хувийн хэвшил болон гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулахад чиглэсэн илүү хүчирхэг институцийг бий болгох нь нэн чухал юм.

Хотлоор амгалан/Энх тайван (Peace)

- 1990-ээд оны эхэн үеэс Монгол Улс ардчилсан, нээлттэй засаглалд амжилттай, тайван замаар шилжиж, дөрвөн жилд нэг удаа ерөнхийлөгчийн болон Улсын Их хурлын сонгуулийг тасралтгүй зохион байгуулж, засаглалын эрх мэдлийг сонгууль бүрээр тайван замаар шилжүүлж авч байсан (2008 оны сонгуулийн дараах хүчирхийллийн зарим хэлбэрийг эс тооцвол). Гэсэн хэдий ч хамтын хөгжил цэцэглэлт, төрийн санхүүжилтийн асуудлын тухайд улс төрийн эрх мэдэл ихээхэн ээдрээтэй байна. Эдгээр санаа зовоосон асуудлын төвд байгалийн баялгийн нөөц ашигласны орлогыг захиран зарцуулах, хуваарилах улс төрийн дарамт шахалт, ивээн тэтгэх замаар ашиг хуваалцах, үйлчлүүлэгчдийг татах тогтолцоотой улс төрийн зохицуулалт оршсоор байна.^[274] Хүний нөөцийн халаа сэлгээ, байгууллагуудын бүтцийн өөрчлөлтийг ойр ойрхон хийх, улс төрийн нөлөө бүхий боловсон хүчнийг албан тушаалд томилох зэрэг нь төрийн байгууллагын чадавх, шударга байдлыг алдадуулахын зэрэгцээ ихээхэн өртөг зардалтай. Авлигад хамгийн ихээр өртөж

байгаа таван байгууллагын тоонд улс төрийн намууд орж байгаа талаарх олон нийтийн үзэл санал нэмэгдэж байна. Улс төрийн болон төрийн захиргааны салбарт өргөн хүрээний шинэчлэл хийж иргэний нийгмийнхний орон зайг нэмэгдүүлж, бодлого боловсруулах үйл явцад тэднийг татан оролцуулахад дорвитой хүчин чармайлт гаргах хэрэгтэй.

Хамтын түншлэл (Partnership) – Монгол Улсын төр засаг нь ТХЗ-ыг хэрэгжүүлэхийн тулд иргэний нийгэм, хувийн хэвшил болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллах, үндэсний хөгжлийн төлөвлөгөө, санхүүжилтийн төлөвлөгөөндөө ТХЗ-ыг тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавих зэргээр бүхий л арга хэрэгслийг дайчлах нь чухал байна. Либералчлал, зах зээлийн эдийн засгийн чиг хандлагад тулгуурлан Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элссэн. Тэр цагаас хойш Монгол Улсын Засгийн газар нь олон улсын болон бүс нутгийн интеграцлалд илүү няхуур хандаж, худалдааны түншлэлээ голчлон хоёр талт зарчмаар байгуулах болсон. Монгол Улс нь ОХУ, БНХАУ-тай харилцан сайн хамтын ажиллагаатай байгаагийн зэрэгцээ “гуравдагч хөрш”-ийн бодлого баримталж байна. Саяхан НҮБАНДЭЗНК-ын дэмжлэгтэй олон жилийн идэвхтэй яриа хэлэлцээ хийсний үр дүнд Ази Номхон далайн бүсийн худалдааны хэлэлцээрт нэгдэн орж, БНХАУ-Монгол Улс-ОХУ-ын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж байна. Эдийн засгийн тогтворгүй байдлын ээлжит давалгаанаас зайлсхийхийн тулд Монгол Улс цаашид худалдааны сагс, зах зээлээ илүү төрөлжүүлэх шаардлагатай. Монгол Улс худалдааны түншүүд болон экспортын бүтээгдэхүүний сагсаа хэр зэрэг төрөлжүүлэх нь өөрийн хөрөнгийн бааз суурь, тухайлбал, хүний нөөц, байгууллагууд, биет капиталыг хэрхэн төрөлжүүлж чадахаас ихээхэн хамаарна. Төсвийн санхүүжилт, өрийн менежментийг үр дүнтэй хийх нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үндэслэлгүй зээлээс зайлсхийхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. КОВИД-19 цар тахлын хямрал нь

хойч үеийнхний санхүүгийн дарамт болох их өрийн хэмжээг улам нэмэгдүүлсэн. Өрийн хэмжээ өсөх тусам ТХЗ-ын санхүүжилтэд чиглэсэн төсвийн орон зайг төдийчинээ хумина. Иймээс улс төрийн аливаа дарамт шахалтгүйгээр төсвийн зарцуулалтын шийдвэрийг гаргах чадвартай, бие даасан, хүчирхэг санхүүгийн байгууллагууд бий болох шаардлагатай. Эцэст нь, ТХЗ-ын хэрэгжилтийн ахиц дэвшил нь ТХЗ-ын хэрэгжилтийг хэмжих, хянах, удирдах тоо мэдээллийг бий болгох, улмаар батлагдсан хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн үүрэг амлалт хэрхэн биелэхээс хамаарна. Ийм хүчин чармайлт гаргахгүй байх аваас үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь хэрэгжүүлэх үр ашигтай арга хэрэгсэлгүй, өөрөөр хэлбэл, төсвийн төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөгүй зөвхөн тунхаглалын чанартай болох эрсдэлтэй.

ТХЗ-ын хэрэгжилтийн явцыг бүхий л хүрээнд хэмжиж, хянаж, удирдахын тулд дараах олон улсын хэд хэдэн эх сурвалжийн тоймуудыг ашиглах боломж бий. Тухайлбал:

НҮБАНДЭЗНК-ын Улс орнуудын ТХЗ-ын хэрэгжилтийн явцыг харуулах цахим хяналтын мэдээллийн товчоон (UNESCAP SDG National Tracker Dashboard)^[275] нь ТХЗ бүрийг болон ТХЗ-ын сонгосон шалгуур үзүүлэлтийн өөрчлөлтийг харуулна. Энд үзүүлж буй жагсаалтад олон улсын ТХЗ-ын албан ёсны аргачлалын нэг хэсэг болох шалгуур үзүүлэлтүүд орсон бөгөөд тоо мэдээлэл нь НҮБ-ын Статистикийн хэлтсээс улс орон бүрээр тооцсон ТХЗ-ын хэрэгжилтийн явцыг тусгасан.

НҮБ-ын Статистикийн хэлтсээс гаргадаг Улс орнуудын ТХЗ-ын талаарх мэдээллийн сан нь (UN Statistics Division maintains SDG Country profile)^[276] “ТХЗ-ын нээлттэй мэдээллийн сан” бөгөөд зөвхөн тухайн улсын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн төлөв байдлын талаарх мэдээллийг цуглуулдаг ба тухайн орны ТХЗ-ын хэрэгжилтийн явц, ахиц

275 Үндэсний ТХЗ-ын үзүүлэлт. Үзэх <https://sdg-tracker.unescap.org/snapshot#>

276 ТХЗ-ыг хэрэгжүүлж буй Улс орнуудын танилцуулга. Үзэх <https://country-profiles.unstatshub.org/mng>

дэвшлийг үнэлдэггүй. Харин тус сангийн мэдээллийг ашиглан тухайн улсын ТХЗ-ын хэрэгжилтийн явцыг дүгнэж гаргах боломж олгодог. Тус мэдээллийн сан нь олон улсын түвшинд тодорхойлсон ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийг агуулсан төдийгүй улс орны түвшний мэдээлэл, бүс нутгийн болон дэлхийн хэмжээний нэгдсэн мэдээллийг мөн агуулж байгаа болно.







Дэлхийн Банкны ТХЗ-ын Атлас (World Bank SDG Atlas)^[277] нь ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт тавихад тус болох Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд (ДХУ/WDI)-ийг тооцох тоо мэдээллийг агуулж байгаа боловч тэдгээр нь ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх албан ёсны үзүүлэлтүүд биш юм. Харин холбогдох үзүүлэлтүүдийг сонгон авч ТХЗ-ын хэрэгжилтийн явцын дүн шинжилгээ хийж болно.

Bertelsmann Stiftung болон Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээ (SDSN)-ний хамтран бэлтгэсэн 2021 оны Тогтвортой хөгжлийн тайлан болон тэдгээрийн хариуцан ажиллуулдаг ТХЗ-ын индекс болон хяналтын цахим мэдээллийн товчоон (dashboards)^[278] нь улс орнуудын ТХЗ-ын хэрэгжилтийн явцыг харуулна. ТХЗ-ын индекс нь улс орон бүрийн Тогтвортой хөгжлийн 17 зорилгын хэрэгжилтийн гүйцэтгэлд өгч буй үнэлгээ бөгөөд зорилго бүрийн жинэлэлт ижил утгатай буюу адил ач холбогдолтой. ТХЗ-ын хэрэгжилтийн хамгийн доод оноо нь (0), хамгийн дээд оноо нь (100) юм.

277 Дэлхийн банк. Дэлхийн хөгжлийн үзүүлэлт: Тогтвортой хөгжлийн зорилтууд. Үзэх <https://datatopics.worldbank.org/sdgs/SDG-selected-indicators.html>

278 Тогтвортой хөгжлийн тайлан. Үзэх <https://s3.amazonaws.com/sustainabledevelopment.report/2021/2021-sustainable-development-report.pdf>

ХҮСНЭГТ 1: МОНГОЛ УЛСЫН ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ ТХЗ-ЫН ОЛОН УЛСЫН ХЯНАЛТЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ТОВЧООН

	TX3	BS & SD SNz	WB	NSO	UN-STAT	SDG National Tracker
	TX3 1	↑	↑	↑	↑	↑
	TX3 2	→	↓	→	↓	↓
	TX3 3	↗	↗	↗	↗	↗
	TX3 4	↑	↑	↓	↗	↗
	TX3 5	↗	↗	↗	→	↗
	TX3 6	↗	→	↑	→	↗
	TX3 7	↗	↑	↑	↑	↗
	TX3 8	↗	↗	→	→	↓
	TX3 9	→	↗	↑	↗	↗
	TX3 10	○	↗	↓	→	→
	TX3 11	→	↗	↑	↑	↗
	TX3 12	○	↗	↑	→	↓
	TX3 13	→	↗	↑	↗	↗
	TX3 15	→	→	→	→	↗
	TX3 16	→	↗	↑	↗	↗
	TX3 17	↗	↗	↑	↑	→

- ↑ Төлөвлөсөний дагуу ахиц гарч байгаа
- ↗ Ахиц гарч буй хэдий ч төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байгаа
- Суурь түвшинээс хөдлөхгүй байгаа
- ↓ Суурь түвшинээс ухарч байгаа
- Мэдээлэл байхгүй

Хүснэгт 1-д олон улсын ТХЗ-ын сонгосон мэдээллийн платформууд болон ҮСХ-ны ТХЗ-ын мэдээллийн сан^[279]-гийн мэдээлэлд үндэслэн тооцсон Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтийн явцыг үзүүлсэн болно. Bertelsmann Stiftung болон Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээнээс гаргасан тооцоогоор Монгол Улсын ТХЗ-ын индекс 63.8 (165 орноос 106-д орсон) байгаа нь бүс нутгийн дунджаас 1.9%-иар доогуур байна.

“Хүж Дэлхий” категорийн зорилтуудын биелэлтэд үнэлгээ өгөхөд тоо мэдээлэл ихээхэн хязгаарлагдмал байгаа юм. Энэ нь ялангуяа хэрэглээ, үйлдвэрлэлийн хэв маяг, уур амьсгалын өөрчлөлт, газрын менежмент зэрэг асуудлаарх тоо мэдээлэл хомс байгаатай холбоотой. Өнөөгийн бэлэн байгаа тоо мэдээллээс ажиглахад ус, ариун цэврийн байгууламжийг сайжруулах, хямд төсөр, цэвэр эрчим хүчний хүртээмжийг сайжруулах зорилтууд харьцангуй ахицтай хэрэгжиж, харин газрын доройтлыг бууруулах зорилтын хэрэгжилт ухарсан байдалтай байна.

“Хөгжил цэцэглэлт” категорийн зорилтуудын хүрээнд Монгол Улс эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангах, тэгш бус байдлыг арилгахын төлөө тэмцэж байна. Энэ нь ялангуяа ажилгүйдэл болон албан бус хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдэж байгаа, хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт удаашралтай, хүн амын дунд тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт улам бүр мэдрэгдэх болсон зэрэгтэй холбоотой. Дэд бүтэц, ялангуяа, Улаанбаатар хотын нийтийн тээврийн хүртээмжтэй холбоотой бэрхшээлүүд ч нэмэгдсээр байна.

Монгол Улс амар амгалан, хүртээмжтэй нийгмийг бүтээн байгуулах, шударга байдлыг эрхэмлэхтэй холбоотой “энхтайван” категорийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж байгааг статистикийн тоо мэдээлэл харуулж байна. Мөн ТХЗ 17-ын олон зорилтын биелэлтийг бүрэн үнэлэх тоо мэдээлэл дутдагдалтай байгаа хэдий ч “хамтын түншлэл” зорилтуудад харьцангуй ахиц дэвшил гарч байна.

279 НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газар (ЭЗНАХГ) болон Дэлхийн банкны мэдээллийн санг үндэслэн ТХЗ-ын зорилт, шалгуур үзүүлэлтүүдийн энэхүү тооцоог Монгол Улс дахь НҮБ хийсэн бөгөөд энэ нь НҮБ-ын ЭЗНАХГ болон Дэлхийн банкны тооцоо биш болно.

Товчилсон үгсийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АҮАУХ	Арьс үндсээр алагчлахыг устгах хороо
АХБ	Азийн хөгжлийн банк
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХЗГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын газар
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДБ	Дэлхийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХБ	Дэлхийн Худалдааны Байгууллага
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЁЗСХБХ	Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хороо
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ЖДУ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЗГҮАХ	Монгол Улсын Засгийн газрын 2020- 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
КОВИД-19	Коронавируст халдвар
ЛГБТИ	Лесбиян, гей, бисексуал, трансжендер болон интерсекс
ЛГИ	Ложистикийн гүйцэтгэлийн индекс
МАН	Монгол Ардын Нам
МАОЭНХ	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
МОХЭЗК	Монгол Улс-ОХУ-БНХАУ-ын эдийн засгийн коридор
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МҮЭХ	Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБАНДЭЗНК	НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засгийн нийгмийн комисс
НҮБДАЭДКГ	НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар
НҮБАУХБ	НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага
НҮББОХ	НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр
НҮББШУСБ	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан соёлын байгууллага
НҮБГЭБГ	НҮБ-ын Гамшгийн эрсдлийг бууруулах газар

НҮБЕЭЗК	НҮБ-ын Европын эдийн засгийн комисс
НҮБХАБИТАТ	НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын асуудал эрхэлсэн байгууллага
НҮБСТАТ	НҮБ-ын Статистикийн комисс
НҮБТҮА	НҮБ-ын Төслийн үйлчилгээний алба
НҮБУТЭСАХХ	НҮБ-ын Улс төр, энхийг сахиулах асуудал хариуцсан хэлтэс
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НҮБХАС	НҮБ-ын Хүн амын сан
НҮБХХЗГ	НҮБ-ын Хүмүүнлэгийн хэргийг зохицуулах газар
НҮБХС	НҮБ-ын Хүүхдийн сан
НҮБЭЗНАЭГ	НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУВС	Олон улсын Валютын сан
ОУСБ	Олон улсын санхүүгийн байгууллагууд
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУЦХБ	Олон улсын цахилгаан холбооны байгууллага
ОУШХБ	Олон улсын Шилжилт хөдөлгөөний байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ӨӨХА/SSC	Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагаа
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТХТ	Монгол Улсын Тогтвортой хөгжлийн төлөв
ТХХАХ	Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ
ТХҮБ-2030	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030
УИХ	Улсын Их Хурал
УЦУОСМХ	Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн
ҮСДИ	Үндэсний сайн дурын илтгэл
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ҮХГ	Үндэсний Хөгжлийн газар
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
ХАЁТ	Хөгжлийн албан ёсны тусламж
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ХМХ	Хүүхдийн мөнгө хөтөлбөр
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХТБШ	Хөгжлийн төлөв байдлын шинжилгээ
ХХИ	Хүний хөгжлийн индекс
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ЭАБХУХ	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хороо

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН
ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ
2021

©Монгол дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага
2022

Credits:

Хавтасны гэрэл зургийг Лхагвасүрэнгийн Элбэгзаяа / Гаммафото агентлаг

Зургийг Эрдэнэбилэгийн Санчир

Хэвлэлийн эхийг Дагвадоржийн Болд / Гаммафото агентлаг

Монгол Улсын

**ХӨГЖЛИЙН
ТӨЛӨВ БАЙДЛЫН
ШИНЖИЛГЭЭ**

2021